



ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

СУДАЛГААНЫ ТАЙЛАН 1




Засгийн газрын тохируулагч
агентлаг
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН
ГАЗАР



Монгол Улсын Их Сургууль
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН



ОЮУ ТОЛГОЙ ХХК



ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ОНОЛ
АРГАЗҮЙ

УЛААНБААТАР ХОТ, 2019 ОН

Энэхүү тайланд захиалагч болон санхүүжүүлэгчийн байр суурийг биш, харин судлаачийн байр суурийг илэрхийлсэн болно.

ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

Судалгааны гэгцсийн тайлан

БАГИЙН ГИШҮҮД:

МУИС-ийн багш, Др. Проф.	Б.Чинбат
МУИС-ийн багш, Др. Проф.	В.Батцэнгэл
МУИС-ийн багш, Др. Дэд проф.	Ц.Базарханд
МУИС-ийн багш, Др. Дэд проф.	Д.Энхжаргал
МУИС-ийн багш, магиср.	Ч.Заяа

АГУУЛГА

БҮЛЭГ I. ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ	6
1.1. Бүс нутгийн хөгжлийн онол аргазүй.....	6
1.1.1. Хөгжлийн онол сургааль.....	6
1.1.2. Бүс нутаг төлөвлөлтийн онол үндэслэл.....	8
1.2. Бүсчлэн хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага	9
1.3. Монгол Улсыг бүсчилэн хөгжүүлж ирсэн түүхэн замнал	12
1.4. Бүсчилсэн хөгжлийн талаарх гадны туршлага, сургамж	14
1.4.1. Вьетнамын бүс нутгийн хөгжлийн бодлого	14
1.4.2. БНСУ-ын үндэсний нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого	16
БҮЛЭГ II . ЭДИЙН ЗАСГИЙГ БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ АРГАЗҮЙ	18
2.1. Гео орон зайг тодорхойлох аспект, судалгааны ерөнхий аргазүйн схем.....	18
2.2. ГМС-ийн технологид суурилсан судалгааны аргазүй.....	22
2.3. Нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтын аргазүй.....	28
2.4. Бүс нутаг дахь аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтцийг судлах арга зүй	30
2.5. Эдийн засгийн бүсэд бичил бүс, бүлэг суурингийн төв тогтоох.....	36
2.5.1. Байгалийн нөхцөлийн суурь үнэлгээний үр дүн.....	36
2.5.2. Нийгэм эдийн засгийн суурь нөхцөлийн үнэлгээний үр дүн.....	37
2.5.2.1. Хүн амын өсөлт, бууралт	37
2.5.2.2. Орон нутгийн хөгжлийн индекс	38
2.5.3. Дэд бүтцийн суурь нөхцөлийн үнэлгээний үр дүн	39
2.6. Говийн дэд бүсийн бичил бүс, бүлэг суурингийн төв тогтоох.....	42
2.6.1. Говийн дэд бүсийн бичил бүс, бүлэг суурингийн төв тогтоосон судалгааны ажлууд.....	42
2.6.2. Говийн дэд бүсийн хот суурингийн эрэмбэ, бичил бүс, бүлэг суурингийн төв тогтоох ...	45
2.7 Говийн дэд бүс дэх үйлдвэрүүдийн байршил	47
БҮЛЭГ III. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ БА БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	48
3.1. Эдийн засгийн бодлого ба бүсчилсэн хөгжлийн бодлогын хамаарал	48
3.2. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн судалгаа.....	49
3.3. Говийн дэд бүсийн хөгжлийн концепцид тусгах санал	55

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Зургийн жагсаалт

Зураг. 1 Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарилалтын түүхэн хандлага, зохион байгуулалтын хэлбэрүүд (Эх сурвалж: Монголын бүсчилсэн хөгжлийг дэмжих нийгэмлэг, 2018).....	1
2	
Зураг. 2 Монгол Улсын эдийн засгийн мужлалын түүхэн үйл явц (Эх сурвалж: Базарханд нар, 2016).....	13
Зураг.3 Өмнийн говийн хүн амын нутагишил, суурьшил.....	27
Зураг.4 Авто ба төмөр зам, стратегийн ордын байршил.....	28
Зураг. 5 Давхаргуудын давхцуулалт, Өмнийн Говийн дотоод бүсчлэлийн урьдчилсан төсөөлөл.....	29
Зураг 6 Бүс нутгийн хөгжилд нөлөөлөх оронзайн суурь үзүүлэлтүүд.....	31
Зураг 7. Аж ахуйн нутаг дэвсгэрийн уялдаа холбоо.....	32
Зураг 8. Нутаг дэвсгэрийн бүтцийн чанарын түвшнийг судлах.....	32
Зураг 9. Эдийн засгийн бүсүүд дахь нутаг дэвсгэрийн бүтцийн схем.....	33
Зураг 10. Нутаг дэвсгэрийн бүтэц, бүрэлдэн тогтох схем.....	33
Зураг 11. Нутаг дэвсгэрийн бүтцийн циклийн схем.....	34
Зураг.12 Нутаг дэвсгэрийн бүтцийн бүрэн циклийн дүрслэл.....	35
Зураг. 13.Аж ахуйн нутаг дэвсгэрийн орон зайн шатлалын дүрслэл.....	35
Зураг 14.. Нутаг дэвсгэрийн бүтэцийн түвшин.....	36
Зураг. 15 Байгалийн нөхцөлийн суурь үнэлгээний үр дүн, баллын утгаар.....	37
Зураг. 16 Сум тус бүрийн хүн амын дундаж өсөлтийн хувь болон хүн амын өсөлт, бууралт.....	38
Зураг. 1 Орон нутгийн хөгжлийн индексд харгалзах баллын үнэлгээний зураглал.....	39
Зураг. 2 Сум, суурингуудын улсын чанартай авто замын сүлжээнд холбогдсон байдал	40
Зураг. 19 Сум, суурингуудын улсын чанартай төмөр замын сүлжээнд холбогдсон байдал	41
Зураг 20. Говийн дэд бүсийн бичил бүс	45
Зураг 21. (Базарханд, Ц., 2015). Төвийн бүсийн бичил бүс.....	46
Зураг 22. Өмнийн говийн бичил бүсийн төв, бүлэг суурингууд.....	47
Зураг 1. Бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал ба эдийн засаг, нийгмийн бодлогын хамаарал.....	49

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Хөгжлийн онол сургааль	6
Хүснэгт 2. Монгол орны нутаг дэвсгэрийн хуваарилалт, түүхэн үе шат.....	11
Хүснэгт 3. Бүсийн хөгжлийн стратеги, үйл ажиллагаа.....	15
Хүснэгт.4. БНСУ-ын үндэсний нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөөний концепци.....	16
Хүснэгт 5. Гео орон зайг тодорхойлох аспект.....	18
Хүснэгт 6. Өмнийн говийн бүлэг суурингийн тогтолцоо.....	43
Хүснэгт 7. Өмнийн говийн бичил бүсийн төв, бүлэг суурингууд.....	47
Хүснэгт 8. Бүс нутгийн хөгжил ба эдийн засгийн бодлогын хамаарал.....	50
Хүснэгт 9. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд.....	51

ОРШИЛ

Монгол Улс нь хүн амын амьдралын түвшний хот, хөдөөгийн болон бүс нутаг хоорондын ялгааг багасгах, иргэн бүр төрж өссөн нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн бүсчилж хөгжүүлэх үзэл баримтлалыг хөгжлийн бодлого болгон дэвшүүлээд арав гаруй жил болж байна. Гэсэн хэдий ч хөдөө орон нутгаас хот суурин газар руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимтэй явагдаж, хотжилтын түвшин 67.5 хувьд хүрч байгаа ба зарим бүс нутагт хүн ам, үйлдвэрлэл, мал сүрэг хэт бөөгнөрч экологийн тэнцвэрт байдал алдагдах, зах хязгаар нутаг эзгүйрэх, хөгжлийн чадавхи буурах, орлого болон хэрэглээний тэгш бус байдал улам бүр нэмэгдэх нөхцөл бүрдэж байна

Хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд гарч буй өөрчлөлт нь хот-хөдөөгийн хөгжлийн ялгааг улам бүр гүнзгийрүүлж, хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг сааруулах, улмаар үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх шалтгаан, нөхцөл болж хувираад байна.

НҮБ-аас дэлхийн “Тогтвортой хөгжлийн зорилго”-ыг 2015 онд шинэчлэн тодорхойлсоны дагуу Улсын Их Хурлаас “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг 2016 онд баталсан бөгөөд дэлхийн цаашдын хөгжлийн чиг хандлага хийгээд Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, хэтийн зорилго, зорилтуудтай уялдуулан бүсчилсэн хөгжлийн үзэл, баримтлал, бодлогыг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага урган гарч ирсэн болно.

Өнгөрсөн хугацаанд тус улсын эдийн засаг, нийгэм, байгаль орчны төлөв байдал хийгээд хөрш орнууд болон гадаад эдийн засгийн орчин нөхцөл ихээхэн өөрчлөгдсөнтэй уялдуулан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн, Монгол Улсын эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх хөтөлбөр шинээр боловсруулах ажлыг Үндэсний Хөгжлийн Газар эхлүүлээд байгаа билээ.

Энэ ажлын хүрээнд Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэн цэгнэж, тус бүсийн хөгжлийн цаашдын чиг хандлага, үзэл баримтлал, хэтийн зорилго, зорилтуудыг шинэчлэн тодотгох ажлыг МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн хариуцан гүйцэтгэж байгаа ба Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах судалгаа шинжилгээний онол аргазүйн үндэслэл боловсруулах ажлын хэсгээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх ерөнхий аргазүйн талаар хийсэн судалгааны зарим үр дүнг уг тайланд тусгасан болно.

БҮЛЭГ I. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн онолын үндэслэл

1.1. Бүс нутгийн хөгжлийн онол аргазүй

1.1.1. Хөгжлийн онол сургааль

Эдийн засгийн бүсчилэл, бүс нутгийн төлөвлөлт гэдэг нь угтаа орон зайн төлөвлөлтийн тодорхой хэлбэрүүд бөгөөд эдгээр нь тухайн нутаг дэвсгэрийн онцлогт нийцсэн стратегийн дагуу салбарын бодлогуудыг орон зайн хувьд нэгтгэн зохицуулах үйл ажилгаа юм. Орон зайн төлөвлөлт нь эдийн засгийн хөгжил, байгаль орчин болон нийгмийн асуудал зэрэг салбарын бодлогуудын хоорондын эсрэг тэсрэг байдал, зөрчилийг сааруулж, зохицуулах замаар тухайн нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг хангах үндсэн тэнцвэрт харьцааг бүрдүүлэх зорилготой.

Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх төлөвлөлтийн судалгааны үндсэн агуулгыг дараах байдлаар тодорхойлж болно: Үүнд

1. Бүс нутгийн тухайн үеийн байдал ба өөрчлөлтийн хэтийн төлөв;
2. Бүс нутгийн хөгжлийн үндсэн үзэл баримтлал, ирээдүйн дүр зураг
3. Бүс нутгийн орон зайн бүтцийн өөрчлөн байгуулалт
4. Бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх, бүс нутгийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого;
5. Бүс нутгийн үнэмлэхүй ба харьцангуй давуу байдалд нийцсэн салбарын зохистой бүтэц бүрдүүлэх
6. Байгалын нөөц баялагийн үр дүнтэй ашиглалт ба менежмент;
7. Амьдралын чанарыг сайжруулах;
8. Байгалийн элдэв гамшигаас урьдчилан сэргийлэх эдгээр болно.

Бүс нутгийн хөгжлийн концепци боловсруулахад хөгжлийн талаарх дараах онол, үзэл баримтлалыг үндэслэл болгон ашигласан болно. Үүнд:

Хүснэгт I Хөгжлийн онол сургааль

дд	Сургааль	Онол	Таамаглал	Төлөөлөгчид
1.	Эдийн засгийн түүхийн онол, сургааль	Хөгжлийн үе шатны онол	Эдийн засгийн хөгжил (бүтээмж ба хөрөнгө оруулалтын түвшингийн өсөлт гэх мэт) -ийг S хэлбэрийн муруйн үе шатаар тодорхойлж болно	W.W.Rostow
		Бүтцийн хөгжлийн онол	эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөөр нөхцөлдсөн хөгжил (анхдагч, хоёрдогч, гуравдагч салбар)	C. Clark J. Fourastié
		Шинэчлэлийн онол modernisation theory	Хөгжил үйлдвэрлэлийн жингээр тодорхойлогдоно	J. Friedmann
		хувьслын онол evolution theory	40-60 жил тутамд бий болсон суурь инновациуд нь эдийн засгийн хөгжлийг үсрэнгүй түргэсгэдэг	J. Schumpeter

2.	Социологи, улс төрийн шинжлэх ухааны онол, сургааль	Протестант ёс зүй Protestant ethics	Пуританы зан үйл нь хөгжлийн гол хүчин зүйл юм	M. Weber
		Ангигүй нийгмийн онол	Мөлжлөгийг устгах нь хөгжлийг дэмжинэ.	H. Babek K. Marx
		орон нутгийн онцлогийн онол theory of local iden-tity	орон нутгийн үүрэг хариуцлага хүмүүний нэмүү эрчим хүчийг бий болгодог	S. Kopátsy
3.	Эдийн засгийн онол сургааль	Институцичлэлийн онол institutionalist theory	институциудын үр ашигтай үйл ажилгааны систем нь хөгжлийг бий болгодог	D. North
		Шинэ сонгодог тэнцвэрийн онол neo- classic equilib-rium theory	Хүчин зүйлсийн чөлөөтэй урсгал нь хөгжлийн доод түвшний бүс нутгийн хөгжилд тусалдаг	R. Solow
		Туйлшрал (төв- хязгаар)-ын онол polarisation (centre - periphery) theory	Үйлдвэрлэлийн хүчин чадлын үр ашиг ба өргөжин буй гадаад хэмнэлтийн харьцаа хөгжилд хүргэдэг	J. Friedmann I. Wallerstein
			Бөөгнөрлийн давуу тал нь хөгжлийг өдөөдөг (шинэ хүмүүнлэгийн газарзүй)	P. Krugman
		Экспортод суурилсан онол export basis theory	Гадаад хэмнэлтийн харьцаа хөгжлийг өдөөдөг	D. North G. Myrdal
		Эндоген хөгжлийн онол theory of endogenous development	Технологийн дэвшил нь гадаад боломж биш, харин хөгжлийн загварыг тодорхойлох хүчин зүйл юм	P. Romer
Өсөлтийн туйлын онол theory of poles of growth	Туйлууд нь эдийн засгийн хөгжлийн төвүүд юм	F. Perroux J. R. Boudville J. R. Lausen		

Эдгээр онол сургаалийг нэгтгэн дүгнэж үзвэл бүс нутгийг төлөвлөн хөгжүүлэх үзэл баримтлалд харгалзан үзэх шаардлагатай дараах чухал үндэслэлүүд гарч ирж байна. Үүнд

1. Говийн дэд бүсийн хүрэн дэх хот суурингууд, бүлэг суурингийн эдийн засаг, нийгэм, соёл ахуйн, орон зайн бүтэцлэг тогтолцоог бүрдүүлж, үйлдвэржилтийг дэмжих;
2. Суурь инноваци, технологийн дэвшлийг нутагшуулж, хөгжлийн туйл болсон эдийн засгийн хөгжлийн төвүүдийг үүсгэн байгуулах;
3. Бүс нутгийн хэмээнд эдийн засгийн бүтцийн өөрчлөлт (анхдагч, хоёрдогч, гуравдагч салбар) хийх, кластерийн зохион байгуулалтад шилжих;
4. Бүс нутгийн хэмжээнд орон нутгийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх үндсэн дээр хүмүүний эрчим хүчийг нэмэгдүүлэх, институцийн үр ашигтай үйл ажилгааны систем бүрдүүлэх
5. Хүчин зүйлсийн чөлөөтэй урсгалыг хөгжлөөр хоцрогдсон орон нутгийн хөгжилд түлхүү үр дүнтэй ашиглах;
6. Бүс нутгийн хүрэн дэх төв ба дагуул хот суурингууд дахь төвлөрлийн дотоод гадаад хэмнэлтийн зохистой харьцаа, аж ахуй эдийн засгийн чиг үүргийг тогтоох эдгээр болно.

1.1.2. Бүс нутаг төлөвлөлтийн онол үндэслэл

1. Бүс нутаг гэдэг нь (Region as hierarchical systems of central places) Кристаллер (1933), Лёш (1954) нарын боловсруулсан Төв байрлалын онолоор бол төв байрлал буюу хотуудын иерарх систем болох ажээ. Регион бүр тодорхой тооны том эрэмбийн төв ба бусад жижиг эрэмбийн төвүүдээс бүрдэл болж байдаг ба хотуудын эрэмбэ нь тэдгээр дэх үйлдвэрлэл, үйлчилгээний тоо чанар, зах зээлийн багтаамж хүрээгээр тодорхойлогддог байна. Энэхүү системийн хүрэн дэх жижиг эрэмбийн төвүүд нь том эрэмбийн төвүүдийн үйлчилгээний хүрээний босго, хязгаар буюу эрчимтэй таталцал нөлөөллийн хүрээнд багтаж, зах зээл, нийгэм эдийн засгийн хувьд тэдгээрт бүрэн татагдан оршиж байдаг байна.

2. Хувер, Гиарратани нарын дэвшүүлсэн төвийн буюу зангилаа бүс нутгийн онолоор (Nodal region.1985) бүс нутаг гэдэг нь орон зайн хувьд харилцан хамааралтай, өөрөөр хэлбэл, тодорхой зангилаа үүсгэж, харилцан таталцсан хөдөлмөрийн зах зээл болох ажээ. Үүнд а. Бүс нутаг нь бусад орон нутагтай харьцуулбал дотооддоо функционал нягт уялдаа холбоотой, энэ хүрээнд хөдөлмөр, хөрөнгө ба бараа үйлчилгээний биеэ даасан харилцаа, урсгал бүрэлдэн тогтсон байдаг. б. Бүс нутгийн хүрээнд үйл ажилгаа нь тодорхой цэг буюу төв зангилаанд чиглэн татагдаж байх ба тэр нь эргэн тойрон дахь хязгаар нутгийнхаа хөгжлийн тулгуур нь болж байдаг.

3. Карл Фоксийн 1994 онд дэвшүүлсэн Эдийн засгийн функциональ бүсийн үзэл баримтлал нь (Functional economic area) ажиллах хүчин орон зайн хувьд ойролцоох ажил хэргийн төвөөс илүү хамааралтай байдаг гэдгийг үндэслэл болгодог ба зангилаа бүс нутгийн онолоос зохих ялгаатай байна. Фоксийн энэ үзэл баримтлал нь дараах шалтгааны улмаас онол, практикийн хувьд ач холбогдолтой гэж үздэг. Үүнд:

а. Хөдөлмөр ба ажиллах хүч нь бүс нутгийн дотоод функциональ уялдаа холбоо ба нийгмийн халамжийн шинжилгээнд үндсэн хэмжигдхүүн болон хэрэглэгддэг.

б. Орон зай ба бүс нутгийн хүрэн дэх эдийн засгийн нэгжүүдийн орон зайн интеграцийн холбоог тодорхой харуулдаг ба учир нь ажиллах хүчний тээврийн зардлаар дамжуулан орон зайн хүрээг илэрхийлдэг.

в. Ажилчид ажилдаа ирж буцах тээврийн зардалаа багасгахыг хүсэх ба ажил олгогчид ажилчдын зорчих зардлын нөхөн олговрыг аль болох багасгахыг эрмэлзэж байдаг энэхүү эдийн засгийн зүй тогтол нь функциональ эдийн засгийн бүсийн орон зайн хүрээ хийгээд чиг үүргийн хувьд интеграцлагдсан хөдөлмөрийн зах зээлийг тодорхойлно.

4. Хөгжлийн зарим хүчин зүйлсийн дотоод ижил төстэй байдлын ялгаанд тулгуурлан бүс нутгийг (Homogeneous region) ялган тодорхойлдог ба газар нутаг, байгалийн нөхцөл нөөц, аж ахуй эрхлэлт, ажиллах хүчний нөөц, орлогын түвшин зэрэг олон хүчин зүйлсийг бүсчлэл тогтооход ашигладаг.

5. Төлөвлөлтийн бүс нутаг нь (Planning region) тодорхой улс төр, засаг захиргааны нэгжүүдийг дан ба нэгтгэсэн байдлаар бүс нутаг болгон, төлөвлөлт, хяналттайгаар хөгжүүлэх үзэл баримтлал болно.

6. Байгалийн нөхцөл нөөц ба хүн амын харилцан хамааралд суурилсан түүхэн бүс нутгийн үзэл баримтлал (Historical region) байдаг ба Маркусений 1987 тодорхойлосоноор хүн байгалийн харилцан үйлчилгээний түүхэн хөгжлийн явцад хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засаг, улс төр болон соёлын өвөрмөц онцлогоороо бусдаас тодорхой ялгарах бүс нутаг бүрэлдэн тогтдог байна.

7. Бүс нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг кластерийн (Cluster based region) хандлагаар дээшлүүлэх онолыг Майкл Портер 1998 дэвшүүлсэн. Кластер нь газарзүйн байршилдаа тулгуурлан хэлхээ холбоо тогтоон бөөгнөрч нэгдсэн компаниуд, тэдгээрт бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэгч тухайн салбарын бусад компаниуд, түүнчлэн тэдгээр компанийн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд тодорхой салбарт өрсөлдөж байдгийн зэрэгцээ мөн хамтран ажиллаж байдаг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, агентлагууд, худалдааны нэгдлүүдээс бүрддэг. Кластерийн хөгжил нь түүнд суурилсан бүс нутгийн хөгжлийн үндэс болдог байна.

8. Бүлэг суурингийн тогтолцоо нь (Групповая система расселения) хүн амын нутагшил суурьшил ба хот бүс нутгийн төлөвлөлтөнд өргөн хэрэглэгддэг ойлголт бөгөөд энэ нь том хотуудын өсөлт, хэт төвлөрлийг сааруулах, том хоттой функциональ холбоо уялдаа бүхий жижиг, дунд хот суурингуудыг хөгжүүлэх үндсэн дээр төв ба дагуул хот суурингуудын тогтолцоо бүрдүүлж хот ба бүс нутгийн тогтвортой хөгжлийн суурь нөхцөлийг хангахад чиглэгдэнэ.

9. Хот-бүс нутаг (City region) гэдэг нэр томъёо 1950 оноос хэрэглэгдэх болсон ба метрополитан томоохон хотууд ба тэдгээрийн үйлчилгээний хүрэн дэх хот суурин, дүүргүүд бизнесийн төв дүүрэг, хөдөлмөрийн зах зээл, зам тээврийн сүлжээгээр нэгдсэн бие даасан нутаг дэвсгэрийн систем буюу бүс нутаг болон хөгждөг байна.

10. Улс орон бүрд нийслэл хот ба түүний нөлөөллийн хүрэн дэх орон зайгаас бүрдэх нутаг дэвсгэрийн систем байх ба түүнийг нийслэлийн бүс нутаг (Capital region), нийслэлийн дүүрэг, нийслэлийн нутаг дэвсгэр зэргээр нэрлэдэг боловч угтаа энэ нь хот- бүс нутгийн нэгэн онцлог хэлбэр болно.

1.2. Бүсчлэн хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Монгол улсад хөдөө орон нутгаас хот суурин газар руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимтэй явагдаж, хотжилтын түвшин 67.5 хувьд хүрч байгаа ба зарим бүс нутагт хүн ам, үйлдвэрлэл, мал сүрэг хэт бөөгнөрч экологийн тэнцвэрт байдал алдагдах, зах хязгаар нутаг эзгүйрэх, хөгжлийн чадавхи буурах, орлого болон хэрэглээний тэгш бус байдал улам бүр нэмэгдэх нөхцөл бүрдэж байна. Зөвхөн нийслэл Улаанбаатар хотод улсын нийт хүн амын 46 хувь нь төвлөрч, аж ахуйн нэгж, байгууллагуудын 80 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 64.6 гаруй хувийг үйлдвэрлэж байгаа юм.

Хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд гарч буй энэхүү өөрчлөлт нь хот-хөдөөгийн хөгжлийн ялгааг улам бүр гүнзгийрүүлж, хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг сааруулах, улмаар үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх шалтгаан, нөхцөл болж хувираад байна. Хүн амын амьдралын түвшний хот, хөдөөгийн болон бүс нутаг хоорондын ялгааг багасгах, иргэн бүр төрж өссөн нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчинг бий болгоход чиглэгдсэн бүсчилж хөгжүүлэх үзэл баримтлалыг хөгжлийн бодлого болгон дэвшүүлээд арав гаруй жил болж байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын гэсэн 5 бүсийг тогтоож улмаар бүсийн тулгуур төвүүдээр Ховд, Улиастай, Хархорин, Эрдэнэт, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудыг тогтоосон юм. Дээрх цогц бодлогоор хязгаар нутгийн хөгжлийн жигдрүүлэх, хүн амын хэт төвлөрөл, хотжих үйл явцаас үүдэн гарах сөрөг нөлөөллийг хязгаарлах, төвөөс алслагдсан сум суурингуудыг үйлчилгээний хүрээгээр нь таталцал үүсгэх зорилгоор нэг төвтэй тогтолцооноос олон төвтэй тогтолцоонд шилжүүлэх эхлэл тавигдсан.

Одоогийн байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдаж нийслэл, 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 1671 баг, хороотой болоод байна.

Орон нутагт хөгжлийн ойролцоо түвшиний бие даан хөгжих эдийн засаг, санхүүгийн чадавхгүй, зах зээлийн багтаамж бага, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих боломж хязгаарлагдмал суурингууд олон байгаагаас ажилгүйдэл ядуурал бий болж, хүн амын амьжиргааны түвшин буурч, боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээг цогцоор авч чадахгүйд хүрч иргэд олноор томоохон суурин газар руу шилжин нүүх явдал зогсохгүй байна.

Хөдөөгийн хүн амд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэх, хөдөөгийн иргэд орон нутагтаа амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол улсын засаг захиргааны нутаг дэвсгэрийн хуваарийг Бүлэг суурингийн тогтолцоонд тулгуурлан тодорхой үе шаттайгаар шийдвэрлэх боломжтой гэж зарим судлаачид үздэг.

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан, бүсчлэлийн схемийг эргэн харж, эдийн засгийн макро бүс нутгуудын дотоод бүсчлэлийг нарийвчлан тогтоох үндсэн дээр дэд ба бичил бүс, бүлэг суурин, хот суурингийн чиг үүрэг, үйлдвэр аж ахуйн төрөлжилт, хөгжлийн бодлогыг тодорхойлох төлөвлөлт, судалгаа шинжилгээний ажил хийгдэх шаардлага урган гарч байна (Базарханд, Ц., 2015).

Хот суурингуудыг төлөвлөн хөгжүүлэхдээ бүлэг суурингийн тогтолцоо, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан, хот-бүс нутгийн зарчимд тулгуурлан, таталцал нөлөөллийн бүсийг тогтоон, нэгдмэл тогтолцооны хүрээнд төлөвлөх шаардлагатай байгаа болно.

Бүлэг суурингийн тогтолцоог тодорхойлох асуудлыг дэд бүтцийн үндсэн сүлжээ, бүс нутгийн оновчтой бүтэц, бүсийн тулгуур төв хотуудтай харилцан уялдаатай, цогц байдлаар авч үзэх шаардлагатай бөгөөд ингэснээр бүсчилсэн хөгжлийн бодлогыг үндэсний түвшинд, бүс нутгийн хүрээнд, орон нутгийн нөхцөлд бодитойгоор хэрэгжүүлэх үндэс суурь тавигдах бололцоотой.

Хүн амын нутагшилт хөгжлийн хүрээнд бүлэг суурингийн тогтолцоог Монгол орны байгаль, цаг уурын нөхцөл, эрдэс баялагийн нөөц, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, хүрээлэн буй байгаль орчны хамгаалал, тухайн төв суурингийн суурьшлын өвөрмөц онцлог цаашдын хөгжлийн төлөв, нийгэм эдийн засгийн одоогийн болон шинэлэг хандлага зэргийг харгалзан үзэх шаардлагатай.

Нутагшилт, хот байгуулалтын үүднээс улс орныг бүсчилэн хөгжүүлэх чиглэлээр УБЗТИ-/хуучин нэрээр/-д 1988 онд ЗХУ /хуучин нэрээр/-ын мэргэжилтнүүдийн шууд оролцоотойгоор хийж боловсруулсан нилээд дорвитой ажил нь “Генеральная схема расселения на территории МНР” /төслийн хуучин нэрээр/ юм.

Улс орон эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн тогтолцоонд шилжин орсон нөхцөл байдалтай уялдан 1996 онд боловсруулсан “Монгол Улсын хүн амын нутагшилт хөгжлийн ерөнхий төсөл” нь дээрх ажлын шууд үргэлжлэл байсан. Тус төсөлд Монгол орны хөгжлийг тэтгэх зам, эрчим хүч, харилцаа холбооны үндсэн тэнхлэг, хөгжлийн тулгуур төвүүд болон бүс нутгаар хөгжих, чөлөөт бүс байгуулах, хүн амын нутагшилт, хот байгуулалтын шийдэлд тулгуурлан засаг захиргааны хуваарийг өөрчлөх, салбар хоорондын асуудлыг нутаг дэвсгэр зохион байгуулалт, хүн амын нутагшилт, хот байгуулалтын бодлоготой зохицуулан шийдвэрлэх асуудлыг улсын хөгжлийн хэтийн бодлоготой уялдуулан авч үзсэн бөгөөд салбаруудын холбогдох эрдэмтэд, мэргэжилтнүүдийг оролцуулж боловсруулсан байдаг. Тус төслөөр бүсчилсэн хөгжлийн үндэс суурь болох бүлэг суурингийн тогтолцоо нь анх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үеэс “сум дундын төв” гэсэн нэртэйгээр

эхлэл нь тавигдаж байсан төдийгүй тухайн төвд сум дундын эмнэлэг, 8, 10 жилийн сургууль, соёлын төв, дэлгүүр хоршоо зэрэг соёл ахуйн үйлчилгээний объектуудыг цогц байдлаар төлөвлөгдөж энэ ажил нь тухайн үедийн нөхцөл байдалтай уялдан хэрэгжиж ирсэн бөгөөд бүлэг суурингийн тогтолцоог төлөвлөхөд энэ байдлыг харгалзан үзсэн байдаг. Тус төсөлд Монгол улс 2010 оны байдлаар нутагшилтын бүс нутгийн 5 тогтолцоо, аймгийн 18, бүлэг суурингийн 91, сумдын 334 тогтолцоо байна гэж төлөвлөсөн байна.

Бүлэг суурингийн тогтолцоо нь хөдөөгийн хүн амд нийгэм соёл ахуйн үйлчилгээг ойртуулах, үйлдвэрлэлийг хэрэглэгч, түүхий эд, ажиллах хүчний нөөцөд нь тулгуурлан хорших, дагнах чиглэлээр орон нутгийн нөхцөл бололцоонд түшиглэн хөгжүүлэх, цаг хугацаа, өртөг зардлыг хэмнэх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр бүх төрлийн үйлчилгээний зохистой хүрээгээр тогтоогдож байгаагаараа онцлог юм. Мөн 2006 онд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг “Бүлэг суурингийн тогтолцоо”-нд тулгуурлан боловсронгуй болгох төслийг засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн байдаг. Тус төсөлд улсын хэмжээнд нийт 95 бүлэг суурингийн тогтолцоо байх санал оруулсан ба үүнээс нийслэл, бүсийн тулгуур төв хот, аймгийн төв хотын 23, сум дундын 72 бүлэг суурингийн тогтолцоо байхаар санал болгосон.

Бүлэг суурингийн тогтолцоог тогтоохдоо дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн. Үүнд:

- Бүлэг суурингийн төвүүдээр сумуудыг сонгохдоо ойр зэргэлдээ сумуудтай нь харьцуулахад хөгжлийн түвшин, ирээдүйн төлвөөр давуу, байршлын хувьд бусад сумуудаас нийгэм, соёл ахуйн болон бизнесийн үйлчилгээг хүргэх боломжтой сумуудыг сонгож тогтоосон. Мөн зам харишаа, дэд бүтцийн хангамжийн эх үүсвэрийг одоогийн байдал цаашдын хандлагад тулгуурласан байна.
- Бүлэг суурингийн тогтолцооны хувьд УИХ-ын шийдвэрийн дагуу аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэрийг үндэс болгосноос гадна нэгэнт тогтсон аймаг, сумуудын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг хадгалах, засаг захиргааны үндсэн төврүү чиглэсэн үйлчилгээнд сөрөг урсгал гаргахгүй байх, үйлчилгээний зохистой хүрээнд хамрагдах байдал зэрэг өмнөх хэлэлцүүлгийн явцад тохирсон зарчмын дагуу зарим цөөн сумуудад холбогдох өөрчлөлт, тодруулга оруулжээ.
- Бүлэг суурингийн төвүүдийг монгол орны байгаль-газарзүйн болон инженер-геологийн нөхцөл зэрэг хүчин зүйлүүдээр харьцуулан үнэлж хот байгуулалтанд тохиромжтой байдлыг харгалзан тогтоосон.

Бүс нутагт дотоод бүсчлэл, бүлэг суурингууд хөгжсөнөөр дараах ач холбогдолтой. Үүнд:

- Орон нутгийн төр захиргааны үүрэг хариуцлага нэмэгдэж, аймаг сумуудын уялдаа холбоо сайжирч, бие дааж тогтвортой хөгжих нийгэм сэтгэл зүйн үндэс бүрдэнэ.
- Сум, орон нутгийн хөгжлийн талаарх сэтгэлгээний хүрээ тэлж, бүлэг суурингийн тогтолцооны хүрээнд сэтгэдэг болж, зах зээлийн үр ашигтай нөхцөл бий болох бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд үйл ажиллагаа нь чиглэгдэнэ.
- Сумууд харилцан уялдаатай хөгжихийн тулд бүлэг суурингийн зөвлөл байгуулж ажиллах боломжтой.
- Бүлэг суурингийн түвшинд оюуны чадавхитай болох удирдлагын менежементийг боловсронгуй болгох шаардлага аяндаа тавигдана.
- Бүлэг суурингийн төвийн тогтолцоог бий болгосноор хүн амын хэт бөөгнөрөл, их нүүдлийг сааруулах, төв болон хязгаар нутгийн хөгжлийн ялгааг жигдрүүлэх бодит нөхцөл бүрдэнэ.

- Бүлэг суурингийн төвд бүрэн дунд боловсролын сургууль, сум дундын эмнэлэг, соёл, ахуйн үйлчилгээг түлхүү хөгжүүлж, бөөний худалдааны төвийг байгуулснаар сум орон нутагт тогтвортой суурьших нөхцөл бүрдэнэ.
- Бүлэг суурингийн нутаг дэвсгэрийн хөгжил, хүн ам, хөдөлмөрийн нөөцийн ашиглалт, аж ахуйн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, үйлдвэр үйлчилгээг дагнах, хорших чиглэлээр ажиллах боломж бүрдэнэ.
- Бүлэг суурингийн төвийн тогтолцооны түвшинд фермер болон эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, аялал жуулчлал зэрэг шинэлэг, үр ашигтай чиглэлийг хөгжүүлэх замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломж бий болно.

Монгол улсын хувьд бүс нутгийг дотоод бичил бүс, бүлэг суурингийн тогтолцоонд оруулах, тухайн бүлэг суурингуудын чиг үүрэг, үйлдвэр аж ахуйн төрөлжилт, хөгжлийн бодлогыг тодорхойлох төсөл, саналууд нэг бус удаа хийгдэж байсан байна. Гэсэн хэдий ч энэ асуудал одоог хүртэл шийдэгдээгүй л байна. Тиймээс одоо байгаа эдийн засгийн бүсийг эргэн харж, дотоод дэд бүс, бичил бүс, бүлэг суурингийн тогтолцоог бий болгох судалгааны орон зай байсаар байна.

1.3. Монгол Улсыг бүсчилэн хөгжүүлж ирсэн түүхэн замнал

Монголын нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, хуваарилалтын түүхэн хандлагыг авч үзвэл:

Хүснэгт 2. Монгол орны нутаг дэвсгэрийн хуваарилалт, түүхэн үе шат

№	Улсуудын нэр	Нутаг дэвсгэр /газар нутаг/-ийн хуваарилалт
1	Хүннү /МЭӨ 200-300-р зуунаас МЭ VI зуун/ - гэс Нирун , Сүмбэ, Хамаг Монгол улс хүртэл	Төв, Баруун, Зүүн хэсэг, /гар/, МЭ III зуунаас түмт, аравт
2	Их Монгол улс/МЭ XIII -XIV зуун/ Чингис хаант/, Бага хаадын улсууд	Төвийн, Баруун, Зүүн тойрог буюу түмэн, бага түмэн, мянгат, аравт/Бага хаадын үед – түмтийн хуваарь/
3	Ар Монгол Манж Чин улсын вассаль улс/ XVII - XX зууны эх/	Аймаг/ ЗХ, СНХ, ТХ, СХ -4/,хошуу/74 -123/, сум, баг, 10 гэр, нийслэл гүрээ, амбаны газар ,сүм
4	Богд хаант Монгол улс 1911 -1921 он	6 аймаг,118 хошуу,56 отог, шавь, Өргөө хот, сүм, хийд
5	БНМАУ/1924 -1990 он/	18 аймаг, 311 сум, баг, УБ, Дар., Эр., Чойр хот
6	Монгол Улс 1990 оноос	аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, БН, НХ хот


Эх сурвалж: Монголын бүсчилсэн хөгжлийг дэмжих нийгэмлэг.2018

Шинжлэх ухааны үндэслэлтэй нутаг дэвсгэрийн суурь судалгааны ажлууд Ардын хувьсгалын дараагаас Судар бичгийн хүрээлэнгийн Газарзүйн тасагт эрчимтэй хийгдэж эхэлсэн .Тус хүрээлэнгийн судалгааны үр дүнд “БНМАУ-ын Газарзүйн атлас” “БНМАУ-ын говийн хязгаар”, “Төв хангай” зэрэг бүтээлүүд хэвлэгдэн гарсан байна (Ринчинбазар, 2004). Эдгээр судалгааны ажлуудын дараагаар тодорхой нутаг дэвсгэрийн эдийн засгийн нөөцийг судлан “Дорнод районы эдийн засгийн байдал”, “Доод Сэлэнгийн газар тариалангийн район”, “Улиастайн районы эдийн засгийн байдал” зэрэг судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн нь Монгол Улсын хэмжээнд анх эдийн засаг, аж ахуй эрхлэлтийн бүсэд нарийвчлан хийсэн анхны судалгааны ажлууд болсон. Улс орны нийт нутаг дэвсгэрийг хамарсан шинжлэх ухааны үндэслэлтэй бүсчлэл, нутаг дэвсгэрийн зохион

байгуулалтыг шийдвэрлэх зорилготой хийгдсэн судалгааны ажил нь 1931 онд Засгийн газрын тусгай комиссын гүйцэтгэсэн ажил болно.

Судлаач Р. Ринчинбазар “Тэрхүү комиссын саналаар аж ахуйн хөгжилд нөлөөлөх байгаль, газарзүйн шинжүүд, зам харилцааны байдал, бүсийн төв болохуйц суурин газруудын байршил, газар нутгийн асуудал хийгээд үндэсний цөөнхийн байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж 5 аймаг, худалдааны 6 бүс, МАА-ын 8 бүсийн оронд засаг захиргаа-эдийн засгийн 13 аймаг байгуулах шийдвэр гаргажээ, үүнийг ХАА-ын бүсчлэлийн анхны хэлбэр” гэж үзэж болох талтай гэж судлаачид дүгнэсэн байдаг.

Зураг. 1 Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарилалтын түүхэн хандлага, зохион байгуулалтын хэлбэрүүд




Эх сурвалж: Монголын бүсчилсэн хөгжлийг дэмжих нийгэмлэг, 2018

Улс орныг эдийн засгийн бүсчлэлд тулгуурлан хөгжүүлэх зорилго бүхий анхны судалгаа нь ШУА-ийн санаачлагаар 1961-онд Монгол, Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран гүйцэтгэсэн ажил юм. Хамтарсан судалгааны үр дүнд Монгол орны нутаг дэвсгэрт Төв, Дорнод, Өрнөл гэсэн гурван бүсийг тогтоох, үндэслэл санал боловсруулсан байна. Энэхүү нутаг дэвсгэрийн зохион байгуулалт нь нэлээн ерөнхийлсөн шинжтэй ч тухайн үеийн улс орны хөгжил, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий үйлдвэр аж ахуйн төлөвлөлтөд тохиромжтой байсан.

Бүсчилсэн хөгжилд үндсэн бүсүүдийг дэд бүсүүдэд хуваан хөгжүүлэх шинэлэг санааг академич Б. Гунгаадаш гаргаж, БНМАУ-ын эдийн засгийн Төв муж (1967) бүтээлдээ анх дурджээ. Тэрээр 1969 онд Монгол-Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран боловсруулсан бүсчлэлийн схемийг нарийвчилж дэд бүсүүдийг тогтоон тус бүрт тодорхойлолт өгсөн. Төвийн бүсийг дотор нь Ерөө-Туул (Улаанбаатарын аж үйлдвэрийн зангилаа, Төв, Сэлэнгэ аймаг), Хангай-Хөвсгөл (Эрдэнэтийн аж үйлдвэрийн зангилаа, Булган, Хөвсгөл, Архангай), Онги-Байдраг (Өвөрхангай, Баянхонгор), Говийн (Дорноговь, Дундговь, Өмнөговь) гэсэн дөрвөн дэд муж, Өрнөд бүсийг дотор нь Завхан-Бигэр (Завхан, Говь-Алтай) Увс-Ховдын (Увс, Ховд, Баян-Өлгий) гэсэн хоёр дэд муж болгох санал дэвшүүлсэн байна.

Зураг. 2 Монгол Улсын эдийн засгийн мужлалын түүхэн үйл явц



Эх сурвалж: Базарханд нар, 2016

Монгол Улсад улс төр, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөлт, нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүн амын нутагшил суурьшилтын схемийг оновчтой тогтоох зэрэгт анхаарлаа хандуулж ирсэн байна. Улс орон улс төр, нийгэм, эдийн засгийн бүх хүрээг хамарсан өөрчлөлт байгуулалтад орсноор бүсчилсэн хөгжлийн асуудал ахин шинэ түвшинд тавигдаж эхэлсэн (Ринчинбазар, 2004).

1.4. Бүсчилсэн хөгжлийн талаарх гадны туршлага, сургамж

НҮБ-ын 1996 оны бага хурлаас дэвшүүлсэн Хабитатын зарчмуудад орчин үеийн нийгэм эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр ашигтай, хүрээлэн буй орчин болон хүмүүнлэгийн хөгжилд саад учруулахгүй байх хот бүс нутгийн хөгжлийн стратеги боловсруулж, хэрэгжүүлэхийг засгийн газар, орон нутгийн удирдлага болон бусад нөлөө бүхий хүчнүүдэд зөвлөмж болгосон байдаг байна.

1.4.1. Вьетнамын бүс нутгийн хөгжлийн бодлого

1) Зорилго

Бүс нутгийн хөгжлийн үндсэн зорилго нь өсөлт хөгжлийг тогтвортой хөгжлийн замд хөтлөх, тэнцвэртэй хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэгш бус байдал, байгаль орчны доройтлыг саармагжуулахад чиглэнэ.

Бүсчилсэн хөгжлийн гол зорилтууд:

(i) Бүсчилсэн хөгжил нь тус улсын хөгжлийг залах, дэлхийд өрсөлдөх тэнхлэг бүхий, Вьетнам улс төдийгүй Меконгийн сав газар дахь бүсчилсэн хөгжлийн тогтолцоо болохын зэрэгцээ Зүүн Өмнөд Ази дахь эдийн засаг, соёл, байгаль орчны асуудлуудад чухал үүрэг гүйцэтгэнэ.

(ii) Бүс нутаг нь бодлого боловсруулах, бүс нутгийн эдийн засгийн өсөлт, уламжлалт соёл, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, өндөр чанартай хүний нөөцийг бүрдүүлэхэд тодорхой байр суурь эзэлнэ.

(iii) Орон нутаг ба Нийслэлийн хөгжлийн бодлогыг уялдуулах, Ханой хот дахь хүн ам ба нийгэм эдийн засгийн хэт их төвлөрлийг сааруулах, тус бүс дэх бусад орон нутгуудтай үр дүнтэй хамтран ажиллаж, бүс нутгийн тэнцвэрт өсөлтийг хангана.

2) Санал болгож буй стратеги, үйл ажиллагаа, стратегийн төслүүд

Бүс нутгийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжихийн тулд таван стратегийг боловсруулав.

Үндсэн стратегиуд нь дараах байдалтай байна:

- (i) Бүсийн хөгжлийн стратегийг шинэчлэх
- (ii) Дэлхийд өрсөлдөх чадвартай өсөлтийн коридорыг хөгжүүлэх
- (iii) Ядуурлыг бууруулах стратеги, хөтөлбөрийг өргөжүүлэх
- (iv) Бүсийн зохицуулах механизмыг хөгжүүлэх
- (v) Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх

Нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратегийн төслүүд:

- (i) Дэлхийд өрсөлдөх стратегийн өсөлтийн коридоруудыг хөгжүүлэх
- (ii) Хил дамнасан бүсийн хөгжил
- (iii) бүс нутгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг нэгтгэх, нэг төвийн зохицуулалт хийх
- (iv) Бүс нутгийн төлөвлөлтийн мэдээллийн сан, мэдээллийн системийг сайжруулах
- (v) Бүс нутгийн зохицуулах зөвлөлийг байгуулах
- (vi) Хот, бүс нутгийн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх байнгын байгуулагуудыг ажиллуулах

Хүснэгт 3. Бүсийн хөгжлийн стратеги, үйл ажиллагаа

Стратеги	Үйл ажилгаа	Хянах индикатор
A1 Бүсийн хөгжлийн стратегийг шинэчлэх	A11 Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн зохицуулалттай, нэгтгэсэн цогцолбор төлөвлөгөө A12 Хувийн Санхүүгийн Санаачлага болон Төр хувийн хэвшлийн түншлэлийн өргөн хүрээний практик үйл ажиллагааг хэрэгжүүлэх механизмыг сайжруулах A13 Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн зохицуулалттай / нэгдсэн төслүүдийг тодорхойлж, хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөө / стратегийн талаар оролцогч талуудын ойлголт, зөвшилцөл • Төслийн явц
A2 Олон улсын өрсөлдөх чадвартай өсөлт бүхий коридорыг хөгжүүлэх	A21 Дээд зэрэглэлийн тээвэрлэлт / логистикийн коридорыг бий болгох A22 өрсөлдөх чадвар бүхий үйлчилгээтэй Хот суурин газар, үйлдвэрлэлийн бүсийг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> Төслийн явц • Коридор дахь хөрөнгө оруулалтын хэмжээ • Хөрөнгө оруулагчдын сэтгэл ханамж

	A23 Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх ГШХО-ыг дэмжих	<ul style="list-style-type: none"> • Корридорын худалдааны хэмжээ / үнэ цэнийн эзлэх хувь
A3 Ядуурлыг бууруулах стратегийг бэхжүүлж, хөтөлбөрийг өргөжүүлэх	A31 бүс нутгийн ядуурлыг тодорхойлох A32 Ядуурлын асуудлын талаархи тусгайлсан цэс, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх A33 Ядуурлыг бууруулах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх зохицуулалтын механизмыг бий болгох	<ul style="list-style-type: none"> • Ядуурлын үзүүлэлтүүд • Ядуурлыг бууруулах талаар хэрэгжсэн хөтөлбөр • Ядуурлыг бууруулахад чиглэсэн төсөв / зардал
A4 Ажиллах чадвартай, бүсийн зохицуулалтын механизмыг сайжруулах	A41 Орон нутгийн засаг захиргаа хоорондын бүс нутгийн хөгжлийн зохицуулалтыг бэхжүүлэх A42 Орон нутгийн засаг захиргааны төлөөлөл бүхий бүсийн хөгжлийн зохицуулах зөвлөл байгуулах A43 Хотын форумар дамжуулан хандивлагчидтай хамтран ажиллах ажлыг өргөжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Институцийн зохицуулалтын явц • Хурлын тоо / давтамж
A5 Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх	A51 Бүс нутгийн төлөвлөлт, хөгжлийн чиглэлээр нийтлэг мэдээллийн сан бүрдүүлэх A52 Төв засгийн газрын доорхи орон нутгийн ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх байнгын сургалтын тогтолцоо бүрдүүлэх A53 Орон нутгийн засаг захиргааны төлөвлөлтийн газруудыг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Системийн дизайн ба үйл ажиллагааны явц • Сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо • Боловсруулсан төлөвлөгөөний тоо

1.4.2. БНСУ-ын үндэсний нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого

БНСУ 60-аад оноос эхлэн Сөүл ба зүүн хойд эргийн бүсийг үйлдвэржүүлэх замаар хөгжлийн анхдагч голомт бий болгох өсөлтийн туйл бодлого баримталж эхэлсэн бөгөөд энэ бодлогын нөлөөгөөр нийслэлийн бүс нутаг болон Сөүлийн метрополитан бүсэд хүн ам, нийгэм эдийн засгийн хэт өсөлт төвлөрөх болсон байна.

Нийслэлийн бүс нутаг болон Сөүлийн метрополитан бүсийн хэт өсөлт зохицуулалт шаардах болсон ба Солонгосын засгийн газар өсөлтийн менежмент буюу Сөүлийн төвлөрлийг сааруулах бодлого барих болж, энэ чиглэлээр олон тооны бодлого, хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийг ашиглахын зэрэгцээ үндэсний нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан, хөгжлийн үе шат бүрийн онцлогт нийцсэн стратеги, зорилт, бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлж ирсэн байна. БНСУ-ын энэхүү туршлага нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа эргэн харж, төгөлдөржүүлэх, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр шинээр боловсруулан мөрдөхөөр зорьж буй манай орны тухайд илүү ойр, наалдацтай жишиг сургамж байж болох юм.

Хүснэгт.4. БНСУ-ын үндэсний нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөөний концепци

Д/д	Үндсэн стратеги	Зорилт, томоохон бүтээн байгуулалт
Үндэсний нутаг дэвсгэрийн 1-р ерөнхий төлөвлөгөө (1972-1981)	Хязгаарлагдмал нөөцөд түшиглэн өсөлтийн боломжийг нэмэгдүүлэх	1.Томоохон аж үйлдвэрийн газрууд болон нийслэлийн бүс нутгийг хөгжүүлэх -Зүүн өмнөд эрэг орчмын аж үйлдвэрийн бүс, -Сөүлийн метрополитан бүс 2. Өндөр ач холбогдолтой дэд бүтцийн (Хурдны зам, боомтууд) хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, томоохон аж үйлдвэрийн газруудыг холбох 3. Эдийн засгийн уналттай бүс нутгийн хөгжлийг сэргээх -Шинэ тосгон болон шинэ коммуните хөдөлгөөн
Үндэсний нутаг дэвсгэрийн 2-р ерөнхий төлөвлөгөө (1982-1991),	Өсөлтийн үр нөлөөг үндэстэн даяар дэлгэрүүлэх	1. Сөүлийн метрополитан бүсийн (Нийслэлийн бүс) хэт төвлөрөлийг таслан зогсоох 2. Үндэстний хэмжээнд өсөлт хөгжлийн олон төвүүдийг хөгжүүлэх -Өсөлтийн хөдөлгүүр болсон бусад метрополитан бүс нутгуудыг хөгжүүлэх 3. Нутаг дэвсгэрийн хөгжүүлэхдээ хүрээлэн буй орчны асуудалд анхаарал хандуулах
Үндэсний нутаг дэвсгэрийн 3-р ерөнхий төлөвлөгөө (1992-1999),	Олон төвт үндэсний нутаг дэвсгэрийн бүтэц үүсгэх	1.Төвлөрлийг сааруулах үндэсний хөгжил Баруун эргийн аж үйлдвэрийн газрууд, орон нутгийн хотуудыг хөгжүүлэх 2.Зам тээврийн цогц сүлжээг (7х9 артер замын сүлжээ) хөгжүүлэх 3.Өмнөд ба Умардын харилцааг өргөтгөх, нэгдсэн Солонгос байгуулах бэлтгэлийг хангах
Үндэсний нутаг дэвсгэрийн 4-р ерөнхий төлөвлөгөө (2000-2020),	Бүс нутгуудын тэнцвэртэй хөгжил ба нээлттэй, нэгдсэн үндэсний нутаг дэвсгэр	1. Стратегийн гарц болон үйлчлэх үүрэгтэй л-хэлбэртэй нутаг дэвсгэрийн тэнхлэгүүдийг байгуулах 2. Бүс нутгуудын өрсөлдөх чадавхийг дэмжих -Аж үйлдвэрийн кластерууд, бүс нутгийн инновацийн систем бүрдүүлэх 3. Өндөр хурдны тээврийн сүлжээ байгуулах 4. Бүс нутгуудын хоршил, хамтын ажилгааны орон зайн суурь бүрдүүлэх
Үндэсний нутаг дэвсгэрийн 4-р ерөнхий төлөвлөгөөний тодотгол (2011-2020),	Үндсэн стратеги Глобал-Ногоон, үндэсний нутаг дэвсгэр	1. Өрсөлдөх чадавхитай нэгдмэл нутаг дэвсгэр 2. Байгальд ээлтэй хөгжил бүхий тогтвортой нутаг дэвсгэр 3. Амьдралын өндөр чанартай, сэтгэл татсан нутаг дэвсгэр 4. Глобал зах зээлд нээлттэй нутаг дэвсгэр

БҮЛЭГ II . Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх судалгааны ерөнхий аргазүй

2.1. Гео орон зайг тодорхойлох аспект, судалгааны ерөнхий аргазүйн схем

Гео орон зай гэдэг нь байгаль, нийгэм, эдийн засгийн харилцан үйлчлэлийн түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн тогтдог байгаль нийгэм эдийн засгийн нутаг дэвсгэрийн тодорхой тогтолцоо бөгөөд түүний хил хязгаарыг тогтооход дараах аспектиудыг харгалзан үзэх шаардлагатай болно.

Хүснэгт 5. Гео орон зайг тодорхойлох аспект

Аспект	Шалгуур
а) Байгалийн газарзүйн	Байгалийн комплекс ба компонентийн
б) Улс төр, засаг захиргааны	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд
в) Түүх соёлын	Түүх угсаатан, шашин соёлын
г) Функциональ	Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлал
д) Статистикийн	NUTS I, NUTS II, NUTS III
е) Эдийн засгийн	Хөгжингүй, хөгжиж буй, хоцрогдсон
ё) Орон зайн бүтцийн	Хотожсон, бүлэг суурин, хөдөөгийн

Улс орны эдийн засгийн бүсүүдийг сонгогдсон шалгууруудын тусламжтайгаар ангилах аргазүй нь дараах үе шаттайгаар явагдана. Үүнд:

1. Эдийн засгийн бүсүүдэд хийгдэх шинжилгээний хүчин зүйлсийг тодорхойлон орц гарцыг тодорхойлох
2. Бүс нутгуудын талаар цуглуусан өгөгдөлд тооцоолол хийх
3. Бүс нутгийн ангилалын үндэсийг бүрдүүлэх өгөгдөлүүдийг нормчлох
4. Эдийн засгийн бүсүүдийг ангилах

Улс орны байгалийн нөхцөл, эрдэс баялгийн нөөц, үйлдвэрлэлийн салбаруудын онцлог зэрэг нийгэм эдийн засгийн нөхцөл байдал болон төрөөс баримтлах бодлого, гадаад болон дотоод орчны хүчин зүйлс тодорхойлох эдийн засгийн бүсүүдийн шалгууруудыг сонгох анхдагч алхам болно. Үүний тулд дараах байгаль нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлын талаар өмнө хийгдсэн болон одоо байгаа судалгааны материалуудтай танилцан хянан үзэж, шаардлагатай шинэ өгөгдөл мэдээллээр баяжуулан дүн шинжилгээ хийнэ.

1. Эдийн засгийн хөгжлийн талаарх төрийн бодлогын баримт бичгүүд

а. Монгол улсын эдийн засгийн болон бүсчилсэн хөгжил, хүн ам, хөдөлмөрийн нөөц, байгаль орчны талаар төрөөс баримтлаж буй бодлого, хууль тогтоомж тэдгээрт холбогдох баримт бичгүүд

б. Аймаг сумдын буюу орон нутгийн эдийн засгийн хөгжлийнхөө талаар баримтлаж буй бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө

с. Үйлдвэрлэлийн үндсэн салбаруудын хөгжлийн талаар баримтлаж буй бодлого, хөтөлбөр төлөвлөгөө

2. Монгол орны байгаль газарзүйн нөхцөл, эрдэс баялагийн нөөц байршил

а. Физик газарзүйн нөхцөл (уур амьсгал, геологи, геоморфологи, хөрс, ургамал, ландшафт)

б. Нийгэм эдийн засгийн газарзүйн нөхцөл (Газарзүйн байрлал, засаг захиргааны хуваарь, хүн амын нутагшил суурьшил, үйлдвэрлэлийн болон нийгмийн үйлчилгээний салбаруудын орон зайн тархалт байршил, дэд бүтэц, тээврийн сүлжээ зангилаа)

с. Эрдэс баялгийн нөөц, түүний орон зайн тархалт, байршил

3. Монгол улсын нутаг дэвсгэрийн оронзайн хөгжлийн нөөц, төлөвлөлт

а. Монгол улсын газрын нөөц, газрын сангийн ангилал

б. Хот суурингийн сүлжээ, бүлэг суурингийн тогтолцоо, тэдгээрийн үүргийн бүтэц

4. Үйлдвэрлэлийн үндсэн салбаруудын өнөөгийн нөхцөл байдал цаашдын чиг хандлага, дотоод болон гадаад орчны хүчин зүйлс

а. ХАА

б. Уул уурхай

с. Боловсруулах үйлдвэр

д. Үйлчилгээний салбар

5. Нийгмийн үйлчилгээний салбарууд өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага

а. Боловсрол

б. Эрүүл мэнд

Дээрх дүн шинжилгээний үр дүнг ашиглан эдийн засгийн бүсүүдийн үндсэн орц гарцуудыг тодорхойлоно. Эдийн засгийн бүсүүд нь системийн хандлагын үүднээс авч үзвэл оронзайн нээлттэй динамик систем болох учир түүний хөгжилд системийн орц болон гарц чухал үүргийг гүйцэтгэнэ.

Хоёрдугаар шатанд өмнө хийгдсэн дүн шинжилгээндээ үндэслэн холбогдох статистик болон бусад өгөгдөл мэдээлэлийг цуглуулан өгөгдөлийн сан үүсгэж түүндээ дүн шинжилгээ хийснээр бүс нутгийн шинжилгээнд зориулсан хүчин зүйлсийг тодорхойлоно. Үүний тулд эдийн засгийн бүс тус бүрт нөлөөлөх хүчин зүйлсийг илэрхийлэх боломжтой шалгуур үзүүлэлтүүдтэй холбоотой өгөгдөлүүдийг олж авч эдийн засгийн бүсүүдийг шинжлэх, тодохойлох үзүүлэлтүүдийн матрицыг байгуулах аргаар өгөгдөлүүдэд тооцоолол хийнэ.

Гуравдугаар шатанд сонгон авсан шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой параметр лүү хувиргах шаардлагатай, энэ нөхцөлд, эдийн засгийн бүс нутгуудыг шинжлэх, тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийнхээ матрицыг байгуулна. Мөн энд цуглуулсан олон төрлийн асар их өгөгдлийг нормчлох шаардлагатай болно. Нормчлол нь өгөгдлийн сангийн бүтцийг хамгийн бага логик нөөцтэй болгох хэлбэрийг бий болгох зорилготой байдаг. Өгөгдлийг нормчилсноор өгөгдлийн санд хадгалагдсан мэдээллийн зөрүү багасгадаг. Энэ шатанд бүс нутгийн ангиллыг бүрдүүлэхэд дутагдаж байгаа зарим төрлийн нөөц, бодит байдлын чанарыг төлөөлөх өгөгдлийг илрүүлэх,


орон зайн шинэ төлөвлөлт хийхэд гарах гажуудлыг багасгах, өгөгдлүүдийн харилцан тэнцвэргүй байдлыг арилгах, шаардлагатай хязгаарлалтуудыг хийх үйл ажиллагаа явагдах ёстой.

Энэхүү аргазүйн эцсийн шатанд эдийн засгийн бүс нутгуудыг ангилах, орон зайн ялгааг илрүүлэх шинжилгээг явуулна. Статистик мэдээлэлүүдээ тооцоолол хийх замаар кластерийн шинжилгээг явуулах ба дараах аргуудыг ашиглана. Үүнд:

1. Ижил төстэй хэмжүүрийн арга
2. Бүлэглэлийн арга
3. Бүлэглэлийн техникийн арга
4. Нэгтгэлийн арга

Ижил төстэй хэмжүүрийн суурь хэмжигдэхүүн нь зайн хэмжээс болно. Бүлэглэх аргын хувьд орон зайн шатлах захирах зүй тогтолыг илрүүлэхэд анхаарах ёстой. Бүлэглэх техникийн аргаар тухайн объектуудын орон зайн төвлөрөл, шугаман болон тэнхэлэгт татагдсан байдлыг тогтооно. Объектуудыг нэгтгэх шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох нь нэгтгэлийн аргын гол зорилго болдог. Энд Ward-ын шаталсан кластерийн шинжилгээний аргазүйг өргөн ашиглах боломжтой байдаг. Дээрх аргуудыг ашиглан өгөгдөлүүдэд боловсруулалт, тооцоо, шинжилгээ хийснээр тодорхой нутаг дэвсгэрийн эдийн засгийн бүс нутгийн ангилалыг хийх боломжтой болно.

Эдгээр аспект болон тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх судалгааны ерөнхий аргазүйн дараах бүдүүвчийг урьдчилсан байдлаар санал болгож байгаа байна.



Схем 1. Монгол улсын бүсийн хөгжлийн бодлого
Эх сурвалж: Зохиогчид

2.2. ГМС-ийн технологид суурилсан судалгааны аргазүй

Гео орон зайн хил хязгаарыг тодорхойлох, бүс нутгийн хөгжлийн загвар боловсруулах үйл ажиллагаанд ГМС-ийн технологид суурилсан аргазүй ашиглах нь дараах олон талын боломжууд олгоно.

GIS ашиглах давуу талууд

- Төлөвлөлтийн тасралтгүй үйл явцыг хангах,
- Төлөвлөлтийн аппликейшн болон чадамж өргөн хүрээтэй,
- Олон хувилбарт төлөвлөлт хийх боломж,
- Бүс нутгийн загварчлал болон зохиомж,
- Өгөгдөл, мэдээлэл нарийчлалтай
- Визуаль чадамж өндөр,
- Өгөгдлийг шинэчлэх үйл явц хялбар,
- орон зайн "гүн гүнзгий" дүн шинжилгээ хийх боломж илүү сайн,
- Мониторинг хийх чадамж сайн,
- нэгдсэн мэдээллийн менежментийн орчин,
- Илүү зохион байгуулалттай архив, гэх мэт.

ГМС-ийн технологи ашиглахад тулгарах сорилт

Эдийн засгийн бүсчлэл, бүс нутгийн төсөл боловсруулах ажлын орчинд ГМС-ийн технологи хэрэглэхэд дараах сорилт тулгарч болох юм. Үүнд

- Ажлын орчин дахь функциональ өөрчлөлт (шинэ organogram)
- Хот бүс нутгийн захиргааны байгууллагын ГМС-ийн эрх бүхий ажилтан, байгууллагын хэрэглэгч болон түншүүдийн ур чадвар
- Тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээлэл цуглуулах, үйл ажиллагааны санхүүжилт
- Өгөгдөл боловсруулах болон хэвлэн нийтлэх хууль эрхзүйн орчин
- ГМС-ийн өгөгдлийн стандартчлал
- Засаг захиргааны янз бүрийн түвшин хоорондын зохицуулалт (бүс нутгийн, орон нутгийн, Төрийн (төлөвлөлт, кадастрын гэх мэт), орон нутгийн байгууллага (хот төлөвлөлт, барилга, дэд бүтэц) болон хот ба бүс нутаг төлөвлөлтийн салбар хоорондын зохицуулалт
- үргэлжилсэн (насан туршийн) сургалтыг зохион байгуулах,
- тасралтгүй шинэчлэх үйл явцыг бий болгох (update process)
- мэдээлэл олж авах арга (GPS, сансрын зураг, гэх мэт) -ын шинэчлэл,
- холбооны дэд бүтэц (өргөн хүрээтэй).

ГМС-ийн хэрэглээний түвшин

ГМС нь энгийн софтвер биш бөгөөд энэ нь шийдвэр гаргах ба төлөвлөлтийн үйл явцыг дэмжих, мэдээллийн орчны цөм болно.

Ер нь хот бүс нутаг төлөвлөлт (эсвэл хот суурин газрын мэдээллийн систем) дэх ГМС нь өвөрмөц хэрэглээний гурван түвшинг багтаана:

Өгөгдлийн сангийн удирдлага

- Мэдээлэл олж авах,
- Мэдээллийн шалгалт,
- Мэдээллийн өөрчлөлт,
- Мэдээллийн шинэчлэх,
- Нарийвчлалын түвшин,
- Нээлттэй эх сурвалж.

Орон зайн дүн шинжилгээ хийх, хяналт тавих, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх

- Мэдээлэл боловсруулах, ашиглах,
- Мэргэжлийн программууд,
- Хот суурин газрын хяналт тавих,
- Сүлжээнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, төлөвлөлт,
- Төлөвлөлт ба хотын эд хөрөнгийн удирдлага,
- Төлөвлөлт, барилгын зөвшөөрөл олгох үйл явцын менежмент, мэдээлэл
- Сэдэвчилсэн үр дүн: газрын зураг, хүснэгт, зураг,
- Тусгай гарц, програмууд: Интернет хэрэглээ болон өгөгдлийн.

Бүс нутгийн мэдээллийн системийг боловсруулж, хэрэгжүүлэх ерөнхий схемийг дараах байдлаар үзүүлэв:

Боломжит судалгаа,

Үзэл баримтлалын загварчлал,

"Pilot application" -ийн хөгжил,

Мэдлэг, ойлголтын сайжралт,

Ажилтнуудын сургалт,

Өргөтгөсөн боловсруулалт, хэрэгжилт,

Тасралтгүй мэдээлэл болон системийн шинэчлэлтийн процесс,

Үйл ажиллагааны хүрээний шинэчлэл,

Улс төрийн дэмжлэг,

ГМС-ийг хөгжүүлж, ажиллуулах үе шат

Техникийн нөхцлүүд нь ГМС-ийг хөгжүүлж, ажиллуулах дараагийн гурван тусдаа үе шатны талаарх мэдээлэл өгч, дэлгэрэнгүй тодорхойлох болно:

Оролт

- Шаардлагатай мэдээлэлийг дижиталчлах үйл явц
- Шаардлагатай тоон зураглалын бүтцийг хангах,
- Хот суурин газрын одоогийн ба шинэ ерөнхий төлөвлөгөө, байр зүйн ба кадастрын ажлын төсөл, одоо байгаа ба шинэчилсэн газрын зураг хуудас, агаарын зураг, хиймэл дагуулын дүрс мэдээлэлийг оруулах гэх мэт
- Мэдээллийн нийцтэй (орц ба экспорт дахь өөр өөр форматтай мэдээлэл)
- Арифметик буюу текстэн хүснэгт гэх мэт график бус өгөгдөлийг оруулах,

Боловсруулалт

- Өгөгдлийн бүтэц тодорхойлох (орон зайн эсвэл рефренс биш)
- Мэдээллийн санг хөгжүүлэх, мэдээлэл кодлох,
- График болон график бус өгөгдөл засварлах
- Зураглал боловсруулах чадамж,
- Зураг зүйн хувиргалт - илэрхийлэл representation,
- Аналитик чадвар,
- Дүрслэл чадвар,
- Мэргэжлийн програмууд Specialized applications

Гарц

- зураглалын үйл явц, автоматжуулалт (динамик арга зам, гарц, тоног төхөөрөмж)
- зураглалын синтезид (шошго болон тайлбар гэх мэт) зориулсан хэрэгслүүд,
- тайлан зураг,
- Интернет нийтлэл (формат болон чадамж).

ГМС-ийн бүрдүүлэх практик асуудлууд

Ерөнхий практик алхмууд

- Зорилго, хэрэгцээг тодорхойлох..... (хэнд зориулж? Яагаад?)
- Анхдагч эх сурвалжуудыг судлах (юу байгаа?)
- Газрын зургийн форматыг сонгох(Растер, вектор, эсвэл аль аль нь?)
- Мэдээллийн сангийн дизайн(чухам юу хэрэгтэй байгаа?)
- Үндсэн газрын зураг дээрх шийдлүүд(нийлэмж, хэрэгцээний хүрээ)

- Давхаргуудын тодорхойлолт(талбайг давхцуулах)
- Ажилгааны зохион байгуулалт(хэрхэн яаж?)
- Давхаргыг бий болгох(өгөгдлийн нэгж сонголт)
- Сэдэвчилсэн мэдээлэл (атрибут хүснэгтүүд)
- орон зайн анализ, сэдэвчилсэн зураг зүй(мэдээлэл)

Вектор давхаргыг тодорхойлох нь (Газрын зураг)

- Орон зайн өгөгдлүүдийн тодорхойлолт.....(полигон, шугам, цэг гэх мэт)
- Топологийн шийдэл.....(полигонлог, шугаман, цэгэн гэх мэт)
- Дижитацчлах(дүрэм)
- Байрзүйн холболт-геореференсин.....(tics / хяналтын цэгүүд)
- Засварлах, алдаа шалгах(нарийвчлал, үнэн зөв байдал)
- Хаягжуулах (уншигдах байдлыг нэмэгдүүлэх)
- Кодчиллын систем(ID-ууд, анхдагч мэдээлэл)
- Топологи журам(орон зайн харилцаа)
- Засварлах, алдаа хянах(топологи дүрэм)
- Геометр.....(эсвэл анхдагч?)
- Атрибутуудыг харуулах буюу нэгтгэх.....(мэдээллийн сан үйл ажиллагаа)
- Засварлах, алдаа шалгах, боловсруулах.....(геометр болон сэдэвчилсэн атрибутуудын нийлэмж)
- Эцсийн дижитал газрын зургийн давхарга..... (хэлбэр, geodatabase гэх мэт)

Орон зайн өгөгдлийн бүтцийн төлөвлөлт

ГМС-ийг хөгжүүлэх нэг гол арга зам нь орон зайн мэдээллийн сан байгуулах явдал юм. Үүнийг хийхэд урт удаан хугацаа шаардах ба түүнийг үргэлжлүүлэх олон сонголтууд байдаг. Концептуал дизайн (үзэл баримтлалын загвар) бэлтгэх замаар эдгээр сонголтуудын хариултыг шийдвэрлэх болно.

Жишээ нь:

- а) Автоматжуулалтын аль ажлуудыг ГМС-ийн байгууллагын ажилтнууд гүйцэтгэх вэ?
- б) Алийг нь автомат вендорoor (vendor)?
- в) Аль өгөгдөийг тоон хэлбэрээр олж авч болох вэ?

Энэхүү арга замын гол аспект нь Хот бүс нутаг төлөвлөлтөнд зориулан янз бүрийн geodata давхаргуудыг (зураг давхарга) тодорхойлох явдал юм. Эдгээр давхаргууд нь хот бүс нутгуудын

төрх чанар, хэмжээ болон захиалгын (desired applications) хэв шинжээс шууд хамаардаг ба ерөнхий схем нь дараах байдалтай байна:

Бүс нутгийн зонхилох давхаргууд layer

Бүс нутгийн нэгдсэн гео-өгөгдлийн бүтэц нь наад зах нь дараах давхаргуудыг агуулсан байх шаардлагатай:


1. Бүс нутгийн хөгжлийн ерөнхий схем (үндсэн ба дэд бүсүүд:цаг хугацаа, эрхзүй гэх мэт)
2. Байгалийн нөхцөл (Геологи, геоморфологи, уур амьсгал, ус зүй, хөрс, ургамал, амьтан, гамшигийн эрсдэл гм)
3. Байгалийн нөхцөл нөөц (Газрын хэвлийн нөөц, шатах ашигт малтмал, хар ба өнгөт төмөрлөг гм)
4. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (үүрэг зориулалтын бүсчлэл)
5. Хот суурин газар, нутагшил суурьшлын эрэмбэлсэн тогтолцоо
6. Авто ба төмөр замын тэнхлэгүүдийн эрэмбэлсэн тогтолцоо
7. Засаг захиргааны нэгжүүдийн хил, төвүүдийн байршил
8. Бэлчээрийн хэв шинж, нөөц
9. Тариалангийн талбай
10. Гол мөрөн, гол горхи, бусад
11. Дамжуулах хоолой, бусад шугман объект
12. Геодезийн хатуу цэг
13. Эрчим хүчний шугам, сүлжээ
14. Тусгай хамгаалалттай газар нутгууд
15. Харилцаа, холбооны шугам, сүлжээ гэх мэт.

Мөн дээрх давхаргууд дээр нэмэлтээр растер давхаргын багцтай байх шаардлагатай ба тэр нь бүхийл бүтцэд дэмжлэг үзүүлэх болно. Эдгээр растер давхаргад агаарын фото зураг, хиймэл дагуулын зураг болон сэдэвчилсэн давхаргад зориулагдсан бусад растер зураг багтана.

Нийтлэг давхаргын харагдах байдал


Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн шинэчлэл боловсруулалтын түвшинд байгаа ба ГМС-ийн технологи ашиглан цаашид боловсруулах нийтлэг давхаргын төлөөлөл болгон дараах зургийн давхаргуудыг жишээ болгон үзүүлэв.

Зураг.3 Говийн дэд бүсийн хүн амын нутагшил, суурьшил




Эх сурвалж: Судалгааны баг, 2019

Зураг.4 Авто ба төмөр зам, стратегийн ордын байршил



Эх сурвалж: Судалгааны баг, 2019

Зураг. 5 Давхаргуудын давхцуулалт, Говийн дотоод бүсчлэлийн урьдчилсан төсөөлөл



Эх сурвалж: Судалгааны баг, 2019

2.3. Нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтын аргазүй

Нийгэм-эдийн засгийн хөгжлийн тодорхой үе шат бүрийг даган хүмүүсийн амьдралын орон зайн зохион байгуулалт өөрчлөгдөн хувьсаж байдаг. Аливаа улс орон, бүс нутаг бүр өөрийн гэсэн нутаг дэвсгэртэй. Тэрхүү нутаг дэвсгэрийг орон зайн хувьд хэрхэн зохион байгуулах нь улс төр нийгэм эдийн засгийн дотоод болон гадаад олон хүчин зүйлээс хамаардаг.

Дэлхий дахинаа даяаршил гүнзгийрч, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграц өргөжин, улс хоорондын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч байгаа өнөө үед улс орнуудын эдийн засгийн хөгжил нь тухайн орны өөрийн дотоод хүчин зүйлсээс гадна дэлхийн зах зээлийн чиг хандлага, олон улсын болон бүс нутгийн эдийн засгийн харилцаа, хөрш зэргэлдээ орнуудын улс төр эдийн засгийн бодлого зэрэг гадаад орчны хүчин зүйлсээс ихээхэн хамаарах болжээ. Энэхүү гадаад хүчний нөлөөллийг багасгах түүнийг эерэгээр ашиглах нэг арга зам бол өөрийн орны хөгжлийн нөөцийг нутаг дэвсгэрийн хувьд зөв зохион байгуулах явдал юм. Иймээс Монгол улсын хувьд газарзүйн өвөрмөц байршил, байгалийн нөхцөл нөөц, хүн ам хөдөлмөрийн нөөцийнхөө чадавхид түшиглэсэн хамгийн үр ашигтай нутаг дэвсгэрийн эдийн засгийн орон зайн зохион байгуулалтын зарим хэлбэрүүдийг ашиглах шаардлагатай байгаа билээ.

Нутаг дэвсгэрийн зохион байгуулалт гэдэг нь эдийн засгийн объектууд, хүн ам, нутаг дэвсгэрийн нөөц баялаг, тэдгээрийн хоорондох орон зайн уяалдаа холбоо, харилцан хамааралыг харгалсан нутаг дэвсгэрийн ялгааг илрүүлэх байршуулах зохион байгуулах үйл явц юм.

Нэгдмэл эдийн засгийн орон зайн хамгийн чухал бүрэлдхүүн хэсгүүдэд үндэсний түүхий эдийн зах зээл, хөдөлмөр, капитал тэдгээрийн нэгдэл, ялгарал, сегментчлэл, шилжилтийн үйл явцууд түүний дотор эдийн засгийн бүсчлэл орно.

Эдийн засгийн бүсчлэл нь нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын нэг хэлбэр болох бөгөөд орон зайн тодорхой түвшинд нутаг дэвсгэрийг эдийн засгийн харилцаа түүний орон зайн шинж чанар, онцлогийг харгалзан зохион байгуулах асуудал юм.

Нутаг дэвсгэрийг эдийн засгийн үүднээс бүсчлэхийн тулд гео орон зайн шатлан захирах нарийн төвөгтэй байдал болон эдийн засгийн орон зайн янз бүрийн түвшинд бүрэлдэн тогтдог нэгдмэл, цогц байх гэсэн үндсэн шинж чанаруудыг харгалзан үзэх шаардлагатай байдаг.

Бүс нутаг судлалын болон эдийн засгийн газарзүйн ухаан, байршлын онолоор бүс нутгийн хөгжилд үйлдвэрлэлийн болон хэрэглээний цэгүүдийн хоорондын зай, байршил, орон зайн хүртээмж, ойр дөхөм байдал, сүлжээний нөлөө, орон зайн олон янз байдал, нягтрал зэрэг параметруудээр тодорхойлогдох хүчин зүйлс нөлөөлж байдаг.

Нийгэм, эдийн засгийн бүхий л үйл явц орон зай, цаг хугацаанд явагдана. Тэдгээр үйл явцын үйлчлэх орон зай нь үндсэн хүчин зүйлийн нэг нь газар зүйн байршил юм. Газарзүйн байршлын дараах онцлог шинж чанаруудыг тодорхойлсон байдаг.

Үүнд:

1. Орон зайн, газарзүйн ойр дөхөм байдал
2. Орон зайн, газарзүйн ялгарал
3. Орон зайн, газарзүйн зайн хэмжээс, хөдөлгөөн
4. Орон зайн, газарзүйн цар хүрээ, бүтэц

Эдгээр чанар нь бүс нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн орон зайн суурь үзүүлэлтүүд болно. (Зураг 6)

Зураг 6 Бүс нутгийн хөгжилд нөлөөлөх оронзайн суурь үзүүлэлтүүд



Эх сурвалж: Судалгааны баг, 2019

Орон зайн судалгааны нэгдсэн арга зүйд тулгуурлан эдийн засаг, улс төр, эдийн засгийн газарзүй, экологи болон нийгмийн шинжлэх ухааны бусад салбаруудын дундаас “Бүс нутгийн шинжлэх ухаан”-ы салбар үүсэж хөгжиж байгааг АНУ-ын эдийн засагч У.Айзерд өөрийн бүтээлдээ дурьдсан байдаг. Иймд бүс нутаг судлалын ухаанд шинжлэх ухааны олон салбарын онол хандлага, аргазүйг ашигладаг. Говийн дэд бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах судалгааны ажилдаа бид газарзүйн болон эдийн засгийн шинжлэх ухааны зарим онол хандлагыг ашиглахыг зорьсон.

2.4. Бүс нутаг дахь аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтцийг судлах арга зүй

Эдийн засгийн газарзүйд нутаг дэвсгэрийг бүсчлэх, эдийн засгийн оронзайн ялгааг илрүүлэх, бүрэлдэн бий болсон бүс нутгуудад орон зайн шинжилгээг явуулахдаа бүтцийн болон системийн гэсэн үндсэн 2 хандлагыг баримтлана.

Аж ахуйн ямар ч салбар үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж ашигтай ажилласанаар эдийн засгийн аль түвшинд нэмүү өртөг бий болгож бусад салбарууд (үйлдвэр)-тай түүхий эд, нөөц, техник, технологи, борлуулалт, худалдааны сүлжээнд холбогддог. Эдийн засгийн энэхүү үйл ажиллагаа нь хүн амын нутагшил, суурьшил, хөдөлмөр эрхлэлтийг бий болгож түүнийг дагасан нийгмийн үйлчилгээний салбар, тээврийн сүлжээ (логистик) бий болж хөгждөг. Харин нийгэм-эдийн засгийн газарзүйн ухаанд дээр дурьдсан нөөц-үйлдвэрлэл-хуваарилалт гэсэн эдийн засгийн циклийг нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалт гэсэн аргазүйн хандлагаар авч үздэг. Ийм нөхцөлд хүн амын нутагшил, суурьшил (хот, хот маягийн суурин ба бусад) түүхий эд-үйлдвэрлэл-бүтээгдэхүүн хуваарилалтын нутаг дэвсгэрийн ялгаа, тодорхой бүс нутаг, тэдгээрийг холбогч тээврийн сүлжээ (ялангуяа зам харилцаа), үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн (түүхий эдийн бус) цогцолборын түвшинд судалдаг.


Эдийн засгийн газарзүйд аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтэц нь нутаг дэвсгэрээр хязгаарлагдсан үйлдвэрлэл, хүн амын суурьшлын жижгэвтэр нийгэм-эдийн засгийн цэгээс эхлэн бүхэл бүтэн эдийн засгийн бүс нутаг, үндэсний хэмжээний эдийн засгийн нутаг дэвсгэрийн дүн шинжилгээ хийх гол ашигладаг хэрэглүүр гэж үздэг. Ямар нэг үйлдвэрлэл, аж ахуйн эсвэл эдийн засгийн аль нэг салбаргүй аж ахуйн (эдийн засгийн) нутаг дэвсгэрийн бүтэц гэж байдаггүй.

Эдийн засгийн газарзүйн үүднээс нутаг дэвсгэрийн бүтцийн ба нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын аргазүйг хэрэглэхдээ дараах үе шаттайгаар орон зайн шинжилгээг явуулна. Үүнд:


1. Аж ахуйн нутаг дэвсгэрийн энгийн бүтцийг судлах
2. Нутаг дэвсгэрийн бүтцэд гарах чанарын өөрчлөлтийг судлах
3. Эдийн засгийн бүтцээр аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтыг судлах
4. Аж ахуйн нутаг дэвсгэрийн систем бүрэлдэн тогтох үйл явцыг судлах

Аж ахуйн нутаг дэвсгэрийн энгийн бүтцийг судлахдаа аж ахуйн нутаг дэвсгэрийн энгийн элементүүд тэдгээрийн хоорондын уяалдаа холбоог олж тогтоохоос эхлэнэ.(Зураг 7) Тодорхой нутаг дэвсгэр дээр орших үйлдвэрийн газрууд нь үйл ажиллагааны явцдаа ямар нэг нутаг дэвсгэрийн уялдаа холбоог бий болгодог нь нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтыг судлах анхдагч алхам болдог.

Зарим үйлдвэрүүд хоорондоо түүхий эд, техник технологи, бүтээгдэхүүн, солилцоо зэрэг эдийн засгийн үйл ажиллагааг явуулах явцдаа засаг захиргааны нутаг дэвсгэр эсвэл эдийн засгийн бүс, түүний төв (хүн амын суурьшлын нутаг дэвсгэр), улсын нутаг дэвсгэрийн хүрээнд бүтцийн чанарын өөрчлөлтыг бий болгодог. (Зураг.7) байдаг.



Зураг 7. Аж ахуйн нутаг дэвсгэрийн уялдаа холбоо




Зураг 8. Нутаг дэвсгэрийн бүтцийн чанарын түвшинийг судлах

Эдийн засгийн бүс нь ойролцоо байгаль газарзүйн нөхцөлд бүрэлдэн тогтдог нутаг дэвсгэрийн систем тул аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтцийг судлахдаа тэдгээрийг тодорхой бүсийн түвшинд авч үздэг. Эдийн засгийн бүсүүд нь дараах шалгуурыг хангасан байхыг шаарддаг. Үүнд:


- үйлдвэрлэлийн чиглэл,

- төрөлжилт адил
- бүтээгдэхүүний солилцоо дотроо хийгддэг
- түүхий эдийн эх сурвалж ойр
- дэд бүтцийн шугаман ба түүнийг дагасан үйлдвэрлэл, суурьшлын зангилаагаар эдийн засгийн үйл ажиллагаа нь явагдаж байдаг (Зураг 8) зэрэг болно.

Нутаг дэвсгэрийн (бүс) аль нэг байршил дээр бэлэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ үүсч үйлдвэрлэл эрхлэх шаардлага гардаг. Эндээс үндэслэн аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтэц бүрэлдэн тогтох үйл явц (Зураг.9) эхэлнэ.



Зураг 9. Эдийн засгийн бүсүүд дахь нутаг дэвсгэрийн бүтцийн схем




Зураг 10. Нутаг дэвсгэрийн бүтэц, бүрэлдэн тогтох схем

Аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтцийг судлахдаа дараах аргазүйн дарааллыг баримтлана.


1. Үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн бүтэцийн доорх элементүүдийг тодорхойлох, дүн шинжилгээ хийхдээ заавал харгалзан үзнэ. Үүнд:
 - а. Зангилаа-бэлэн бүтээгдэхүүн, өөр үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардагдах нөөцийг үйлдвэрлэгчийн нутаг дэвсгэрийн цогцолбор
 - б. Тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн түүхий эдийн бүс

- c. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, солилцоог (логистик) хангах тээврийн хэрэгсэл, зам, суурин газар бүхий шугаман зангилааны (тэнхлэг) систем
 - d. Эрэлт хэрэгцээгээр тодорхойлогддог зах зээлийн бүс
- 2. Дээр дурьдсан элементүүд ба шугаман зангилааны систем нь шугаман зангилааны сүлжээний янз бүрийн хэлбэрүүд ба зах зээлийн бүсүүд үүсдэгийг анхаарах
- 3. Нутаг дэвсгэрийн бүтцийн аль сүлжээнд бүрдүүлэгч элементүүд давтагдаж (Зураг 11) байгааг тодорхойлох. Эрэлтийн бий болсоноор үйлдвэрлэл явагдаж тодорхой орон зайд зах зээлийн бүс үүсдэг. Эхний үйлдвэрлэлийн явцад бий болсон бүтээгдэхүүн нь хоёрдогч үйлдвэрийн үйлдвэрлэлийн эх сурвалж болж нийлүүлэгдэх ба үйлдвэрлэлийн зарим тоног төхөөрөмж бүтээгдэхүүн нь эргээд эхний үйлдвэрийн нөөцийн хувьд шаардлагатай болдог. Ийм циклээр үйлдвэрлэл нь сүлжээ болон өргөжин тэлэх явцдаа үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн бүрэн циклийг бий болгодог (Зураг 11). Энэ нь эрэлтээр бий болсон бүтээгдэхүүн (эхний зангилаанд бий болсон) үйлдвэрлэгдэн дараагийн зангилаанд ирж (борлуулагдах, эсвэл угтвар бүтээгдэхүүн болох) эцсийн бүтээгдэхүүн болон хэрэглэгчид очно. Үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн бүтэц нь дээр дурьдсан уялдаа холбоон дээр суурилж зангилаа хэлбэртэй байхын зэрэгцээ заавал шугаман зангилааны хэлбэртэй байдаг.




Зураг.12 Нутаг дэвсгэрийн бүтцийн бүрэн циклийн дүрслэл

- 4. Нутаг дэвсгэрийн бүтцийн элементүүдийг тодорхой дэс дарааллаар энгийнээс нийлмэл хэлбэрт хэрхэн шилжиж хөгжиж байгаад дүн шинжилгээ хийх (Зураг 12)
- 5. Аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтэц бүрэлдэн тогтох үйл явцыг нэгтэн судлах. Аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтэц нь түвшний хувьд:
 - a. Шугаман-зангилааны орон зайн ердийн бүтцийн түвшин
 - b. Нутаг дэвсгэрийн бүтцийн түвшин
 - c. Нутаг дэвсгэрийн ерөнхий (эцсийн) түвшин гэсэн гурван түвшинтэй байна. (зураг.....)




Зураг 11. Нутаг дэвсгэрийн бүтцийн циклийн схем

Харин нутаг дэвсгэрийн бүтэц нь зангилаа, ареал (хүрээ), нутаг дэвсгэрийн бүс, түүний нөлөөллийн хүрээ, урсгалууд, хэлхээ холбоо гэсэн элементүүд (параметр)-тэй байна. Аливаа энгийн салангид үйлдвэрлэлийн шатанд тэр нь шугаман зангилааны энгийн оронзайн бүтэцтэй. Энэ үед үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүн, борлуулалт, тээвэрлэлт, эрэл хэрэгцээ, бүгд салангид, нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл бус, хэлхээ холбоогүй (Зураг 12) байдаг.



Зураг 13. Аж ахуйн нутаг дэвсгэрийн орон зайн шатлалын дүрслэл

Үйлдвэрлэлийн түүхий эд ханган нийлүүлэгчдийн хэлхээ холбоо бий болохын зэрэгцээ үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүний эрэлт шинээр үүсч, шугаман зангилааны систем, нутаг дэвсгэрийн бүтцийн хэлбэрт өөрчлөлт орно. Нэгэнт нутаг дэвсгэрийн бүтцийн түвшинд хүрч хөгжин (Зураг 13) үйлдвэрлэгч нөлөөллийн өөрийн нутаг дэвсгэрийн хүрээтэй болж бусад үйлдвэрлэлтэй хэлхээ холбоо тогтоож борлуулалт, зах зээлийн бүсэд хамтран ажиллах эсвэл хоорондоо техник технологи, бүтээгдэхүүний төрөлжилтөөр хамтрах зайлшгүй шаардлага гарна.



Зураг 14.. Нутаг дэвсгэрийн бүтэцийн түвшин

Аж ахуй нутаг дэвсгэрийн бүтэц нь шугаман зангилааны системтэй болсноор эдийн засгийн бүсийн хөгжлийн зөв гольдролдоо орлогийг эрдэмтэд нотолсон байдаг. Энэ нь үйлдвэрлэлийн хэсэг бүлэг циклүүд, түүхий эдийн эргэлтэнд орж чадахгүй түүхий эдийг анхдагч байдлаар гадагш худалдах үйлдлүүдийг зогсоож тэдгээрийг шугаман зангилааны систем бүхий нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн нэгдсэн циклд багтаан нутаг дэвсгэрийн зохистой бүтцийг үүсгэдэг. Нутаг дэвсгэрийн зохистой бүтэц бүрэлдэн тогтсоноор улсын хэмжээний эдийн засгийн бүсүүдийг үүсгэдэг.

Аливаа бүс нутгийн нутаг дэвсгэрийн бүтцийг судлахад дээр дурьдсан арга зүйг улам бүр боловсронгуй болгон өнөөг хүртэл баримталсаар ирсэн. Бид ч бас энэхүү аргазүйг сайжруулан судалгааны ажилдаа хэрэгжүүлэхийг зорилоо. Мөн нутаг дэвсгэрийн бүтцийн дүн шинжилгээнд нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг заавал авч үзэх шаардлагатай байдаг.


Иймд бид нийгэм-эдийн засгийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтанд нийгэм, аж ахуйн салбарын нутаг дэвсгэрийн байршил, тэдгээрийн байгаль, нийгэм-эдийн засгийн газарзүйн тодорхойлолт, салбарын хамрах хүрээ, нутаг дэвсгэрийн ба үйлдвэрлэлийн хоорондын уялдаа холбоо хүчин чадал, үйлдвэрлэлийн болон үүргийн төрөлжилт, хүн амын ажиллах хүчний хангамж, түүхий эдийн нөөцийг авч үзсэн төдийгүй үйлдвэрлэлийн салбарын шинжилгээнд үндэслэсэн бүсчлэлийн асуудлыг хөндөж байна.

2.5. Эдийн засгийн бүсэд бичил бүс, бүлэг суурингийн төв тогтоох

2.5.1. Байгалийн нөхцөлийн суурь үнэлгээний үр дүн

Байгалийн нөхцөлийн суурь үнэлгээг уур амьсгалын бүсчлэл, газрын гадаргын төрх буюу ургамалан бүрхэвч, гадаргын болон гүний ус, уул уурхайн ордын байршил, газар хөдлөлтийн мужлал гэсэн шалгуур хүчин зүйлсийг эрэмбэлэн 330 сум, суурингуудад хүчин зүйл тус бүрээр 1-5 хүртэлх баллын үнэлгээ өгсөн. Жигнэсэн дундаж баллын нэгдсэн үнэлгээгээр дараах зургийг гүйцэтгэв (Зураг.15).

Зураг. 15 Байгалийн нөхцөлийн суурь үнэлгээний үр дүн, баллын утгаар



Эх сурвалж: Судлаач

Жигнэсэн дундаж баллын утга 1.66-4.66 хооронд гарсан ба энэ нь монгол орны нутаг дэвсгэрийн хойноос урагшлах тусам газрын өндөршил намсах, ургамалан бүрхэвч, ус зүйн нөхцөл, уур амьсгалын нөхцөл зэрэг нь харилцан адилгүй учраас сумдын үнэлгээний утга өөр хоорондоо ялгаатай үнэлэгдсэн.


2.5.2. Нийгэм эдийн засгийн суурь нөхцөлийн үнэлгээний үр дүн

2.5.2.1. Хүн амын өсөлт, бууралт

Нийгэм эдийн засгийн суурь үнэлгээг хүн амын өсөлт, бууралт, орон нутгийн хөгжлийн индекс болон үйлдвэрүүдийн байршил гэсэн шалгуур хүчин зүйлсийг эрэмбэлэн 330 сум, суурингуудад хүчин зүйл тус бүрээр 1-5 хүртэлх баллын үнэлгээ өгсөн.

Нийгэм эдийн засгийн суурь үнэлгээн дэх хүн амын хүчин зүйлээр 2007-2018 оны хооронд 10 жилийн хүн амын өсөлт, бууралтаар болон хүн амын дундаж өсөлтийн хувийн үр дүнгээр дараах зураглалыг гүйцэтгэв (Зураг.16).

Зураг. 16 Сум тус бүрийн хүн амын дундаж өсөлтийн хувь болон хүн амын өсөлт, бууралт




Эх сурвалж: Судлаач

Сүүлийн жилүүдэд төрөөс баримтлах бодлоготой холбоотойгоор сум суурингуудын хүн амын нутагшил, суурьшилтад өөрчлөлт гарч эхэлжээ. Иймээс дийлэнх сумд буюу 272 сумдын хүн амын тоо өсөлттэй байна. Хүн ам бууралттай 58 сум суурин илэрсэн ба -9%(-0.01%) хүртэл хүн ам буурсан ба дийлэнх нь баруун бүсийн болон говийн аймгуудын сум суурингийн хүн ам буурсан үзүүлэлттэй байна.

2.5.2.2. Орон нутгийн хөгжлийн индекс

“Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал”-ын дагуу 6 бүлэг 33 хүчин зүйлсээр тооцоологдсон индексийн дунжийг 1-5 хүртэлх баллын утгаар үнэлсэн. Тус баллын үнэлгээг хөгжлийн индекс доогуур, хөгжлийн индекс дундаж, хөгжлийн индекс дээгүүр гэж ангилан зураглав (Зураг.17).

Зураг. 3 Орон нутгийн хөгжлийн индексд харгалзах баллын үнэлгээний зураглал




Эх сурвалж: Судлаач

Орон нутгийн хөгжлийн индексийн баллын үнэлгээгээр хөгжлийн индекс дээгүүр 34 сум суурин, хөгжлийн индекс дундаж 169 сум, суурин, хөгжлийн индекс доогуур 127 сум, суурин байна.

2.5.3. Дэд бүтцийн суурь нөхцөлийн үнэлгээний үр дүн

Авто замын сүлжээ

Зураг. 4 Сум, суурингуудын улсын чанартай авто замын сүлжээнд холбогдсон байдал




Эх сурвалж: Судлаач

Улсын хэмжээнд тухайн сум, суурингийн нутаг дэсвгэрээр хатуу хучилттай зам дайран өнгөрсөн 129 сум суурин байна. Тэдгээрийн дийлэнх нь төвийн бүсэд байна. Харин УИХ-ын 2001 оны 9-р тогтоолоор батлагдсан “Мянганы зам” төслийн зорилгод тусгагдсан хатуу хучилттай авто зам барихаар төлөвлөгдсөн 54 сум суурин байна.

Төмөр замын сүлжээ

Зураг. 19 Сум, суурингуудын улсын чанартай төмөр замын сүлжээнд холбогдсон байдал



Эх сурвалж: Судлаач

Улсын хэмжээнд тухайн сум, суурингийн нутаг дэвсгэрээр төмөр замын сүлжээ дайран өнгөрсөн 43 сум, суурин байна.

Дэд бүтцийн үнэлгээнд авто болон төмөр замын сүлжээнд холбогдсон эсэхээр үнэлсэн. Хатуу хучилттай авто замд 129 (37.94%) сум суурин холбогдсон бол төлөвлөгдсөн 54 (15.88%) сум суурин, холбогдоогүй 153 (45%) сум, суурин тогтоогдсон. Төмөр замын сүлжээнд 43 сумд буюу нийт сумдын 12.64 % нь холбогдсон байна. Эдгээр хүчин зүйлсийн дундаж баллын үнэлгээ 3.04 буюу сум суурингууд дэд бүтцийн дундаж хөгжилтэй байна.

Байгалийн нөхцөлийн суурь үнэлгээ, нийгэм эдийн засгийн үнэлгээ болон дэд бүтцийн үнэлгээнүүдийн 15 хүчин зүйлийн жигнэсэн дундаж үнэлгээнд тулгуурлан бүлэг суурингийн төвийг тодорхойлов. Харин бүлэг суурингийн тогтолцоог тогтоохдоо дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн. Үүнд:

- Орон зайн, газарзүйн төвдөө ойр дөхөм байдал
- Байршлын хувьд бусад сумуудаас нийгэм, соёл ахуйн болон бизнесийн үйлчилгээг хүргэх боломжтой
- Зам харилцаа, дэд бүтцийн хангамжийн эх үүсвэрийг одоогийн байдал, цаашдын хандлагад тулгуурласан
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарь зэргийг харгалзан үзэв.

Монгол Улсын 21 аймгийн 330 сум, суурин газруудыг хамруулж байгалийн нөхцөлийн суурь үнэлгээ, нийгэм, эдийн засгийн суурь үнэлгээ болон дэд бүтцийн гэсэн 3 бүлэг суурь үнэлгээний 15 хүчин зүйлсээр сум суурин тус бүрийг үнэлсэн. Хүчин зүйлс бүрийн утгаас хамаарч 1-5 хүртэлх баллаар сум суурин тус бүрийг үнэлсэн. Эдгээр хүчин зүйлс бүр ижил жингээр нөлөөлөхгүй учир ач холбогдолоор нь АНР программ ашиглан эрэмбэлсэн.

Байгалийн нөхцөлийн суурь үнэлгээний баллын утга 1.66-4.66 хооронд гарсан ба энэ нь монгол орны нутаг дэвсгэрийн хойноос урагшлах тусам газрын өндөршил намсах, ургамалан бүрхэвч, ус зүйн нөхцөл, уур амьсгалын нөхцөл зэрэг нь харилцан адилгүй учраас сумдын үнэлгээний утга өөр хоорондоо ялгаатай үнэлэгдсэн.

Нийгэм эдийн засгийн суурь үнэлгээн дэх хүн амын хүчин зүйлийн тооцоогоор 2007-2018 оны хооронд хүн ам өсөлттэй 272 сум, хүн ам бууралттай 58 сум суурин илэрсэн ба -9%(-0.01%) хүртэл хүн ам буурсан ба дийлэнх нь баруун бүсийн болон говийн аймгуудын сум суурингийн хүн ам буурсан үзүүлэлттэй байна. Орон нутгийн хөгжлийн индексийн баллын үнэлгээгээр хөгжлийн индекс дээгүүр 34 сум суурин, хөгжлийн индекс дундаж 169 сум, суурин, хөгжлийн индекс доогуур 127 сум, суурин илэрсэн.

Дэд бүтцийн суурь үнэлгээнд авто болон төмөр замын сүлжээнд холбогдсон эсэхээр үнэлсэн. Хатуу хучилттай авто замд 129 (37.94%) сум суурин холбогдсон бол төлөвлөгдсөн 54 (15.88%) сум суурин, холбогдоогүй 153 (45%) сум, суурин тогтоогдсон. Төмөр замын сүлжээнд 43 сумд буюу нийт сумдын 12.64 % нь холбогдсон байна. Эдгээр хүчин зүйлсийн дундаж баллын үнэлгээ 3.04 буюу сум суурингууд дэд бүтцийн дундаж хөгжилтэй байна.

Шатлан эрэмбэлэх аналитик буюу АНР программаар тооцоолж үзэхэд нийгэм эдийн засгийн суурь үнэлгээ 0.3509 хувийн жингээр, дэд бүтцийн суурь үнэлгээ 0.3330 хувийн жингээр, байгалийн нөхцөлийн суурь үнэлгээ 0.3161 хувийн жингээр тус тус нөлөөлж байна.

Монгол Улсын хэмжээнд нийгэм эдийн засаг, байгалийн суурь нөхцөлийн болон дэд бүтцийн гэсэн 3 бүлэг суурь үнэлгээний 15 шалгуур хүчин зүйлсийн жигнэсэн дундаж баллын үнэлгээгээр 77 бүлэг суурингийн төв байх боломжтой байна.

Бүлэг суурины тогтолцооны хувьд замын анализ, зах зээлийн орон зайн нөлөөллийн байдал, засаг захиргааны хуваарь, бүсчилсэн хөгжлийн баримт бичгүүд зэргийг харгалзан үзэж тэдгээр төвүүдэд татагдах сум суурингуудыг тогтоов. Нийт 77 бүлэг суурингийн тогтолцоо байх санал оруулсан ба үүнээс нийслэл, бүсийн тулгуур төв хот, аймгийн төв хотын 22, сум дундын 55 бүлэг суурингийн тогтолцоо байхаар санал болгосон. Бүлэг суурингийн төвүүд нь өөрт татагдах сум, суурингуудын хамтаар хоршин хөгжих боломжтой гэсэн таамаглалыг дэвшүүлж байна. Бүлэг суурингуудын тогтолцооны харилцан хамаарлыг судалснаар бичил бүс, дэд бүс бий болгох боломжтой гэж үзэж байна.

Аливаа төлөвлөлтийн нутаг дэвсгэрийг дэд бүс, бичил бүс, бүлэг суурингийн тогтолцоонд хуваах нь орон зайн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бүс нутгийн хөгжлийг төлөвлөхөд илүү ач холбогдолтой болох нь бидний судалгааны үр дүнгээр илэрхийлэгдэж байна. Цаашид бичил бүс, бүлэг суурингуудад тодорхой чиг үүрэг бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний кластеруудыг төлөвлөж хөгжүүлэх боломж судалгааны үр дүнгээр илэрч байна.

Аливаа бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг судалгааны ажилд оновчтой, үндэслэлтэй хүчин зүйлсүүдийг тогтоон боловсруулж байх шаардлагатай байна.

2.6. Говийн дэд бүсийн бичил бүс, бүлэг суурингийн төв тогтоох

2.6.1. Говийн дэд бүсийн бичил бүс, бүлэг суурингийн төв тогтоосон судалгааны ажлууд

Хүн амд үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулах, хөрөнгө оруулалтыг жигд хуваарилах, хөдөөгийн иргэд орон нутагтаа амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол улсын засаг захиргааны нутаг дэвсгэрийн хуваарийг бүлэг суурингийн тогтолцоонд тулгуурлан тодорхой үе шаттайгаар шийдвэрлэх боломжтой гэж зарим судлаачид үздэг.

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан, бүсчлэлийн схемийг эргэн харж, эдийн засгийн макро бүс нутгуудын дотоод бүсчлэлийг нарийвчлан тогтоох үндсэн дээр дэд ба бичил бүс, бүлэг суурин, хот суурингийн чиг үүрэг, үйлдвэр аж ахуйн төрөлжилт, хөгжлийн бодлогыг тодорхойлох төлөвлөлт, судалгаа шинжилгээний ажил хийгдэх шаардлага урган гарч байна (Базарханд, Ц., 2015).

1996 онд Дэд бүтцийн хөгжлийн яам зураг төсөл судалгааны үндэсний төвд боловсруулсан Монгол улсын хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төсөлд говийн 4 аймгийг 12 бүлэг суурингийн төвтэй, тэдгээр бүлэг суурин бүрт татагдах сум, суурин газруудыг тодорхойлсон ба тэдгээр суурингуудын чиг үүргийн ялгааг авч үзсэн байдаг (Хүснэгт 5).


Хүснэгт 6. Говийн дэд бүсийн бүлэг суурингийн тогтолцоо

№	Бүлэг суурингийн төвийн нэр	Хот суурингийн нэр	Хот суурингийн ангилал	Хот суурингийн үүргийн ялгаа
1	САЙНШАНД	Сайншанд	Аймгийн төв	Засаг захиргаа, үйлдвэр, тээвэр, соёлын төв
		Алтанширээ	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Дэлгэрэх	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Өргөн	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Эрдэнэ	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
2	ЧОЙР	Чойр	Орон нутгийн хот	Засаг захиргаа, тээвэр, хөнгөн хүнс
		Шивээговь	Хоторхуу тосгон	Эрчим хүч, уул уурхай, тээвэр
		Айраг	Хоторхуу тосгон	Эрчим хүч, уул уурхай, тээвэр
		Халзан-Уул	Хоторхуу тосгон	Аялал жуулчлал, амралт сувилал
		Даланжаргалан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Өндөршил	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Баянжаргалан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Говь-Угтаал	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Цагаандэлгэр	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
3	ЦАГААНСУВАРГА	Цагаансуварга	Орон нутгийн хот	Засаг захиргаа, эрчим хүч, уул уурхай
		Сайхандулаан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

		Мандах	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
4	ЗҮҮНБАЯН	Зүүнбаян	Орон нутгийн хот	Засаг захиргаа, эрчим хүч, уул уурхай
		Улаанбадрах	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
5	ХӨВСГӨЛ	Хөвсгөл	Хөдөөгийн тосгон	Орон нутгийн төв
		Хатанбулаг	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
6	ЗАМЫН-ҮҮД	Замын-Үүд	Хоторхуу тосгон	Засаг захиргаа, тээвэр
7	ДАЛАНЗАДГАД	Даланзадгад	Аймгийн төв	Засаг захиргаа, үйлдвэр, соёлын төв
		Цогт-Овоо	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Номгон	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Хүрмэн	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Баяндалай	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Булган	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Мандал-Овоо	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Ханхонгор	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
8	СЭВРЭЙ	Сэврэй	Хөдөөгийн тосгон	Орон нутгийн төв
		Гурвантэс	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Ноён	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
9	ТАВАНТОЛГОЙ	Тавантолгой	Орон нутгийн хот	Засаг захиргаа, эрчим хүч, уул уурхай
		Цогтцэций	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Манлай	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Ханбогд	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Баян-овоо	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
10	МАНДАЛГОВЬ	Мандалговь	Аймгийн төв	Засаг захиргаа, үйлдвэр, соёлын төв
		Тэвшийн говь	Хоторхуу тосгон	Эрчим хүч, уул уурхай
		Дэлгэрцогт	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Адаацаг	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Сайнцагаан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Дэрэн	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Гурвансайхан	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Хулд	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Луус	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл


11	ЭРДЭНЭДАЛАЙ	Эрдэнэдалай	Хөдөөгийн тосгон	Орон нутгийн хот
		Дэлгэрхангай	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
		Сайхан-Овоо	Хөдөөгийн тосгон	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
12	ӨЛЗИЙТ	Өлзийт	Хөдөөгийн тосгон	Орон нутгийн хот

Зураг 20. Говийн дэд бүсийн бичил бүс



Эх сурвалж: Монгол улсын хүн амын нутагшил суурьшлын төсөл. 1996.

Ц.Базарханд “Нийслэлийн бүс нутгийн орон зайн төлөвлөлтийн асуудал” судалгааны ажилдаа төвийн бүсийн дэд бүс, дотоод бүсчлэлийг тодорхойлсон байдаг.



Зураг 21. (Базарханд, Ц., 2015). Төвийн бүсийн бичил бүс


Тус бүтээлдээ судлаач бүс нутгийн хөгжлийн эдийн засгийн газар зүйн шинэ хандлагад хамаарах бүс нутаг төлөвлөлтийн аналогийг загварыг дэвшүүлсэн ба уг загварт эдийн засгийн бүс нь дотоод буюу дэд бүстэй байх бөгөөд төв бүс, хязгаар бүсүүдэд мезо түвшинд хуваагдана. Бүс бүр бүлэг суурингийн тогтолцоотой байх бөгөөд гол тэнхлэгийн дагуу орших суурин газар нь бүсийн аль нэг эрэмбийн төвүүд байна. Өөрөөр хэлбэл дэд бүс бүр нь бүсийн төвтэй байх ба төв, дэд бүсийн төв болох суурин газар нь эдийн засгийн бүсийн төв болж бусад бүс, дэд бүс, суурин газруудыг холбосон тэнхлэгийн дагуу байрших нь зүйтэй. Шинээр дэвшүүлж буй аналогийг загвар нь тэнхлэг, төв, хязгаар гэх үндсэн 3 хүчин зүйлийг харгалзсаны зэрэгцээ макро, мезо түвшиний бүсчлэлийг авч үзсэн цаашид микро бүсүүдийг тогтоон хөгжүүлэх боломжийг олгоно гэж үзсэн байна.

Бүс нутгийн бүлэг суурингийн тогтолцоог тодорхойлсны үндсэн дээр, байгалийн нөхцөл нөөц, газар ашиглалтын байдал, үйлдвэр, уурхайн байрлал, дэд бүтцийн тэнхлэгийг харгалзан төвийн бүсийн 3 дэд бүсийг тогтоосон. Төвийн бүсийн дотоод бүсүүдийг тогтоохдоо байгалийн нөхцөл, нөөц, орон зайн хамаарлыг чухалчлан авч үзээд бүсийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөрт дурдагдсан хөгжлийн чиг хандлагыг харгалзсан үзсэн.

Дэд бүс тус бүрт үйлдвэрлэл аж ахуйн төрөлжилт бүхий бичил бүсчлэл тогтоох санал дэвшүүлсэн байна. Бичил бүс тогтоосноор оронзайн зохион байгуулалт хийхэд нутаг дэвсгэрийн онцлог ялгаа, байгаль, аж ахуйн нөхцөл нөөц, хот суурингийн чиг үүрэг зэргийг төлөвлөлтөнд харгалзах боломжийг нэмэгдүүлэхээс гадна бичил бүс бүлэг сууринг тодорхой чиг үүрэгтэйгээр төлөвлөн хөгжүүлэх боломжтой болно. Өөрөөр хэлбэл, үндсэн бүсийн төлөвлөлтөнд тусгагдаагүй арга хэмжээ, харгалзаагүй нутаг дэвсгэр, орон зайн нөхцөл нөөцийн ялгаат байдлыг дэд бүсийн түвшинд, дэд бүсийн түвшинд хийгдээгүй ажлуудыг бичил бүсийн түвшинд төлөвлөн оронзайн зохион байгуулалтыг авч үзэж төлөвлөлтийг хэрэгжүүлнэ. Дэд бүс, бичил бүсийн төлөвлөлтийн зорилго зорилт нь бүсийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилттой бүрэн нийцэж байх албагүй ч тэдгээрийн тодорхой хэсгүүдийг шийдвэрлэх шаардлагатай. Тиймээс бүсийн дотоод бүс, түүний доторх бичил бүсүүд нь төлөвлөлтийн нэгжийн үүрэг гүйцэтгэх, бүлэг суурингууд, тэдгээрийн багтаасан засаг захиргааны нэгж сумын хамт бүс нутаг төлөвлөлтийн хамгийн бага нэгж болно. Эдгээр зорилго, зорилтод тулгуурлан нийгэм, эдийн засаг орон зайн зохион байгуулалтын дүн шилжилгээний үр дүнд үндэслэн төвийн бүсийн нутаг дэвсгэрийн нэгдсэн схемийг доорх байдалтай боловсруулжээ. Төвийн бүс нь 3 Дэд бүс, 16 бичил бүсийн хэмжээнд нутаг дэвсгэрийн системийг авч үзсэн. Уг судалгааны ажилд Говийн дэд бүс нь Говийн уул уурхай, аж үйлдвэр, байгаль хамгааллын дэд бүс гэж тодорхойлогдсон ба дотор нь Мандалговийн засаг захиргааны төвийн бичил бүс, Сайншандын засаг захиргаа, аж үйлдвэрийн бичил бүс, Оюутолгойн зам тээврийн зангилаа, уурхайн хот орчмын бичил бүс, Даланзадгадын засаг захиргаа, зам тээврийн бичил бүс, Чойрын зам тээврийн зангилаа, засаг захиргааны бичил бүс, Цагаан суваргын зам тээврийн зангилаа, уурхайн хот орчмын бичил бүс, Цогтцэций зам тээврийн зангилаа, Тавантолгойн уурхай орчмын бичил бүс, Гурвантэсийн зам тээврийн зангилаа, нүүрс олборлох үйлдвэрлэлийн бичил бүс, Замын-Үүдийн олон усны чөлөөт худалдааны бүс гэсэн 9 бичил бүсэд хувааж, тухайн бичил бүрт татагдах сум, суурин газруудыг тодорхойлсон байна.

2.6.2. Говийн дэд бүсийн хот суурингийн эрэмбэ, бичил бүс, бүлэг суурингийн төв тогтоох

Говийн дэд бүсэд бичил бүс, бүлэг суурингийн төвийг байгалийн нөхцөлийн суурь үнэлгээ, нийгэм эдийн засгийн суурь нөхцөлийн үнэлгээ, дэд бүтцийн нөхцөлийн суурь үнэлгээ гэсэн 3 бүлэг, 43 хүчин зүйлээр эрэмбэлэн шинжилж үзэхэд Говийн дэд бүс нь II эрэмбийн 7 төв буюу бичил бүсийн төв, III эрэмбийн 14 төв буюу бүлэг суурингийн төв байхаар байна (Зураг 16).



Зураг 22 Говийн бичил бүсийн төв, бүлэг суурингууд
Эх сурвалж: Зохиогчид


Хүснэгт 7. Говийн бичил бүсийн төв, бүлэг суурингууд

№	II эрэмбийн төвийн нэр	III эрэмбийн төвийн нэр	Хот суурингийн нэр	Хот суурингийн чиг үүрэг
1	Чойр	Баянтал	Баянтал	Засаг захиргаа, тээвэр, логистик
		Шивээговь	Шивээговь	
2	Сайншанд	Айраг	Айраг	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, тээвэр, логистик
			Даланжаргалан	
			Иххэт	
	Өргөн	Алтанширээ	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	
		Дэлгэрэх		
	Мандах	Өргөн	Уул уурхай, хөдөө аж ахуй	
		Мандах		
		Сайхандулаан		
3	Замын-Үүд	Эрдэнэ	Хатанбулаг	тээвэр, логистик, уул уурхай
			Хөвсгөл	
			Эрдэнэ	
4	Мандалговь	Дэлгэрцогт	Улаанбадрах	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
			Адаацаг	
			Дэрэн	
			Дэлгэрцогт	
			Цагаандэлгэр	
	Эрдэнэдалай	Сайхан-Овоо	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	
		Дэлгэрхангай		
		Эрдэнэдалай		
	Луус	Луус	Хулд	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
			Өлзийт	
Луус				

		Гурвансайхан	Гурвансайхан	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	
			Говь-Угтаал		
			Баян		
			Өндөршил		
5	Даланзадгад	Ханхонгор	Цогт-Овоо	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	
			Ханхонгор		
			Булган		
			Мандал-Овоо		
			Гурвантэс	Гурвантэс	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, уул уурхай
				Ноён	
				Сэврэй	
				Хүрмэн	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
			Баяндалай		
			Номгон		
6	Ханбогд	Баян-Овоо	Баян-Овоо	Уул уурхайн үйлдвэрлэл	
7	Цогтцэций	Манлай	Манлай	Уул уурхайн үйлдвэрлэл	

Эх сурвалж: Зохиогчид

2.7 Говийн дэд бүс дэх үйлдвэрүүдийн байршил



Зураг 23. Говийн дэд бүс дэх үйлдвэрүүдийн байршил, ангиллаар

Говийн дэд бүсэд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн байршлыг орон зайд зураглалаа.


- Хөнгөн үйлдвэр-65
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр-26
- Хүнд үйлдвэр-3 үйлдвэр тус тус байна.

БҮЛЭГ III. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг ба бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал

3.1. Эдийн засгийн бодлого ба бүсчилсэн хөгжлийн бодлогын хамаарал

Өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн түүхэн үеийг туулахдаа баримталж ирсэн болон цаашид баримтлах эдийн засаг, нийгмийн философи түүнээс урган гарсан горизонталь ба салбарын бодлогуудын харилцан хамаарал, эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин, цаашид зорих чиг хандлага зэрэг асуудал нь Монгол Улсын эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэхэд гол чиглүүлэх үүрэгтэй болно.

Зураг 2. Бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал ба эдийн засаг, нийгмийн бодлогын хамаарал



Төрөөс эдийн засгийн ямар бодлого баримтлахаас хамааран бүс нутгуудын тэгш бус байдлын шалтгаан, бүс нутгийн хөгжилд төр захиргааны оролцоо, бүс нутгийн хөгжлийн бодлогын хэлбэр ямар байж болохыг Неолиберал ба Пост-Кейнсийн эдийн засгийн бодлогын жишээгээр доор (Хүснэгт.4) үзүүлэв.

Хүснэгт 8. Бүс нутгийн хөгжил ба эдийн засгийн бодлогын хамаарал

Үзүүлэлт	Неолиберал эдийн засгийн бодлого	Пост-Кейнсийн эдийн засгийн бодлого
Бүс нутгийн тэгш бус байдлын шалтгаан	уналт, үр ашиг багатай, микро-эдийн засагт оролцогчдын нийгмийн болон эдийн засгийн уян хатан байдал сул байх	гадаад (дэлхийн эдийн засгийн мөчлөг) дотоод (бүтцийн, хөрөнгийн гэх мэт)
Оролцооны арга	Зонхилон зах зээлийн эдийн засгийн арга, хэрэгслээр	зах зээлийн эдийн засгийн ба улс орны дахин хуваарилалтын арга хэрэгслийг хослуулан ашиглах
Бүс нутгийн хөгжлийн бодлогын хэлбэр	сонгон татаас олгох, орон нутгийн чөлөөт зах зээлийн хэлбэрийг хөгжүүлэх (аж ахуйн нэгжүүд, хөгжлийн агентлагууд); орон нутгийн түвшин дэх эдийн засгийн өрсөлдөөн, орон нутгийн түвшин дэх хувийн ба нийгмийн үүрэг хариуцлагыг хөгжүүлэх	өргөн хүрээтэй улсын татаас, бүс нутгийн агентлагууд, орон нутгийн засаг захиргаанаас өргөн хүрээнд оролцдог.

Монгол Улсын эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд дараах асуудлуудыг тодруулан үзэх шаардлага тулгарч байна. Үүнд

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин цаашид зорих чиг хандлага
2. Өнгөрсөн хугацаанд баримталж ирсэн болон цаашид баримтлах эдийн засаг, нийгмийн философи, идеологи
3. Эдийн засаг нийгмийн горизонталь ба салбарын бодлогуудын харилцан хамаарал, нийцэл, цаашид хийгдэх өөрчлөлт эдгээр болно.

3.2. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн судалгаа

Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн ерөнхий аргазүй, үзэл баримтлал боловсруулахад дараах бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, тэдгээрийн үзэл баримтлал гол үндэслэл болно.

- Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий Ассемблейн чуулганаар 2015 онд батлагдсан “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030”
- Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”
- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”

- Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал”
- Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”
- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”

Хүснэгт 9. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд

Д/Д	Баримт бичгийн нэрс	Холбогдох заалт
1	НҮБ-ийн Ерөнхий ассемблейн чуулганаар 2015 онд батлагдсан “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030”	<ul style="list-style-type: none"> • Зорилт 11.3. 2030 он гэхэд бүх улс орнуудад хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах • Зорилт 11.4. Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах • Зорилт 11.5. 2030 он гэхэд нас барсан болон байгалийн гамшигт өртсөн хүмүүсийн тоог үлэмж хэмжээгээр бууруулж, ядуу болон эмзэг бүлгийн хүн амыг голлон анхаарч байгалийн гамшиг, түүний дотор устай холбоотой гамшгийн улмаас ДНБ-тай харьцуулсан эдийн засгийн алдагдлыг [x] хувиар бууруулах • Зорилт 11.a. Үндэсний болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах замаар хот, хагас суурин газар, хөдөө орон нутгийн хооронд эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр дүнтэй уялдаа холбоо дэмжих • Зорилт 11.b. 2020 он гэхэд бүх талын оролцоог хангах, хөрөнгө баялгийг үр ашигтай ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, төлөвлөгөө батлан хэрэгжүүлдэг хот, хүн амын суурьшлын тоог [x] хувиар нэмэгдүүлж, удахгүй гарах Хөгогийн үйл ажиллагааны баримт бичигтэй уялдуулан бүх түвшинд гамшгийн эрсдэлийн цогц менежментийг боловсруулж, хэрэгжүүлэх • Зорилт 11.c. Орон нутгийн материалыг ашиглан даац сайтай, гамшгийн үед тэсвэртэй, эдийн засгийн хэмнэлттэй барилга байгууламж барихад санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэх замаар нэн буурай хөгжилтэй орнуудыг дэмжих
3	Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”	<ul style="list-style-type: none"> • 4.7.5. хүн амын нутагшил, хот байгуулалтын хүрээнд: • 4.7.5.a. бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх агуулгаар "Хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг"-ыг боловсруулж, шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх; • 4.7.5.б. бүс нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, хүн амын тоо, түүх, соёлын уламжлал, хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх хүрээ зэргийг

		<p>харгалзан Монгол Улсын хот, тосгоны зохистой хэмжээ, бүтцийн загварыг боловсруулж, хот, тосгоныг үе шаттайгаар сэргээн хөгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> • 4.7.5.в. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэх шаардлагын дагуу бүсийн төв болгон хөгжүүлэх хотуудын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; • 4.7.5.г. Улаанбаатарын болон бусад бүсийн хэмжээнд Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрлийг задлах зохистой чиглэл, хотын оршин суугчдын амьдрах орчны чанар, аюулгүй байдлыг хангах, хотын газрыг үр ашигтай ашиглах, инженерийн шугам сүлжээ, замын байгууламжийг шинэчлэх шаардлагыг бодолцон нийслэл хотын хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын хүч чармайлтыг нэгтгэн зохион байгуулах; • 4.7.5.д. эрх зүй, эдийн засаг, нийгэм сэтгэл зүйн зохих нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Монгол Улсын нийслэлийг Улаанбаатар хотоос тус улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт шилжүүлэн байршуулах асуудлыг иж бүрнээр судалж 2020 он хүртлэх хугацаанд шийдвэрлэх; • 4.7.5.е. улсын хэмжээнд эдийн засгийн бүсчлэл, хот байгуулалтын стратегийн удирдлага, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, нутаг дэвсгэр зохион байгуулалтын товчоод байгуулах ажлыг дэмжих;
4	<p>Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”</p>	<ul style="list-style-type: none"> • Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн томоохон нэгж байгуулах, концесс олгох, дэд бүтэц шинээр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлэх төсөл, арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ. • монгол орны байгаль, түүх, соёлын өв санд түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх, үйлчилгээг нь олон улсын түвшинд хүргэх, олон улсын сүлжээнд хамрагдах, соёлын бүтээгдэхүүнийг гадаадад борлуулахад дэмжлэг үзүүлэх • гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцөлийг олох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөл бүрдүүлэх; • "Ногоон", "Цэнхэр" эдийн засгийг хөгжүүлэх, уул уурхайн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад дэмжлэг үзүүлэх; • Үндэсний хөгжилд нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг хөгжингүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг

		<p>боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p>
5	<p>Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх • Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлж, хүн амын 90-ээс доошгүй хувийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангаж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг 60-аас доошгүй хувьд хүргэх • Банк, санхүүгийн байгууллагын байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгож, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх; • Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх; • Хот, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт хийж, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах; • Улаанбаатар хот болон бусад хот сууриныг дахин төлөвлөж эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 15 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх; • Үр ашигтай, хэмнэлтэй технологийг дэмжих, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хаягдлыг бууруулах зохистой менежментийг төлөвшүүлж, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувь бууруулах; • Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, найдвартай, эрсдэлгүй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, иргэд тав тухтай зорчих орчныг бүрдүүлэх
6	<p>Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030”</p>	<ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна. • Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна. • Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100 хувьд хүргэж, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ. • Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно. • Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно.

		<ul style="list-style-type: none"> • Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно. • Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна. • Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэх • Жилд 100.0 мянган тонн ган туйван, барилгын болон төмөр замын металл хийц үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулах. • Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана. • Тээвэр логистикийн шинэ төвүүдийг хөгжүүлж, улсын болон олон улсын чанартай авто замын уртыг 470 км-ээр нэмэгдүүлж, бүсүүдийн төмөр замыг барьж дуусгах. • Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. • Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах. • Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг хот, суурин газруудад хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 25 хувиар бууруулах • Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, олон улсын стандартад нийцсэн эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлсэн хот, суурин газруудыг хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 40 хувиар бууруулах • Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкны бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ.
--	--	--

		<ul style="list-style-type: none"> • Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй болгох. • Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх.
7	Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”	<ul style="list-style-type: none"> • Хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсээр иргэдээ хангах; • Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, хүнс экспортологч орон болох; • Бүс нутаг, хөрш орнуудтай эдийн засгийн интеграцид нэгдэх замаар гадаад худалдааны шинэчлэл хийж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих худалдааны сүлжээг бий болгох; • Аялал жуулчлалын дэд бүтэц, өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, тухайн орон нутгийн онцлогт тулгуурласан иргэдийн оролцоотой тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх • Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн нэгдсэн тээвэр, логистик, дэд бүтцийг хөгжүүлж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлэх. • Эдийн засгийг бүсчилж хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого хэрэгжүүлэх • Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж, хүн амд эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх; • Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот, суурин газрын хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах • Жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацаргана үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр хангаж, экспортын орлогыг нэмэгдүүлэх • Аж үйлдвэрийн салбарыг борлуулалтаар дэмжих тээвэр, логистикийн сүлжээг байгуулах ажлыг эхлүүлэх • Импортыг орлох барилгын материалын үйлдвэрийг бодлогоор дэмжих; • Эрэлт хэрэгцээг харгалзан барилгын материалын логистикийн сүлжээг үндэсний хэмжээнд төлөвлөж, цементийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах; • Зочид буудал, хоол үйлдвэрлэлийн салбар дахь эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэрлэгээний нэгдсэн үйлдвэрийг хүн ам ихтэй хот, суурин газарт байгуулахыг дэмжих • Төв, суурин газарт нийтийн хоолны үйлдвэрийн цогцолбор байгуулахыг бодлогоор дэмжих; • Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх • Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хөдөө аж ахуй, түргэн тусламжийн

		<p>үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглах;</p> <ul style="list-style-type: none"> • Хот байгуулалт, дэд бүтэц, барилга бүтээн байгуулалтын тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх; • Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хот байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх; • Хот, суурин газрын хог хаягдлыг цуглуулах, ангилах, боловсруулах, дахин ашиглах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор байгаль орчинд ээлтэй арга, технологи, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулал, татаасын бодлогоор дэмжих; • Орон нутгийн хөгжлийн загварт тулгуурласан нийгмийн үйлчилгээний жишиг нормативыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй болгох, нийгмийн үйлчилгээний болон үйлдвэрлэл, бизнесийн барилга байгууламжийн нэг маягийн загвар зураг, түүний урсгал зардлын тооцоог төсвийн төлөвлөлтөд нэвтрүүлэх;
--	--	---

3.3. Говийн дэд бүсийн хөгжлийн концепцид тусгах санал

Бүс нутгийн хөгжлийн чиг хандлагын санал

1) Зорилго. Бүс нутгийн хөгжлийн үндсэн зорилго нь МУ-ын өсөлт хөгжлийг тогтвортой хөгжлийн замд хөглөх, тэнцвэртэй хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэгш бус байдал, байгаль орчны доройтлыг саармагжуулахад чиглэнэ.

Бүсчилсэн хөгжлийн гол зорилтууд:

1. Говийн дэд бүс нутаг нь МУ-ын эрдэс баялгийн болон хүнд үйлдвэрийн хөгжлийг залах, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татсан зангилаа бүс нутаг болохын зэрэгцээ хил залгаа бүсийн эдийн засаг, соёл, байгаль орчны асуудлуудад чухал үүрэг гүйцэтгэнэ.

2. Говийн дэд бүс нутаг нь МУ хийгээд Төвийн бүс нутгийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, уламжлалт соёл, орчин үеийн техник, технологид суурилсан, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, өндөр чанартай хүний нөөцийг бүрдүүлэхэд тэргүүлэх байр суурь эзэлнэ.

3. Говийн дэд бүс дэх аймаг, хот суурингийн хөгжлийн бодлогыг уялдуулах, бүсийн хөгжлийн төвүүдийг хөгжүүлэх үндсэн дээр нийслэлийн хүн ам ба нийгэм эдийн засгийн хэт төвлөрлийн ачааг үүрэлцэх, бусад орон нутгуудтай үр дүнтэй хамтран ажиллаж, бүс нутгийн тэнцвэрт өсөлтийг хангана.

2) Санал болгож буй стратеги

1. НУТАГШИЛ, СУУРЫШЛЫН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛСЭН БҮС НУТАГ
2. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, РЕКРЕАЦИ - АЯЛАЛЫГ ЗОХИСТОЙ ХОСЛУУЛСАН БҮС НУТАГ
3. ХҮН АМЫН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН НАЙДВАРТАЙ ОРОН ЗАЙ БҮРДҮҮЛСЭН БҮС НУТАГ
4. ШИНЭ ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИД СУУРИЛСАН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖҮҮЛСЭН БҮС НУТАГ
5. САЙН ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН БҮС НУТАГ

1. НУТАГШИЛ, СУУРЫШЛЫН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛСЭН БҮС НУТАГ зорилтын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлж байна.

1. Говийн дэд бүсийн хот суурингууд, бүлэг суурингийн эдийн засаг, нийгэм, соёл ахуйн, орон зайн бүтэцлэг тогтолцоог бүрдүүлэх замаар бичил бүсүүдийн эдийн засаг, нийгмийн тулгуур төвүүдийн хөгжлийг дэмжих,
2. Бүсийн хүрээнд зам тээвэр, холбоо, эрчим хүч зэрэг инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамжийг сайжруулах, дээд зэрэглэлийн тээвэрлэлт / логистикийн коридорыг бий болгох
3. Хот тосгод, бичил бүсийн тулгуур төвүүдийн үүрэг бүтэц, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бичил бүсүүдийн төрөлжилтөнд тулгуурлан бүсийн хэмжээний интеграци, нийгэм, эдийн засгийн чиг, үүргийг тодорхойлох

2. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, РЕКРЕАЦИ - АЯЛАЛЫГ ЗОХИСТОЙ ХОСЛУУЛСАН БҮС НУТАГ зорилтын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлж байна.

1. Бүс нутгийн хүрээ дэх улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт рекреаци-аялал жуулчлалын нөөцийг харгалзан олон улс, улс, орон нутгийн чанартай аялал жуулчлалын бүс, “хүний эрүүл мэнд, соёл ба экологийн ач холбогдол бүхий олон зориулалтат коридор” хөгжүүлэх
2. Аялал-рекреацийн бүс, “хүний эрүүл мэнд, соёл ба экологийн ач холбогдол бүхий олон зориулалтат коридор” байгуулах ажлыг улс үндэстний хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалт, хот байгуулалт, бүс, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө болон байгаль хамгаалал, түүх, соёл-биеийн тамир, спортын зэрэг салбарын төлөвлөгөө, ОНБ-ын төсөл хөтөлбөртэй нягт уялдуулах
3. Бүс нутаг ба орон нутгаас гарч буй хөгжлийн төлөвлөгөө, тодорхой үүсгэл санаачилга бүхий төсөл, хөтөлбөрүүдийг төр засгийн газраас дэмжих, аялал-рекреацийн бүс, “хүний эрүүл мэнд, соёл ба экологийн ач холбогдол бүхий олон зориулалтат коридор” байгуулж, хэрэгжүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах институцийн тогтолцоо, менементийн системийг бүрдүүлэх.

3. ХҮН АМЫН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН НАЙДВАРТАЙ ОРОН ЗАЙ БҮРДҮҮЛСЭН БҮС НУТАГ

1. Мах, сүү, төмс хүнсний ногоо, үр тариа зэрэг хүнсний тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний хангалтын байдал, тэдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн орон зайн бүтцийг төгөлдөржүүлэх үндсэн дээр бүс нутгийн хүнсний найдвартай орон зай бүрэлдүүлэх,
2. Эрчимжсэн мал аж ахуй, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, боловсруулалт, дахин боловсруулалт, түгээлтийн орон зайн конвьерчилсон бүтэцлэг, тогтолцоог бүрдүүлэх,
3. Бичил бүсийн төвүүдэд хүнс, хөнгөн үйлдвэрийн газруудыг байгуулах, агро үйлдвэрлэлийн цогцолборуудыг хөгжүүлэх асуудлыг бодлогоор дэмжих

4. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИД СУУРИЛСАН ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ БҮС НУТАГ зорилтын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлж байна.

1. Тэргүүний технологи, инновацид суурилсан үйлдвэрлэлийг, үйлдвэр технологийн парк хэлбэрээр зохион байгуулж хөгжүүлэх

2. Үйлчилгээний салбарт ухаалаг системийг эрчимтэйгээр нэвтрүүлж, хотын амьдралын хэв маяг болгох

3. Ашигт малтмал, байгалийн нөөцийг хуулийн хүрээнд ашиглах, хариуцлагатай уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих, шат дараалан боловсруулах, үйлдвэрлэл технологийн кластеруудыг хөгжүүлэх

5. САЙН ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНТОЙ ХОТ зорилтын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлж байна.

1. Бүсийн зохицуулах механизмыг бий болгох, орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх, Бүс нутгийн зохицуулах зөвлөлийг байгуулах

2. Бүс нутгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг нэгтгэх, нэг төвийн зохицуулалтыг бий болгох

3. Бүс нутгийн төлөвлөлтийн мэдээллийн сан, мэдээллийн системийг бий болгох

4. Хот, бүс нутгийн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх, байнгын ажилгаатай байгууллагуудыг бий болгох эдгээр болно.

Тайлбар	
№	Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгах бодлогын санал
1	2
Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгах бодлогын санал	
Зорилго. Бүс нутгийн хөгжлийн үндсэн зорилго нь МУ-ын өсөлт хөгжлийг тогтвортой хөгжлийн замд хөглөх, тэнцвэртэй хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэгш бус байдал, байгаль орчны доройтлыг саармагжуулахад чиглэнэ.	
	Өмнийн говийн хот суурингууд, бүлэг суурингийн эдийн засаг, нийгэм, соёл ахуйн, орон зайн бүтэцлэг тогтолцоог бүрдүүлэх замаар бичил бүсүүдийн эдийн засаг, нийгмийн тулгуур төвүүдийн хөгжлийг дэмжих,
1	Бүсийн хүрээнд зам тээвэр, холбоо, эрчим хүч зэрэг инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамжийг сайжруулах, дээд зэрэглэлийн тээвэрлэлт / логистикийн коридорыг бий болгох
	Хот тосгод, бичил бүсийн тулгуур төвүүдийн үүрэг бүтэц, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бичил бүсүүдийн төрөлжилтөнд тулгуурлан бүсийн хэмжээний интеграци, нийгэм, эдийн засгийн чиг, үүргийг тодорхойлох
2	Бүс нутгийн хүрээ дэх улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт рекреаци-аялал жуулчлалын нөөцийг харгалзан олон улс, улс, орон нутгийн чанартай аялал жуулчлалын бүс, “хүний эрүүл мэнд, соёл ба экологийн ач холбогдол бүхий олон зориулалтат коридор” хөгжүүлэх
	БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, РЕКРЕАЦИ - АЯЛАЛЫГ ЗОХИСТОЙ

	ХОСЛУУЛСАН БҮС НУТАГ	Аялал-рекреацийн бүс, “хүний эрүүл мэнд, соёл ба экологийн ач холбогдол бүхий олон зориулалтат коридор” байгуулах ажлыг улс үндэстний хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалт, хот байгуулалт, бүс, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө болон байгаль хамгаалал, түүх, соёл-биеийн тамир, спортын зэрэг салбарын төлөвлөгөө, ОНБ-ын төсөл хөгөлбөртэй нягт уялдуулах
3	ХҮН АМЫН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН НАЙДВАРТАЙ ОРОН ЗАЙ БҮРДҮҮЛСЭН БҮС НУТАГ	Мах, сүү, төмс хүнсний ногоо, үр тариа зэрэг хүнсний тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний хангалтын байдал, тэдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн орон зайн бүтцийг төгөлдөржүүлэх үндсэн дээр бүс нутгийн хүнсний найдвартай орон зай бүрэлдүүлэх, Эрчимжсэн мал аж ахуй, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, боловруулалт, дахин боловсруулалт, түгээлгийн орон зайн конвьерчилсон бүтээлцлэг, тогтолцоог бүрдүүлэх, Бичил бүсийн төвүүдэд хүнс, хөнгөн үйлдвэрийн газруудыг байгуулах, агро үйлдвэрлэлийн цогцолборуудыг хөгжүүлэх асуудлыг бодлогоор дэмжих
4	ДЭВШИЛГЭТ ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИД СУУРИЛСАН ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ БҮС НУТАГ	Тэргүүний технологи, инновацид суурилсан үйлдвэрлэлийг, үйлдвэр технологийн парк хэлбэрээр зохион байгуулж хөгжүүлэх Үйлчилгээний салбарт ухаалаг системийг эрчимтэйгээр нэвтрүүлж, хотын амьдралын хэв маяг болгох Ашигт малтмал, байгалийн нөөцийг хуулийн хүрээнд ашиглах, хариуцлагагай уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих, шаг дараалан боловруулах, үйлдвэрлэл технологийн кластеруудыг хөгжүүлэх Бүсийн зохицуулах механизмыг бий болгох, орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх, Бүс нутгийн зохицуулах зөвлөлийг байгуулах
5	САЙН ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНТОЙ ХОТ	Бүс нутгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг нэгтгэх, нэг төвийн зохицуулалтыг бий болгох Бүс нутгийн төлөвлөлтийн мэдээллийн сан, мэдээллийн системийг бий болгох Хот, бүс нутгийн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх, байнгын ажиллагаатай байгууллагуулыг бий болгох

		"ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА"	
		"ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГАА"	
№	Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгах бодлогын санал	Тайлбар	
1	2	3	
Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгах санал			
Зорилго. Аймгуудын хөгжлийн хөтөлбөрийг бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн зорилтуудад нийцүүлэн боловсруулах.			
1	ГОВИЙН ДЭД БҮСИЙГ БИЧИЛ БҮС, БҮЛЭГ СУУРИНЫ ТОГТОЛЦОО ХЭЛБЭРЭЭР ХӨГЖҮҮЛЭХ	<p>Өмнийн говийн хот суурингууд, бүлэг суурингийн эдийн засаг, нийгэм, соёл ахуйн, орон зайн бүтэцлэг тогтолцоог бүрдүүлэх замаар бичил бүсүүдийн эдийн засаг, нийгмийн тулгуур төвүүдийн хөгжлийг дэмжих. Хот тосгод, бичил бүсийн тулгуур төвүүдийн үүрэг бүтэц, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бичил бүсүүдийн төрөлжилтөнд тулгуурлан бүсийн хэмжээний интеграци, нийгэм, эдийн засгийн чиг, үүргийг тодорхойлох</p>	

2	<p>ГОВИЙН ДЭД БҮС ДЭХ АЙМАГ, ХОТ СУУРИНГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ УЯЛДУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ</p>	<p>Говийн дэд бүс дэх аймаг, хот суурингийн хөгжлийн бодлогыг уялдуулах, бүсийн хөгжлийн төвүүдийг хөгжүүлэх үндсэн дээр нийслэлийн хүн ам ба нийгэм эдийн засгийн хэг төвлөрлийн ачааг үүрэлцэх, бусад орон нутгуудтай үр дүнтэй хамтран ажиллаж бүс нутгийн тэнцвэрт өсөлтийг хангах.</p>
<p align="center">"ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА"</p>		
<p align="center">"ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГАА"</p>		
№	<p>Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгах бодлогын санал</p>	<p align="center">Тайлбар</p>
1	2	3
<p align="center">УИХ-д хандсан бодлогын санал</p>		

<p>Зорилго. Бүс нутгийн хөгжлийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бүсийн хөгжлийн хөтөлбөр болон аймгуудын хөгжлийн хөтөлбөр зэрэг баримт бичгүүдийн эрхзүйн чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.</p>	<p>Бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжих боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх үүднээс</p> <p>УИХ, ЗГ болох төрийн шийдвэр гаргах дээд байгууллагаар тогтоол гаргуулж бүсийн хөгжлийн хөтөлбөрийн эрхзүйн чадамжийг дээшлүүлэх.</p>
<p>1</p> <p>Бүсийн хөгжлийн хөтөлбөрийн эрхзүйн чадамжийг нэмэгдүүлэх</p>	

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээрх ашигласан материалын жагсаалт

Батбуян Б. “ Монгол улсын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарийг оновчтой болгох газарзүйн асуудалд “ 2000. УБ.

Батхишиг. Б., “Монгол орныг бүсчлэн хөгжүүлэх арга зүйн зарим асуудал” 1999. УБ.

Базарханд. Ц. Чинбат. Б. Мягмарцэрэн . П. “Улаанбаатар бүсийн орон зайн төлөвлөлтийн асуудал” Нэг сэдэвт бүтээл, 2016. УБ

Газарзүй-Геоэкологийн хүрээлэн “Монгол орны газарзүйн асуудал” 2015. УБ.

Гунгаадаш, Б. “БНМАУ-ын эдийн засгийн төв муж” 1967. УБ.

Галбадрах, С. “ Бүс нутгийн хөгжлийн удирдлагын асуудалд “УБ.

Дааш. Д. “Монгол орны ландшафт-экологийн асуудлууд” 2015. УБ.

Дааш.Д, Монгол орны физик газарзүйн судалгааны тойм, 2002, УБ.

Жигж. С., Монгол орны хотгор гүдгэрийн үндсэн шинж, 1975, УБ.

Нацагдорж, Л., Монгол орны уур амьсгал, 2017, УБ.

Ринчинбазар, Р. “ Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд “УБ.

Ринчинбазар, Р. “Монгол орны бүс нутгийн хөгжлийн эдийн засгийн математик загварчлалын асуудал” 2006. УБ.

Сүхбаатар, О. “БНМАУ-ын хүн амын газарзүйн зарим асуудлууд” 1971. УБ.

Санжмятав. З. “Монгол орны байгалийн газарзүй” 2007. УБ.

Цэгмид,Ш. Монгол орны физик газарзүй, 1969, УБ.

Чинбат Б. Заяа Ч. Базарханд Ц. Цахиур С. Рэгзмаа Ч. Нарангэрэл Г. “Хот ба бүс нутаг” 2018. УБ.

ШУА-ийн Газарзүйн хүрээлэн, Ерөнхий редактор Д.Доржготов, Монгол Улсын Үндэсний Атлас, 2009, УБ.

Шагдар. Ш, Монголын Газарзүйн нэрийн товч толь бичиг, 2007, УБ.

Англи хэлээрх ашигласан материалын жагсаалт

Bachtler J. Downes R. Regional police in the transition countries : A comparative assessment . European Planning studies . Dec 1999.

John. G, Tim. M, Regional planning 2007. USA

Эрх зүйн баримт бичиг

“ Монгол орны бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” 2001.

“Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр” 2005.

“Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги” УИХ-ын тогтоол

“Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай”
2007 УИХ-ын тогтоол

“Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал” 2017

Интернет дэх эх сурвалж

<https://marine.rutgers.edu/~cfree/gis-data/mongolia-gis-data/industry4.nda.gov.mn/geoportal/index.php>

<http://1212.mn> “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”

<http://nda.gov.mn> “Засгийн газрын тохируулагч агентлаг, Үндэсний хөгжлийн газар



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

**ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН
ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ ЭЦСИЙН ТАЙЛАН

Улаанбаатар 2019

Энэхүү тайланд захиалагч болон санхүүжүүлэгчийн байр суурийг биш, харин судлаачийн байр суурийг илэрхийлсэн болно.

Зөвлөхийн овог нэр:

Түдэвийн Энэбиш

Албан тушаал:

Монголын Бүсчилсэн хөгжлийг дэмжих нийгэмлэгийн дэд тэргүүн

Байгууллагын байршил, хаяг: ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн Хүрээлэн

УБ 211238, Баруун Сэлбэ 15, Утас: 11-325487, 11-325680, Факс: 976-321862

Email: enebish_reg@yahoo.com

АГУУЛГА

1. СУДАЛГААНЫ ХҮРЭЭ, ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ.....	4
2. ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ.....	6
3. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ҮНЭЛГЭЭ	8
4. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	18
4.1. Бодлого боловсруулах арга загвар, зарчмыг сонгох.....	18
4.2. Хөтөлбөрийн хүрээнд авч үзэх боломжтой хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд.....	20
4.3. Хөтөлбөрийн бүтэц, хэрэгжүүлэх үе шат, арга хэмжээг тодорхойлох нь.....	23
4.4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	23
4.5. Хөтөлбөрийн санхүүжилт	24
4.6. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт /2040 оноор баримжаалахад/	24
5. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ.....	26
Говийн дэд бүсийг Төвийн бүсийн хөгжлийн бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэх санал.....	26
ГДБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн үндэслэл – бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн талаарх ерөнхий дүгнэлт	26
ГДБ-ийн хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж, саналууд	27
Хөтөлбөрийн үзэл баримтлалыг удирдлагын түвшинд хэрэгжүүлэх санал, зөвлөмж.....	30
Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	32
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	34
ХАВСРАЛТ 1. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЛОГИК - БҮТЭЦ	35
ХАВСРАЛТ 2. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН БҮРДЭЛ ХЭСГҮҮД, УЯЛДАА, МАТРИЦ.....	36
ХАВСРАЛТ 3. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ГАРСАН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН БАРИМТ БИЧГҮҮД.....	37
ХАВСРАЛТ 4. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТ БИЧГҮҮД /БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭГ ТУСГАСАН/	37
ХАВСРАЛТ 5. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАГВАР /ЗГ-ЫН 2005 ОНЫ ТОГТООЛООР БАТЛАГДСАНААР/	39
ХАВСРАЛТ 6. ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ҮНДЭСНИЙ, БҮСИЙН, АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ХАМТРАН АЖИЛЛАХ АСУУДЛУУД (“ОЮУТОЛГОЙ” ХХК-ИЙН ЖИШЭЭГЭЭР) ..	39

1. СУДАЛГААНЫ ХҮРЭЭ, ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Судалгааны хүрээ. Энэхүү судалгаанд бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт, Говийн дэд бүсийн хөгжлийн одоогийн байдал, Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулалтыг үндэсний, Төвийн бүсийн, дэд бүсийн түвшинд авч үзсэн.

Судалгааны зорилго, зорилтууд. Энэхүү судалгаагаар Говийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн оршил хэсэг, түүнийг боловсруулах үзэл бодлын үндсийг бүрдүүлэхийг зорьсон болно. Учир нь судалгааны гол хэсэг болсон “Үзэл баримтлал” (англиар “concept”) буюу “төсөөлөн бодох” гэсэн үг)-ыг аливаа үзэгдэл юмс, үйл явцын хөдлөл, хөгжлийн чиг хандлагыг урьдаас төсөөлж, түүнийг ирээдүйн зөв дүр төрх, төлөв байдал руу нь чиглүүлэх алсын хараа, “стратегийн” маягаар ойлгож байгаа юм. Энэхүү зорилго, ойлголтын хүрээнд дор дурдсан тодорхой зорилтуудыг тавьж хөтөлбөрт тусгуулахыг хичээсэн. Үүнд:

- 1.) Говийн дөрвөн аймгийг нийгэм, эдийн засгийн бие даасан “дэд бүс”-ийн жишгээр хөгжүүлэх шаардлагын үндсийг тодорхойлох;
- 2.) Говийн дэд бүсийн хөгжлийн гарааны нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг тоймлон харуулах (СВОТ шинжилгээгээр);
- 3.) Хөтөлбөрийн бүрдэл хэсгүүд (салбарын болон аймаг, орон нутгийн гол зорилт, арга хэмжээ)-ийн хоорондын уялдааг хангаж, цаашид энэ бүсэд бүс нутгийн хөгжлийн нэгдмэл систем үүсэх үзэл санаа, баримтлалыг тодорхойлох;
- 4.) Дээрх гол үзэл санаа, баримтлалыг хэрэгжүүлэх “хөгжлийн тэргүүлэх чиглэл”-ийн төслүүдийг төсөөлж, хөтөлбөрт тусгуулах;
- 5.) Тэргүүлэх чиглэлийн төслүүдийн хүрээнд говийн бүсийн аймгууд, тэдгээрийн Төвийн бүс болон Улаанбаатарын бүстэй холбох салбар хоорондын, аймаг, бүс нутаг хоорондын аж ахуйн хоршилт, төрөлжилтийг бий болгох арга зам, чиглэлийг тоймлох;
- 6.) Хөтөлбөрийн салбар дундын, аймаг дундын нийтлэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр буй болох эдийн засгийн өсөлт, таталцлын төвүүд (үйлдвэрлэл – технологийн парк, кластер, аялал жуулчлал, соёлын бүс нутгууд, бүлэг суурингууд г.м хэлбэрээр)-ийг төсөөлөн зураглах;

Энэхүү “үзэл баримтлал”-ыг хөтөлбөрт тусгаснаар дараах асуудалд зохих хариулт авах болно гэж үзэж байна. Үүнд:

- Ойрын ирээдүйд ямар зүйлийг чиг баримжаа болгох, ямар асуудалд голлон анхаарах;
- Ямар хүчин зүйл голлох нөлөөлөх, ямар саад бэрхшээл тохиолдох;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ямар үр дүн, хэдийд гарч болох;
- Хөтөлбөрийг ямар арга механизм, зохион байгуулалтаар хэрэгжүүлэх;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар байгууллага хамтарч оролцох, хэн ямар үүрэг, хариуцлага хүлээх г.м;

Говийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлогын үндсэн гурван хувилбарыг санал болгосон бөгөөд тэдгээрийг тухайн үеийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс хамааруулан сонгон авах буюу хослон хэрэгжүүлж болох талтайг үзэл баримтлалын төсөлд санал болгосон.

Дээр дурдсан зүйлсийг тусгасан “үзэл баримтлал”-ыг оруулж өгснөөр “Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр” энэ удаа (урьд нь янз бүрийн түвшин, хэмжээнд тодорхойлогдож байсан)-д илүү үр дүнтэй хэрэгжих боломжтой юм. Хөтөлбөр ба үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зөвлөмж, авах арга хэмжээг төлөвлөж өгсөн нь хэрэгжилтэд бас нааштай нөлөөлнө гэж үзсэн.

Судалгааны арга зүй. Судалгаанд “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”, журамд тусгасан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлого тодорхойлох нөхцөл байдлын дүн шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн заалтуудыг үндэс болгов. Бодлогын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх, үзэл баримтлалын төсөл боловсруулахад салбар дундын, бүс хоорондын болон удирдлагын түвшингүүдийн хоорондын уялдааг хэрхэн хангасан ба хангах арга зүйн хандлага, зарчмыг баримталсан. Үүнд:

- Говийн бүсийн аймгуудын хөгжлийн түвшин, гарааны нөхцөл байдалд шинжилгээ хийх;
- Говийн бүсийг цаашид бие даасан дэд бүсийн жишгээр хөгжүүлэх стратегийг гол зорилго болгох. Ингэхдээ, Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангах, Говийн бүсийн бүрдэл хэсгүүдийн тогтвортой байдал, тэнцлийг хангах, Улаанбаатарын төвлөрлийг сааруулах шаардлагыг харгалзах;
- Говийн дэд бүсийн хөгжлийн төлөв, төр, иргэн, аж ахуйн нэгж, ТББ-ын хамтын ажиллагаа, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын харилцан түншлэлийг дэмжиж өргөжүүлэх;
- Говийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэх, түүнийг тодотгон сайжруулахад оролцогч талуудын зөвшилцөл, зохион байгуулалтыг тодорхойлох;

Хөтөлбөрийн гарааны нөхцөлийг үнэлэх, үзэл баримтлалыг тодорхойлоход дор дурдсан үндсэн хоёр аргыг хэрэглэсэн. Үүнд:

- 1.) Шинжлэх ухаан – танин мэдэхүйн ерөнхий арга (баримт бичгийн судалгаа, хэрэгжилтийн үр дүнгийн хяналт – шинжилгээ, мэдээ баримтыг тайлбарлах, үнэлэлт өгөх);
- 2.) Хөгжлийн үзэл баримтлалыг босгох логик – бүтцийн схемийг зураглах, түүний бүрдэл хэсгүүдийн дэс дараалал, хоорондын уялдаа, гарах үр дүнг системчлэх матриц;

Эдгээрийн үндсэн дээр хөгжлийн хөтөлбөрт үзэл баримтлалын хэсэг (оршил) байх үндсэн зорилго ба бүтэц нь хөтөлбөрийн хүрээнд тус бүсэд байгаа нөөц, чадавхийг улс орон, аймаг, бүс нутаг, аж ахуйн салбарын нийтлэг эрэлт, хэрэгцээ, дотоод, гадаад орчны хувьсал өөрчлөлттэй уялдуулж, нэгэн цогц бодлого болгож өгөхөд оршино гэж үзсэн (хавсралт 1, 2 схемийг үзэх).

2. ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Говийн дэд бүс (цаашид “ГДБ” гэх) нь байгалийн олон төрлийн эрдсийн баялаг, түүх, соёлын өв, палентологийн нөөц чадавх ихтэй, Ази, Европын орнуудыг холбосон авто ба төмөр замын улсын гол тэнхлэгийн дагуу буюу түүнд татагдсан тээвэр – газарзүйн байрлал сайтай дэвсгэр нутгийг хамарч байгаа юм. ГДБ хөгжлийн олон давуу талтай, үүний дотор:

- 1.) дотоод, гадаад зах зээлд харьцангуй үр өгөөжтэй ашиглах түлш /нүүрс, газрын тос, занар/ эрчим хүчний их нөөц;
- 2.) иж бүрэн боловсруулах боломжтой байгалийн эрдсийн баялгийн үлэмж нөөц;
- 3.) Оюутолгой, Тавантолгойн ордод түшиглэн бий болж буй уул уурхайн үйлдвэрлэлийн болон дэд бүтцийн чадавх, ажиллах хүчний сургалт, мэдлэг, дадлага;
- 4.) мал аж ахуйн түүхий эдийг үйлдвэрлэлийн аргаар иж бүрэн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн дотоод, гадаад зах зээлд нийлүүлэх боломж;
- 5.) түүх, соёлын өв, байгалийн өвөрмөц тогтоц, палентологийн ховор олдворыг түшиглэн улс хоорондын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж,
- 6.) Ази, Европыг холбосон тээвийн гол тэнхлэг, БНХАУ, түүгээр дамжин Номхон далайн бүсийн орнуудтай холбогдон далайг ашиглах боломж бүхий эдийн засаг газарзүйн тохиромжтой байрлал;
- 7.) Замын - Үүдийн боомтод түшиглэн бий болсон буюу шинээр үүсэж буй улс хоорондын худалдаа, хил, гаалийн үйлчилгээний туршлага, тээвэр логистикийн үйл ажиллагаа зэргийг оруулж байна.

Үүний зэрэгцээ энэ бүс нутгийн аймаг, орон нутгийн хөгжлийн өнөөгийн түвшний хоцрогдол, байгаль экологийн нэн эмзэг байдал, усны нөөцийн хомсдол болон мэргэшилтэй ажиллах хүчнээр хангахтай голлон холбогдсон дор дурдсан саад, бэрхшээлийг хөгжлийн хөтөлбөрт зайлшгүй харгалзан, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох хэрэгтэй байгаа юм. Үүнд:

- 1.) Өмнөговийн бусад аймаг, сумдад хүн амын ажил эрхлэлт, хөдөлмөрийн бүтээмж ихээхэн доогуур;
- 2.) энэ бүсэд хүн ам олноор амьдран суурьших сонирхолыг татсан хот, тосгон /капитал барилга, байгууламж бүхий/ хөгжөөгүй, ажиллах хүч бэлтгэж, мэргэшүүлэх тогтолцоо бүрдээгүй;
- 3.) Говийн аймгуудын хооронд болон Төвийн бүсийн бусад хэсэгтэй хоршсон эдийн засгийн тогтвортой хоршилт холбоо хөгжөөгүй;
- 4.) Эрдсийн баялгийн ашиглалт, боловсруулалтын түвшин /байгаа чадавхтай нь харьцуулахад/ үр өгөөж доогуур, Өмнөговийн бусад бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл бага;
- 5.) Байгалийн баялгийн ашиглах, хамгаалахад аймаг, орон нутгийн иргэд, ААНБ, үндэсний том компаниудын хамтын оролцоо сул, Засгийн газрын бодит дэмжлэг зохицуулалт дутагдалтай байгаа;
- 6.) ГДБ-ийн аймаг, сумдын хооронд болон гол тэнхлэгтэй холбосон зам тээвэр, эрчим хүчний нэгдсэн систем бүрдээгүй. Төвийн бүсийн бусад хэсэг, Монгол, Хятад хоёр улсын хил, гаалийн гарцуудын хооронд түүхий эд, бараа, бүтээгдэхүүнийг солилцох зах зээлийн зөөлөн дэд бүтэц /банк, санхүү, мэдээлэл холбоо/ нийлүүлэлтийн зохистой сүлжээ хөгжөөгүй;
- 7.) Замын - Үүдэд чөлөөт бүсийг үр ашигтай хөгжүүлэх шаардлагатай дэд бүтэц өнөө хир бүрдээгүй, гэрээ, хэлцэл хийгдээгүй, БНХАУ-ын Эрэн хотод 2017 онд чөлөөт бүс нээснээр энэ асуудал бүрхэг, тодорхойгүй болсон;
- 8.) Өмнөговийн бусад аймаг, орон нутгийн хүн амын аж байдлын түвшин доогуур, ядуурал ихсэж байгаа;

9.) ГДБ-д хамрагдаж байгаа бараг бүх газар нутагт цөлжилт, улс дамнасан хүчтэй шороон шуурганы нөлөө идэвхжсэн, гадаргын усны нөөц, хуримтлуурын сан байхгүй, эрдсийн томоохон ордуудыг урт хугацаанд ашиглах, хот суурин байгуулах газрын доорх усны нөөц хүрэлцээгүй, бусад бүс нутгаас ус татаж, ашиглах зохистой хувилбар, ТЭЗҮ-ийг одоогоор эцэслэн сонгож, тогтоогүй байгаа зэрэг олон шалтгаан байна.

Эдгээрээс зарим гол гэж үзсэн бэрхшээлийг шийдвэрлэх боломж, арга замыг жишээ болгон доор авч үзлээ. Үүнд:

Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:

	Асуудал	Нөлөөлж буй хүчин зүйлс	Шийдвэрлэх арга зам	Үр дүн
1	Цөлжилт	- Хуурайшилт - Тоосжилт - Усны хомсдол - Хариуцлагагүй уул уурхай	- Орхон голоос говийн бүс рүү ус дамжуулах хоолой татаж, усан сан, цөөрмүүд байгуулах	- Цөлжилтийг багасгана - Байгаль орчныг сэргээнэ - Газар тариалан мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжинэ
2	Байгаль орчны бохирдол	- Хүний буруутай үйл ажиллагаа - Хариуцлагагүй уул уурхай	- Уул уурхайг дэс дараалалтай ашиглах - Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх - Нөхөн сэргээх - Мод тарих	- Хүн амьдрахад таатай орчин бүрдэнэ - Экологийн тэнцвэрт байдал хадгалагдана
3	Хүн ам сийрэг	- Төрөлт багассан - Шилжих хөдөлгөөн	- Нутгийн хишиг олгох - Говийн нэмэгдэл олгох - Хүн амын өсөлтийг дэмжих - Бүс нутгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх	- Хүн амын тоо өснө - Ажиллах хүч нэмэгдэж, үйлдвэрлэл хөгжино
4	Орлогын тэгш бус байдал	- Хууль эрх зүй - Монополь орчин	- Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бий болгох - Хууль эрх зүйн орчинг сайжруулах	- Иргэдийн амьжиргаанд эерэг нөлөөлнө
5	Боловсон хүчний хомсдол	- Их дээд сургууль байхгүй - Шилжих хөдөлгөөн их	- Бүс нутгийн тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх - Их дээд сургууль байгуулах - Залуу боловсон хүчний ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх	- Мэргэжлийн ажиллах хүчин нэмэгдэнэ

3. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ҮНЭЛГЭЭ

Сангийн яам, Дэлхийн банк, Үндэсний статистикийн хороо, Үндэсний хөгжлийн газраас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хийсэн Монгол Улсын макро эдийн засгийн өсөлтийн төсөөллөөс үндэслэн ГДБ-ийг хөгжүүлэх үндэсний бодлогыг хэрэгжүүлсэнээр ДНБ энэ бүсэд 2017 онтой харьцуулахад 2003 онд (Оюутолгойн зэс боловсруулах үйлдвэр, Тавантолгойн нүүрс цэвэршүүлэх үйлдвэр ба эрчим хүч, Дундговийн Тэвшийн говийн эрчим хүчний үйлдвэр, Дорноговийн Алтанширээний газрын тос боловсруулах үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүдийг ашиглалтанд оруулснаар) 10 гаруй хувиар өсч, цаашид 2030 он хүртэл жил бүр 10 – 15 хувиар өсөх боломжтой гэж төсөөллөө. Ингэснээр ГДБ нь энэ хугацаанд улсын эдийн засгийн өсөлтийн 15-аас (2023 он) 30 хувийг хангах юм.

Дэд бүсийн ДНБ-ий дээр төсөөлж буй өсөлтийн хурдыг хангахын тулд бүс нутгийн хөдөлмөрийн бүтээмжийг 2020 оноос цааш улсын дундажаас дээгүүр байхаар нэмэгдүүлэх шаардлагатай болно. Хөдөлмөрийн бүтээмжийн энэхүү харьцангуй өндөр өсөлтийг хангах нь байгалийн эрдсийн баялаг, мал аж ахуйн түүхий эдийг ашиглаж буй үйлдвэрүүдэд орчин үеийн өндөр бүтээмжтэй техник технологи нэвтрүүлэх, олборлолт, анхан шатны боловсруулалтын ажиллагааг механикжуулах, үйлдвэрлэлийн үндсэн болон, туслах, үйлчлэх үйл ажиллагааны бүтээмжийг нийтэд нь сайжруулахыг шаардах болно. Мөн нүүрс, зэс зэрэг эрдсийн баялгийг дан ганц олборлох аргаар буюу байгалийн түүхий эд байдлаар нь гадаадад гаргаж байгааг аль болох багасгаж, 2020 оноос цаашид боловсруулалт хийж, ДНБ-д эзлэх үйлдвэрлэсэн капитал болон нийгмийн цэвэр орлого /хүний болон удирдлагын чадавхиар бүтээгдсэн/-ыг нэмэгдүүлэх боломжийг бий болгоход анхаарах хэрэгтэй болно. Цаашид үйлдвэрлэсэн жинхэнэ орлогыг тооцохдоо ч хөрс хуулалт, тээвэрлэлтээс үүссэн агаар орчны бохирдол, хөрсний эвдрэлийн хохиролыг тооцож, байгалийн баялгийг үр өгөөжтэй ашиглуулах менежмент, марктенгийг ААНБ-ын үйл ажиллагаанд тэдгээрийн урт хугацааны зорилтот түвшин болгон хэрэгжүүлэхийг төрийн зохицуулалтын нэг гол чиглэл гэж үзэж байна.

ГДБ -ийн үйлдвэрлэлийн нийгмийн бүтээмж, орлогыг ингэж нэмэгдүүлснээр энэ бүс нутгийн төдийгүй тус улсын нийт хүн амын мөнгөн орлого, хуримтлалыг өсгөх боломжтой гэж төсөөлж байна. Энэ бүс нутгийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх нийлбэр үзүүлэлтийн нэг нь хүн амын дундаж наслалт улсын дундажтай харьцуулахад өндөр /хамгийн өндөр нь Дундговь аймаг – 2017 онд 73,8, улсын дундаж -69,8/ буюу амьдралын үргэлжлэх хугацаа 2-оос 3 жилээр урт байгаа явдал юм. Төлөвлөлтийн хугацаанд бүс нутгийн нийт аймгийн нийгэм, соёл, ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, тоосжилт, ундны усны чанар, хүнс тэжээлээс хамаарсан өвчлөлтийг багасгаж чадвал хүн амын дундаж наслалтыг 2025 онд 78, 2030 онд 80-д хүргэж, улсын дундажаас илүү буюу хөгжингүй орнуудын дундаж түвшинд ойртуулах боломжтой болно.

ГДБ-ийг эрчимтэй хөгжүүлэхэд шаардлагаар уугуул хүн ам, ялангуяа хүүхэд залуучуудыг ажиллуулж, мэргэшүүлэх, Төвийн бүсийн бусад аймаг, хотоос ирж буй ажиллах хүчийг тогтвор, суурьшилтай ажиллуулахын тулд 2020 онд 2017 онтой харьцуулахад ажлын байрыг 1.5 дахин, тохилог орон сууцны хангамжийг 20%-иар нэмэгдүүлж, 2030 он хүртэл жил бүр тогтвортой нэмэгдүүлэхээр тооцож байна. Үүний тулд аймгийн төвүүд, тээврийн зангилаа, хилийн боомтуудын хот нийтийн ахуй үйлчилгээний дэд бүтцийг шинэчлэх байгуулах, уул уурхайн томоохон орд газар, тэдгээрийн ойролцоох сууринг тохижуулж, түр сууцуудыг байнгын тохилог орон сууцаар эрэмбэ дараатай солиход оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. 2025 он хүртэлх эхний үе шатанд энэ асуудлыг шийдэх үндсэн чиглэл болгон орон нутгийн элс шохойн чулуу, бий болсон цементийн үйлдвэрлэлийн хүч чадлыг ашиглан дээр дурдсан газруудад инженерийн төвлөрсөн систем бүхий 4-өөс 5 давахар тохижсон нийтийн сууцуудыг барьж ашиглах төсөөллийг хийж байна.

Эрх зүйн орчин:

ГДБ –ийг хөгжүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулахад одоо хүчин төгөлдөр байгаа эрхзүйн дор дурдсан үндсэн баримт бичгүүдийг үндэслэл болгон ашиглалаа. Үүнд:

- 1.) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал;
- 2.) УИХ-аас 2003 оны 5сарын 30-нд баталсан “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль”;
- 3.) УИХ-ын 2015 оны 2-р сарын 12 нд баталсан “Чөлөөт бүсийн тухай хууль”;
- 4.) Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор засгийн газраас баталсан/ 2018 оны 42 дугаар тогтоол/ “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”;
- 5.) УИХ-ын, Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулах тухай 2007 оны 02-р сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоол;
- 6.) Монгол Улс, ОХУ, БНХАУ –ын төрийн тэргүүн нарын 2016 оны 06.23-нд Узбекистаны Ташкентийн уулзалтын үеэр үзэглэсэн Ази, Европыг холбосон гурван улсын “Эдийн засгийн хамтарсан коридор байгуулах хөтөлбөр”;
- 7.) “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль / УИХ-ын 2015 оны 11-р сарын 26-ны өдөр/, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас баталсан /2016 оны 249-р тогтоол/ “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- 8.) Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичиг.

Бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилт:

Өмнөт говийн дэд бүсийн талаар урт хугацааны бодлого боловсруулах ажил цаг хугацаа алдаж, хэрэгжилт хангалтгүй болох дор дурдсан сорилттой тулгарч болзошгүй байна. Үүнд:

1.) хүмүүсийн харилцан ойлголцол, хамтын ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд их цаг хугацаа шаардах говийн аймаг, алслагдсан сумдын хөгжлийн түвшин доогуур, хүмүүсийн зах зээлд өрсөлдөн амьдрах сонирхол, чадвар сул; энэ хутагт ажиллаж байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн харилцан ойлголцол, дэмжлэг хангалтгүй байгаа г.м;

2.) тус улсын эдийн засаг, нийгмийн хүдрэл, бэрхшээлтэй холбоотой энэ бүсийг хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх хөрөнгө санхүүгийн дэмжлэг сул, харин ч ашигт малтмал, бусад баялгийг ашиглуулснаас авах орлогыг нэмэгдүүлэх эрэлт ихтэй байгаа;

3.) хөдөө аж ахуй, бусад салбарын хөгжил доогуур байгаагаас аймаг орон нутгийн уул уурхайгаас хамаарсан байдал нилээд урт хугацаанд үргэлжилж болзошгүй;

4.) бодит амьдрал дээр үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж, өндөр мэргэшлийн бүтээлч ажиллах хүч бэлтгэн түүхий эдийг гүн боловсруулж, өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргахад олон жил шаардагдаж байгаа;

5.) энэ бүсийн нийт аймагт усны нөөц хомсдолтой, чанар хангалтгүй байгаа, бүтээн байгуулалтыг цаашид өргөжүүлэхэд хэрэгцээтэй усны хэрэгцээг дотроос нь болон бусад нутгаас шийдэхээр яригдаж байгаа төслүүд урьдчилсан хайгуул, үнэлгээний шатанд байгаа бөгөөд тэдгээрийг сонгож, зохистой хэрэгжүүлэхэд их урт хугацаа, хөрөнгө мөнгө шаардах төлөвтэй байгаа;

6.) уул уурхайн олборлолт, уур амьсгалын дулаарал, усны хомсдолоос шалтгаалан говь нутгийн байгаль орчин доройтож, түүнийг нөхөн сэргээхэд улам их хөрөнгө хүч шаардагдаж байгаа. Ялангуяа цөлжилт гүнзгийрч, шороон шуурганы давтамж, хамрах хүрээ тэлж, усны чанар, хомсдолтой нэгдээд хүн ам эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжийг цаашид хязгаарласаар байна;

7.) Говийн дэд бүсийн хөгжилд цаашид зайлшгүй харгалзаж байх нэг томоохон сорилт бол олон улсын зах зээл дэх уул уурхайн түүхий эдийн үнийн болзошгүй хэлбэлзэл юм. Экспортын

гол бүтээгдэхүүн нүүрс, зэс, түүхий ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ цаашид буурах хандлагатай байгаа бөгөөд эдгээрийг экспортлогч гол орон Хятад улс аль болох түүхийгээр нь хямд авах сонирхолтой байгаа нөхцөлд манай улсын эдийн засаг, төсөв, иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа юм. Иймд, энэ бүс нутгийн гол салбар уул уурхайн үйлдвэрлэлээс орж ирэх орлогыг тухайн аймаг, орон нутаг, нийт улсын хэрэгцээнд хэрхэн зохистой хуваарьлаж, ухаалаг зарцуулах вэ гэдэг сорилт тулгарч байна.

Эдгээр сорилтоос үүдээд энэ бүс нутгийн хөгжлийн асуудлаар Засгийн газар, аймаг, орон нутаг, дотоод, гадаадын бусад төрөлжсөн байгууллага, компаниудын зүгээс боловсруулж, дэвшүүлж ирсэн олон чухал хөтөлбөр, төслүүд, тэдгээрт тусгагдсан аймаг дундын салбар хоорондын ач холбогдолтой үйлдвэр барих, усжуулах, дэд бүтэц байгуулах томоохон арга хэмжээнүүд цаг тухайдаа хэрэгжиж чадаагүй, тулгамдсан асуудал болон хуримтлагдаж ирсэн байна.

**ГОВИЙН ДЭД БҮСИЙН АЙМГУУДЫН ХӨГЖЛИЙН АСУУДЛЫГ ТУСГАСАН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛГИЙН БАРИМТ БИЧГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛБАР**

Баримт бичгийн нэр	Батлагдсан газар, огноо (хэрэгжих хугацаа/ мэдээллийн эх сурвалж	Говийн дэд бүсийн хөгжлийн асуудлыг тусгасан байдал Бодлого ба байршил заагдсан, эсэх	Хөгжүүлэх гол салбар, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”/ТХҮБ/-тай нийцэл
I. Үндэсний хэмжээний бодлого			
1. Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого /ҮХЦБ/	<p align="center">I.</p> <p>УИХ –ын 2008 оны 12-р тогтоол /2007-2015, 2016 – 2021 он/ 5.4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого https://www.legalinfo.mn/</p>	<p>Бүс нутаг, дэд бүтцийг хөгжүүлж, хот, хөдөөгийн ялгааг багасгах нийтлэг бодлого. Байршил заагдсан арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> - говийн болон зүүн бүсэд төмөр замын сүлжээг өргөтгөх; - говийн бүсийн цахилгаан хангамжийн бодлогыг тодорхойлж, ойрын жилүүдэд баригдах Оюутолгой, Тавантолгой, Цагаансуварга болон бусад уул уурхайн үйлдвэрүүдийн эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг бий болгох; -Тавантолгойн коксжих нүүрсний ордыг түшиглэн нүүрс боловсруулах, нүүрс-химийн судалгааны лаборатори, төв байгуулж ажиллуулах 	<ul style="list-style-type: none"> - экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн өндөр технологий мэдээлэл, харилцаа, био, нанотехнологи, транзит тээвэр, логистик, санхүүгийн зуучлалын үйлчилгээ - уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг гүн боловсруулахад суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ - стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг байгаль орчинд хал багатай ашиглан хуримтлал бий болгох - ТХҮБ-д нийцүүлэн шинэчлэн тодорхойлох

		<p>-Чойр-Нялгын нүүрсний сав газарт түлш, эрчим хүч, нүүрс-химийн цоцолбор байгуулах;</p> <p>-Замын-үүд эдийн засаг, худалдааны чөлөөт бүс, томоохон орд газрыг түшиглэн дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн хот, тосгодыг бий болгох;</p> <p>-Төвийн болон Улаанбаатарын бүсийн 2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;</p>	
<p>2. Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал /БХҮБ/</p>	<p>УИХ-ын 2001 оны 57-р тогтоол /2001 - 2020 он/ https://www.legalinfo.mn/</p>	<p>Төвийн бүсэд: Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийг хамааруулж, хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уг хуваарийг уян хаган өөрчилж байна</p>	<p>-Эдийн засгийн бүсүүдэд аж ахуйн дараахь салбарыг нийтлэг байдлаар хөгжүүлнэ: мал аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэр, ул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, барилга, барилгын материалын үйлдвэр, оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, амралт, рашаан сувилах, үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээний дэд бүтцийн салбарууд, зах зээлийн дэд бүтцийн бүрдэл хэсгүүд. ТХҮБ-тай үндсэндээ нийцэж байгаа.</p>
<p>3. Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги</p>	<p>УИХ-ын 2003 оны 24-р тогтоол /2010 он хүртэл/ https://www.legalinfo.mn/</p>	<p>Төвийн бүс түүний дотор говийн аймгуудыг эдийн засаг, нийгэм соёлын уялдаа, хоршилтыг хөгжүүлэх зорилт тавьсан боловч хэрэгжиж чадаагүй. Уг баримт бичгийн хэрэгжих хугацаа дууссан</p>	

4. МУ -д эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал	УИХ-ын 1995 оны 87-р тогтоол https://www.legalinfo.mn/	Дорноговь аймгийн Замын үүдэд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зорилт тусгагдсан	ТХҮБ-д нэр зааж тусгагдаагүй
5. Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	Төсөл /2018 он/ “Газар дэлхий” ХХК	Говийн бүсийн аймгуудын газар зохион байгуулалтын бүтэц, зураглал, бүсчлэлийн асуудлууд тусгагдсан	ТХҮБ, БХҮБ-д нийцүүлэн баглуулж, мөрдүүлэх
6. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогын судалгааны тайлан, материалууд	ҮХГ /2018 – 2019 он/ http://industry4.nda.gov.mn/	17 салбар, чиглэлээр хийгдсэн тайлан судалгаанд одоо байгаа болон цаашид хэрэгжүүлэх боломжтой төсөл арга хэмжээ байршил болон бүсчлэлээр заагдаж, тусгагдсан.	Цаашид бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинэчлэн тодорхойлох үед ТХҮБ, БХҮБ –тай уялдуулах
II. Бүсийн хэмжээний бодлого			
1. Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр	ЗГ-ын 2005 оны 202-р тогтоол /2006 – 2015 он/ https://www.legalinfo.mn/	Говийн 4 аймгийг төвийн бүсийн бусад аймаг, УБ-тай хоршин хөгжүүлэх цогц бодлого арга хэмжээг тодорхойлсон боловч хэрэгжилт, хангалтгүй, 2016 онд хэрэгжих хугацаа нь дууссан	Цаашид үргэлжлүүлэх нь эсэхийг хэрэгжих боломжийг бүсчилсэн болон ТХ-ийн удирдлага зохицуулалттай холбон судалж шийдэх шаардлагаартай
2. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага	УИХ-ын 2013 оны 23-р тогтоол /2030 он хүртэл/ https://www.legalinfo.mn/	Уг төлөвлөгөөнд ИУБ-ын төвлөрлийг сааруулах асуудлыг Говийн дэд бүстэй холбон бүсчлэл, байршилтын нэгдсэн сүлжээний хүрээнд хэрэгжүүлэх шийдэл тусгагдсан	БХҮБ-ыг шинэчлэх шаардлагаартай нийцэж байгаа.
3. Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр	ЗГ-ын 2010 оны 151-р тогтоол /2010 – 2015 он/ https://www.legalinfo.mn/	Дэд бүтцийн төслүүдийн байршилт аймаг, салбар нэг бүрээр тусгагдсан. Хэрэгжиж амжаагүй, хөтөлбөрийн хугацаа дууссан	Цаашид Төв ба Говийн дэд бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинэчлэн тодорхойлох үед аймаг, бүсүүдийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрт уялдуулан тусгах

<p>4. Говийн дэд бүсийн дэд бүтцийн хөгжлийн стратеги</p>	<p>ОУСБХБ/Дэлхийн Банкны тайлан материал. 2010 он /2020 он хүртэл/ Интернет: www.worldbank.org</p> <p>Инженер геодези компани 2007 /2020 он хүртэл/ БХБЯ-ны сайдын тушаал 2008 он https://mcud.gov.mn</p>	<p>Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний байршил, шаардагдах хөрөнгө оруулалтын ойролцоо тооцоо тусгагдсан</p> <p>Тавантолгой, Оюутолгой Цагаан – суваргын орд газрыг эзэмших асуудлыг уялдаатай шийдэх, тэдгээрт түшиглэн хот суурин байгуулах, говийн аймгуудын нийгэм соёлын цогц хөгжлийг хангах орон зайн төлөвлөлтийн үндсэн шийдэл, зураг, төслүүд хийгдсэн /байршилтаар/</p>	<p>Цаашид Төв ба Говийн дэд бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинэчлэн тодорхойлох үед ТХҮБ/аймаг бүсүүдийн/, БХҮБ –тай уялдуулан тодогтох</p> <p>Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр боловсруулахад бусад баримт бичигтэй уялдуулж, ашиглах</p>
<p>6. Говийн дэд бүсэд Таван толгой, Оюу толгой, Цагаан суваргын уул уурхайн орд газрыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги, хот байгуулалтын төлөвлөгөө, зураг төсөл</p>	<p>БХБЯ, “Шинэ хотжилт” ХХК., 2008 он/2007-2015, 2016-2020 он хүртэл https://mcud.gov.mn</p>	<p>Тавантолгой, Оюутолгой Цагаан – суваргын орд газрыг эзэмших асуудлыг уялдаатай шийдэх, тэдгээрт түшиглэн хот суурин байгуулах, говийн аймгуудын нийгэм соёлын цогц хөгжлийг хангах хот байгуулалт, төлөвлөлтийн зураг төслийн шийдлүүд / байршилтаар/</p>	<p>Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр боловсруулахад бусад баримт бичигтэй уялдуулж, ашиглах</p>
<p>7. Говь хээрийн бүсийн экосистемийг нөхөн сэргээх, хамгаалах шинжлэх ухааны үндэслэл</p>	<p>ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоол /2003 он/ https://www.eic.mn/DLDbase/upl/oad/2012/fadesertbook/3/20121220_0_6190_3.pdf</p>	<p>Говийн бүсийн газар нутаг, нөөц, баялгийг цөлжилтөөс хамгаалах иж бүрэн арга хэмжээг нийгэд нь төлөвлөж, заримынх нь байршилтыг зааж тусгасан.</p>	<p>Аймаг, бүсүүдийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрт тусган уялдуулах</p>

8. “Орхон-Говь” Говийн дэд бүсийг усаар хангах ТЭЗҮ-ийн урьдчилсан төсөл: “/Орхон гол дээр урсац тохируула бүхий ус хуримтлуулах сан байгуулах” ТЭЗҮ-ийн ажлын даалгавар	<p align="center">ПРЕСТИЖ ХХК</p> <p>Хаяг: Соёлын төв өргөө# Утас: 11-313392, 9911-1529, 9911-2972 И-мэйл: ganzorig@prestige.mn, wat@prestige@gmail.com.</p>	Төслийн агуулга, арга хэмжээ, хамрах нутаг дэвсгэр, байршил, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн урьдчилсан үнэлгээ өгөгдсөн	Говийн дэд бүсийн хөгжлийн хөгөлбөр боловсруулахад бусад хувилбар болон төслийн баримт бичигтэй уялдуулж, ашиглах
9. “Замын – Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө	ЗГ-ын 2011 оны 187-р тогтоол /2030 он хүртэл/	Олон арга хэмжээ тусгагдсан боловч хэрэгжилт хангалтгүй байгаа.	БНХАУ –ын Эрээнд чөлөөт бүс байгуулсан/20018 онд/-тай уялдуулан асуудлыг бүхэлд нь шинээр авч үзэх
III. Аймгуудын хөгжлийн бодлого			
1. Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого	Аймгийн ИТХ-ын тогтоол /2011 оны №03/, (2010 – 2021 он) http://shivee.govi.gs.gov.mn/12.html	Аймгийн хөгжлийн арга хэмжээ нэр, байршил заагдаж тусгагдсан. 2011 онд аймгийн ЗДТГ-аас хэрэгжилтийн хяналт-шинжилгээ хийсэн мэдээ байгаа	Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичиг бүхэлдээ хүчингүй болж, оронд нь ТХҮБ-2030 он гэсэн нэгсэн бодлого улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа. Цаашид аймгийн түвшинд ийм баримт бичиг байх эсэхийг шийдэх
2. Говьсүмбэр аймгийн 2017 оны нийгэм, эдийн засгийн байдал	Аймгийн ЗД-ын Статистикийн хэлтэс – 2018 он http://www.govisumber.nso.mn/uploads/users/86/files/JE-2017-taniltsuulga.pdf	Статистикийн энэ эмхэтгэлд хөгжлийн одоогийн түвшний талаар дэлгэрэнгүй тоо мэдээ аймгийн сум бүрээр үнэлгээ, тайлбарын хамт тусгагдсан. 2018 оны мэдээ албан ёсоор гараагүй байна.	Энэ эмхэтгэлд орсон мэдээ судалгааг Өмнөд бүсийн хөгжлийн хөтөлбөрт ашиглах боломжтой.
3. Дорноговь аймгийн Аймгийн засаг даргын гйл ажиллагааны “Шинэ Дорноговь -2” Тогтвортой хөгжлийн хөтөлбөр	Аймгийн ИТХ-ын тогтоол-2012 /2012-2016 он/ zdftg@dornogovi.gov.mn Dga_zdftg@yahoo.com	Энэ баримт бичгийн хэрэгжих хугацаа дууссан, одоогоор албан ёсны хяналт –шинжилгээ хийгдээгүй байна	Энэ ажлыг үргэлжлүүлэх эсэхийг “Хөгжлийн бодлого, төлөвлөлийн хууль” /ХБТХ/-ийн 4.1.1, 4.1.2 мөн 41.5 дахь заалттай холбон шийдэх/журамлах/

4. Дорноговь аймгийн хөгжлийн Мастер төлөвлөгөө	Аймгийн ИТХТ-ийн тогтоол /2011 оны №26/ (2011 – 2021 он) http://domogovi.gov.mn/v/20155264	Монголын орон нутгийн хөгжлийн бодлогыг сум суурин, хөлөөгийн асуудалтай холбон нарийвчлан хэрэгжүүлэх арга хэмжээ, байршилтыг заасан туршилтын загвар-ажил болсон.	Ийм мастер өлөвлөгөөг цаашид аймгийн түвшинд хийх нь хэр зохистой, үр дүнтэйг судалж шийдэх/журамлах/
5. Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн байдал	Аймгийн 3Д-ын Статистикийн хэлтэс – 2018 он http://www.dornogovi.nso.mn/pag/e/231	Статистикийн энэ эмхэтгэлд хөгжлийн одоогийн түвшний талаар дэлгэрэнгүй тоо мэдээ, аймгийн сум бүрээр үнэлгээ, тайлбарын хамт тусгагдсан. 2018 оны мэдээ албан ёсоор гараагүй байна	
6. Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө	Аймгийн ИТХ-ын тогтоол /2012 он/ (2012 – 2031 он) https://mercycorps.org.mn/beta/documents/publications/ledplan/2012/DG-Mandalgovi.pdf	Урт хугацаанд хэрэгжүүлэх томоохон төсөл арга хэмжээг байршилт зааж харуулсан байна.	Бүс нутаг, аймгийг хөгжүүлэх стратеги/урт хугацааны/ төлөвлөгөөг ХБТ-ийн хуультай холбон зохистой шийдэх/журамлах/
7. Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал	Аймгийн 3Д-ын Статистикийн хэлтэс – 2018 он http://www.dundgovi.nso.mn/pag/e/1263	Статистикийн энэ эмхэтгэлд хөгжлийн одоогийн түвшний талаар дэлгэрэнгүй тоо мэдээ, аймгийн сум бүрээр үнэлгээ, тайлбарын хамт тусгагдсан. 2018 оны мэдээ албан ёсоор гараагүй байна	Энэ эмхэтгэлд орсон мэдээ судалгааг Өмнөд бүсийн хөгжлийн хөтөлбөрт ашиглах боломжтой.
8. Өмнөговь аймгийг 2016 – 2020 онд хөгжүүлэх аймгийн 3Д-ын үйл ажиллагааны “ БИД ХАМТДАА” хөтөлбөр	Аймгийн ИТХ-ын тогтоол /2016 оны №2/2/ (2016 – 2020 он) http://www.omnogovi.gov.mn/v1/15938.shtml-se1=468.htm	Төсөл арга хэмжээний байршилт заагдсан	Энэ баримт бичгийн агуулгыг ХБТ-ийн тухай хуулийн 4.1.5 дахь заалттай холбон цаашид нарийвчлан тодорхойлох

<p>9. Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр – “Байгалийн баялаг – Сайн засаглал – Хөгжсөн Өмнөговь”</p>	<p>Аймгийн ЗДТГ /2009 он/ (2010 – 2020 он) http://www.omnugovi.gov.mn/i/2 43</p>	<p>Төсөл арга хэмжээний нэр, байршилг сум, суурин, аймгийн дотоод бүсчлэлээр тодорхой заагдсан байна.</p>	<p>ТХҮБ болон БХҮБ-тай нийцэж байгаа. Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тодотгох шаадлагаатай</p>
<p>10. Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн байдал</p>	<p>Аймгийн ЗД-ын Статистикийн хэлтэс - 2018 он http://www.omnugovi.nso.mn/pag/e/1321</p>	<p>Статистикийн энэ эмхэтгэлд хөгжлийн одоогийн түвшний талаар дэлгэрэнгүй тоо мэдээ аймгийн сум бүрээр үнэлгээ, тайлбарын хамт тусгагдсан. 2018 оны мэдээ албан ёсоор гараагүй байна</p>	<p>Энэ эмхэтгэлд орсон мэдээ судалгааг Өмнөд бүсийн хөгжлийн хөтөлбөрт ашиглах боломжтой.</p>

4. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

4.1. Бодлого боловсруулах арга загвар, зарчмыг сонгох

Дээр дурдсан хөгжлийн боломж, сорилтоос үүдэлтэй эрсдэлийг урьдчилан харж, тооцохын тулд ГДБ-ийн хөгжлийн бодлогыг аль болох урт хугацаагаар, хэрэгжих бодит боломжид үндэслэсэн хэд хэдэн үе шаттай байхаар боловсруулах нь зүйтэй байна. Энэ үүднээс ГДБ-ийн хөгжлийн хөтөлбөрийг “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 ба 6.2-т заасны дагуу урт хугацааны, бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлбэрээр боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөвөө. Нэрийн хувьд, энд Засаг төрийн түвшинд шийдэгдэх нийт улс орны ач холбогдолтой олон асуудлыг авч үзэх учир “үндэсний” хэмжээний хөтөлбөр болно гэж үзэж байна. Бодлогын хугацааг 2020 - 2040 оноор авч, түүнд хөгжлийн чиг баримтлал, хэрэгжүүлэх бодлогын үндэслэл хоёрыг хөёуланг нь тусгахыг санал болгож байна.

Урт хугацааны энэ бодлогыг аль болох үр дүнд суурилсан төр, иргэний нийгмийн бүх талууд оролцсон хамтын менежментийн цогц арга механизмаар дэмжин хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үзэл баримтлал, бодлогын үндэслэл, төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа гэсэн дээрх хуульд заасан харилцан уялдаатай, нэгдмэл зорилго, зорилтод чиглүүлсэн байна. Үр дүнд суурилсан ийм хамтын менежментийг хэрэгжүүлснээр Монгол улсын урт хугацааны тогтвортой, тэнцвэрт хөгжлийг хангахад ГДБ-ийн байгалийн баялгийг асар их өртөг зардал/ магадгүй зарим салбарт алдагдал, хохирол хүлээх/-аар ашигласнаар оруулах үнэ цэнийг нөхөж болох юм гэж төсөөлж байна. Үүний тулд, бодлого боловсруулах үйл явцыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн “Бодлогын мөчлөг” гэсэн загварт суурилах нь зүйтэй байна.

Энэхүү загвар ёсоор ГДБ-ийн баялгийг эрчимтэй эзэмшихэд тулгарч байгаа байгаль орчны, нийгмийн болон эдийн засгийн өсөлтийн томоохон сорилтуудыг даван туулж, тогтвортой хөгжлийн суурь нөхцөлийг бүрдүүлэхийн тулд, **нэгдүгээрт**, хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг үндэслэн улс үндэсний, бүсийн, салбар яам, аймаг орон нутаг, ААНБ-ын бүх түвшинд, энэ хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах нэгдсэн стандартыг баримтлах, **хоёрдугаарт**, үндэсний хөтөлбөрт урт хугацааны чиг баримтлал, бодлогын тэргүүлэх чиглэлийг голлон тодорхойлж, цаашид тулгарч байгаа гол сорилтуудыг даван туулах арга зам чиглэл, үе шат, зохицуулалтын арга хэмжээнүүдийг тусгаж, үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, Засгийн газрын дунд, богино хугацааны бодлого, компани, аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, бизнес санхүүгийн болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, **гуравдугаарт**, энэ хөтөлбөрийг бүх түвшинд, бүх талуудын оролцоотой боловсруулах шинжлэх ухаан арга зүйн үндэслэл, хөгжлийн бодлого, төлөвлөлт, зохицуулалт, хяналт шинжилгээний нэгдмэл зохистой бүтэц бий болгох замаар энэхүү хөтөлбөрийг бодитой хэрэгжүүлж, цаг тухайд нь шаардлагатай өөрчлөлт оруулж байх нөхцөлийг бүрдүүлэх, **дөрөвдүгээрт**, улс төрийн сонгуулийн үр дүнд төрийн удирдлага солигдох үйл явцаас үл хамааран бодлого үргэлжлэн хэрэгжих хууль эрх, ёс зүйн орчинг бүрдүүлэх, **тавдугаарт**, үндэсний хөтөлбөрт, нийгэм, эдийн засаг, байгаль орчны бүх асуудал, биелэгдэх, биелэгдэхгүй бүх зорилтыг хамруулан иж бүрэн төлөвлөх биш, харин тухайн цаг хугацаанд хэрэгжих бодит зорилт, гол зангилаа, түлхүүр асуудал / эдийн засгийн өсөлт туйлууд, нийгмийн үйлчилгээний таталцлын гол бүс нутаг/, бүс дундын, салбар хоорондын нийтлэг ач холбогдолтой тэргүүлэх, цогц чиглэлийн төсөл арга хэмжээг сонгон, тэдгээрийн хүрэх боломжтой **үр дүнгээр** төлөвлөх /индикатив төлөвлөлт/ зэрэгт анхаарч байна.

Дээр дурдсанаас үндэслэн, ГДБ-ийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг сонгох шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- 1.) үндэсний аюулгүй байдалд харшлахгүй, иргэний нийгмийн нийтлэг эрх ашигт нийцсэн байх;
- 2.) байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, түүнийг нөхөн сэргээх шаардлагад нийцсэн байх;
- 3.) эдийн засгийн өсөлт, бүтцийн зохистой өөрчлөлт тогтвортой хөгжлийн тэнцлийг хангасан байх;
- 4.) төр - хувийн хэвшлийн түншлэлийн харилцаа, дотоод, гадаадын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруудлагчдын хамтын ажиллагааг хөгжүүлж, тэдгээрийн нөөц боломж, санаачилгыг бүрэн зохистой ашигласан байх;
- 5.) төр, Засгийн газар, аймаг орон нутаг, компани, ААНБ –ын харилцан сонирхол, хамтын ажиллагааг уялдуулсан байх;
- 6.) төсөл, арга хэмжээ нь судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх, цаг тухай, үе шат бүрд нь уян хатан өөрчлөлт, зохицуулалт хийх боломжтой байх;
- 7.) Иргэд, ТББ-ын оролцоог хангасан байх, хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэдгээрийн үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлсэн байх;
- 8.) тодорхой нэг салбар, үйл ажиллагааны алдагдсан боломжийг өөр салбарын илүүц үр ашигаар нөхөж, нийгмийн эцсийн үр өгөөжийг давуу байлгах.

Энэ бүх шаардлага, зарчмыг хэрэгжүүлэхдээ бусад улс оронд нийтлэгээр баримталж байгаа бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн онцлог хандлагыг харгалзаж байна. Энэ нь аймаг, сумын Засаг даргад хуулиар олгогдсон орон нутгийн хөгжлийн асуудлыг давхардуулахгүйгээр бүс нутаг хоорондын, салбар хоорондын, улс үндэсний ач холбогдолтой нийтлэг асуудлыг сонгон тодорхойлж, шийдвэрлэх цаг хугацаа, арга зам, боломжийг төсөөлж төлөвлөх явдал гэж үзсэн болно.

Алсын хараа, стратегийн зорилгыг тодорхойлох:

Төвийн бүсийн Говийн хэсгийг бие даасан дэд бүсийн хэмжээнд эрчимтэй хөгжүүлэх урт хугацааны бодлого нь энэ нутгийн тээвэр – газарзүйн тохиромжтой байрлал, эхний ээлжинд Өмнөговь аймгийн Тавантолгойн нүүрс, Оюутолгойн эсгийн байгалийн баялгийг зах зээлд ашиглаж буй дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын хамтын үйл ажиллагааны нааштай ололт, туршлагыг бусад аймаг, орон нутагт цаашид шатлан өргөжүүлж, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх замаар нийт улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжил, экологийн тэнцлийг хангахад бодитой хувь нэмэр оруулж, хүчтэй түлхэц үзүүлэх давшингүй үзэл баримтлалд үндэслэгдэж байна.

ГДБ -ийг 2040 он гэхэд, тогтвортой өсөлт, үр ашиг өгдөг, байгаль орчиндоо нэн зохицсон, эдийн засгийн уян хатан бүтэцтэй, амьдрах орчны хувьд хүн ам олноор шилжин суурьших сонирхолыг татсан, орчин үеийн өндөр технологи, бүтээмж өндөртэй, мэдлэг, мэдээлэл, нийгэм, соёлын үйлчилгээний тэргүүний арга туршлага нэвтэрсэн Монголын хөгжийн нэг жишиг бүс нутаг болгон хөгжүүлэх Алсын харааг барьж байна. Байгаль, нийгмийн хамтын менежментийн хэрэгжүүлэх үндсэн дээр Монголын говь хээрийн геологи газарзүйн нэн өвөрмөц тогтоц, био уур амьсгалын тааламжтай нөхцөлийг зүй зохистой ашиглаж, хүн ам нутагшин амьдрах, загвар бүс нутаг болгон хөгжүүлэх ирээдүйн зураглалыг төсөөлж байна.

Энэхүү үзэл баримтлалын хүрээнд, ГДБ-ийг 2030 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх стратегийн зорилго нь эдийн засгийн талаас энэ нутагт байгаа ашигт малтмалын арвин нөөц, мал аж ахуйн түүхий эдийг аль болох бүрэн, үр өгөөжтэй ашигладаг олборлох, боловсруулах аж үйлдвэрийн цогцолбор байгуулах үйлдвэрлэлийн болон зах зээлийн үндэс суурийг тавихаар төсөөлж байна. Нийгмийн талаасаа, энэ зорилго нь хүн ам тав тухтай суурьшин амьдрах хот, хөдөөгийн суурины харилцан уялдсан тогтолцоог бүрдүүлэх зам тээвэр, мэдээлэл, инженерийн дэд бүтэц, нийгэм соёлын болон аялал жуулчлалын орчин үеийн үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Хүрээлэн буй орчны хүрээнд говийн бүс нутгийн газарзүйн

өвөрмөц тогтоц, байгаль уур амьсгалын тааламжтай нөхцөлийг үр өгөөжтэй ашиглахын хамт, хөгжлийн үе шат бүрд хүмүүсийн аливаа үйл ажиллагааг экосистемийн бүрдэл хэсгүүд, биологийн төрөл зүйлийн харилцан шалтгаалсан тэнцлийг алдагдуулахгүй байлгахаар зохион байгуулах чадвартай “ашиглалт - хамгаалалт – нөхөн сэргээлтийн нэгдсэн менежмент” -ийг бүрдүүлэхийг зорих ёстой.

4.2. Хөтөлбөрийн хүрээнд авч үзэх боломжтой хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд

ГДБ-ийг 2025 он хүртэлх хугацаанд, одоо байгаа эрдсийн томоохон баялгийг ашиглаж, экспортыг нэмэгдүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчинг сайжруулах, 2025 оноос цааш тэдгээрийг гүнзгийрүүлэн боловсруулж, өндөр өртөг бүхий бүтээгдэхүүн гаргах бүх үйл ажиллагаанд дэвшилтэт техник технологи, бүтээмж нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн гаргах зураг төсөв, зохиомж боловсруулах, мэргэшсэн залуу ажиллах хүчийг сургах, дадлагажуулах улс орны өөрчлөн байгуулалтын эдийн засгийн гол орон зай байхаар төсөөлж байгаа юм.

Үүнтэй уялдан байгаль ашиглалт, хамгаалалтын голлох үйл ажиллагаанд Оюутолгой, Тавантолгойн бүтээн байгуулалтад нэвтрүүлж эхлээд байгаа шинэтгэлийг гүнзгийрүүлж, цаашид бусад газар шатлан хэрэгжүүлэх явдлыг дэд бүсийн хөгжлийн зорилгыг хангах арга гэж үзэж, энэ хүрээнд дараах асуудлыг тэргүүлэх чиглэл болгон дэвшүүлж байна. Үүнд:

1. Эдийн засгийн эрчим хүч багтаамж, үр ашгийг дээшлүүлэх, Төвийн бүсийн эдийн засаг, хүн амын хямд, аюулгүй эрчим хүчээр тасралтгүй хангах. Нар, салхины эрчим хүчийг зохистой ашиглах дэвшилтэт арга технологийг боловсруулж, нэвтрүүлэх; Бүсийн эдийн засгийн түлш – эрчим хүчний үр ашиг, багтаамжийг дээшлүүлэх нь нэг талаас хөдөлмөрийн бүтээмж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, нөгөө талаас нийт бүс нутгийн хүн амын амьдралын чанарыг хангах, эрчим хүчийг экспортлох боломжийг өргөжүүлэхэд чиглэгдэх ёстой.
2. Байгалийн эрдсийн баялгийг орчинд халгүй, үр өгөөжтэй олборлох, улмаар гүн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, экспортлох хэмжээг нэмэгдүүлэх. Эрдэс баялгийг байгальд хал багатай олборлож, боловсруулах, доройтсон орчныг нөхөн сэргээж, экологийн тэнцлийг хангах дэвшилтэт технологи, байгаль хамгаалал- нийгмийн хөгжлийн хамтын менежментийн тэргүүний арга туршлага нэвтрүүлэх. Үүний зэрэгцээ бүс нутгийн бүтээн байгуулалтад шаардлагатай барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, ялангуяа, хот, хөдөөгийн суурингийн оршин суугчдыг орон сууцаар хангах асуудлыг шийдвэрлэхэд онцлон анхаарна. Олборлох боловсруулах аж үйлдвэрийн цогцолборыг шинэтгэн хөгжүүлэх нь мөн эрдсийн хам болон бусад дагалдах баялгийг иж бүрэн ашиглахад чиглэгдэх ёстой.
3. Бүс нутгийн хүн амын хүнсний аюулгүй байдал, чанарыг хангах. Мах, сүүний хэрэгцээг дэд бүсийнхээ дотоод үйлдвэрлэлээр, гурил, хүнсний ногоог Төвийн бүсийн хойт хэсгийн нийлүүлэлтээр голлон хангах бодлого баримталж байна. Амт чанар сайтай хонь, ямааны мах, нарийн ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хот, хөдөөг холбосон түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалтын орон зайн дамжлага бүхий агро – үйлдвэрлэлийн мөчлөгүүдийг аймаг орон нутагт байгуулж, тэдгээрийг хооронд нь болон Улаанбаатарт байгаа төрөлжсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлдэг томоохон компанитай хоршсон бүс нутгийн нэгдсэн зах зээлийн системийг бэхжүүлэхээр төсөөлж байна. Шинэчилсэн (инноваци) технологийг шатлан нэвтрүүлэх замаар агро үйлдвэрлэлийн цогцолбор бүрт хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, байгаль, цаг агаарын нөхцлөөс шалтгаалсан эрсдлийг бууруулах зорилт тавьж байна. Үүний ачаар хөдөөгийн хүн амын амьдралын түвшин тогтвортой дээшилж, өргөн хэмжээний

барааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт ажлын байрууд олноор бий болох боломжтой гэж үзсэн болно.

4. ГДБ-ийг Төвийн бүсийн бизнесийн, шинжлэх ухаан – технологи, шинжлэх ухаан – боловсролын, экологи – соёлын томоохон төвийн хэмжээнд хөгжүүлж, 2030 оноос цааш Монгол Улсын эдийн засгийг Ази – Номхон далайн бүс нутгийн орнуудтай хоршиж холбосон түшиц газар болгон хувиргах боломжтой. Энэ бүс нутгийн Ази – Европыг холбосон Монгол Улсын улс хоорондын худалдаа, зам тээврийн гол тэнхлэгт таталцсан гео – улс төр, гео эдийн засгийн тохиромжтой байрлалыг ашиглан улс хооронд дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээврийн урсгалыг нэмэгдүүлж, олон улсын байгууллага, сонирхогч улс оронтой хамтран шинжлэх ухаан, соёл боловсрол, аялал жуулчлал, байгалийн шинжлэл, судлалыг хөгжүүлэх, ялангуяа, дэлхийн хуурай газрыг цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах олон улсын туршилтын төвийн статустай болгох зорилт дэвшүүлж байгаа юм. Мэдлэг, оюун, үйлдвэрлэл – үйлчилгээний шинэтгэл нь амьдралын материаллаг орчныг төдийгүй, нийгэм – соёл, сэтгэлгээний хүрээг мэдэгдэхүйц өөрчлөх болно. Энэ бүс нутагт нүүдэлчдийн уламжилж ирсэн түүх соёл, дүр төрхийг суурин иргэншлийн ололттой хослуулан өөрчилж, монголын говь, хээрийн бүсийн нийтлэг ач холбогдолтой, Ази, Европын орнуудын сонирхлыг татсан экологи – соёлын төслүүдийг хэрэгжүүлж, хүн ам амьдран суурьших, амарч, аялан зорчих ая тухтай орчныг бүрдүүлэхээр төсөөлж байна.

Говийн дэд бүсэд хамрагдаж байгаа нутаг дэвсгэр нь экологи – ландшафтын ойролцоо хэв шинжтэй ч аймаг, сумд нь хөгжлийн түвшнээр ихээхэн ялгаатай. Өмнөговь аймаг харьцангуй илүү хөгжсөн бол Дорноговь дунд зэрэглэлийн, Дундговь, Говьсүмбэр аймаг хөгжлийн олонх үзүүлэлтээр бусдаас доогуур байх жишээтэй. Иймд, зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ, аж ахуйн төрөлжилт, хөгжлийн чиглэлийг нь хөдөө орон нутгийг өөртөө таталцуулах чадвартай дотоод бүсүүдийг тогтоон ялгаатай авч үзэж байна. Гэхдээ засаг захиргаа- нутаг дэвсгэрийн нэгжүүдийн бие даасан байдлыг цаашид хадгалж, гол нь эдийн засгийн хувьд төрөлжиж хоршсон нэгдмэл цогц бүс нутгийг бүрдүүлэхийг зорих учраас дотоод бүсүүдийн эдийн засаг – газарзүйн зааг ялгааг хатуу тогтооход бус, харин тэдгээрийн хоорондын харилцан нэгнээсээ хамаарсан уялдаа холбоог нь хөгжүүлэхэд онцлон анхаарсан болно.

Хөгжлийн таталцлын нэгдэх бүсэд Сайншанд руу татагдсан хойт талаасаа Говь сүмбэр аймаг бүхэлдээ, урагшаа Замын – үүд хүртэлх улс хоорондын тээвэр – худалдааны гол тэнхлэгийг хамарсан өргөн зурвас нутгийг оруулна. Энэ бүс нь байгалийн эрдсийн баялаг, мал аж ахуйн түүхий эдийг боловсруулж, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр төрөлжих болно. Ажиллах хүч, үйлдвэрлэл, үйлчлэгээ, дэд бүтцийн гол чадавх одоогоор Сайншанд, Чойр, Замын – Үүд орчимд төвлөрч байна. Шивээ-говийн нүүрс, Айраг, хажуу –улааны хайлуур жонш ны, Өргөн, Даланжаргалан, Цагаан суварга (Мандах сум)-ын барилгын материал (цемент, шохойн чулуу), зэс молибден, Алтанширээ сумын газрын тосны ордыг ашиглаж тус улсын дотоодын болон экспортын хэрэгцээг хангах чадвартай үйлдвэрлэл – технологийн томоохон баазыг шинэчлэх буюу шинээр бүрдүүлэх болно. Гол хүч чармайлтыг мэргэшилтэй ажиллах хүчийг бэлтгэн сургах, дотоод, гадаадын компанийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж, инновацийн болон зах зээлийн дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглүүлнэ. Мөн шинжлэх ухаан – үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт холбоог хангах, үүнтэй уялдан Сайншандад аж үйлдвэрийн паркийг кластерийн зохион байгуулалтаар барьж байгуулан дээр дурдсан үйлдвэрүүдийг холбосон мэдлэг, мэдээллийн байнгын үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй байна. Шинжлэх ухаан – үйлдвэрлэл – сургалтын энэхүү дэд бүтцийг бүрдүүлэхэд Төвийн бүсийн бусад хэсэг, ялангуяа Улаанбаатарт бий болсон их, дээд сургууль, эрдэм шинжилгээ – туршилтын байгууллагуудын чадавхийг хоршин ашиглахаар төлөвлөж байна. Энэ арга хэмжээг 2019 оноос эхлэн ойрын хугацаанд хэрэгжүүлж эхлэх ба 2025 оноос энд ГДБ-ийн хэмжээнд үйлчлэх инновацийн кластерийг байгуулах зорилт тавьж байна. Үүний зэрэгцээ мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах дэд бүсийн хэмжээний дэвшилтэт технологи, шинэ бүтээмж нэвтрүүлсэн агро – үйлдвэрлэлийн цогцолбор байгуулж, мах

махан болон сүү сүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангаж, гадаад оронд экспортлох боломжийг бүрдүүлнэ. Мөн Дорноговь, Замын – Үүдийн тээврийн гол тэнхлэгт дэд бүсийн байгаль, түүх, соёлын нөөц бүхий газар нутгийг таталцуулан улс хоорондын аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийг сайжруулна.

Бүсийн Өмнөт хэсэгт, Замын – Үүдэд бий болсон улс хоорондын дэд бүтцэд түшиглэн өлөөт бүс, хил гаалийн үйл ажиллагааг үр ашигтай, хослон хөгжүүлсэн тээвэр – логистикийн болон орон сууц – нийгэм хангамж, худалдаа – үйлчилгээ, мэдээлэл – соёлын орчин үеийн технологи бүхий төвүүд, дотоод, гадаад зах зээлийг зохистой холбосон, БНХАУ-ын Эрээн хоттой хоршсон хот байгуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. Тэргүүлэн хөгжүүлэх энэ бүсийн хөгжлийн цөм нь Замын – Үүдийн аялал жуулчлал – үйлчилгээний чөлөөт бүс байх болно.

Тэргүүлэн хөгжүүлэх хоёр дахь таталцлын бүс нь Оюутолгойн зэс молибдены, Тавантолгойн нүүрсний томоохон ордуудад түшиглэсэн Өмнөговийн аж үйлдвэрийн бүс нутаг юм. Энэ бүс нутгийн ашигт малтмал, түүний дотор нүүрсний уурхайнуудыг кластерийн зохион байгуулалтаар аж үйлдвэрийн цогцолбор үүсгэн нэгдсэн менежментээр, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгдсэн дэд бүтцийн хүрээнд олборлолт – баяжуулалт – боловсруулалтын байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга технологиор ашигласнаар, экологийн орчныг сайжруулаад зогсохгүй, Монгол Улс, Төвийн бүсийн тогтвортой хөгжлийг хангахад бодитой түлхэц болно.

Энэ бүсийн аж ахуйн төрөлжилтийн гол чиглэл нь инновацийн технологийн хамгийн боломжтой түвшинд эрдсийн баялгийг иж бүрэн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн гаргах явдал юм. Өмнөговийн аж үйлдвэрийн бүсийг үүсгэснээр ӨГБД, улмаар Төвийн бүсийн хойт, төв хэсгийг бүхэлд нь хамарсан иж бүрэн хоршилт бий болох боломжтой болно. Үүнд, Чойр – Сайншанд – Цагаан суварга – Тавантолгойн төмөр зам, Хятадын хил гарцтай холбогдсон салаа төмөр замууд, Тавантолгой – Тэвшийн говь (Дундговь)-ийн ЦД, өндөр хүчдэлийн шугам, ТЭЗ-ийн урьдчилсан үндэслэлээр харьцангуй ирээдүйтэй, найдвартай гэж үнэлэгдсэн ТЭЗ-ийн урьдчилсан үндэслэлээр харьцангуй ирээдүйтэй, найдвартай гэж үнэлэгдсэн говийн бүсийн усны хэрэгцээг хэрхэн хангах “Орхон говь” төслийг хэрэгжүүлэх юм.

ГДБ-ийг Төвийн бүс, түүний дотор хийслэл Улаанбаатартай холбож, бүс нутгийн харилцан шалтгаалцсан, нэдмэл цогц хөгжлийг хангах гуравдахь таталцлын бүс нутгийг дэд бүсийн хувьд харьцангуй голдоч байрлалтай Дундговь аймгийн Мандалговиор тогтоох боломжтой, ирээдүйтэй гэж үзсэн болно. Хэдийгээр энэ бүс нутаг одоогоор хөгжлийн түвшнээр харьцангуй доогуур байгаа ч ойрын үед хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай бүс дамнасан олон төсөл арга хэмжээний уулзвар болж байгааг харгалзан үзсэн болно. Үүнд, Могуль Энержи ХХК Тэвшийн говийн нүүрсний орд/ Сайнцагаан сум/ - од түшиглэн барьж эхлээд байгаа 600 Мгв.-ынхүч чадалтай бүсийн цахилгаан станцын төсөл, Тавантолгой – Тэвшийн говийн ЦД, өндөр хүчдэлийн шугам, Говийг усаар хангах Орхон голоос Тавантолгой, Оюутолгой руу татах 740 км урттай шугаман хоолойг Мандалговь руу салаалуулан тавих ойр дөт байрлалын боломж, сайн чанарын мах, айраг бэлтгэж ирсэн хүн амын дадлага, нүүдэлчдийн урлаг, соёлын өвийг хадгалж ирсэн зэрэг ололтод тулгуурлан дотоод, гадаадын аялал жуулчлалын төв байгуулах зорилт тавьж байна.

Цаашид Төвийн бүсийн болон энэ дэд бүсийн дээр дурдсан таталцлын хүрээ, чиглэлийн эрчмийг харгалзан, хүн амын нутагшлын төсөл, хот байгуулалтын нарийвчилсан үнэлгээний үндсэн дээр Таван толгой – Цогтцэций, эсвэл Мандалговь, түүний орчмын бүс нутагт ГДБ-ийн тулгуур төвийг байгуулах боломжийг одооноос харьцуулан судалж тогтоохыг энэхүү баримт бичигт хот байгуулалт, орон зайн төлөвлөлтийн гол хувилбар байж болох юм гэж үзсэн болно.

4.3. Хөтөлбөрийн бүтэц, хэрэгжүүлэх үе шат, арга хэмжээг тодорхойлох нь

“ГДБ –ийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” бодлогын баримт бичгийн ерөнхий бүтцийг дор дурдсанаар зураглаж байна. Үүнд:

- I. БҮЛЭГ. ГДБ-ийн үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал;
- II. БҮЛЭГ. ГДБ-ийг хөгжүүлэх бодлогын үндэслэл /бодлогын зорилго, зорилтууд, хүрэх үр дүн г.м./;
- III. ГДБ-ийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл;
- IV. Хөгжлийн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх томоохон төсөл арга хэмжээнүүд /улс, бүсийн, аймаг, салбар хоорондын ач холбогдолтой/;
- V. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохицуулалт, зохион байгуулалт;
- VI. Хавралт хүснэгт тооцоо, зураглал;

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг цаг хугацааны хувьд доорх гурван үе шатаар авч үзнэ:

Нэг дэх нь: 2020 - 2025 онд уул уурхайн орд газруудыг ашиглах төслүүдийн бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн болон инженерийн суурь дэд бүтцийг байгуулах ажлыг хот байгуулалтын оновчтой бодлоготой уялдуулан хийж, хүн амын төвлөрөл илүү суурин руу хөдөөгийн хүн амд нийгмийн үйлчилгээг хүргэх, эрэлт ихтэй бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд үр өгөөжтэй хангахад чиглэгдсэн цогц арга хэмжээ авна.

Хоёр дахь нь: 2026 - 2030 онд уул уурхайн боловсруулах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд онцлон анхаарч, хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний бусад салбарт боломжит бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, нийгэм, соёл, аялал жуулчлалын үйлчилгээний чадавхи сайжруулж, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалахад бодитой ахиц өөрчлөлт гаргана.

Гурав дахь нь: 2030 оноос хойшхи хугацаанд, эрдэс баялгийн үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, өндөр өртөг бүхий бүтээгдэхүүн гаргах чиглэлээр улс орны эдийн засгийн бүтцэд өөрчлөлт хийж, хүнийг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх дэс дараалсан арга хэмжээ авна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг дээр төлөвлөсөн тэргүүлэх чиглэлийн төслүүд болон тогтвортой хөгжлийн салбаруудаар хэрэгжих бодит боломж, нөхцөл /мэргэшсэн хүн хүч, хөрөнгө санхүү, техник, технологи г.м./-тэй нь холбон гаргана. Ингэхдээ, тухайн шатанд, аймаг, бүс хоорондын, салбар дундын чанартай, эн тэрүүнд үр ашгаа өгөх төсөл арга хэмжээнд анхаарч, нэг төсөл үр дүнтэй хэрэгжсэний дараачийн төслийг үндэслэлтэй төлөвлөх дэс дарааллыг баримтална.

4.4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг “Говийн дэд бүсийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах” үүрэг бүхий Засгийн газрын Ажлын хэсэг хариуцан ажиллана. Ажлын хэсгийг оролцогч талуудын хоорондын Гэрээ хэлэлцээрээр байгуулж, түүний ажиллах журмыг Монгол улсын тусгай хууль тогтоомжоор зохицуулна. Ажлын хэсгийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд ахалж, орлогч даргаар нь Үндэсний хөгжлийн газрын дарга, бүрэлдэхүүнд нь Сангийн, Зам, тээврийн, Барилга, хот байгуулалтын, Уул уурхай, хүнд үйлдвэрийн, Эрчим хүчний, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, Гадаад харилцааны, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, Эрүүл мэндийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн Засаг дарга нар, МХАУТанхим, Монголын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөлийн гишүүд, мөн Оюутолгой, Эрдэнэс Тавантолгой болон бусад компаниудын удирдлагууд, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын төлөөллүүд байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ хийх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж сайжруулах, баталгаажуулахыг Ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллана.

Олон нийтэд хөтөлбөрийн ач холбогдлыг сурталчлах, санал солилцох уулзалт, хөрөнгө оруулагчдын зөвлөгөөнийг жил бүр, шаардлагатай бол аль нэг талын саналаар зохион байгуулах ба уг зөвлөлгөөнийг Ажлын хэсэг, Үндэсний хөгжлийн газар, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн ЗДТГ, төслийн нэгжүүд хамтран зохион байгуулна.

4.5. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- Улсын болон орон нутгийн төсөв;
- Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө оруулалт;
- Банкны зээл;
- Гадаад орон, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл;
- Гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж;
- Хөрөнгийн бирж дээр босгосон хөрөнгө;
- Бусад;

Говийн дэд бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад... их наяд орчим төгрөг шаардлагатай гэсэн урьдчилсан тойм тооцоо байгаа бөгөөд, хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлэх шаардлагатай байна

4.6. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт /2040 оноор баримжаалахад/

Үндэсний хөтөлбөрийн үр дүн:

- А. Өмнөд говьд уул уурхайн олборлох, баяжуулах, боловсруулах аж үйлдвэр, хот, суурин хөгжих үндсэн нөхцөл болох инженерийн суурь дэд бүтэц /цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам, төмөр замын суурь бүтэц, хатуу хучилттай авто зам, усан хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, мөн мэдлэг, мэдээлэл түгээж ашиглах технологи/ баригдсан байх;
- Б. Эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэн, төсвийн орлогын хэмжээ өсөж, үүнтэй уялдан нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өссөн байна;
- В. Өндөр өртөг бүхий бүтээгдэхүүнийг экспортлох үндэс тавигдаж, эрдэс түүхий эдийн экспортын эзлэх хувийн жинг аажмаар багасгаснаар улс орны эдийн засгийн бүтцэд чанарын өөрчлөлт гарч, гадаад худалдааны тэнцэл сайжирах;
- Г. Тэргүүлэх бүс нутагт дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, инновацийг импортлох, бүтээлчээр ашигласан хэмжээ нэмэгдсэн байх;
- Д. Дэд бүсийн уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарын гадаад зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэх;
- Е. Хөгжлийн таталцлын гол төв, тэнхлэгүүд хөгжиж, ажлын орлого сайтай байр олноор бий болж, ажилгүйдлийн түвшин аажмаар буурсан байх. Дэд бүс болон Төвийн бүсийн хэмжээнд аймаг, салбар хоорондын уялдаа сайжирч, үйлдвэрлэл, үйлчилгээний тогтвортой хоршилт холбоо, төрөлжилт хөгжиж эхлэх;
- Ё. Эрдсийн нөөцийг ашигласны орлогоос “Үндэсний баялгийн сан” байгуулж, байгалийн жинхэнэ засаглалыг бүрдүүлэх;
- Ж. Говийн бүсийн байгаль орчин, хүн амд, үйлдвэржилт, хотжилтоос үзүүлэх сөрөг нөлөөлөл багассан байх;

Үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт /дээр дурдсан төсөл хэрэгжих 2040 он хүртэлх гол төлөвлөлт, төсөөллийн үе шатаар/.

“А” үндэсний түвшинд:

1. Говийн дэд бүсийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа цахилгаан станц, дэд станц, цахилгаан дамжуулах сүлжээний хүчин чадлын ашиглалт, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн хүртээмж;
2. Шинээр баригдах өргөн төмөр зам, нарийн төмөр замын суурь бүтцийн хэмжээ;
3. Шинээр баригдсан хатуу хучилттай авто замын хэмжээ;
4. Усан хангамжийн эх үүсвэр, нөөцийн төрөл, тоо, хэмжээ;
5. Хот, суурины шинээр баригдсан инженерийн дэд бүтцийн /нийтийн тээвэр, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, үерийн далан суваг г.м/ төрөл, тоо, хэмжээ;
6. Шинээр баригдсан орон сууцны тоо;
7. Шинээр бий болсон нийгмийн үйлчилгээний төрөл, тоо, хэмжээ;
8. Өмнөд говийн дэд бүтцийг ашиглан үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрийн тоо, тэдгээрт ажиллаж байгаа ажиллах хүчний тоо;
9. Дэд бүсийн хэмжээнд, шинээр бий болсон ажлын байрны тоо, мэргэжил дээшлүүлсэн болон урт, богино хугацааны сургалтад хамрагдаж шинэ мэдлэг, мэргэшил эзэмшсэн хүний тоо, үүнээс тухайн аймаг орон нутгийн;
10. Агаар, хөрс, усны бохирдлын хэмжээ буурсан үзүүлэлт;
11. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, эдийн засгийн өсөлтийн хурдац, төсвийн орлогын хэмжээ, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, экспорт, импортын хэмжээ бүтэц, гадаад худалдааны тэнцэл зэрэг болно.

“Б” бүсийн түвшинд:

Дээрх үзүүлэлтээс гадна аймаг, бүс нутгийн хоорондын уялдааг харуулах дор дурдсан тоо, чанар /бүлэгчилсэн ба индексчилсэн/-ын үзүүлэлтийг Үндэсний хөгжлийн газрын хэмжээнд тооцож гаргана.

Үүнд:

1. Үйлдвэрлэлийн бөөгнөрлийн коэффициент;
2. Төрөлжилтийн коэффициент;
3. Бүс нутаг хоорондын хоршилтын үзүүлэлтүүд;
4. Бүсийн зах зээлийн солилцооны үзүүлэлтүүд:
 - Түүхий эд, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн сувгууд (сүлжээ);
 - Бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сувгууд (сүлжээ);
 - Худалдаа, үйлчилгээ, барааны эргэлт (бүсийн дотоодод гаргасан), (бүс ба бусад бүсээс оруулсан, импорт).
5. Хүний хөгжлийн индекс;
6. Ажилгүйдлийн индекс;
7. Ядуурлын индекс;
8. Улсын төсөв, хөрөнгө оруулалтын үзүүлэлтүүд;
9. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт (аж ахуйн нэгжээр);
10. Банкны урт хугацааны зээл;
11. Иргэдийн хадгаламж;
12. Хүн амын шилжих хөдөлгөөний үзүүлэлтүүд гэх мэт.

“В” аймгуудын түвшинд:

Улс, бүсийн хөгжилд аймгуудын эзлэх байр суурийг тодорхойлох боломжтой аймгуудын эдийн засаг - статистикийн болон төлөвлөгөөний үндсэн үзүүлэлтийг аймаг, сум, аж ахуйн нэгж бүрээр хөтөлбөрийн хэрэгжилтийг үе шатуудаар гаргаж, хяналт шинжилгээ - үнэлгээ өгөхөд ашиглана.

5. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Говийн дэд бүсийг Төвийн бүсийн хөгжлийн бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэх санал

Төвийн бүсийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь 4 аймгийг Говийн дэд бүс /ГДБ/ -ийн хэмжээнд бие даалган хоршин хөгжүүлэх үндэслэлийг юуны өмнө дор дурдсан гурван шаардлагатай холбож, Засгийн газрын түвшинд боловсруулж байгаа “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлого” /ҮХГ/, “ Хүн амын нутагшил, суурьшлын ерөнхий төсөл”/БХБЯ/ болон цаашид тэдгээрийн дагуу аймаг, хотын түвшинд боловсруулах хөгжлийн хөтөлбөр, ерөнхий төлөвлөгөөний ажлуудад тусган хэвшүүлэх. Үүнд:

- 1.) **Үндэсний хэмжээнд**, ГДБ-ийн газар нутагт байгалийн эрдсийн баялаг нөөцийг нь үр өгөөжтэй ашиглан, тус улсын дотоод, гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээг зүй зохистой хангаж, эдийн засгийн өсөлт, хуримтлалыг нэмэгдүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэх эрчимтэй хөгжлийн нэг гол талбар, шинэ технологи, орлого сайтай ажлын байранд залуу үе өндөр мэрэгшин бүтээлчээр ажиллах тав тухтай орчин бүрдсэн таталцлын бүс нутаг байгуулах;
- 2.) **Төвийн бүсийн хэмжээнд**, нутаг дэвсгэрийн хойт, төв, өмнөт бүрдэл хэсгүүдийн тогтвортой хөгжлийн дотоод уялдаа, хоршилт холбоог сайжруулах замаар нийслэл Улаанбаатарын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөлийг бүсийн хэмжээнд задалж, уг бүсийн цогц хөгжлийг хангах орон зайн нэгдсэн, оновчтой менежментийг бий болгох;
- 3.) **Орон нутгийн түвшинд**, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн нийгэм соёл, экологийн нэгдмэл байдлыг хангах зорилт тавьж, байгалийн эрдсийн баялаг нөөц, мал аж ахуйн түүхий эдийг эрэмбэ дараатай бүрэн, үр өгөөжтэй ашиглах замаар, эдгээр аймгийг харилцан нэгнээ нөхөн хангах чадвартай, эдийн засаг, нийгмийн бие даасан цогцолбор нутаг болгон хөгжүүлэх. харилцан сонирхол нэгдсэн хамтын ажиллагааны шинэ бүс үүсэх чиг хандлага.

Говийн экосистемийг хамгаалах, хүн амын аж байдлыг дээшлүүлэх зорилгод “байгаль – нийгмийн хамгааллын хамтын менежмент” –ийн арга ухааныг ашиглан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын харилцан сонирхолыг хангаж чадвал Монголын Өмнөт говьд тогтвортой хөгжлийн урт хугацааны хамтын ажиллагааны үлгэр загвар болох шинэ бүс нутаг бүрэлдэх үндсийг тавих болно.

ГДБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн үндэслэл – бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн талаарх ерөнхий дүгнэлт

Бүсчилсэн хөгжлийг дэмжих дээр дурдсан бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр нөлөө муу байгаа нь үндэсний, бүсийн, аймаг, салбарын бүх түвшинд тэдгээрийн хоорондын болон бусад хууль тогтоомжтой холбогдох уялдааг хангаж чадаггүйтэй холбоотой байна. Энд дор дурдсан хоёр хандлага ажиглагдаж байна. Үүнд, нэгд нь, боловсруулалтын шатанд, босоо чиглэлээр үндэсний, бүсийн болон салбарын түвшинд тавьсан макро эдийн засгийн бодлого, зорилт, төлөвлөсөн томоохон арга хэмжээнүүд ямар нэг хэмжээгээр уялдсан байна. Харин тэдгээрийг бүс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэвтээ чиглэлийн уялдаатай төлөвлөх шаардлага хангагдаж чадаагүй байна.

ГДБ-ийн тухайд жишээлж үзвэл, 2000 оноос хойшхи хугацаанд боловсруулсан Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр, Говийн дэд бүсийн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр (2011 онд Засгийн газраас баталсан), мөн Дэлхийн банкны дэмжлэгээр хийсэн энэ бүсийн дэд бүсийн хөгжлийн стратеги (2010), тухайн үеийн яам газар (ҮХЯ, БХБЯ г.м)-аас төсвийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн олон ажлууд (Галбын говийн хөгжлийн хөтөлбөр, Замын-Үүдийн чөлөөт бүс байгуулах ерөнхий төлөвлөгөө, Говийн бүсийн уул уурхайн ордод түшиглэн хот байгуулах төлөвлөгөө, зураг төсөл г.м. Тайланд хавсаргав.) нь өөр хоорондоо болон аймгуудын хөгжлийн цогц бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй, цаг хугацаа агуулгын хувьд уялдаагүй болсон байна. Эдгээр ажилд тусгагдсан бүс нутгийг хөгжүүлэх олон арга хэмжээ аймгууд, түүний дотор тус хөтөлбөрт хамруулж буй Өмнөд говийн 4 аймгийн хөгжлийн албан ёсны баримт бичиг болон Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрүүд, аймгуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд бүрэн тусгагдаагүй байна.

Хоёр дахь хандлага нь хэрэгжүүлэх шатанд, үндэсний, бүсийн, аймгийн бүх түвшний удирдлага, зохицуулалт, улс, орон нутгийн төсөв, санхүүгийн менежмент, мэдээлэл, хяналт – шинжилгээ, үнэлгээ, тайлагналтын уялдаа холбоо үгүйлэгдэж иржээ. Энэ бүхэн зах зээлийн нөхцөлд тус оронд, бүх түвшинд хөгжлийн бодлогыг төлөвлөж, хэрэгжүүлэх, үр дүнг нь мэдээлж, хариуцдаг эрх зүй, эдийн засаг – санхүүжилт, удирдлага, зохион байгуулалт, мэдээлэл – хяналт шинжилгээний харилцан уялдсан нэгдмэл тогтолцоо бүрдэж ирээгүйтэй холбоотой юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль (2016 он) батлагдан гарснаар бүс нутгийн хөгжлийн бодлогыг үндэсний түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх ажлын уялдааг хангах эрх зүйн зохицуулалтын анхдагч үндсийг бүрдүүлж байна. Гэвч энэхүү бодлогыг бүсийн болон аймгийн түвшинд хэрхэн уялдаатай боловсруулж, хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт, хэрхэн санхүүжүүлэх баталгаа, түүнд төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллага, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид (компани, пүүс)-ын оролцоог хэрхэн хангах нарийвчилсан журам, шинжлэх ухаан, аргагүй, мэдээллийн баазыг бүрдүүлэх цогц ажил хүлээгдэж байна. Хэрэв эдгээр асуудлыг нэн даруй шийдвэрлэхгүй бол бүсчилсэн хөгжлийн аль ч түвшний бодлого, түүний дотор бидний боловсруулж буй “Говийн дэд бүсийн хөтөлбөр” үр дүнтэй хэрэгжих баталгаа хангагдахгүй байж болохыг анхаарах хэрэгтэй байна.

ГДБ-ийн хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж, саналууд

2030 он хүртэл хөгжүүлэх бодлогын хувилбар (сценари)-ын талаар:

Санал болгож буй бодлогын 3 хувилбар:

- **Инерцийн** буюу энэ бүс нутгийг оруулаад Монголын Төвийн бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн одоогийн хандлага, Улаанбаатар хотын хэт бөөгнөрөл хэвээр үргэлжлэ хандлага;
- **Эрчим хүч - нүүрсний** (“шинэ үйлдвэржүүлэлтийн хувилбар”), бүс нутгийн хөгжлүүлэх бодлого нүүрс- эрчим хүчний аж үйлдвэр, түүнд шаардлагатай дэд бүтцийн хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд голлон чиглэгдэх бөгөөд ингэхдээ 2025 он хүртэл эрдсийн баялгийг олборлож, анхан шатны боловсруулалт хийж, цаашид дахин боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүч чадлыг бүрдүүлэх үе шатанд аажмаар шилжиж, шинэтгэл болон дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын боломжуудыг аль болох бүрэн ашиглах;
- **Шинэтгэл (инноваци)-ийн буюу тэнцвэрт хөгжил, хуримтлалын хувилбар.** Энэ бүс нутгийн болон Төвийн бүсийн хүн хүч, байгалийн баялаг, түүний дотор эрчим хүчний нөөц, мал аж ахуйн түүхий эдийн нөөцийг иж бүрэн хоршин ашиглаж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тус улсын экспортын боломжийг өсгөн нэмэгдүүлэх;

Тайлбар: Дээрх 3 хувилбарыг хөгжлийн үе шат бүрээр хослуулан хэрэгжүүлэх:

- 1.) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хувилбаруудыг улс орны эдийн засгийн цаашдын өсөлт, хязгаарлагч болон дэмжигч хүчин зүйлтэй холбож, сонгон авах (зонхилох буюу хослуулах);
- 2.) Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн шалгуур, үзүүлэлтийг бодлогын хувилбараас хамааруулан ялгавартай тооцох;
- 3.) Аймгуудын (доороос гаргасан) өөрсдийн санаачилга, тооцоог хувилбаруудтай харьцуулан үзэж сонгох;
- 4.) Аймаг бүр хүрсэн түвшин, чадавхиас хамааруулан дотоод бүсчлэлийг хийж, тэргүүлэн хөгжүүлэх төрөлжсөн бүс нутгуудыг тогтоох зураглах /үзэл баримтлалын төсөлд эдгээр бүсүүдийг Сайншанд, Замын – Үүд, Даланзадгад, Тавантолгой – Оюутолгой, Мандалговь – Говьсүмбэр гэх мэт чиглэлээр авч үзэх/;

ГДБ-ийн 2030 онд хөгжүүлэх бодлогын хүрээнд тусгах тэргүүлэхийг бүрэн төслүүдийн талаар:

- 1.) Төвийн бүстэй холбогдсон эрчим хүчний дэд бүтцийн нэгдмэл систем байгуулах /Тавантолгой – Оюутолгой, Цагаан суварга – Тэвшийн говь, Шивээ овоо г.м/;
- 2.) Алтанширээ дэх газрын тос олборлож, боловсруулах цогцолбор;
- 3.) ХАА-н гол тулгуур бүс нутагт дэд бүсийг хамарсан мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах, нэмүү өртгийн зах зээл бий болгох /агро – үйлдвэрлэл – үйлчилгээний цогцолбор буюу агро аж үйлдвэрийн кластер/;
- 4.) Тавантолгой, Тэвшийн говийн нүүрс – эрчим хүчний цогцолор;
- 5.) Оюутолгой, Цагаан суваргын зэс, молибдений олборлох, боловсруулах, тээвэрлэх цогцолбор;
- 6.) цемент, шохойн чулуу үйлдвэрлэх барилгын материалын үйлдвэрлэл, их барилгын цогцолбор;
- 7.) улс хоорондын экологи – соёлын аялал жуулчлалын цогцолбор;
- 8.) хот, хөдөөгийн суурингийн нэгдмэл тогтолцоог хангасан хот байгуулалт, орон зайн төлөвлөлтийн бүс нутгийн иж бүрэн төслүүд;
- 9.) ЖДҮҮ-г том үйлдвэрлэлтэй холбосон дотоодын бизнес эрхлэгч – эздийн нэгдэж, хоршсон зах зээлийг бүрдүүлж эхлэх;
- 10.) “Орхон - говь” ус дамжуулах хоолой байгуулах иж бүрэн төсөл;
- 11.) эдийн засаг, нийгэм – соёлын хүрээнд инновацийн шинэ технологи, өндөр бүтээмж менежмент боловсруулж, нэвтрүүлэх;
- 12.) Нийгэм, соёл, эрүүл мэнд, боловсрол, спортын салбарын үйлчилгээний хүрээ, чанар, хүртээмжийг бүс нутгийн хэмжээнд төр – хувийн хэвшлийн нэгдмэл систем үүсгэн шинэчлэн сайжруулах. Залуу үеийг ажилтай болгох, сургаж, мэргэшүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх.

ГДБ-ийг хөгжүүлэх үзэл баримтлал (стратегийн)-ийг хэрэгжүүлэх арга хэрэгсэлийн талаар:

- Монголын улс төр, эдийн засгийн амьдралын хүрээнд нийгмийн өргөн зөвшилцөл, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдаас бий болгох харилцан ойлголцол, дэмжлэг;
- Төр, иргэн, орон нутгийн удирдлага, үйлдвэрлэлийн эзэд, шинжлэх ухаан – нийгмийн үйлчилгээний байгууллагын хамтын хүч чармайлт, оролцоо;
- Дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр, иж бүрэн төслүүдийг боловсруулах, газар байршилтыг тогтоох, хэрэгжүүлэх, хяналт – шинжилгээ хийх, хөрөнгө санхүү, төсөл, арга хэмжээг үе шат бүрээр тодотгох үүрэгтэй Төр – хувийн хэвшлийн (бүх талууд оролцсон) зөвлөлдөх, шийдвэр гаргах хороог Засгийн газрын дэргэд байгуулах;

- Үзэл баримтлал (цаашид стратегийн хөтөлбөр)-ыг хэрэгжүүлэх тулд “Өмнөт – Говийн дэд бүс”-ийн зөвлөл гэсэн тусгай статусыг бий болгож, дэд бүсийн зөвлөлд томоохон компанийн удирдлага, аймгуудын Засаг даргын орлогчид, орон нутгийн иргэдийн төлөөллийг оруулах;

- Аливаа томоохон иж бүрэн хөгжүүлэх төсөл, зорилтот хөтөлбөрийг “Дэд бүсийн гэрээ, хэлэлцээр”-ийн үндсэн дээр хэрэгжүүлэхээр болно.

Нийгэм, соёлын хөгжлийн бодлогын талаар:

а/ Боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар:

-бүс нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг харгалзан их, дээд сургуулийн төрөлжилт, байршлыг оновчтой тогтоож, сургалт-шинжлэх ухаан судлал-мэдээллийн холбоог бэхжүүлэн, сургалтын чанарыг дээшлүүлэх;

- бүс нутгийн болон орон нутгийн төв сууринд ерөнхий боловсролын цогцолбор сургууль, ахлах сургууль, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт, шатлалыг оновчтой тогтоож, уялдаатай хөгжүүлэх;

-мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг аймаг бүрт байгуулж, орон нутгийн зах зээлийн эрэлт, оюуны чадавхид зохицсон мэргэшилтэй ажиллах хүч бэлтгэх;

-аймгуудын мэргэжлийн урлагийн байгууллагуудын ангилал, байршлыг оновчтой тогтоож, соёлын төвүүдийг сум дунд үйлчлэх зориулалтаар шинэчлэн байгуулах;

- хөгжлийн таталцлын төв сууринд хотод шинжлэх ухаан, мэдээлэл-технологийн төвүүдийг байгуулахыг дэмжихийн хамт, бүс нутгийн нөөц, чадавхийг зах зээлд бүрэн зохистой ашиглах, хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, соёл иргэншлийн үнэт зүйлсийг хадгалан хамгаалах, говийн хүн амд суурин амьдралын шинэ үзэл бишрэлийг төрүүлэх чиглэлээр эрдэм судлал, туршилт, мэдээллийн ажлыг өргөжүүлэх.

б/ Эрүүл мэндийн талаар:

-бүсүүдийн хөгжлийн тулгуур төв хотуудын оношилгоо эмчилгээний төвийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ийм төвүүдийг шинээр байгуулах;

- мал аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэл эрхэлдэг алслагдсан орон нутагт/ Өмнөговийн баруун сумдад / эмчилгээ оношилгооны явуулын үйлчилгээ, яаралтай тусламж үзүүлэхэд нисдэг тэрэг ашигладаг болох;

-эмнэлгийн тусламж үйлчилгээнд теле-анагаахын сүлжээний дэвшилтэт хэлбэр нэвтрүүлж, хот, хөдөөгийн хүн амын тусламж үйлчилгээний чадамжийг дээшлүүлэх;

-сумдад "эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн сүлжээ байгуулж, эмнэлгийн суурь технологи"-ийг хөгжүүлэх;

-Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тусламжаар "Эрүүл хот" хөтөлбөрт ГДБ-ийн зарим аймгийн төв, сум дундын /бүлэг суурингийн / төвүүдийг үе шаттайгаар хамруулж эхлэх.

в/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар:

-хүн ам олноор суурьших хот, суурин/одоо байгаа цаашид байгуулах/-д хүн амыг ядуурлаас сэргийлэх, амьдрах ухаанд суралцуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих мэргэжлийн "инкубатор төв"-үүдийг байгуулж, хөдөлмөр, тэтгэвэр, тэтгэмж, даатгалын цогц үйлчилгээ үзүүлэх;

-бүлэг суурингийн төвүүдэд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажил эрхлэлтийг дэмжих "нөөцийн төв"-үүдийг байгуулж ажиллуулах;

-сум дундын төвүүд, зарим сумын төвд хөдөлмөр, нийгмийн үйлчилгээний төв байгуулж, хамт олон, гэр бүлийн гишүүдийн харилцан дэмжлэгт түшиглэн ажилгүйдэл, ядуурлаас сэргийлэх орон нутгийн чадавхийг дээшлүүлэх.

г/ Хүн ам уугуул нутагтаа амьдрах хэрэгцээ, бусад газарт чөлөөтэй шилжин суух сонирхол зэргийг харгалзсан нутагшилт, суурьшилтын олон хэв маяг бүхий бүсчилсэн тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх талаар:

- газар эзэмшлийн харилцааг гүнзгийрүүлэх, ус худаг ус хамгаалалт, нөхөн сэргээлтийн/бэлчээрийн менежментийг сайжруулах, байгаль, цаг уурын гамшигт үзэгдэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх замаар хүн ам нийслэл болон бусад аймаг, гадаад орон руушилжиж байгаа зохисгүй үзэгдлийн шалтгаан, үр дагаврыг судалж, сааруулах;
- ГДБ-ийн аймгийн төв, орон нутгийн бүлэг суурингийн татах чадварыг дээшлүүлж, дэд бүтцийн үйлчилгээний дотоод, гадаад сүлжээг сайжруулах арга хэмжээг эрчимжүүлэх замаар хүн ам суурьшин амьдрах өртөг хямд байх нөхцөлийг бүрдүүлж эхлэх;
- аймгуудын хоршилт, төрөлжилтийн чадавхид түшиглэн уул уурхай, амралт сувилал, аялал жуулчлалын бүс, чөлөөт бүс, байгалийн шинжлэл, судлалын болон агро үйлдвэрлэлийн парк байгуулах замаар хөгжлийн таталцлын олон голомтыг үүсгэж, бүсийнхээ хүрээнд хүн ам чөлөөтэй шилжин амьдрах бололцоог өргөжүүлэх.

Хөтөлбөрийн үзэл баримтлалыг удирдлагын түвшинд хэрэгжүүлэх санал, зөвлөмж

Энэхүү үзэл баримтлалыг үндэсний, бүсийн, аймгийн түвшний бодлого, арга хэмжээнд харилцан уялдаатай, тэгэхдээ тус тусын онцлогтой тусгахыг зөвлөмж болгож байна.

I. Үндэсний түвшинд:

1. Говийн дэд бүсийн Монгол Улсын эдийн засгийн өсөлт, экспортын боломжийг нэмэгдүүлэхэд тээвэр – газарзүйн байрлал, байгалийн эрдсийн баялгийн ашиглалт талаасаа онцгой хувь нэмэр оруулах боломжтойг харгалзан “Өмнөд говийн дэд бүсийн хөгжлийн бодлого” (цаашид “ГДБ”)-ыг “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”-ийн 10-р зүйлд заасны дагуу “үндэсний хөтөлбөр”-ийн түвшинд авч үзэж, Засгийн газраар батлуулан, төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүх талын оролцоо, харилцан дэмжлэгээр хэрэгжүүлэх;

2. Энэхүү хөтөлбөрийн төслийг Засгийн газарт оруулахын өмнө холбогдох бүх яам газар, мэргэжлийн холбоодод танилцуулж, тэдний санал, зөвлөмжийг тусгаж, тодотгон боловсруулж, ялангуяа хэрэгжих боломжийг нь сайтар хангаж, үндэслэсэн байх;

3. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр үндэсний эдийн засгийн өсөлт, хуримтлалыг нэмэгдүүлэх ямар бодит боломж гарахыг хөгжлийн үе шатаар төсөөлөн гаргах, мөн Өмнөд бүсийн ашигт малтмалыг эзэмших, байгаль орчныг хамгаалах талаар олон нийтийн дунд гарч буй маргаан, зөрүүтэй ойлголтыг цэгцэлж, нэгдмэл нэг үзэл бодлыг бий болгох ач холбогдолтойг тэмдэглэх;

4. Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ГДБ-ийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн яамд, мэргэжлийн холбоод, аймгуудын Засаг дарга нар оролцсон Ажил төрлийн “Зөвшилцөл зохицуулалтын байнгын хэсэг” байгуулж, улс, бүсийн ач холбогдолтой томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх салбар дундын уялдааг хангах, хөрөнгө санхүүгийн шаардлагатай нөөцийг бүрдүүлэх ажлыг хариуцуулах. “Ажлын хэсэг” хөгжлийн томоохон төслүүдийг “Бүсчилсэн хөгжлийн Гэрээ” (2010 онд баталсан, одоо хүчинтэй байгаа)-ний үндсэн дээр хэрэгжүүлэх ажлыг дэмжин зохицуулах;

II. Бүсийн түвшинд:

1. ГДБ-ийн хөгжлийн асуудлыг Монголын Төвийн, Хангайн бүсийн хөгжил (ялангуяа улс хоорондын худалдаа, дэд бүтцийн асуудал), Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах хэрэгцээ шаардлагатай уялдуулсан нэмэлт арга хэмжээг боловсруулж, цаашид гаргах “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд”-эд тусгах;

2. ГДБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн гол үзэл санаа

Говийн 4 аймгийн газарзүйн байрлал, байгалийн эрдсийн баялгийн тархалт, байгаль орчныг хамгаалах аж ахуй, соёлын нэгдмэл байдлыг хадгалах нийтлэг шаардлагад тулгуурлан “Говийн дэд бүс нутгийн эдийн засаг – нийгмийн нэгдсэн систем” буюу цогцолбор байгуулах зорилгоор холбогдох яам, мэргэжлийн холбоодын түвшинд дор дурдсан эдийн засаг, санхүүгийн макро төслүүдийг шинэчлэн боловсруулж, үе шаттай хэрэгжүүлэх:

- Уул уурхай – хүнд үйлдвэрийн цогцолборууд байгуулах;
- Шинжлэх ухаан – үйлдвэрлэл – технологийн паркууд байгуулах;
- Ази – Европ, ЗХА, ЗӨА-ийн орнуудтай холбосон улс хоорондын хурдны зам, төмөр зам байгуулж, худалдаа – тээвэр – борлуулалтын үр ашигтай системийг бүрдүүлэх;
- Эрчим дхүч, ялангуяа Говийн бүсийн нар, салхины дулааны эрчим хүчийг ашиглаж, эрчим хүч экспортлох;
- ГДБ-ийн аймгуудын үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээг хооронд нь хоршуулан холбох, дагнаж, төрөлжүүлэх, түүхий эд нийлүүлэх, бэлэн бүтээгдэхүүн борлуулах нэгдсэн зах зээлийн бүрдүүлэх;
- Аймгуудын хүн амын хүнс тэжээлийн эрэлт хэрэгцээг хангах бүсийн болон бүс нутгийн агро – үйлдвэрлэлийн цогцолборыг кластерийн түвшинд зохион байгуулах;
- Хангайн бүс (Булган, Өвөрхангай аймаг)-ийн голуудаас авах бүс дундын ус дамжуулах “Орхон Говь” төслийн ТЭЗҮ-ийг эцэслэн боловсруулж, 2020 оны наана хэрэгжүүлэх;
- Бүтээн байгуулалтын төслүүдтэй уялдуулан ГДБ-ийн байгаль орчин – нийгмийн нөлөөллийн үнэлгээ (2010 онд Оюу-толгой компаниас санаачлан боловсруулсан төслийн жишгээр) – хамтын менежментийг бүрдүүлэх;
- ГДБ-ийн эко – аялал жуулчлалын байгаль судлал, ховор амьтан ургамал, уул уурхайн орчныг нөхөн сэргээх (ойжуулалт) – олон улсын хамтын ажиллагааны загвар бүс нутаг бий болгох;
- ГДБ-д НҮБ-ын дэмжлэг оролцоотой “Төв Азийн цөлжилтийн судалгаа, дасан зохицлын төв” байгуулах;
- Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүсүүдийг олон улсын нийтлэг жишиг, оновчтой шалгуур чиглэлээр хөгжүүлэх, эдийн засгийн өсөлт, хуримтлалыг бий болгох;
- ГДБ-д хөрөнгө оруулалтын томоохон төслийн жишгээр “Байгаль орчны стратегийн үнэлгээ” (БОНХ-ийн яамны 2014 онд баталсан)-г хийлгэж, мөрдүүлэх;

III. Аймгийн түвшинд:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн 4 дүгээр зүйлд заасаг “аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт”-ын дагуу ГДБ-ийн энэ хөтөлбөртхэрхэн оролцох дээр дурдсан бүсийн түвшний төсөл арга хэмжээг аймаг, орон нутагтаа хэрэгжүүлэх “хэтийн зорилт”-оо тодорхойлох;

2. Хэтийн зорилтоо тодорхойлоход бүсийн болон бусад аймгийн хөгжилтэй уялдуулах үүднээс яам, аймаг, мэргэжлийн холбоод орсон ажлын нэгдсэн хэсэг байгуулж ажиллах;

3. Бүсийн аймгууд, сум орон нутгийн хөгжлийн уялдаа, хоршилтыг хангах үүднээс нутаг дэвсгэрээ бүсчлэх (бүлэг суурингийн төвүүд – бичил бүсүүдийг тогтоож, үйлдвэрлэл, үйлчилгээ хорших, түүхий эд татан авалт, бүтээгдэхүүн боловсруулах, борлуулах зах зээлийн сувгуудыг тодорхойлж, зураглах). Үзэл баримтлалаас ГДБ-д дараах бичил бүсүүдийг урьдчилсан байдлаар төсөөлж, аймгуудын хэтийн зорилтод тусгаж, цаашид тодотгох саналыг оруулж байна. Үүнд:

- Мандалговийн засаг захиргааны төвийн бичил бүс - Бүлэг суурингийн төв нь Мандалговь, хамрагдах сумд нь Сайхан-овоо, Дэлгэрхангай, Хулд, Луус, Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Дэлгэрцогт, Гурвансайхан, Өлзийт;
- Сайншандын засаг захиргаа, аж үйлдвэрийн бичил бүс - Бүлэг суурингийн төв нь Сайншанд, Иххэт, Алтанширээ, Дэлгэрэх, Сайхан дулаан, Өргөн, Эрдэнэ, Улаанбадрах, Замын-үүд, Зүүнбаян сумд;

- Оюутолгойн зам тээврийн зангилаа, уурхайн хот орчмын бичил бүс - Бүлэг суурингийн төв нь шинээр үүсэх Оюутолгой тосгон, Ханбогд, Баян-овоо сумд, Гашуунсухайт боомтын хамт;
- Даланзадгадын засаг захиргаа, зам тээврийн бичил бүс - Бүлэг суурингийн төв нь Даланзадгад, Номгон, Хүрмэн, Баяндалай, Булган, Ханхонгор, Мандал-овоо, Цогт-овоо;
- Чойрын зам тээврийн зангилаа, засаг захиргааны бичил бүс - Бүлэг суурингийн төв нь Чойр, Говьсүмбэр аймгийн Шивээ-овоо, Баянтал сумд, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-утгаал, Баянжаргалан, Өндөршил, Дорноговь аймгийн Даланжаргалан сумд;
- Цагаан суваргын зам тээврийн зангилаа, уурхайн хот орчмын бичил бүс -Бүлэг суурингийн төв нь шинээр үүсэх Цагаансуварга уурхайн суурин, Дорноговь аймгийн Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумд, Хангимандал боомтын хамт Цогтцэций зам тээврийн зангилаа;
- Тавантолгойн уурхай орчмын бичил бүс - Цогтцэций бүлэг суурингийн төвтэй. Шинээр үүсэх уурхайн тосгон, Манлай сумын хамт;
- Гурвантэсийн зам тээврийн зангилаа, нүүрс олборлох үйлдвэрлэлийн бичил бүс - Бүлэг суурингийн төв нь Гурвантэс сум, Ноён, Сэврэй сумд, Шивээхүрэнгийн боомтын хамт;
- Замын-Үүдийн олон усыг чөлөөт худалдааны бүс - Замын-Үүдийн олон улсын чөлөөт худалдааны бүс;

Оюутолгойн төслийн хөрөнгө оруулалтын гэрээний 4-р бүлгийн 4.1 – 4.4 дэх заалтын дагуу байгуулсан Өмнөговийн бүсийн хөгжлийн зөвлөлийг цаашид бүсийн хэмжээнд аймаг дундын аж ахуйн хоршилт, төрөлжилтийг хангах зорилтыг дэмжин чиглүүлэх үүрэгтэй “Товийн дэд бүсийн хөгжлийн зөвлөл” болгон өргөжүүлж, Засгийн газрын тогтоолоор батлуулах (Засгийн газрын 2012 оны 212-р тогтоолыг хүчингүй болгох). Зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах журмыг аймгуудын Засаг даргын төлөөлөл, Мэргэжлийн холбоод, толгойлох компани, мэргэжлий хүмүүсийг оролцуулж, үр дүнтэй ажиллуулахаар шинэчлэн тогтоох.

Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө


	Хийх үндсэн ажлууд	Санаачлагч ба оролцогч талууд	Хугацаа
0	1	2	3
1	ГДБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг Үндэсний Хөгжлийн газарт танилцуулж, ЗГ-т оруулж батлуулан, холбогдох яам, газар, аймгуудын ЗДТГ-т хүргүүлэх	ҮХГ, МУИС-ийн ЭЗХүрээлэн	2019 оны 4, 5-р сар
2	ГДБ-ийн хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөр боловсруулах асуудлаар төв орон нутагт явуулсан нэгдсэн болон салбарын судалгааны мэдээ тайлан, баримталсан арга зүйг нэгтгэж, ҮХГ-ын мэдээллийн сан, “Оюу –толгой” ХК-ийн цогц мэдээллийн сан, холбогдох яам, аймгуудын вэб сайт, мэргэжлийн холбоодын цахим хуудсанд тус тус байршуулах	ЗГХЭГ, ҮХГ, “ОТ” ХК, МУИС-ийн ЭЗХ, мэргэжлийн холбоод	2019 оны 4 – 6-р сар
3	ГДБ-ийн хөгжлийн батлагдсан хөтөлбөрийн тэргүүлэх арга хэмжээг улсын хөгжлийн нэгдсэн бодлого, холбогдох аймгуудын	ЗГХЭГ, ҮХГ, аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын тамгын газар, Дэд бүсийн зөвлөл, мэргэжлийн холбоод	2019 – 2020 он

	хөгжлийн баримт бичгүүд болон “Оюу – толгой” ХК, “Эрдэнэс – Таван толгой” ХХК-ийн бизнес стратегийн төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авах		
4	ГДБ-ийн хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн тэргүүлэх чиглэл болон байгаль орчны асуудлаар нэмэлт төсөл, арга хэмжээ боловсруулж, хэрэгжилтийг зохицуулах	ЗГХЭГ, Сангийн яам, ҮХГ, Холбогдох яам, газрууд, Дэд бүсийн зөвлөл, мэргэжлийн холбоод	2020 оноос үе шаттайгаар
5	ГДБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг олон нийтэд мэдээлж, арга хэмжээг тодотгох	ЗГХЭГ, ҮХГ, Холбогдох яамд, аймгуудын ЗДТГ, Дэд бүсийн зөвлөл, мэргэжлийн холбоод	2020 оноос үе шаттайгаар

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 2010 оны 48-р тогтоолын хавсралт. <http://www.legalinfo.mn>
2. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. 2011 он. <http://www.legalinfo.mn>
3. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн гарын авлага. Сангийн яам. УБ 2016. <http://www.legalinfo.mn>
4. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журам. ЗГ-ын 2016 оны 249-р тогтоол. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн гарын авлага. 27х. <http://www.legalinfo.mn>
5. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030. УИХ-ын 2016 оны 19-р тогтоолын хавсралт. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн гарын авлага. <http://www.legalinfo.mn>
6. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 97-р тогтоолын хавсралт. <http://www.legalinfo.mn>
7. Чөлөөт бүсийн тухай хууль. 2015 он. <http://www.legalinfo.mn>
8. Өмнөд говийн дэд бүтцийг хөгжлүүлэх хөтөлбөр. ЗГ-ын 2010 оны 151-р тогтоол. <http://www.legalinfo.mn>
9. Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр. 2014 он.
10. Процедура разработки концепции развития региона на прогнозируемый период. <http://referat-work.ru>
11. Методы и технологии разработки концепций и программ. <http://studfiles.net>
12. Концепция социально-экономического развития Иркутской области РФ. <http://inkut.info.ru>

**ХАВСРАЛТ 1. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛЫН ЛОГИК - БҮТЭЦ**




ХАВСРАЛТ 2. ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН БҮРДЭЛ ХЭСГҮҮД, УЯЛДАА, МАТРИЦ

А. Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлалын бүрдэл хэсгүүд, уялдаа



Б. Үзэл баримтлалын дэс дараалал (алхмууд)-ын матриц - схем



**ХАВСРАЛТ 3. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ГАРСАН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН
БАРИМТ БИЧГҮҮД**

№	Хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр	Хамрах хугацаа	Батлагдсан он
1	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал УИХ-ын 57 –р тогтоол	2001-2020	2001
2	Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль	Одоо хүчинтэй байгаа	2003
3	Зарим бүс/Баруун Хангайн, Төвийн, Зүүн/- ийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 202-р тогтоол	2006-2015	2005
4	Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги/ 2010 он хүртэлх/ УИХ –ын 24-р тогтоол	2003 – 2010 он	2003
5	Бүсийн тулгуур төв хотуудын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлах тухай. ЗГ-ын 201-р тогтоол	2005-2020 он хүртэлх	2005
6	Чөлөөт бүсийн тухай хууль	Шинэчлэн найруулсан	2015

**ХАВСРАЛТ 4. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТ
БИЧГҮҮД /БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭГ ТУСГАСАН/**

№	Аймаг нийслэл	Хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр	Хамрах хугацаа	Батлагдсан он
1	Архангай	Архангай аймгийн 2006-2015 оны хөгжлийн хөтөлбөр	2006-2015	2006
2	Баян-Өлгий	Баян Өлгий аймгийн хөгжлийн хөтөлбөр	2010-2020	2009
3	Баянхонгор	Баянхонгор аймгийн хөгжлийн хөтөлбөр	2006-2020	2006
4	Булган	Булган аймгийн эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр	2006-2020	2005
		Булган аймгийн хөгжлийн 2010-2021 оны цогц бодлого	2010-2021	2010
5	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого	2008-2021	2008
6	Говьсүмбэр	Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр	2003-2020	2003

		Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2010-2021 оны цогц бодлого /төсөл/		
7	Дархан-Уул	Дархан-Уул аймгийн 2009-2021 он хүртэлх хөгжлийн цогц бодлого	2009-2021	2009
8	Дорноговь	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө	2011-2021	2011
		Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр	2002-2020	2002
9	Дорнод	Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлого	2009-2021	2009
10	Дундговь	Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого	2003-2020	2003
11	Завхан	Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого	2009-2021	2009
12	Орхон	Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого	2009-2021	2009
13	Өвөрхангай	Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлого	2007-2015	2006
14	Өмнөговь	“Байгалийн баялаг – Сайн засаглал – Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр	2010-2020	2009
15	Сүхбаатар	Сүхбаатар аймгийн хөгжлийн хөтөлбөр	2007-2015	2007
16	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн 2007-2021 оны хөгжлийн хөтөлбөр	2007-2021	2007
17	Төв	Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр	2008-2023	2008
18	Увс	Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр	2008-2021	2008
19	Ховд	Ховд аймгийн хөгжлийн хөтөлбөр	2007-2015	2007
20	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр	2008-2015	2008
21	Хэнтий	Хэнтий аймгийн хөгжлийн 2009-2021 оны цогц бодлого /төсөл/		
22	Нийслэл	Улаанбаатар бүсийн хөгжлийн хөтөлбөр	2006-2015	2006
		Улаанбаатар хотын “Мянганы хөгжлийн зорилтууд”	2009-2015	2009
		Улаанбаатар хотыг 2020 оны хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн хандлага	2013	

ХАВСРАЛТ 5. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАГВАР /ЗГ-ЫН 2005 ОНЫ ТОГТООЛООР БАТЛАГДСАНААР/

Үндэсний хороо	
<ul style="list-style-type: none"> • Үндэсний хорооны дарга – Ерөнхий сайд • Орлогч дарга – Тэргүүн шадар сайд • Засгийн газрын гишүүн-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга; • Байгаль орчин, зам, тээвэр, аялал жуулчлал, барилга, хот байгуулалт, түлш, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд; • Бусад яамдын Төрийн нарийн бичгийн дарга; • Бүсийн Зөвлөлийн дарга нар 	<ul style="list-style-type: none"> • Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, • Бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох
↓	
Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооны дэргэдэх Ажлын алба	
<ul style="list-style-type: none"> • Бүсийн зөвлөлийн дарга нар /5 бүсийн/ • Тухайн бүсэд багтаж буй аймгийн Засаг дарга • Бүсийн хөгжлийн тулгуур төв хотын захирагч • Нийслэлийн хувьд нийслэл, дүүргийн засаг дарга, дагуул хотын захирагч 	<ul style="list-style-type: none"> • Бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, • Бүсийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах

ХАВСРАЛТ 6. ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ҮНДЭСНИЙ, БҮСИЙН, АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ХАМТРАН АЖИЛЛАХ АСУУДЛУУД (“ОЮУТОЛГОЙ” ХХК-ИЙН ЖИШЭЭГЭЭР)

Улсын хэмжээний болон салбарын хөгжлийн судалгаа, төслийн ажилд Оюу толгойн стратегийн төслийг гол төлөв уул уурхайн олборлох үйлдвэрийн хэмжээнд хэрэгжиж буй гадаадын хөрөнгө оруулалттай арга хэмжээ болох талаас нь түлхүү авч үзэж, нийгэмд ойлгуулж ирсэн байна. Тэгвэл, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлж, төвлөрлийг сааруулах зорилгын үүднээс Оюу толгойн ордыг ашиглах асуудлыг Монголын тогтвортой өсөлт, хөгжлийг тэтгэх учиртай төр засаг, аймаг, орон нутаг, компанийн хамтын ажиллагаа, харилцан уялдааны үндсэн дээр хэрэгжих улс үндэстэн дамнасан цогц хөтөлбөр гэж авч үзэх нь илүү үр дүнтэй, ирээдүйтэй байх боломжтойг бидний хийсэн үнэлгээ, төсөөлөл харуулж байгаа юм. Үүнд, наад зах нь дараах нөөц, боломжууд, тэдгээрийг ашигласнаар ирээдүйд бий болох эдийн засаг, нийгмийн үр ашгийг хүлээж болох байна:

- 1.) Оюу толгойн ашигт малтмалын орд нь зэс, алтны зэрэгцээ молибден, мөнгө гэх мэт бусад дагалдах эрдсийг агуулсан зөвхөн уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн төдийгүй хүнд үйлдвэрийн салбар дундын цогцолбор (кластер) хөгжүүлэх чадавхитай болох;
- 2.) Улс хоорондын үйлдвэрлэл, үйлчилгээний дэд бүтцэд тулгуурлан дээрх чадавхийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид хамтран ашиглаж, өндөр өртөг бүхий экспортын үйлдвэрлэлийг үе шаттай хөгжүүлэх боломжийг бүрдүүлснээр одоогийн Оюу толгой компанийг үндэстэн дамнасан, тогтвортой үр ашгаа өгөх, хоршиж дагнасан том аж ахуйн хэмжээнд шинэчлэн гаргах;

- 3.) Тус улсын үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт орчин үеийн инновац, дэвшилтэт технологи, менежмент нэвтрүүлж, түүнийг говийн аймгууд, цаашдаа бусад бүс нутагт дэлгэрүүлэх;
- 4.) Жижиг, том үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд мэргэшсэн, бүтээмж сайтай ажиллах хүчийг бэлтгэн, дадлагажуулж, бусад аймаг, бүс нутагт нийлүүлэх;
- 5.) Говийн бүс нутагт орчин үеийн инженерийн дэд бүтэц бүхий хот суурин хөгжих эхлэлийг тавьж, Улаанбаатар хот болон бусад бүс нутгаас хүн ам шилжин суурьшиж, төвлөрөл саарах;
- 6.) Хөгжингүй орны жишгээр үйлдвэрлэл эрхлэх, байгаль орчинд ивээлтэй дэвшилтэт техник, технологи, менежмент үе шаттай нэвтрүүлэх, ирээдүйд монголын говийн байгалийн их нөөцийг экосистемийн даацад нь нийцүүлэн зохистой эзэмших, нөхөн сэргээх тогтвортой хөгжлийн загвар бүс нутаг болох;

Эдгээр боломж, нааштай үр дагаварыг буй болгох гол арга зам нь тэдгээрийг дан ганц одоогийн Оюу толгой ХХК-д үүрүүлэх бус, харин тус компанитай боломжтой бүх түвшинд хамтран ажиллаж, оролцогч талууд хойшид авах ашиг орлого, гарч болзошгүй эрсдлийг харилцан хуваалцах нь зүйтэй байна. Үүнтэй уялдан, “Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийн энэхүү төслийг баталж, хэрэгжүүлэх хүрээнд, Оюу толгой ХХК-тай үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд хамтран ажиллах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дор дурдсанаар төлөвлөж, төсөлд тусгалаа.

Нэгдүгээрт, үндэсний (УИХ, Засгийн газар) хэмжээнд:

- 1.) Энэхүү хөтөлбөрийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж, “Төвийн бүсийн Говийн дэд бүсийг хөгжүүлэх зорилгот хөтөлбөр” болгон байгуулах. УИХ-ын тогтоолд хөтөлбөрийн удирдлага нь “Засгийн газрын Ажлын байнгын хэсэг” байхаар зааж, Засгийн газар, Оюу толгой ХХК-ийн харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгөх;
- 2.) УИХ-ын түвшинд, улсын хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй уялдуулан “Засгийн газар, Оюу толгой ХХК”-ийн хөрөнгө оруулалтын гэрээ (ХОГ)-г шинэчлэн баталж, мөрдүүлэх;
- 3.) Засгийн газрын “Ажлын байнгын хэсэг”-ийн бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг Засгийн газрын тогтоолоор баталж, мөрдүүлэх;
- 4.) Шаардлагатай үед зорилгот хөтөлбөрийн хэрэгжилтийг түргэтгэх зорилгоор холбогдох яам, Оюу толгой ХХК-ийн хооронд хамтран ажиллах гэрээ (ХАГ)-г байгуулж, Ерөнхий сайдаар батлуулж ажиллах;
- 5.) Дээр дурдсан ХОГ, ХАГ-д үндэсний ач холбогдолтой дор дурдсан асуудлыг шийдвэрлэхэд Оюу толгой ХХК-ийн зүгээс оролцох чиглэл, холбогдох дэмжлэгийн арга хэмжээг тус компанийн саналаар тусгайлан тусгаж ажиллах:
 - Баялгийн болон хөгжлийн сан байгуулж, ашиглах;
 - Эрдсийн нөөц, дагалдах түүхий эдийг иж бүрэн ашиглах, гүн боловсруулах үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах, ашиг хуваарилах;
 - Үйлдвэрлэл, үйлчилгээнд дэвшилтэт техник, технологи (инноваци) нэвтрүүлэх, бусад бүс нутагт нутагшуулах;
 - Байгаль орчны хамтын менежментийг бүрдүүлэх;
 - Улс, бүсийн ач холбогдолтой эрчим хүч, зам тээвэр, усан хангамж, дамжуулах хоолой, мэдээлэл – холбооны дэд бүтцийг сайжруулах, шинээр байгуулах;
 - Говийн бүсэд болон бүсээр дамжуулан улс хоорондын худалдаа – эдийн засгийн коридор, тээвэр – логистикийн төвүүд, үндэстэн дамнасан төрөлжиж, дагнасан аж ахуй байгуулах;
 - Хил, худалдаа, гаалийн чөлөөт бүс байгуулах, шинжлэх ухаан – үйлдвэрлэл, үйлчилгээ (мэргэжил сургалтын чадавхийн, шинжлэх ухаан – технологийн, аялал жуулчлал – экологи, түүх – соёлын, байгаль судлал, нөхөн сэргээлтийн г.м төрөл бүрийн парк, кластер, төвүүд)-ний цогцолборууд хөгжүүлэх г.м.

Хоёрдугаарт нь, бүсийн болон орон нутгийн хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд Оюу толгой компанийн үүрэг, оролцоог Говийн бүсийн 4 аймаг, энд ашиглалтад орсон болон ойрын үед хэрэгжих

нийтлэг ач холбогдолтой бусад томоохон төсөл арга хэмжээ (Эрдэнэс Таван Толгой, Цагаан суварга, Тэвшийн говь, Алтанширээ г.м)-ний үр дүнг нэгтгэн, цогц байдлаар, уялдаатай авч үзэх нь бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлого, хүлээгдэж буй үр дүнд илүү нийцнэ гэж үзэж байна. Зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлого, зохицуулалтад Оюу толгойн асуудлыг дараахь гурван үндсэн чиглэлээр хамруулж шийдвэрлэх боломжтой юм. Үүнд:

- Оюу толгой - Таван толгой – Цагаан суварга (“Галбын говийн”), цаашдаа Оюу толгой – Баянжаргалан – Тэвшийн говь (Дундговь) – Алтанширээ, тэдгээрийн ойролцоо хот сууринг холбосон үйлдвэрлэл, үйлчилгээ, мэдээлэл – технологийн дэд бүтцийн таталцлын босоо, хэвтээ тэнхлэгийг байгуулах;
- Дэд бүтцийн таталцлын тэнхлэг, өсөлтийн төв (кластер)-д тулгуурлан Оюу толгойн орчим (Ханбогд)-д орчин үеийн хот суурин байгуулж, говийн бүсийн аймгуудын хүн амын ажиллаж, амьдрах мэдлэг чадварыг дээшлүүлэх мэдээлэл – сургалт – инновацийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх;
- Оюу толгой ХХК-ийг үндэстэн дамнасан корпораци (нэгтгэл)-ийн жишгээр шинэчлэн зохион байгуулж, үйлдвэрлэлд дэлхийн тэргүүний технологи, өндөр бүтээмж, удирдлага, санхүүгийн менежмент – маркетингийг нэвтрүүлж, бусад газарт нутагшуулах говийн бүсийн инновацийн гол төв болж хөгжих.

Эдгээр арга хэмжээг Говийн дэд бүсийн хэмжээнд бүсийн зөвлөл (аймгуудын удирдлага, томоохон компаниудын захирлууд орсон) байгуулж, “Бүсийн хөгжлийн хэлэлцээр” (ийм журам бий), бүсийн хөгжлийг дэмжих сан (Оюу толгой ХХК-ийн Говийн хөгжлийг дэмжих санг холбох)-гаар дамжуулан хэрэгжүүлэх боломжийг судалж, хөтөлбөрийн эхний үе шат (2021 – 2016)-тай шийдвэрлэх.


Гуравдугаарт нь, аймаг орон нутгийн түвшинд, Оюу толгой компаниас зарим аймаг (Өмнөговь), сум (Ханбогд, Манлай, Баян-овоо г.м)-тай хамтран ажиллаж байгаа дор дурдсан төсөл, хөтөлбөрийн хамрах хүрээ, бүрдэл хэсгүүдийг нь шинэчлэн, өргөжүүлж, харилцан үр өгөөжийг нь сайжруулах үндсэн дээр говийн бүсийн хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд оруулах хувь нэмрийг нь нэмэгдүүлэх чиглэл барьж болох юм. Үүнд:

- Эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр, төслийг өргөжүүлж, бүсийн чанартай эмчилгээ – оношилгооны орчин үеийн төв байгуулах;
- Хамтын оролцоотой багйаль орчны хяналт, үнэлгээний хөтөлбөр;
- Усыг хэмнэх, хаягдал сангийн усыг эргүүлэн ашиглах төсөл;
- Бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх, хамтын оролцоотой бэлчээрийн менежментийн төсөл;
- Малчдын амьжиргааг дэмжих цогц арга хэмжээний хөтөлбөр;
- Соёлын өвийн менежментийн хөтөлбөр (түүх, палеонтологи – археологи, аялал жуулчлал ороод);
- Орон нутгийн бизнес, эдийн засгийг дэмжих хөтөлбөр (бүтээмж, инновац, нэмүү өртгийн сүлжээ, компанийн удирдлага, санхүүгийн менежментийн төслүүдээр өргөжүүлэх);
- Мэргэжилтэй ажиллах хүчийг сургаж бэлтгэх, цахим мэдээлэл (мэдээллийн ил тод байдлыг хангах)-ийн гэсэн бүрдэл хэсэгтэй шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх;

“Оюу толгой” стратегийн төслийн чадамжийг бүрэн ашиглах хүрээнд, Оюу толгой ХХК-тай хамтран ажиллах боломж, чиглэлийн талаарх дээрх төсөөллийг Засгийн газар, компанийн түвшинд дахин тодотгох, эцэслэн зөвшилцөх шаардлагатай тул “Говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийн төсөлтэй хамтад нь батлах боломжгүй юм. Түүнийг батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Зөвлөмж” байдлаар цаашид тодотгон, уян хатан хэрэгжүүлэхээр тогтоолын төсөлд хавсарган Засгийн газар, холбогдох аймгууд, Оюу толгой ХХК-д чиглэл болгон хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

--- 000 ---

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, БАЙРШЛЫН СУДАЛГАА Эцсийн тайлан



Зөвлөх:

С.Намжилмаа

(Монгол Улсын Зөвлөх Архитектор)

Ахлах судлаач:

М.Алтанбагана

(доктор PhD)

Судлаач:

Х.Билгүүн

(Хот төлөвлөлтийн архитектор)

2019 он

Зөвлөх: С.Намжилмаа (Монгол Улсын Зөвлөх Архитектор)

Ахлах судлаач: М.Алтанбагана (доктор, дэд профессор, ШУА-ын Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын дарга)

Судлаач: Х.Билгүүн (Хот төлөвлөлтийн архитектор)

Хаяг: Монгол Улс. Улаанбаатар хот. Баянгол дүүрэг.
Амарсанаагийн гудамж. Колорадо төв, 209 тоот

Энэхүү тайланд захиалагч болон санхүүжүүлэгчийн
байр суурийг биш, харин судлаачийн байр суурийг илэрхийлсэн болно.

АГУУЛГА

Талархал

Товчилсон үгийн жагсаалт

Хүснэгтийн жагсаалт

Зургийн жагсаалт

Хураангуй

НЭГ. УДИРТГАЛ

1.1 Судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлага

1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт

1.3 Судалгааны ажлын хамрах хүрээ

ХОЁР. БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

2.1 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх үе шат, аргачлал

2.1.1 Хөгжлийн бодлогод шинжилгээ хийх үе шат

2.1.2 Хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт тодорхойлох

2.2 Төвийн бүсийн говийн дэд бүсийн Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын хөгжлийн бодлогод хийсэн шинжилгээ

ГУРАВ. ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗУРАГЛАЛ

3.1 Хөгжлийн ирээдүй сайтай сум, хот, сууринг тодорхойлох арга зүй, шалгуур үзүүлэлт

3.2 Хөгжлийн ирээдүй сайтай сум, хот, сууринг тодорхойлсон үр дүн

3.3 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын өнөөгийн байдал

3.4 ДҮГНЭЛТ

Ашигласан эх сурвалж:

ТАЛАРХАЛ

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үндэслэн Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинээр боловсруулж буй энэ цаг үед Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, түүний хүрээнд орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршлын судалгааг хийж байгаа нь бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах ажилд чухал хувь нэмэр оруулж байна.

Тус ажлыг санаачилсан, санхүүжүүлсэн, судалгааны ажлыг удирдан зохион байгуулсан Үндэсний хөгжлийн газар, Оюутолгой компани, МУИС-ийн Эдийн Засгийн Хүрээлэнд оюуны хөрөнгө оруулалт хийж хамтран ажилласанд судалгааны багийн хамт олны зүгээс талархсанаа илэрхийлж байна.

Төвийн бүсийн Говийн дэд бүсийн аймгуудын удирдлагууд, судалгааны үр дүнг бодлого, шийдвэртээ тусган, хөгжлийн хөшүүрэг, хөтөч болгон орон нутгаа хөгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Судалгааг боловсруулахад идэвхи санаачлага гарган ажилласан судалгааны багийн эрдэмтэн, судлаач нартаа талархал илэрхийлж эрдэм шинжилгээ судалгааны ажилд нь өндөр амжилт хүсье.

Судалгааны багийн Зөвлөх С.Намжилмаа (Монгол Улсын Зөвлөх Архитектор)

Товчилсон үгийн жагсаалт

БХҮБ	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
ТХҮБ 2030	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030
ТХЗ	Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГС	Говьсүмбэр
ДО	Дорноговь
ДУ	Дундговь
ӨМ	Өмнөговь
ОХУ	Оросын Холбооны Улс
ШУТПарк	Шинжлэх Ухаан Технологийн Парк
ИДС	Их, Дээд сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ХАА	Хөдөө аж ахуй
ШҮ	Шалгуур үзүүлэлт
АНР	Analytic hierarchical process
ХН	Харгалзах жин

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 2.1.2** Бүсчилсэн хөгжлийн агуулгаар орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт
- Хүснэгт 2.2.1** Бодлогын шинжилгээ хийсэн баримт бичгүүд
- Хүснэгт 2.2.2** Аймгуудын хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтууд (салбараар)
- Хүснэгт 2.2.3** Аймгуудын хөгжлийн бодлогын шинжилгээ
- Хүснэгт 3.1.1** Хөгжлийн ирээдүй сайтай сум, хот, сууринг тодорхойлох шалгуур үзүүлэлт
- Хүснэгт 3.2.1** Төвийн бүсийн говийн дэд бүсийн сум тус бүрийн шалгуур үзүүлэлтэд харгалзах жин ба ижил эрэмбэтэй гэж үзэн нийт жингээр нь эрэмбэлсэн байдал
- Хүснэгт 1.2.2** Хөгжлийн ирээдүй сайтай сумдыг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг матрицаар эрэмбэлсэн байдал /АНР бодуулсан харгалзах жин/
- Хүснэгт 3.2.3** Ижил жингийн болон шаталсан үнэлгээний аргачлалаар үнэлж гаргасан Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн ирээдүй сайтай сумууд /аймаг бүрээр/
- Хүснэгт 3.4.1** Улс, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад өгөх санал

Зургийн жагсаалт

- Зураг 2.1.1** Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх аргачлалын үе шат
- Зураг 2.1.2.1** Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх арга зүйн схем
- Зураг 2.1.2.2** Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтийн ангилал
- Зураг 2.2.1** Аймгуудын хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтууд (салбараар, хувиар)
- Зураг 2.2.2** Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (2003-2020) Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)
- Зураг 2.2.3** Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого (2002-2020) Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/
- Зураг 2.2.4** Дундговь аймгийн 2020 он хүртлэх хөгжлийн бодлого
- Зураг 2.2.5** “Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он)
- Зураг 3.2.1** Төвийн бүсийн говийн дэд бүсийн сумдыг 15 үзүүлэлтээр баллаар нэгтгэн үнэлсэн үзүүлэлтийн зураглал
- Зураг 3.2.2** Төвийн бүсийн говийн дэд бүсийн сумдыг шаталсан дүн шинжилгээний аргаар нэгтгэн үнэлсэн үзүүлэлтийн зураглал
- Зураг 3.3.1** Монгол Улсын хүн амын нутагшилтын тогтолцоо /2002 он/
- Зураг 3.3.2** Хот суурины төвлөрөл /2002 он/
- Зураг 3.3.3** Монгол Улсын хүн амын нутагшилтын тогтолцоо /2017 он/

Зураг 3.3.4 Хот суурины төвлөрөл /2017 он/

Зураг 3.3.5 Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог /Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол/

Зураг 3.3.6 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүн амын нягтшил

Зураг 3.3.7 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ

Зураг 3.4.1 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн стратеги

Зураг 3.4.2 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн чиг хандлага

ЭДДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЭЛЭН

ХУРААНГУЙ

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинээр боловсруулах явцад бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд өөрчлөлт орох магадлал байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Төвийн бүсийн өмнөд хэсэгт уул уурхай, хүнд үйлдвэр, археологи, палеонтологийн чиглэлийн тусгай сонирхлын аялал жуулчлал зэрэг улсын тэргүүлэх салбарууд хөгжиж, эрчимтэй хөгжлийн дэд бүс болон хөгжих нөхцөл бүрдээд байна. Иймээс Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын нутаг дэвсгэрийг Төвийн бүсийн говийн дэд бүс болгон хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа дэд бүсийн аймгуудын одоогийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд шинжилгээ хийж, санал зөвлөмж өгч, хөгжлийн ирээдүй сайтай сум, хот, сууринг тодорхойлон, хөгжил, байршлын орон зайн төлөвлөлт, зураглалыг боловсруулах шаардлагатай.

Түлхүүр үгс: Бүсчилсэн хөгжлийн бодлого, Төвийн бүсийн Говийн дэд бүс, Бодлогын шинжилгээ, Хөгжил, байршлын орон зайн төлөвлөлт, зураглал

НЭГ. УДИРТГАЛ

1.1 Судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлага

Үндэслэл.

Тус судалгааг Үндэсний хөгжлийн газрын захиалгаар хийж байгаа бөгөөд тус газар нь “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн хамтран боловсруулах чиг үүрэгтэй. Мөн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2017 оны 15 дугаар тогтоолын 5 дугаар заалтад тус газарт Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах талаар чиглэл өгсөн.

Төвийн бүсийн говийн дэд бүсийн “Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршлын судалгаа” нь “Бүсчилсэн хөгжлийн бодлого” боловсруулах ажлын хүрээнд хийгдэж байгаа бөгөөд судалгааны үр дүн, санал, зөвлөмжийг бүсчилсэн хөгжлийн болон тухайн бүсэд хамаарах Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын хөгжлийн бодлогод тусган хэрэгжүүлэх боломжтой.

Бүс нутгийн хүрэн дэх хэрэгцээ шаардлага

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн боловсруулсан Монгол Улсын Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацаа (нэгдүгээр үе шат-2006-2010 он, хоёрдугаар үе шат-2011-2015 он) дууссан.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан шинээр боловсруулах шаардлагатай байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд баталсан бөгөөд одоогийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, олон улсын харилцаа тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн өөрчлөгдөөд байна.

Даяаршлын нөхцөлд дэлхийн улсууд, түүний дотор хоёр хөрш орон болох ОХУ, БНХАУ-ын геополитик, геоэдийн засгийн бодлогын чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж, ОХУ нь Зүүн хойт Ази, Номхон далайн орнуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхийг зорих боллоо. БНХАУ нь Ази, Европыг холбож байсан торгоны замын худалдаа, эдийн засгийн харилцааг үндэслэн “Нэг бүс-Нэг зам” бодлогыг тодорхойлж, энэ чиглэлд татагдаж байсан бүх орон, түүний дотор Хятад-Монгол-Орос гурван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг багламжилж, хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

Орон нутгийн хүрэн дэх хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын өргөн уудам газар нутаг, түүний газрын доорх болон дээрх нөөц баялагийг дотоод, гадаад зах зээлд бүрэн, зохистой ашиглаж, үр өгөөжийг нь зөв хуваарилаж ирээгүйгээс ажилгүйдэл, ядуурал ихсэж, хүн амын амьдралын түвшин жигд дээшилж чадалгүй, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хот болон уул уурхайн цөөн тооны төв суурин газар руу шилжин суурьших, гадаад оронд гарч ажиллах явдал үргэлжилж байна.

Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрөл нь эдийн засгийн үр ашгийг тогтвортой нэмэгдүүдэх өсөлтийн хүчин зүйл болхоосоо илүү, хотын хүрээлэн буй орчны даац, чанарыг муутгаж, оршин суугчдын амьдрал, эрүүл мэндэд ноцтой нөлөөлсөн олон тооны сөрөг үр дагаврыг харуулж, үндэсний аюулгүй байдлын түвшинд хүрээд байна.

Хүн амын төвлөрлийг сааруулах талаар хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр тухайлбал чөлөөт бүсүүд, аж үйлдвэрийн парк, бүсийн тулгуур төвүүдийн төслүүд улсын хөрөнгө оруулалтын

хөтөлбөр, төсөв санхүүгийн бодлого, арга хэмжээтэй уялдаж чадаагүйгээс үр дүн хангалтгүй хэрэгжихгүй байгаа асуудал байсаар байна.

1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт

Зорилго

Төвийн бүсийн говийн дэд бүсийн “Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршлын судалгаа”-ны зорилго нь тухайн дэд бүсэд байрлаж буй Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, учир шалтгааныг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Зорилт

1) Бүсчилсэн хөгжлийн агуулгаар боловсруулсан шалгуур үзүүлэлтээр төвийн бүсийн говийн дэд бүсийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын хөгжлийн бодлогод дүн шинжилгээ хийх

2) Төвийн бүсийн говийн дэд бүсийн түвшинд хөгжлийн ирээдүй сайтай сум, сууринг тодорхойлж, дэд бүсийн хөгжил байршлын нэгдсэн төлөвлөлт, зураглалыг боловсруулж, улмаар Монгол Улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлогын баримт бичигт тусгах санал, зөвлөмж боловсруулах

1.3 Судалгааны ажлын хамрах хүрээ

Монгол Улсын Төвийн бүс, Төвийн бүсийн говийн дэд бүсийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгууд тэдгээртэй хил залгаа аймаг, хөрш улсын хүрээнд судалгааг хийсэн.

ХОЁР. БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

2.1 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх үе шат, аргачлал

2.1.1 Хөгжлийн бодлогод шинжилгээ хийх үе шат

Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх төвлөрлийг сааруулах агуулгаар аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт бодлогын шинжилгээ хийж, дүгнэлт өгөхдөө дараахь үе шат, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

Схем 2.1.1 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх аргачлалын үе шат



Эх сурвалж: Судалгааны баг

2.1.2 Хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт тодорхойлох

Бүсчилсэн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг дэлхийн Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг хангах асуудалтай уялдуулан, тухайн улс орон бүр өөрийн онцлог, нөхцөлд тулгуурлан харилцан адилгүйгээр тодорхойлж байна.

Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх “шалгуур үзүүлэлт”-ийг тодорхойлохдоо, бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь бүсчилсэн хөгжлийн болон үндэсний түвшиний хөгжлийн бодлоготой уялдах дараахь *агуулга, хэв шинжийг* хамрах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлах;
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол агуулга, бодлогын зорилго, зорилтуудад тулгуурлах;
- *Доороос дээш*: Аймаг орон нутаг нь бүс нутгийн болон үндэсний түвшний хөгжилд ямар үүрэг гүйцэтгэх талаарх бодлогын зорилтуудаа тодорхойлж, хөгжлийн бодлогын баримт бичигтээ тусгах;
- *Дээрээс доош*: Аймаг орон нутгийн хөгжлийн бодлого нь бүс нутгийн, салбарын, үндэсний түвшний бодлого, хөтөлбөртэй уялдах;
- Бүсчилсэн хөгжлийн онолын хандлага, үзэл санаатай хэр нийцэх;
- Бодлогод орон зайн хөгжлийн хамаарал (нийгэм, эдийн засаг, байгаль орчин) –ын хувьд хамтрах, өөр хоорондоо хоршин хөгжих зорилт тусгагдсан эсэх;
- Орон нутгийн онцлог, хөгжлийн **нөөц, боломжийг** ашиглах;
- Ижил төстэй бодлогын зорилтын давхцал байгаа эсэх;

Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх “шалгуур үзүүлэлт”-ийг тодорхойлохдоо бүсчилсэн хөгжилтэй холбоотой дараахь *суурь ойлголт (keystones)*-ыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- Бүс нутаг-хотжилт-хөдөө нутгийн нэгдмэл орчныг бий болгох;
- Босоо ба хөндлөн тэнхлэгийн бүсчлэл;
- Коридор /эдийн засгийн, тээвэр хөгжлийн, ногоон хөгжлийн г.м/;
- Эдийн засгийн хөгжлийн бүс;
- Эдийн засгийн зохицуулалтын нийтлэг болон ялгавартай бодлого;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, төрөлжилт;
- Бүс нутгийн зах зээлийн өрсөлдөөн, худалдаа, экспорт, импорт;
- Кластер: Бүс нутгийн хөгжлийг өрсөлдөх чадвар сайтай хэд хэдэн кластерийн байршилд авч үзэх (Кластерийг нэмүү өртгийн сүлжээ бий болгоход хүчтэй хамтран оролцож буй судалгааны институт, аж үйлдвэрийн дэд бүтэц, хэрэглэгч, үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн сүлжээ торлог хэлбэрээр авч үзэх);
- Хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сууринг тэргүүн ээлжинд сонгох, хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Бүсийг ажлын байр бий болгох, суурь эдийн засгийн нөөцөд суурилсан салбар хоорондын хамтын ажиллагаа бүхий үйлдвэрлэл, нийгэм, шинжлэх ухаан, судалгааны байгууллагуудын нэгдэл хэлбэрээр авч үзэх;
- Бүс нутгийн аж ахуйн бие даасан байдлыг хангах.

Хүснэгт 2.1.2 Бүсчилсэн хөгжлийн агуулгаар орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн үндэслэл, холбоотой бодлого, хөтөлбөрийн зорилт	Шалгуур үзүүлэлтээр бодлогын шинжилгээ хийх баримт бичиг	
			Үндэсний болон бүс нутгийн түвшинд	Орон нутгийн түвшинд
1	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ тогтоож, өөр хоорондоо хоршин хөгжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2, 4.7.1.е, 4.7.1.ж - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4		аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
2	Бүсийн түвшинд өөр хоорондоо хоршин хөгжих бизнесийн орчныг бүрдүүлэх, дэмжих, дотоод, гадаад зах зээлтэй холбох зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2, 4.7.2.г, 4.7.2.д, 3.14 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2		аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
3	Хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, шилжилт хөдөлгөөнийг бууруулах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.2 - Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого	- Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого ¹ - Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого ²	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)

¹ Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоол. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр.

² Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоол. Ноолуур хөтөлбөр (2018-2021).

4	Бүсийн хүрээнд байгалийн баялгийн нөөц ашигласны эцсийн үр өгөөжийг тухайн бүсийн аймаг, сумд адил тэнцүү хүртэх орлого хуваарилалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.4, 4.7.3.e - НҮБ-ын ТХЗ-ын 10	- Ногоон хөгжлийн бодлого ³	
5	Бүсүүдэд Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны төв (ШУТПарк, R&D, инноваци г.м)-үүдийг байгуулахыг дэмжих, тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.а. - НҮБ-ын ТХЗ-ын 4 - ТХҮБ 2030-ын 2.1.3-ын зорилт 4, 5	- Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого ⁴ - Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого ⁵ - Судалгаанд суурилсан их их сургуулийг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр ⁶	
6	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.б. - НҮБ-ын ТХЗ-ын 3 - ТХҮБ 2030-ын 2.2.2-ын зорилт 1	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
7	Бүс нутгийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бий болгох бүс нутаг-хотжилтын нэгдмэл орчныг бий болгох зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.5 - НҮБ-ын ТХЗ-ын 11 - ТХҮБ 2030-ын 2.1.5-ын зорилт 5, 6	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
8	Эдийн засаг, тээврийн коридорын дагуух бүс нутгуудыг олон улсын худалдаа-эдийн засгийн сүлжээнд зохистой холбож, гадаад харилцааны боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 2.3.6 - НҮБ-ын ТХЗ-ын 17	- МУ-ын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр ⁷ - Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр - Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ⁸ - “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр ⁹	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
9	Бүс нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай	- БХҮБ-ын 3.2.1, 3.2.2	- Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны	аймгийн хөгжлийн хэтийн зорилт

³ УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого.

⁴ Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоол. Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого.

⁵ Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого.

⁶ УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол. Ногоон хөгжлийн бодлого.

⁷ Засгийн газрын 2015 оны 474 дүгээр тогтоол. МУ-ын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр.

⁸ УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

⁹ Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоол. “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр.

	бодлого явуулах зорилт, арга хэмжээ		үйл ажиллагааны хөтөлбөр ¹⁰	(бодлого, хөтөлбөр)
10	Бүсийн онцлог, давуу талд тулгуурлан төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн харилцан адилгүй, явгавартай бодлогоор дэмжих зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.в, 4.7.1.г. - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4	- Төсвийн тухай хууль - Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр ¹¹	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
11	Бүс нутгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих, татах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.д	- Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр ¹²	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
12	Үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум сууринг тодорхойлох, тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлэх арга хэмжээ	- БХҮБ-ын 3.5, 3.8	- Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр ¹³ -	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
13	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.е, 4.7.1.ж	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
14	Бүсийн түвшинд салбар болон бизнес эрхлэгч хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.г, 4.7.2.д, 3.14 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2 - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 4	- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ¹⁴	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
15	Бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.1.з.	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
16	Бүс нутгийн түвшинд орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн чадавхийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэлийн сүлжээг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.а.	-	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
17	Гадаад, дотоод хэрэгцээг харгалзан бүсийн түвшинд импортыг орлох бүтээгдэхүүн	- БХҮБ-ын 4.7.2.б. - ТХҮБ 2030-ын 2.1.1-ын зорилт 2	- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ¹⁵	аймгийн хөгжлийн хэтийн зорилт

¹⁰ УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

¹¹ Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр.

¹² Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр.

¹⁴ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого.

¹⁵ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого.

	үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ			(бодлого, хөтөлбөр)
18	Бүсийн түвшинд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах буюу өөрийн салбар, нэгжээ байгуулж ажиллахыг хөхүүлэн дэмжих зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.2.е.		аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
19	Бүсийн түвшинд хүн амын ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүс, аймаг, сум дундын санхүүгийн механизм бий болгох зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.д. - НҮБ-ын ТХЗ-ын 1 - ТХҮБ 2030-ын 2.2.1-ын зорилт 1, 2	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого ¹⁶	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
20	Хил орчмын болон алслагдсан бүс нутагт ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтыг татах, урамшуулах зорилт, арга хэмжээ	- БХҮБ-ын 4.7.4.д.		аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
21	Бүсийн түвшинд аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- ТХҮБ 2030-ын 2.1.3-ын зорилт 1	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого ¹⁷	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
22	Бүсийн хэмжээнд ХАА болон үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилт, арга хэмжээ			аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
23	Бүс нутгийн өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл-кластер хөгжүүлэх зорилт, арга хэмжээ			аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
24	Бүсийн түвшинд боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ			аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
25	Бүсийн түвшинд аялал жуулчлалыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	- ТХҮБ 2030-ын 2.1.2-ын зорилт 1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр ¹⁸	аймгийн хөгжлийн хэтийн зорилт (бодлого, хөтөлбөр)
26	Бүсийн түвшинд зам, тээвэр, ложистикийн сүлжээг	- ТХҮБ 2030-ын 2.1.5-ын зорилт 3	“Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр ¹⁹	аймгийн хөгжлийн хэтийн зорилт

¹⁶ Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого.

¹⁷ УИХ-ийн 2015 оны 62 дугаар тогтоол. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого.

¹⁸ Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоол. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр.

¹⁹ Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоол. “Хөгжлийн зам” Үндэсний хөтөлбөр.

хөгжүүлэх зорилт, арга хэмжээ			(бодлого, хөтөлбөр)
-------------------------------	--	--	---------------------

Эх сурвалж: М.Алтанбагана. 2018.

Схем 2.1.2.1 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх арга зүйн схем



Эх сурвалж: Судалгааны баг

Схем 2.1.2.2 Орон нутгийн хөгжлийн бодлогод шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтийн ангилал



Эх сурвалж: Судалгааны баг

2.2 Төвийн бүсийн говийн дэд бүсийн Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын хөгжлийн бодлогод хийсэн шинжилгээ

Бүсчилсэн хөгжлийн агуулгаар боловсруулсан 26 чанарын шалгуур үзүүлэлтээр Төвийн бүсийн говийн дэд бүсийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын хөгжлийн бодлого, хөтөлбөрийн орчинд бодлогын шинжилгээ хийлээ.

Хүснэгт 2.2.1 Бодлогын шинжилгээ хийсэн баримт бичгүүд

Д.д	Хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр	Аймаг	Хэрэгжих хугацаа
ГС1	Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр	Говьсүмбэр	2003-2020
ГС2	Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого	Говьсүмбэр	2010-2021
ДО1	Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого	Дорноговь	2002-2020
ДО2	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө	Дорноговь	2011-2021
ДУ1	Дундговь аймгийн 2020 он хүртлэх хөгжлийн бодлого	Дундговь	2003-2020
ӨМ1	“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр	Өмнөговь	2010-2020

**Хүснэгт 2.2.2 Аймгуудын хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтууд
(салбараар)**


№	Аймаг	Хөгжлийн баримт бичгийн нэр	Зорилтууд	Нийгмийн хөгжлийн бодлого		Эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлого		Байгаль орчны бодлого		Нутгийн удирдлага, нийгмийн оролцоо, түншлэлийг хангах бодлого		Нийт	
				Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт	Стратегийн зорилт	Дэд зорилт
1	Говьсүмбэр	Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)	тоо	20	212	27	174	5	39	4	29	56	454
			хувь	35.7	46.7	48.2	38.3	8.9	8.6	7.2	6.3		
2	Дорноговь	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө (2011-2021)	тоо	27	124	72	371	7	73	9	56	115	624
			хувь	23.5	19.9	62.6	59.5	6.1	11.7	7.8	8.9		
3	Дундговь	Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого	тоо	26	194	18	180	1	17	0	0	45	391
			хувь	57.8	49.6	40.0	46.0	2.2	4.3	0	0		
4	Өмнөговь	“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он)	тоо	17	134	28	135	50	67	0	0	95	336
			хувь	17.9	39.9	29.5	39.8	52.6	20.3	0	0		
Нийт			тоо	90	664	145	860	63	196	13	85	311	1805
			хувь	28.9	36.8	46.6	47.6	20.3	10.9	4.2	4.7		

Эх сурвалж: Судалгааны баг

Төвийн бүсийн говийн дэд бүсийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын дунд хугацааны бодлого төлөвлөлтөнд нийт 311 стратегийн зорилт, 1805 дэд зорилт, арга хэмжээг тусгасан байна.


Стратегийн зорилтын 28.9 хувь нь нийгмийн, 46.6 хувь нь эдийн засгийн, 20.3 хувь нь байгаль орчны, 4.2 хувь нь нутгийн удирдлага, нийгмийн оролцоо, түншлэлийн бодлогын хүрээнд хамаарч байна. Харин дэд зорилтын 36.8 хувь нь нийгмийн, 47.6 хувь нь эдийн засгийн, 10.9 хувь нь байгаль орчны, 4.7 хувь нь нутгийн удирдлага, нийгмийн оролцоо, түншлэлийн бодлогын хүрээнд хамаарч байна.

Зураг 2.2.1 Аймгуудын хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтууд (салбараар, хувиар)




Эх сурвалж: Судалгааны баг


**Зураг 2.2.2 Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (2003-2020)
Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)**




**Зураг 2.2.3 Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого (2002-2020)
Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/**



Зураг 2.2.4 Дундговь аймгийн 2020 он хүртлэх хөгжлийн бодлого



Зураг 2.2.5 “Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он)



Эх сурвалж: Судалгааны баг

Хүснэгт 2.2.3 Аймгуудын хөгжлийн бодлогын шинжилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Хөгжлийн бодлогын зорилт, дэд зорилтуудын график
<p align="center">■ Говьсүмбэр ■ Дундговь ■ Дорноговь ■ Өмнөговь</p>		
1	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ тогтоож, өөр хоорондоо хоршин хөгжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	
2	Бүсийн түвшинд өөр хоорондоо хоршин хөгжих бизнесийн орчныг бүрдүүлэх, дэмжих, дотоод, гадаад зах зээлтэй холбох зорилт, арга хэмжээ	
3	Хүн ам тухайн нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, шилжилт хөдөлгөөнийг бууруулах зорилт, арга хэмжээ	
4	Бүсийн хүрээнд байгалийн баялгийн нөөц ашигласны эцсийн үр өгөөжийг тухайн бүсийн аймаг, сумд адил тэнцүү хүртэх орлого хуваарилалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	
5	Бүсүүдэд Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны төв (ШУТПарк, R&D, инноваци г.м)-үүдийг байгуулахыг дэмжих, тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэх зорилт, арга хэмжээ	
6	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулах, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн зорилт, арга хэмжээ	
7	Бүс нутгийн хэмжээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бий болгох бүс нутаг- хотжилтын нэгдмэл орчныг бий болгох зорилт, арга хэмжээ	
8	Эдийн засаг, тээврийн коридорын дагуух бүс нутгуудыг олон улсын худалдаа-эдийн засгийн сүлжээнд зохистой холбож, гадаад харилцааны боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах зорилт, арга хэмжээ	
9	Бүс нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах зорилт, арга хэмжээ	
10	Бүсийн онцлог, давуу талд тулгуурлан төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн харилцан адилгүй, явгавартай бодлогоор дэмжих зорилт, арга хэмжээ	
11	Бүс нутгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих, татах зорилт, арга хэмжээ	

12	Үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гол нөлөөтэй, хөгжлийн ирээдүй сайтай бүс нутаг, хот, сум сууринг тодорхойлох, тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлэх арга хэмжээ	
13	Бүсийн түвшинд аймаг, хот, тосгон, сум хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	
14	Бүсийн түвшинд салбар болон бизнес эрхлэгч хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
15	Бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт, арга хэмжээ	
16	Бүс нутгийн түвшинд орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн чадавхийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэлийн сүлжээг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээ	
17	Гадаад, дотоод хэрэгцээг харгалзан бүсийн түвшинд импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
18	Бүсийн түвшинд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах буюу өөрийн салбар, нэгжээ байгуулж ажиллахыг хөхүүлэн дэмжих зорилт, арга хэмжээ	
19	Бүсийн түвшинд хүн амын ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүс, аймаг, сум дундын санхүүгийн механизм бий болгох зорилт, арга хэмжээ	
20	Хил орчмын болон алслагдсан бүс нутагт ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтыг татах, урамшуулах зорилт, арга хэмжээ	
21	Бүсийн түвшинд аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
22	Бүсийн хэмжээнд ХАА болон үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилт, арга хэмжээ	
23	Бүс нутгийн өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл-кластер хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
24	Бүсийн түвшинд боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
25	Бүсийн түвшинд аялал жуулчлалыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	
26	Бүсийн түвшинд зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ	

ГУРАВ. ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗУРАГЛАЛ

Төвийн бүсийн говийн дэд бүсийн хүрээнд орон нутгийн түвшинд хөгжлийн ирээдүй сайтай сум, сууринг тодорхойлж, дэд бүсийн хөгжил байршлын нэгдсэн төлөвлөлт, зураглалыг боловсруулж, үр дүнг Монгол Улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлогын баримт бичигт тусгах санал боловсруулах нь судалгааны ажлын нэг зорилт юм.

3.1 Хөгжлийн ирээдүй сайтай сум, хот, сууринг тодорхойлох арга зүй, шалгуур үзүүлэлт

Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн ирээдүй сайтай сумдыг хүн ам, эдийн засгийн нөөц, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ, газарзүйн байршил гэсэн 5 салбарын нийт 15 үзүүлэлтээр тодорхойллоо.

15 үзүүлэлт бүр ижил эрэмбэтэй гэж үзэн харгалзах жингийн нийлбэрээр хөгжлийн ирээдүй сайтай сумыг сонгох, хоёр дахь арга салбаруудыг эрэмбэлэх замаар нийт жинг тодорхойлох, гурав дахь арга нь АНР /Analytic hierarchical process/ аргаар 15 үзүүлэлтийг эрэмбэлэн аль үзүүлэлт нь илүү нөлөөтэй болохыг оноох замаар харгалзах жинг тодорхойлно.

Хүснэгт 3.1.1 Хөгжлийн ирээдүй сайтай сум, хот, сууринг тодорхойлох шалгуур үзүүлэлт

№	Салбар, чиглэл	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн ангилал ба харгалзах жин			Код
			1 /ХН Бага/	2 /ХН Дунд/	3 /ХН Сайн/	
			0 /балл/	0.5 /балл/	1 /балл/	
1	Хүн ам	Хүн амын тоо	3000 хүртэл	3000-5000	5000 дээш	F1
2		Хүн амын өсөлт	Буурсан	Хэвийн өссөн	Механик өссөн	F2
3		Хүн амын ачаалал	51 дээш	47-51	47 доош	F3
4	Эдийн засгийн нөөц	Уул уурхайн нөөц	Илрээгүй	Ордтой	Стратегийн орд (15+39)	F4
5		Малын тоо /хонин толгой/	300000	500000	500000 -аас олон	F5
6		Аялал жуулчлалын нөөц	Сул чадавхитай,	Дунд чадавхитай,	Өндөр чадавхитай	F6
7	Дэд бүтэц	Автозам	Зам дайраагүй	Төлөвлөгдсөн	Замд холбогдсон	F7
8		Төмөр зам	Зам дайраагүй	Төлөвлөгдсөн	Замд холбогдсон	F8
9		Эрчим хүч	6 кВт	15 кВт	15 кВт дээш	F9
10	Нийгмийн үйлчилгээ	Боловсролын үйлчилгээ /Сургуулийн төрөл, ИДС, коллеж, МСҮТ ороогүй/	Бага сургууль	Дунд сургуультай	Ахлах сургуультай	F10
11		Хамран сургалт	80% хүртэл	80-100%	100% дээш	F11
12		Эрүүл мэндийн үйлчилгээ /Эмнэлгийн төрөл, нэгдсэн эмнэлэг ороогүй/	Өрхийн эмнэлэг	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	F12
13		Хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	10%	10-15%	15% дээш	F13

14	Газарзүйн байршил	Хил орчмын сумд	Бусад сум	Хилийн бүсийн сум /боомтгүй/	Боомттой	F14
15		Аймгийн төвөөс алслагдсан байдал	40 км	100 км	100 км дээш	F15

Эх сурвалж: М.Алтанбагана. 2018.

3.2 Хөгжлийн ирээдүй сайтай сум, хот, сууринг тодорхойлсон үр дүн

Ижил эрэмбээр нэгтгэсэн үр дүн. Энэ аргаар нэгтгэхийн давуу тал нь нийт шалгуур үзүүлэлтээр аль сум хамгийн их жин авч байгааг ялган харах боломжтой. Хүснэгт 3.2.1-д 15 шалгуур үзүүлэлт тус бүрийн утгад 1, 2, 3 гэсэн харгалзах жинг оноож нэгтгэсэн үр дүнг харууллаа.


Хүснэгт 3.2.1 Төвийн бүсийн говийн дэд бүсийн сум тус бүрийн шалгуур үзүүлэлтэд харгалзах жин ба ижил эрэмбэтэй гэж үзэн нийт жингээр нь эрэмбэлсэн байдал

№	Аймаг	Сум	F1	F2	F3	F4	F5	F6	F7	F8	F9	F10	F11	F12	F13	F14	F15	Нийт
1	Дундговь	Адаацаг	1	1	2	1	3	1	1	1	2	2	1	2	1	1	2	22
2	Дорноговь	Дэлгэрэх	1	2	1	1	2	1	1	2	2	2	1	2	1	1	3	23
3	Дундговь	Сайхан-Овоо	1	1	2	1	2	1	1	1	3	2	1	2	1	1	3	23
4	Дундговь	Гурвансайхан	1	1	2	1	2	2	1	1	3	2	1	2	1	1	2	23
5	Дундговь	Дэрэн	1	1	1	2	2	1	3	1	1	2	1	2	2	1	2	23
6	Өмнөговь	Булган	1	1	3	1	2	1	2	1	2	2	1	2	1	1	2	23
7	Дундговь	Дэлгэрцогт	1	1	1	1	2	1	3	1	3	2	1	2	2	1	2	24
8	Дундговь	Цагаандэлгэр	1	2	2	1	1	1	1	1	3	2	1	2	3	1	2	24
9	Өмнөговь	Манлай	1	2	2	1	2	1	1	2	3	2	1	2	1	1	3	25
10	Дорноговь	Сайхандулаан	1	2	1	3	2	1	1	2	2	2	1	2	2	1	2	25
11	Дундговь	Баянжаргалан	1	2	1	3	1	1	1	1	3	2	1	2	3	1	2	25
12	Дундговь	Өлзийт	1	1	3	1	3	3	1	1	2	2	1	2	1	1	2	25
13	Дорноговь	Хөвсгөл	1	2	1	2	1	2	1	2	2	2	2	2	1	2	3	26
14	Дундговь	Дэлгэрхангай	1	1	1	3	2	1	1	1	2	3	3	2	1	1	3	26
15	Өмнөговь	Мандал-Овоо	1	1	3	2	3	1	1	1	2	2	1	2	2	1	3	26
16	Өмнөговь	Номгон	1	1	3	2	3	1	1	1	2	2	1	2	1	2	3	26
17	Дундговь	Луус	1	1	2	1	2	3	3	1	3	2	1	2	1	1	2	26
18	Дорноговь	Улаанбадрах	1	1	2	2	2	2	1	2	2	2	1	2	2	2	3	27
19	Өмнөговь	Сэврэй	1	1	3	1	2	3	2	1	2	2	1	2	2	1	3	27
20	Дорноговь	Эрдэнэ	1	1	1	1	2	3	3	3	2	2	1	2	1	2	2	27
21	Дундговь	Говь-Угтаал	1	1	2	2	2	3	1	1	3	2	1	3	2	1	2	27
22	Дундговь	Хулд	1	2	2	2	3	1	3	1	3	2	1	2	1	1	2	27
23	Өмнөговь	Хүрмэн	1	1	3	2	2	1	1	2	3	2	1	2	2	2	2	27
24	Дорноговь	Мандах	1	2	2	3	2	2	1	2	1	2	2	2	2	1	3	28
25	Дорноговь	Хатанбулаг	1	1	2	3	3	2	1	2	1	2	1	2	1	3	3	28
26	Дорноговь	Иххэт	1	1	2	2	2	2	1	1	3	3	2	2	2	1	3	28
27	Дундговь	Өндөршил	1	1	3	3	1	3	1	1	2	2	2	2	2	1	3	28
28	Өмнөговь	Цогт-Овоо	1	2	1	1	2	3	3	1	2	2	1	2	3	1	3	28
29	Говьсүмбэр	Баянтал	1	3	1	2	1	1	3	3	3	2	1	2	3	1	1	28
30	Өмнөговь	Ханхонгор	1	1	3	2	3	3	3	2	1	3	1	2	1	1	1	28
31	Өмнөговь	Ноён	1	2	2	2	1	1	1	2	3	2	1	3	3	2	3	29
32	Дорноговь	Алтанширээ	1	2	3	1	1	1	3	3	3	2	1	2	3	1	2	29
33	Дорноговь	Даланжаргалан	1	2	1	3	2	3	3	3	3	2	1	2	1	1	2	30
34	Дорноговь	Өргөн	1	2	3	2	1	2	3	3	3	2	1	2	1	2	2	30
35	Өмнөговь	Баяндалай	1	1	3	2	2	3	2	2	1	3	2	2	2	2	2	30
36	Дундговь	Эрдэнэдалай	3	1	1	2	3	1	1	1	3	3	3	3	2	1	3	31
37	Өмнөговь	Баян-Овоо	1	2	3	2	2	3	3	1	3	2	1	2	2	2	3	32
38	Дорноговь	Айраг	2	2	2	3	1	1	3	3	3	3	3	2	1	1	2	32
39	Говьсүмбэр	Шивээговь	2	3	1	3	1	1	3	3	3	3	3	2	3	1	1	33
40	Өмнөговь	Даланзадгад	3	3	1	1	1	2	3	2	3	3	3	3	3	1	1	33

41	Өмнөговь	Гурвантэс	2	3	1	3	2	3	2	2	3	3	2	2	1	3	3	35
42	Дорноговь	Замын-Үүд	3	3	1	1	1	1	3	3	3	3	3	3	3	3	2	36
43	Өмнөговь	Цогтцэций	3	3	1	3	1	3	3	2	3	3	3	3	2	1	2	36
44	Говьсүмбэр	Сүмбэр	3	3	1	1	3	2	3	3	3	3	3	3	3	1	1	36
45	Дорноговь	Сайншанд	3	3	1	2	1	3	3	3	3	3	3	3	3	1	1	36
46	Дундговь	Сайнцагаан	3	3	1	3	3	3	3	1	3	3	3	3	3	1	1	37
47	Өмнөговь	Ханбогд	3	3	3	3	3	1	3	2	3	3	2	3	1	3	3	39

Эх сурвалж: М.Алтанбагана. 2018.

Зураг 3.2.1 Төвийн бүсийн говийн дэд бүсийн сумдыг 15 үзүүлэлтээр баллаар нэгтгэн үнэлсэн үзүүлэлтийн зураглал



Эх сурвалж: С.Намжилмаа, Х.Билгүүн

Энд 32-38 хооронд их жин авсан нийт 9 сум, 24-32 хооронд дунд жингийн 15 сум, 22-27 хооронд бага жин авсан 23 сум байна. Өмнөговь аймагт 4 сум их, 6 сум дунд 5 сум бага жин авсан бол Дорноговь аймагт 5 сум их, 7 сум дунд, 2 сум бага ангилалд орж байна. Харин Дундговь аймгийн 11 сум бага, 2 сум дунд, 1 сум их ангилд, Говьсүмбэр аймгаас 2 сум их, 1 сум дунд ангилалд орж байна.

Analytic Hierarchy Process (AHP) ашигласан үр дүн. Тус арга нь нь шалгуур үзүүлэлтийн эцсийн үр дүнг нэгтгэхийн тулд харгалзах жинг шалгуур үзүүлэлтүүдийн хооронд хэр их ач холбогдолтой вэ гэдгээр нь оноо өгөх замаар тооцдог.

Ижил жингийн аргаар тооцсон 30-аас дээш жинтэй нийт 12 сумдаас Дундговь аймгийн Эрдэнэдалай, Сайнцагаан сум, Дорноговь аймгаас Даланжаргалан, Айраг, Замын-Үүд,

Сайншанд сум, Өмнөговь аймгаас Баян-Овоо, Даланзадгад, Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сум, Говьсүмбэр аймгаас Сүмбэр, Шивээговь сумууд илүү жинтэй байна.


Шаталсан дүн шинжилгээний аргаар (АНР) нэгтгэсэн үр дүнгээр 2-оос дээш жин авсан 10 сум байна. Энд Говьсүмбэр аймгийн Шивээговь, Сүмбэр сум, Дундговь аймгийн Сайнцагаан, Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг, Замын-Үүд, Сайншанд сум, Өмнөговь аймгийн Даланзадгад, Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумууд байна. Эдгээр сумууд нь хүн амын тоо ихтэй, уул уурхайн түүхий эдийн нөөцтэй, тээврийн дэд бүтцэд холбогдсон болон холбогдохоор төлөвлөгдсөн, 2 талын байнгийн ажиллагаатай боомттой сумууд байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Хүснэгт 2.2.2 Хөгжлийн ирээдүй сайтай сумдыг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг матрицаар эрэмбэлсэн байдал
/АНР бодуулсан харгалзах жин/

№	CR:0.06	Хүн амын тоо	Хүн амын өсөлт	Уул уурхайн нөөц	Малын тоо/хонин толгой/ толгой	Аялал жуулчлалын нөөц	Авто зам	Эрчим хүч	Төмөр зам	Хүн амын ачаалал	АТ аялагдсан байдал	ЕБС төрөл	Хамран сургалт	Эмнэлийн шатлал	Хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	Хил орчмын сүм	Жин
1		1	1	3	3	3	3	3	3	5	5	5	5	5	5	5	17.683
2		1	1	3	3	3	3	3	3	5	5	5	5	5	5	5	17.683
3		0.333	0.333	1	1	1	1	1	1	3	3	3	3	3	3	3	7.581
4		0.333	0.333	1	1	1	1	1	1	3	3	3	3	3	3	3	7.581
5		0.333	0.333	1	1	1	1	1	1	3	3	3	3	3	3	3	7.581
6		0.333	0.333	1	1	1	1	1	1	3	3	3	3	3	3	3	7.581
7		0.333	0.333	1	1	1	1	1	1	3	3	3	3	3	3	3	7.581
8		0.333	0.333	1	1	1	1	1	1	3	3	3	3	3	3	3	7.581
9		0.2	0.2	0.333	0.333	0.333	0.333	0.333	0.333	1	1	1	1	1	1	1	2.735
10		0.2	0.2	0.333	0.333	0.333	0.333	0.333	0.333	1	1	1	1	1	1	1	2.735
11		0.2	0.2	0.333	0.333	0.333	0.333	0.333	0.333	1	1	1	1	1	1	1	2.735
12		0.2	0.2	0.333	0.333	0.333	0.333	0.333	0.333	1	1	1	1	1	1	1	2.735
13		0.2	0.2	0.333	0.333	0.333	0.333	0.333	0.333	1	1	1	1	1	1	1	2.735
14		0.2	0.2	0.333	0.333	0.333	0.333	0.333	0.333	1	1	1	1	1	1	1	2.735
15		0.2	0.2	0.333	0.333	0.333	0.333	0.333	0.333	1	1	1	1	1	1	1	2.735
																	99.997

Зураг 3.2.2 Төвийн бүсийн говийн дэд бүсийн сумдыг шаталсан дүн шинжилгээний аргаар нэгтгэн үнэлсэн үзүүлэлтийн зураглал



Эх сурвалж: С.Намжилмаа, Х.Билгүүн

Хүснэгт 3.2.3-т Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн ирээдүй сайтай сумдыг ижил жингийн болон шаталсан үнэлгээний аргачлалаар үнэлж нэгтгэн харууллаа.

Тус үнэлгээгээр аймгийн төвийн сумдыг эс тооцвол Өмнөговь аймагт 5 сум, Дорноговь аймагт 5 сум, Дундговь, Говьсүмбэр аймагт тус тус 2 сум хөгжлийн ирээдүй сайтай байна.

Төмөр зам, авто зам, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон, уул уурхайн нөөцтэй сумууд хамгийн өндөр үнэлгээтэй байна.

**Хүснэгт 3.2.3 Ижил жингийн болон шаталсан үнэлгээний аргачлалаар үнэлж гаргасан
Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн ирээдүй сайтай сумууд
/аймаг бүрээр/**


№	Аймаг	Сум	Ижил эрэмбэ	АНР
1	Говьсүмбэр	Баянтал	28	1.96635
2		Шивээговь	33	2.30104
3		Сүмбэр	36	2.58103
4	Дорноговь	Алтанширээ	29	1.74106
5		Өргөн	30	1.86533
6		Даланжаргалан	30	2.06541
7		Айраг	32	2.09686
8		Замын-Үүд	36	2.43565
9		Сайншанд	36	2.58103
10	Дундговь	Хулд	27	1.76217
11		Эрдэнэдалай	31	1.95148
12		Сайнцагаан	37	2.65684
13	Өмнөговь	Баяндалай	30	1.61893
14		Баян-Овоо	32	1.92003
15		Даланзадгад	33	2.3536
16		Гурвантэс	35	2.4042
17		Цогтэций	36	2.58103
18		Ханбогд	39	2.60838

Эх сурвалж: Судалгааны баг

3.3 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын өнөөгийн байдал

Төвийн бүсийн Говийн дэд бүс нь 2002 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоогоор ихэнх сумд нь **IV-Б** бүс буюу аймаг, сумдын нөлөөлөл ихтэй, хуурай хээр, говь цөлийн таруу нутагшилтын бүсэд, Дорноговь, Говьсүмбэр аймгийн цөөн сумд **I-Б** буюу аймгийн төв, төмөр замын дагуух суурин газруудын нөлөөлөл ихтэй, хуурай хээр, говийн бүсийн бөөгнөрсөн нутагшилтын бүсэд хамаарч байсан.

Зураг 3.3.1 Монгол Улсын хүн амын нутагшилтын тогтолцоо /2002 он/



ТАНИХ ТЭМДЭГ

- Нутагшилтын бүс, дэд бүсийн хил
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Нийслэл хот
- Аймгийн төв

Дэд бүс



Нийслэл хот, аймгийн төв, төмөр замын дагуух суурин газруудын нөлөөлөл ихтэй ойт хээр, хуурай хээр, говийн бүсийн бөөгнөрсөн нутагшилтын бүс.

Дэд бүс




Аймаг, сумдын нөлөөлөл ихтэй хуурай хээр, ойт хээрийн бүс өндөр уулын бүслүүрийн бөөгнөрөх хандлагатай нутагшилтын бүс.

Дэд бүс



Аймаг, сумдын нөлөөлөл ихтэй хуурай хээр, говь цөлийн бүс өндөр уул, тайгын бүслүүрийн таруу нутагшилтын бүс.

Дэд бүс




Аймаг, сумдын нөлөөлөл ихтэй хуурай хээр, говь цөлийн бүс өндөр уул, тайгын бүслүүрийн таруу нутагшилтын бүс.

Эх сурвалж: Л.Цэдэндамба, Д.Хайсамбуу, С.Намжилмаа

Хот, суурины төвлөрлийн хувьд Дорноговь аймгийн Сайншанд, Говьсүмбэр аймгийн Чойр хотууд аймгийн хүн амын төвлөрлийг татаж бусад аймгийн төв хотууд хүн амаа нийслэл хот руу алдах хандлагатай байсан.

Зураг 3.3.2 Хот суурины төвлөрөл /2002 он/




Эх сурвалж: С.Намжилмаа, Х.Билгүүн

Төвийн бүсийн Говийн дэд бүсийн 2017 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоог харахад 2002 оныхоос эрс ялгаатай болсон байна. Тухайлбал 2002 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоогоор ихэнх сумд нь **IV-Б** бүс буюу аймаг, сумдын нөлөөлөл ихтэй, хуурай хээр, говь цөлийн таруу нутагшилтын бүсэд хамаарч байсан Өмнөговь аймгийн нийт сумдууд 2017 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоогоор **II-Б** буюу улсын хилд ойр, олон улсын болон улсын чанартай авто замд холбогдсон, аймгийн төв хотууд, сумын төвийн нөлөөлөл ихтэй, хээр, говийн нягтаршил ихсэж буй нутагшилтын бүсэд хамаарч байна.

Мөн 2002 оны **IV-Б** бүс буюу аймаг, сумдын нөлөөлөл ихтэй, хуурай хээр, говь цөлийн таруу нутагшилтын бүсэд хамаарч байсан Дундговь аймгийн ихэнх сумд 2017 оны хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоогоор **III-Б** буюу нэг ангиллаар ахисан байна.


Хот, суурины төвлөрлийн хувьд аймгийн төв хотуудаас гадна Өмнөговь аймгийн уул уурхайн үйлдвэрлэлд түшиглэсэн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Дорноговь аймгийн хилийн боомт, ачаа тээвэр логистикийн төв Замын-Үүд, Говьсүмбэр аймгийн уул уурхайд түшиглэсэн Шивээговь, Дундговь аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд түшиглэсэн Эрдэнэдалай сумын төвүүд хөгжлийн таталцлын төв болон хөгжиж эхлээд байна.

Зураг 3.3.3 Монгол Улсын хүн амын нутагшилтын тогтолцоо /2017 он/



Эх сурвалж: С.Намжилмаа, Х.Билгүүн

Зураг 3.3.4 Хот суурины төвлөрөл /2017 он/




Эх сурвалж: С.Намжилмаа, Х.Билгүүн

Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд “Газрын үнэлгээний тойрог”-ийг шинээр баталсан. Төвийн бүсийн Говийн дэд бүс нь Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний Г-6, Г-9, Г-10 дугаар тойргуудад хамаарагдаж байгаа бөгөөд тус бүс нь бэлчээр, тариалан, хадлангийн ашиглалтын зориулалтын талбайн бага үнэлгээтэй тойрогт хамаарч байна.


Зураг 3.3.5 Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог

/Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол/




Эх сурвалж: Х.Билгүүн

3.3.6 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүн амын нягтшил



Эх сурвалж: Х.Билгүүн

3.3.7 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ




Эх сурвалж: “Говийн бүсийн Тавантолгой, Оюутолгой, Цагаан суваргын уул уурхайн орд газрыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги, хот байгуулалтын төлөвлөгөө” БХБЯ, “Шинэ хотжилт” ХХК. 2008 он.

3.4 ДҮГНЭЛТ

“Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршлын судалгаа”-г үндэслэн Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн стратегийн схемийг боловсрууллаа.

Схем 3.4.1 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн стратеги



Эх сурвалж: С.Намжилмаа

Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн стратеги нь бүс нутгийн хөгжлийн бодлого болон хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын бодлогын нэгдмэл харилцан уялдаатай бодлогын хүрээнд тодорхойлогдоно.


Тус бүс нутаг нь Төвийн бүсийн өмнөд хэсгийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийг багтаасан говийн дэд бүс бөгөөд тус бүс нутагт Монгол Улсын ашигт малтмалын Тавантолгой, Оюутолгой, Цагаансуваргын стратегийн ач холбогдолтой том ордууд байршиж байгаагаараа онцлогтой бөгөөд энэ онцлог байдал нь тухайн бүсийн хөгжлийн ирээдүйд нөлөөлөх хандлагатай байна. Энэ утгаараа тухайн бүс нутгийн хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын дүр төрх нь баялаг олон янз бөгөөд бүсийн төв хот, орон нутгийн хот, бүлэг суурингийн төв, хоторхуу суурин, хөдөөгийн суурингийн олон хэв маяг зэрэгцэн орших онцлог байдал ажиглагдаж байна.

Судалгааны үр дүнд тус бүсийн стратегийг боловсруулахад Нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ хийх шаардлагатай болох нь харагдаж байна. Тухайлбал, тус бүсийн аймгууд хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа байгаль экологийн хүчин зүйлсийн үнэлгээг тодорхой төслүүдийг хүрээнд хийж байгаа боловч нийт аймгийн нутаг дэвсгэрийн хүрээнд хийгээгүй байна.

Байгалийн нөхцөл нөөцийн үнэлгээ хийх ажлын хүрээнд Эрсдэлийн хүчин зүйлсийн үнэлгээг хийхгүй байна.

Мөн аймгууд Хот байгуулалтын нэгдсэн үнэлгээг аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах хүрээнд хийж байгаа боловч бүс нутгийн хэмжээнд Хот байгуулалтын нэгдсэн үнэлгээг хийхгүй байна. Аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах хүрээнд нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн үнэлгээг хийж байгаа боловч Архитектур орон зайн төлөвлөлт, ландшафтын хүчин зүйлсийн үнэлгээг хийхгүй орхигдуулж байна. Мөн Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүрээнд Мэдээллийн нэгдсэн сан, төлөвлөлтийн нэгдсэн шийдэлд хүрч, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох нь чухал байна.

Схем 3.4.2 Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хөгжлийн чиг хандлага



Эх сурвалж: С.Намжилмаа

**Хүснэгт 3.4.1 Улс, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг
боловсруулахад өгөх санал**

<p>Аймгийн хөгжлийн хөтөлбөрийг ялгаатай боловсруулахад өгөх санал</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Орон нутгийн төв, бүлэг суурингийн төв, хөдөөгийн сууринг түүх, соёлын өвд тулгуурлан өөрийн онцлог дүр төрхтэйгээр төлөвлөж, эрүүл ногоон хотын зарчмаар хөгжүүлэх ➤ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол агуулга, бодлогын зорилтуудад чиглэсэн бүс нутгийн түвшинд хамтран хөгжих, бүс нутгийн хэмжээн дэх хоршсон үйлдвэрлэл, кластер хөгжүүлэх агуулгатай зорилтуудыг тодорхойлж, хэрэгжүүлэх ➤ Аймгууд тогтвортой хөгжлийн ирээдүй сайтай сум, хот суурингаа тэргүүн ээлжинд сонгон хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүнд ойр байгаа бусад бүс нутгийг таталцуулан хөгжүүлэхдээ дараах хүчин зүйлийг харгалзах. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1). газарзүйн оновчтой байршил 2). бүсчилсэн хөгжлийн бодлого, дэд бүтцийн босоо болон хэвтээ тэнхлэгийн зангилаа, төвүүдийн хөгжлийн төлөвлөлт 3). бүс нутгийн эдийн засгийн интеграци, эдийн засгийн коридорын тэгш, хүртээмжтэй төлөвлөлт 4). хот байгуулж хөгжих орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хүн амын хэт төвлөрлийг сааруулж, улмаар бүс нутгийн түвшинд томоохон хотыг бий болгож хүн амын тогтвортой, тэнцвэртэй суурьшилийг дэмжих 5). хөрөнгө оруулалт, татвар, санхүүгийн хөнгөлөлттэй, урамшуулалттай механизм, эрхзүйн орчинг бүрдүүлж, улмаар тээвэр, худалдаа, ложистикийн томоохон төвлөрөл бий болгох б). нийгэм, эдийн засаг, соёл, үйлчилгээний хувьд Улаанбаатар хоттой өрсөлдөхүйц Улсын зэрэглэлтэй хотуудыг бий болгож бүс нутгийг хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах
<p>Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгах санал</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Төвийн бүсийн говийн дэд бүсийн газар нутгийн хэмжээнд “нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ” хийх ➤ Төвийн бүсийн говийн дэд бүсийн газар нутгийн хэмжээнд “эрсдлийн хүчин зүйлсийн үнэлгээ” хийх ➤ Төвийн бүсийн говийн дэд бүсийн газар нутгийн хэмжээнд “хот байгуулалтын нэгдсэн үнэлгээ” /архитектур орон зайн төлөвлөлт, ландшафтын хүчин зүйлсийн үнэлгээ орно/ хийх ➤ “Мэдээллийн нэгдсэн сан” платформ үүсгэж, төвийн бүсийн болон үндэсний мэдээллийн сантай нэгтгэх ➤ “Түүх, соёлын биет болон биет бус өвийн судалгаа” хийж, хөгжил байршлын зураглал боловсруулах
<p>Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах зарчмын санал</p>	<ul style="list-style-type: none"> ➤ <u>Хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын хөгжлийн стратегийн хүрээнд</u> “Түүх, соёлын өв, байгаль орчны онцлогт тулгуурласан архитектур, хот байгуулалт, орон зайн төлөвлөлтийн оновчтой бүтэц бүхий бүс нутаг” болгон хөгжүүлэх <ol style="list-style-type: none"> 1. Өөрийн нөөц боломж, үүрэг, онцлог дүр төрхтэй хэд хэдэн төвүүдэд таталцсан, хоршин хөгжих орон зайн төлөвлөлттэй, зохистой, хэмнэлттэй газар зохион байгуулалт бүхий бүс нутаг болох

	<p>2. Эдийн засгийн чөлөөт бүс, хилийн боомтууд, уул уурхай, хүнд үйлдвэр түшиглэсэн шинэ хот сууринг олон улсын стандартын дагуу төлөвлөж, эдийн засгийн хөгжлийн коридоруудтай таталцуулан хөгжүүлэх</p> <p>3. Орон нутгийн төв, бүлэг суурингийн төв, хөдөөгийн сууринг түүх, соёлын өвд тулгуурлан өөрийн онцлог дүр төрхтэйгээр төлөвлөж, эрүүл ногоон хотын зарчмаар хөгжүүлэх</p> <p>➤ <u>Эдийн засгийн хөгжлийн стратегийн хүрээнд:</u></p> <p>1. Хариуцлагатай уул уурхай, экологид ээлтэй технологи бүхий хүнд үйлдвэр хөгжсөн, зам тээвэр логистикийн төв, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн бүс болгон хөгжүүлэх</p> <p>2. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн кластер /үрийн аж ахуй, хүлэмжийн аж ахуй, эмийн үйлдвэрлэл/ хөгжсөн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төв болох</p> <p>3. Түүх, археологи, палеонтологи, нүүдлийн өв соёлд тулгуурласан тогтвортой аялал жуулчлал хөгжсөн бүс нутаг болох</p> <p>4. Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт төмөр замын баруун болон зүүн коридорыг “судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд хэрэгжүүлж эхлэх” гэж тусгасан. Иймд Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын баруун болон зүүн коридорыг Бүсчилсэн хөгжлийн бодлого, орон нутгийн хөгжлийн асуудалтай уялдуулан судлах, түүнийг хүрээнд хөгжих сум, орон нутгийн хот тосгоны хөгжлийн бодлогыг тодорхойлох</p>
--	---

Эх сурвалж: Судалгааны баг

Ашигласан эх сурвалж

- a) Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. УБ.
- b) “Бүс нутгийн онцлогт тохирсон хот байгуулалтын бодлого, барилгын архитектур төлөвлөлтийн үндсэн зарчим”. БАК. 2001 он.
- c) Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлого. Аймгийн ИТХ-ын 2002 оны 18 дугаар тогтоол. Сайншанд.
- d) Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги. УИХ-ын 2003 оны 24 дүгээр тогтоол. УБ.
- e) Дундговь аймгийн 2020 он хүртлэх хөгжлийн бодлого.
- f) Бүсийн тулгуур төв хот тогтоох тухай. УИХ-ын 2003 оны 01 дүгээр тогтоол. Улаанбаатар.
- g) Зүүн, Баруун, Төвийн, Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр (2006-2015). Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоол. УБ.
- h) Улаанбаатар бүсийн хөгжлийн хөтөлбөр (2006-2015). Засгийн газрын 2005 оны 45 дугаар тогтоол. УБ.
- i) “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилгот хөтөлбөр. УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол. УБ.
- j) “Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх онол аргазүйн үндэслэл, боломжит хувилбар” эрдэм шинжилгээний тайлан. Газарзүйн хүрээлэн. 2006 он. УБ
- k) Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай. Монгол Улсын Их хурлын 2007 оны 27-р тогтоол. УБ.
- l) Үндэсний статистикийн хороо. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал. Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/152 тоот тушаалын хавсралт. УБ.
- m) Монгол Улсын Үндэсний атлас. Газарзүйн хүрээлэн. 2009 он. УБ.
- n) “Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020 он). Аймгийн ИТХ-ын 2009 оны 5/11 дүгээр тогтоол. Даланзадгад.
- o) Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/. Аймгийн ИТХ-ын 2011 оны 26 дугаар тогтоол. Сайншанд.
- p) Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого. Аймгийн ИТХ-ын 2011 оны 3 дугаар тогтоол. Говьсүмбэр.
- q) Монгол Улсын “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль. Монгол Улсын Их хурал 2015 оны 11 дүгээр сарын 26. УБ.
- r) М.Алтанбагана, Б.Хэрлэнбаяр. 2015. “Экологийн эмзэг байдал шилжилт хөдөлгөөн, ядууралд нөлөөлөх нь”. Нийгэм эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан үзэх нь сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний 3-р бага хурал. УБ.
- s) Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого. Монгол Улсын Их хурлын 2015 оны 62-р тогтоол. УБ.

- t) Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030 он). Монгол Улсын Их хурлын 2015 оны 62-р тогтоол. УБ.
- u) Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 324-р тогтоол. УБ.
- v) M.Altanbagana et al. 2016. Consulting on “National Report of Urban Development of Mongolia for UN HABITAT III” and “Current Assessment for Regional and Human Settlements Development in Mongolia”. Funding by Ministry of Construction and Urban Development and UNDP and Introduced to the *United Nations* Conference on Housing and Sustainable Urban Development in Quito, Ecuador, from 17-20 October, 2016.
- w) Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 142-р тогтоол. УБ.
- x) Гурван тулгуурт хөгжлийн бодлого. Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоол. УБ.
- y) M.Altanbagana. 2018.03.10. “Sustainable Development Vision 2030 and Challenges in Mongolia: Zud Impact on Social-Economic Issues”. Symposium on “Changing Environment and People's life of Mongolia” in Tottori University. Japan
- z) Уул уурхайн салбарын өрхийн амжиргаанд үзүүлэх нөлөө урьдчилсан тайлан. Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн. 2018 он. УБ.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭГЭЛЭН

ӨМНИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН
ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОНОВЧТОЙ БАЙРШЛЫН
МАТЕМАТИК ЗАГВАРЧЛАЛЫН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Г. Баттөр, Т. Дөлтуяа, Б. Дэмчигсүрэн, Ц. Сэлэнгэ
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Contents

1 Судалгааны зорилго	3
2 Удиртгал	3
3 Өндөр хөгжилтэй орнуудын FLP-г хэрэглэсэн туршлага	4
3.1 Байгууламжийн байршил тодорхойлох бодлого	4
3.2 Франц улсын ложистик төвийн байршил тогтоох бодлого	5
3.3 Нью-Йоркийн банкны салбарын бодлого	8
4 Өндөр хөгжилтэй орнуудын АНР болон PROMETHEE аргыг хэрэглэсэн туршлага	10
4.1 Улс орны АНР болон PROMETHEE аргыг хэрэглэсэн байдал	10
4.2 АНР аргын тархалтын судалгаа	11
5 Сонголтуудыг эрэмбэлэх	12
5.1 Аналитик шаталсан процесс	12
5.2 PROMETHEE арга	15
5.3 Үйлдвэрийн салбар бүрийн шалгуур үзүүлэлтийн жинг тодорхойлох	18
5.4 Сүүний үйлдвэрийн оновчтой байршлыг тодорхойлох бодлого	27
6 Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн ашгийг максимумчлах бодлого	30
6.1 Тоон туршилт	32
7 Дүгнэлт	34

1 Судалгааны зорилго

Судалгааны зорилго нь Төвийн бүсийн говийн 4 аймгийн хөгжил байршлыг бүлэг суурингийн тогтолцоонд үндэслэн тодорхойлж, учир шалтгааныг илрүүлж, байршил, хөгжлийн төлөвлөлт талаас шийдвэрлэх орон/зай, байршил, хөгжлийн бодлого төлөвлөлтийн онол, арга зүй, эдийн засгийн үр ашиг, оновчлолын загваруудын хувилбаруудыг тодорхойлоход оршино. Судалгааны үндсэн дээр Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн хөгжлийн загварт нийцэх математик загварыг байгуулж, туршин, Монгол Улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлого хөгжлийн төлөвлөгөөнд тусгана.

2 Удиртгал

Дэлхийн улс орнуудад хот болон бүс нутагт үйлчилгээний төв, аж үйлдвэрүүдийг оновчтой байршуулах, зам, тээвэр ложистикийн сүлжээ байгуулах зэрэг асуудалд математик загварчлалыг өргөн ашиглаж байгааг олон судалгааны ажлуудад харуулжээ. Эдгээр загварууд дотроос үйлдвэр, тоног төхөөрөмж, авто болон төмөр зам, үйлчилгээний төв, цэгүүдийг оновчтой байршуулах (Facility Location Problem (FLP)) бодлого, хамгийн их урсгалын бодлого (Maximum Flow Problem), тоглоомын онолын (Game theory) загварууд чухал ач холбогдолтой. Бид энэ судалгааны ажилд FLP буюу байршил тогтоох бодлого, Курно-Нэшийн загварт тулгуурласан үйлдвэрийн ашигт ажиллагааны загваруудыг авч үзнэ. Байршил тогтоох бодлогод төгсгөлөг тооны объектуудыг (үйлдвэр, агуулах, дэлгүүр, банкны салбар, сургууль эмнэлэг, гал команд, цахилгаан станц, хогийн цэг гэх мэт...) тодорхой орон зай, бүс нутагт (хот, суурин газар) төгсгөлөг тооны хэрэглэгчдийн хэрэгцээ хангагдсан байхаар оновчтой байршуулах асуудлыг авч үздэг. Энэ төрлийн бодлого нь төрийн болон хувийн хэвшлийн бүхий л салбаруудад тулгарах ба урт хугацаанд том хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах төслүүдэд хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад өргөн ашиглагддаг байна. Ямар салбарыг хамарч байгаагаасаа хамаарч үндсэндээ p —медиан бодлого, төвийн бодлого, бүрхэх бодлого гэж ангилагдах ба зорилгоосоо хамаарч төсвийн зааглалттай, зааглалтгүй, хүчин чадлыг тооцсон эсвэл тооцоогүй зэргээр ангилагддаг байна. Байршил тогтоох бодлого нь хүн амын өсөлт, үйлдвэржилт, хотжилттой холбоотойгоор сүүлийн 60-аад жилд эрчимтэй судлагдсан. Энэ чиглэлээр маш олон судлаачид судалгааны ажил хийсэн ба бид энд дараах зарим эх сурвалжуудыг ашиглав (Holmberg et al. (1999)), (Klose & Drexl (2005)), (Daskin (2008)), (Ueda et al. (2009)), (Alfonso-Lizarazo et al. (2013)), (Herazo-Padilla et al. (2015)), (Montoya-Torres et al. (2015)), (Muñoz-Villamizar et al. (2017)). Бид өмнийн говийн 4 аймгийн тодорхой үйдвэрлэлийн тохиромжтой байрлалыг эрэмбэлэх бодлогыг FLP техникийг PROMETEE II аргатай хослуулан хэрэглэж эрэмбийг тогтоох тоон туршилтыг хэрэгжүүлсэн. Энэхүү судалгааны ажилд дараах судалгаанууд хийгдсэн.

1. Үйлдвэрийн тохиромжтой байршил тогтооход олон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох тэдгээр шалгуур үзүүлэлтийн бодит утгуудыг зохистойгоор үнэлэх шаардлагатай. Судалгаанд Аналитик Шаталсан Процессыг (АШП) ашиглан өөрсдийн кодыг зохиож шалгуурын ач холбогдлын жинг тооцоолсон бөгөөд энэхүү тооцооллыг Бүлэг 4, 5-д танилцуулсан. Сонголтуудыг эрэмбэлэхэд PROMETEE II аргыг сонгон хэрэглэсэн. Сонголтуудаар энэ дэд бүсийн 47 сумдыг авсан. PROMETEE II аргыг дэлгэрэнгүй тайлбарлаж сүүний үйлдвэрлэлийн оновчтой байршлын хувьд сумыг эрэмбэлэх бодлогод тэдгээр аргуудыг хэрхэн хэрэглэсэн талаар танилцуулсан.
2. Бүлэг 4-т толилуулсан FLP техникийг PROMETEE II аргатай хослуулан хэрэглэж потенциалуудыг тогтоосон.
3. Тоглоомын онол нь орчин үед эдийн засаг, нийгэм, инженерчлэл, үйлдвэржилт, үйлдлийн шинжлэл, цэрэг дайны салбар, олон улсын худалдаа, гэрээ хэлцэл хийхэд өргөн ашиглагдаж байна. Бид энэ судалгааны

хүрээнд тэг биш нийлбэртэй, N-оролцогчтой, зөрчилдөөнт байдалд байгаа тоглогчдын бодлогыг өмнийн говийн бүсийн 47 сумдад аж үйлдвэр байршуулах оновчлолын бодлогод хэрхэн ашиглаж болох талаар Бүлэг 6-д авч үзнэ.

3 Өндөр хөгжилтэй орнуудын FLP-г хэрэглэсэн туршлага

3.1 Байгууламжийн байршил тодорхойлох бодлого

Сүүлийн жилүүдэд байгууламжийн байршил тодорхойлох загвар төрийн болон хувийн салбаруудад ихээхэн хэрэглэгдэж байгаа юм. Байгууламжийн оновчтой байршил олох загварыг харилцаа холбоо, хүнд хөнгөн үйлдвэрүүд, ложистикийн төвүүд зэрэг олон салбарт хэрэглэдэг. Загварын зорилго нь байгууламж болон үйлчлүүлэгчдийн боломжит байршлын олонлог өгөгдсөн байхад хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах, мөн нийт зардлыг багасгах замаар байгууламжийн оновчтой байршил олох явдал юм.

Бодлогын математик загварыг томъёолбол:

$$v^* = \min \sum_{i=1}^m \sum_{j=1}^n c_{ij} x_{ij} + \sum_{i=1}^m f_i y_i \quad (1)$$

$$\sum_{j=1}^n a_{ij} x_{ij} \leq b_i y_i, \quad \forall i \quad (2)$$

$$\sum_{i=1}^m x_{ij} = 1, \quad \forall j \quad (3)$$

$$x_{ij} - y_i \leq 0, \quad \forall i, j \quad (4)$$

$$x_{ij} \in \{0, 1\}, \quad \forall i, j \quad (5)$$

$$y_i \in \{0, 1\}, \quad \forall i \quad (6)$$

Энд: m - боломжит байгууламжийн тоо, n - хэрэглэгчийн тоо, a_{ij} нь j -р хэрэглэгчийн эрэлт, b_i нь i -р байгууламжийн хүчин чадал (capacity), f_i нь i -р байгууламжийг нээх эсвэл ашиглах тогтмол зардал, c_{ij} нь j -р хэрэглэгч болон i -р байгууламж хоорондын зай эсвэл зардал.

(1)-ийг зорилгын функц гэх ба үйлчлүүлэгчдэд зориулж байгууламжийн оновчтой байршилыг тогтоох, байгууламжийн зардлыг хамгийн бага байхаар байгуулах зорилготой. Эдгээр зорилгод хүрэхийн тулд дараах шийдвэрийн хувьсагчид болон хязгаарлалтуудыг авч үздэг.

Шийдвэрийн хувьсагчид:

$$y_i = \begin{cases} 1, & \text{хэрэв } i\text{-р байгууламжийг нээх бол} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$$

$$x_{ij} = \begin{cases} 1, & \text{хэрэв } i\text{-р байгууламж } j\text{-р хэрэглэгчид үйлчилгээ үзүүлдэг бол} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$$

Хязгаарлалтууд:

(2) нь чадамжийн хязгаарлалт гэж тодорхойлогдож, тухайн байгууламжаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн хэрэгцээ нь түүний хүчин чадлаас хэтрэхгүй байх хязгаарлалт юм.

(3) нь эрэлт хэрэгцээний хязгаарлалт гэж нэрлээд, хэрэглэгч бүрийг яг нэг байгууламжид хуваарилана.

(4) нь зөвхөн нээлттэй байгууламжаар үйлчлүүлэх боломжийг хангах хязгаарлалт юм. Байгууламжийн оновчтой байршил тогтоох бодлогыг төрөл бүрээр өргөтгөх боломжтой болохыг дараагийн бүлэгт авч үзье.

3.2 Франц улсын ложистик төвийн байршил тогтоох бодлого

Muñoz-Villamizar et al. (2017) энэ ажилд хот суурин газрын түгээлтийн төвүүд (Urban Distribution Centers)-ийн байршил олох асуудлыг авч үзсэн ба бүхэл шугаман програмчлалын аргыг үндэслэн стратеги, тактикийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргахад зориулж тохирсон арга санал болгосон. Загварт Францийн Saint-Etienne хотын бодит дата ашигласан. Санал болгож буй загварын үр дүн өгөөжтэй ба дунд хэмжээний өгөгдлийн хувьд бодит шийдвэр гаргахад хэрэглэх боломжтой. UDC нь олон төрлийн байгууламж болон олон нийтийн ложистик терминалууд юм: үүнд шилжүүлэн ачих хашаа, дэлгүүрүүд, бөөний худалдаа, мэдээллийн төв г.м. UDC-ийг мэдээллийн системийг ашиглан хотын ложистикийн системийн олон янзын хэрэгцээг холбоход зориулж байгуулдаг. Хот суурин газрын бүсэд хүлээн авах, хүргэх ачааны машинуудыг илүү үр дүнтэй чиглүүлэх, төлөвлөх системийг бий болгох зорилготой.

- UDC нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ачаа тээврийн үр ашигтай тээвэрлэлтийг хэрэгжүүлэхэд тусалдаг. Эдгээр асуудлыг сайжруулснаар тээврийн хэрэгслийн тоо буурч болох юм. Тээврийн хэрэгслийн тоо буурах явдал нь компаниуд мөнгөө хуримтлах, хотын замын хөдөлгөөний түвшин буурах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, улмаар оршин суугчдын амьдралын чанар сайжрах зэрэг ач холбогдолтой.
- Эдгээрийг шийдэх бодлогыг Location Routing Problem (LRP) гэж нэрлээд, энэ нь боломжит цэгүүдийн доторх байгууламжийн байршил, хэрэглэгч хоорондох маршрутын зохион байгуулалт зэргийг бүхэлд нь зохицуулдаг.

UDC-ийн байршил болон үйл ажиллагааг оновчлох математик загварыг нарийвчлан авч үзье. Энэ загвар нь дараах параметруудийг оролт гэж үздэг.

- Хэрэглэгчийн тоо, хотын төвийн тоо. Мөн түүнчлэн тэдгээрийн байршил, тус бүрийн хоорондын зай эсвэл зардал.
- Ашиглах/нээх түгээлтийн төвийн тоо.
- Тээврийн хэрэгслийн тоо болон тэдгээрийн хүчин чадал.
- Хэрэглэгчийн хэрэгцээ.

Эдгээр параметруудээр загварын хязгаарлалтыг тохируулдаг. Хотын түгээлтийн төвийн системчилсэн дүрслэлийг дараах зургаас харж болно. Загварт зориулсан тэмдэглээнүүдийг танилцуулъя.

Үндсэн олонлогууд:


- $I =$ Хотын түгээлтийн төвүүд $\{1, 2, \dots, i\}$
- $J =$ Хэрэглэгчид $\{1, 2, \dots, j\}$
- $K =$ Тээврийн хэрэгсэлүүд $\{1, 2, \dots, k\}$

Туслах олонлогууд:

- $H, F =$ alias of J

- $L = \text{alias of } K$

Хотын түгээлтийн төвийн системчилсэн дүрслэл



Шийдвэрийн хувьсагчид:

- $A_i = \begin{cases} 1, & \text{хэрэв түгээлтийн төв } i \text{ байршилд байршсан бол} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$
- $X_{ijk} = \begin{cases} 1, & \text{хэрэв } k\text{-р тээврийн хэрэгсэл } i\text{-д байршсан түгээлтийн төвөөс } j\text{-р хэрэглэгчрүү явдаг бол} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$
- $Y_{jik} = \begin{cases} 1, & \text{хэрэв } k\text{-р тээврийн хэрэгсэл } j\text{-р хэрэглэгчээс } i\text{-д байршсан түгээлтийн төврүү явдаг бол} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$
- $B_{jhk} = \begin{cases} 1, & \text{хэрэв } k\text{-р тээврийн хэрэгсэл } j\text{-р хэрэглэгчээс } h\text{-р хэрэглэгчрүү явдаг бол} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$

Параметрууд:

- $C1_{ij}$ = i -д байршсан түгээлтийн төвөөс j -р хэрэглэгчрүү явах зардлын матриц
- $C2_{ji}$ = j -р хэрэглэгчээс i -д байршсан түгээлтийн төврүү явах зардлын матриц
- $C3_{jh}$ = j -р хэрэглэгчээс i -р хэрэглэгчрүү явах зардлын матриц
- C = Нээх түгээлтийн төвийн тоо
- V = Боломжит тээврийн хэрэгслийн тоо
- D_j = j -р хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ
- CAP_k = k -р тээврийн хэрэгслийн хүчин чадал

• $N =$ Хэрэглэгчийн тоо

Дараах тэгшитгэл нь зорилгын функцийг илэрхийлдэг. Энэ нь бүх хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах бөгөөд нийт зай эсвэл өртөгийг UDC-ийн байршил дагуу минимумчлах зорилготой.

$$\min Z = \sum_i \sum_j \sum_k C1_{ij} \cdot X_{ijk} + \sum_i \sum_j \sum_k C2_{ji} \cdot Y_{jik} + \sum_j \sum_h \sum_k C3_{jh} \cdot B_{jhk}$$

Зааглалт (7) нь UDC-ийг нээх хамгийн их тоог тогтоохыг заана. Тухайлбал Saint-Etienne хотын тусгай тохиолдолд зөвхөн нэг төв байршуулна гэж тодорхойлогдсон байна. (ө.х: $C = 1$).

$$\sum_i A_i \leq C \quad (7)$$

Зааглалт (8) нь нээх эсвэл байршуулсан UDC-ээс явах тээврийн хэрэгслийн чиглэлүүдийг тодорхойлж болохыг харуулдаг.

$$V \cdot A_i \geq \sum_j \sum_k X_{ijk}, \quad \forall i \quad (8)$$

Зааглалт (9) нь нийт эрэлт хэрэгцээг хангахад шаардагдах маршрут/тээврийн хэрэгслийн хамгийн бага тоог тооцдог. Хэрэв хүсвэл тээврийн хэрэгслийн тоо нь тогтмол утгатай байж болно;

$$\sum_i \sum_j \sum_k X_{ijk} \geq \frac{\sum_j D}{CAP_k} \quad (9)$$

Зааглалт (10) нь маршрутыг зочлох ёстой хэрэглэгчдийн дарааллаар зочилсон анхны хэрэглэгчтэй холбодог.

$$\sum_i X_{ijk} \leq \sum_h B_{jhk}, \quad \forall j, \forall k \quad (10)$$

Зааглалт (11) нь бүх хэрэглэгчийн хувьд бүрэн маршрутын дарааллыг тодорхойлно.

$$\sum_i X_{ijk} + \sum_h B_{hjk} = \sum_i Y_{jik} + \sum_f B_{jfk}, \quad \forall j, \forall k \quad (11)$$

Зааглалт (12) нь хэрэглэгчээс эсвэл UDC-ээс бүх хэрэглэгчидрүү яг нэг удаа явсан гэдгийг тодорхойлно.

$$\sum_i \sum_k X_{ihk} + \sum_j \sum_k B_{jhk} = 1, \quad \forall h \quad (12)$$

Зааглалт (13) нь тээврийн хэрэгсэл хэрэглэгчрүү очсоны дараа өөр үйлчлүүлэгчрүү очих эсвэл UDC-рүү буцаж ирдэг болохыг тодорхойлно.

$$\sum_h \sum_k B_{ihk} + \sum_i \sum_k Y_{jik} = 1, \quad \forall j \quad (13)$$

Зааглалт (14) нь бүх тээврийн хэрэгслүүдийн маршрут нэг ижил UDC-ээс эхэлж, дуусахыг тодорхойлно.

$$\sum_j X_{ijk} = \sum_h Y_{hik}, \quad \forall i, \forall k \quad (14)$$

Тээврийн хэрэгслийн хүчин чадлыг маршрутын уртын хязгаараар тодорхойлдог. Үүнийг (15) тэгшитгэл харуулна.

$$\sum_i \sum_j X_{ijk} \cdot D_j + \sum_j \sum_h B_{hjk} \cdot D_j \leq CAP_k, \quad \forall k \quad (15)$$

Зааглалт (16) нь нэг тээврийн хэрэгсэлд хамгийн ихдээ нэг маршрут байхаар хязгаарлаж байгааг илэрхийлнэ.


$$\sum_i \sum_j X_{ijk} \leq 1, \quad \forall k \quad (16)$$

Зааглалт (17) ба (18) нь маршрут бүрийн хэмжээ ижил байна гэдгийг баталгаажуулах; Энэ нь ачаалал тэнцвэржүүлэх хязгаарлалт юм. Эдгээр хязгаарлалтуудыг заавал дагаж мөрдөхгүй бөгөөд хэд хэдэн хүчин зүйлээр тооцогддоггүй: тээврийн хэрэгслийн хүчин чадал нэгэн төрлийн бус байх гэх мэт.

$$\sum_j \sum_h B_{jhk} \leq \left(\sum_j \sum_h B_{jhl} \right) + 1 \quad \forall k, \forall l \quad (17)$$

$$\sum_j \sum_h B_{jhk} \leq \left(\sum_j \sum_h B_{jhi} \right) + 1 \quad \forall k, \forall i \quad (18)$$

Энэхүү загварт Францийн Saint-Etienne хот дахь 1227 хэрэглэгчийн бодит координатаар Euclidean зайн хэмжээсээр зардлын матрицыг тооцоолсон. Үүнээс 100 хэрэглэгчтэй үед UDC-ийн 5 боломжит байршлыг оновчтой тогтоохоор шинжлэв. Энэ загварийн шийд нь бодит байдалтай ойролцоо буйг туршилтаар баталсан. Доорх зураг 100 үйлчлүүлэгчдийн хувьд 5 боломжит UDC-ийн цэг болон оновчтой маршрутыг харуулж байна.



UDC location and found distribution route (sub-optimal) using the proposed model with 100 clients and 5 potential locations for UDC

3.3 Нью-Йоркийн банкны салбарын бодлого

Wang et al. (2003) судалгааны ажилд зарим нэг шинэ байгууламж нээх, одоо байгаа зарим байгууламжийг хаах талаар авч үзэж байгаа.(эрэлт хэрэгцээний хуваарилалтын өөрчлөлтөөс шалтгаалан одоо байгаа байгууламжийн тогтолцоо хангалттай үйлчилгээг үзүүлэх боломжгүй байдаг) Үүний тулд төсвийн хязгаарлалт,

нээх байгууламжийн хүссэн тоо зэргээс шалтгаалан нийт сүлжээндээ жинлэсэн зайг хамгийн бага байлгана. Бодлогын томъёололд $G(M, N_1, N_2, D)$ сүлжээгээр илэрхийлэгдэж болох системийг авч үздэг. Энд:

- $M = \{1, \dots, m\}$: хэрэглэгчидийн зангилааны олонлог
- $N = \{1, \dots, n\} = N_1 \cup N_2$: нийт байгууламжийн зангилааны олонлог
- $N_1 = \{j_1, \dots, j_q\}$: одоо байгаа байршсан байгууламжийн зангилааны олонлог
- $N_2 = \{j_{q+1}, \dots, j_n\}$: шинээр байршуулах байгууламжийн зангилааны олонлог
- $D = d_{ij}$: $i \in M$ хэрэглэгч болон $j \in N$ байгууламжийн хоорондох зайн матриц
- w_i : $i \in M$ хэрэглэгчийн эрэлт
- p : менежментийн дагуу хүсэж буй нээх байгууламжийн нийт тоо
- $q = |N_1|$: одоо байгаа байгууламжийн тоо
- c_j : одоо байгаа $j \in N_1$ байгууламжийг хаах зардал эсвэл шинэ $j \in N_2$ байгууламжийг нээх зардал
- b : нийт боломжит төсөв

Мөн шийдвэрийн хувьсагчуудыг дараах байдлаар бичиж болно:

$$y_j = \begin{cases} 1, & \text{Хэрэв } j \in N \text{ байгууламжийг нээх бол} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$$

$$x_{ij} = \begin{cases} 1, & \text{Хэрэв } i \in M \text{ хэрэглэгч } j \in N \text{ -д байршсан байгууламжаас хэрэгцээгээ авдаг бол} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$$

Бодлогын математик загварыг томъёолбол дараах хэлбэртэй байна:

$$\sum_{i \in M} \sum_{j \in N} w_i d_{ij} x_{ij} \rightarrow \min$$

$$\sum_{j \in N_1} c_j (1 - y_j) + \sum_{j \in N_2} c_j y_j \leq b$$

$$\sum_{j \in N_1} x_{ij} = 1, \forall i \in M$$

$$\sum_{j \in N_1} y_j = p$$

$$x_{ij} \leq y_j, \forall i \in M, j \in N$$

$$y_j \in \{0, 1\}, \forall j \in N$$

$$x_{ij} \geq 0, \forall i \in M, j \in N$$

Энд эхний зааглалт зардал нь нийт боломжит төсвөөс гарах зардалаас бага эсвэл тэнцүү байхыг заана, дараагийн зааглалт нь p тооны байгууламж хүсэж байгаа учир нээх байгууламжийн нийлбэр $\sum_{j \in N_1} y_j = p$ байна. Хэрэглэгч зөвхөн нээлттэй байх байгууламжийг үйлчлүүлэх учир $x_{ij} \leq y_j, \forall i \in M, j \in N$ зааглалтыг оруулна. Хэрэглэгч бүр яг нэг байршилд байна гэвэл $\sum_{j \in N_1} x_{ij} = 1, \forall i \in M$ болно.


4 Өндөр хөгжилтэй орнуудын АНР болон PROMETHEE аргыг хэрэглэсэн туршлага

4.1 Улс орны АНР болон PROMETHEE аргыг хэрэглэсэн байдал

Д/д	Улсын нэрс	Салбар	Эх сурвалж	Тайлбар
1	Турк	Агаарын тээвэр	https://www.sciencedirect.com/science/article/pii/S095741741100947X	Turkish Airline болон бусад Агаарын тээврийн компаниудын зах зээлд өрсөлдөх чадварын судалгаа, best strategy-ийг сонгоход уг аргыг ашигласан.
2	Турк	Үйлдвэрлэлийн байршил тогтоох	https://www.researchgate.net/publication/237658597_LOCATION_CHOICE_FOR_FURNITURE_INDUSTRY_FIRMS_BY_USING_ANALYTIC_HIERARCHY_PROCESS_AHP_METHOD	Үйлдвэрийн зах зээлийн болон хөрөнгө оруулалтыг татах потенциалыг үнэлж байршлыг оновчтой тогтооход уг арга хэрэглэсэн
3	Турк	Байгууламжийн байршил тогтоох	http://www.rafikulislam.com/uploads/resources/197245512559a37aadea6d.pdf	Газар хөдлөлтөд сүйрсэн Туркийн Adapazari хотын нүүлгэн шилжүүлэлтийн хамгийн сайн байршлыг 2001 онд АНР аргыг ашиглан тогтоосон.
4	Хятад	Усны менежмент тогтвортой хөгжлийн бодлого	https://pdfs.semanticscholar.org/56eb/05d4c5a5c2069e6adcb175ecd364cba7c61c.pdf	Усны менежментын болон ашиглалтын оновчтой бодлогыг тодорхойлоход энэхүү аргыг хэрэглэсэн
5	Хятад	Хөрөнгө оруулалтын байршил тогтоох	http://www.rafikulislam.com/uploads/resources/197245512559a37aadea6d.pdf	Disney Decision: Disney Park - ийг Хятадад байгуулах оновчтой байршлыг тогтооход АНР аргыг хэрэглэсэн ба энэ судалгааны үр дүнгээр Хонг Конг хамгийн өндөр үзүүлэлттэй гарчээ.
6	АНУ	Цөмийн хог хаягдлын стратегийн үнэлгээ	Saaty and Gholamnezhad (1982)	АНУ-ийн цөмийн хог хаягдлыг аюулгүй байдлаар зайлуулах стратегийн үнэлгээнд АНР аргыг хэрэглэсэн
7	Hong-Kong	Стратегийн Үнэлгээ	https://www.sciencedirect.com/science/article/abs/pii/S0925527397000169	Хонконгийн electronic бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниуд CE хэрэгжүүлэх стратеги боловсруулахад амжилтын хүчин зүйлс, ашиг тус болон зардлуудыг үнэлэх зорилгоор АНР загварыг боловсруулж ашигласан.
8	Mexico	Selection site	https://www.sciencedirect.com/science/article/pii/S0168169913002512?via%3Dihub	Энэхүү ажлын зорилго нь шинэ ХАА хүнсний агуулахын оновчтой байршлыг үнэлэхэд чиглэсэн юм. Байршлын асуудал, агробизнесд хамгийн их ашиглагддаг шинж чанар, шалгуурт дүн шинжилгээ хийж кейс судалгааг толилуулсан.

Өндөр хөгжилтэй орнуудын АНР болон PROMETHEE аргыг хэрэглэсэн байдлын судалгааг тив, дэлхий, салбараар нь тоон статистикийн баримтаар харуулав. Дээрх хүснэгтэд зарим улс уг аргыг ямар салбаруудад хэрэглэсэн болохыг дурдав. Маш олон судалгааны ажлуудаас онцолж орууллаа.

4.2 АНР аргын тархалтын судалгаа






5 Сонголтуудыг эрэмбэлэх

5.1 Аналитик шаталсан процесс

Аналитик шаталсан процессыг (Analytic Hierarch Process) анх Питтсбург Их Сургуулийн профессор Thomas L. Saaty (Univ. Pittsburgh) анх дэвшүүлж улам сайжруулан Аналитик Сүлжээний процессыг (Analytic Network Process) үндэслэсэн төдийгүй эдгээр аргуудын практикийн олон бодлогод хэрэглэн хөгжүүлсэн юм Saaty (2007). Тэдгээр аргуудыг дэлхий олон оронд шийдвэр гаргалтад бодитоор хэрэгжүүлсэн жишээ, олон зуун судалгаа байна Lin et al. (2018). Мөн судлаачид Fuzzy AHP, PROMETHEE Brans et al. (1986) энэ аргыг дэвшүүлэн онолын түвшинд, практик хэрэглээдн өргөн хэрэглэж байна. Энэ арга нь ямар нэг зорилгод нийцсэн сонголтуудыг тоон утгын тусламжтайгаар эрэмбэлэх арга бөгөөд сонголтуудыг зорилгодоо нийцсэн байдлыг шалгахад шаардлагатай шалгуур (хүчин зүйл)-ыг сонгож, шалгуурын ач холбогдолыг жинг тодорхойлон гаргадаг. Энэхүү үйл явцыг дараах зургаар харууллаа.



Аналитик шаталсан процессын чухал үе шат нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд шалгууруудыг (хүчин зүйлүүдийг) сонгох, тэдгээрийн ач холбогдлыг хос хосоор нь эрэмбэлэх бөгөөд энэ үйл явцад туршлагатай экспертүүд (төлөөлөл) оролцох шаардлагатай байдаг. Шалгуурыг сонгох үндсэн дараах зарчимд тодорхойлох шаардлагатай. Бидний энэ үйлдвэрлэлийн байршилын судалгаанд дараах зарчмуудыг баримталсан болно. Үүнд:

- Үйлдвэрлэлийн үндэсний онцлогыг тусгах
- Хэмжигдэх хүчин зүйлийг сонгох
- Улс төрийн, хууль эрх зүйн орчинг бүрдсэн гэж үзэх

Олон экспертүүдийн ач холбогдлын эрэмбэлэлтийн тоон утгын геометр дундажаар нэгдсэн эрэмбэлэлтийг гаргаж болно. Шалгууруудын ач холбогдлыг хос хосоор нь жинлэх техникийг нарийвчлан авч үзье.

Аналитик шаталсан процесс нь сонголтыг эрэмбэлэхэд хэрэглэгдэх шалгууруудаа ач холбогдлын жингийн утгыг тодорхойлох нь хамгийн чухал үйл явц юм. Энэхүү аргад шалгуур $\{C_1, C_2, \dots, C_k\}$ ын ач холбогдлыг хос хосоор нь жинлэхдээ тогтсон $\{1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9\}$ онооны хуваарилалтыг авч үзсэн байдаг. Энэ нь психофизикийн Вебер-Фехнер хуультай холбоотойгоор тогтоосон байна. Тайлбарыг дараах хүснэгтээр үзүүлээ.

Ач холбогдолы н оноо	Тодорхойлолт	Тайлбар
1	Адил ач холбогдолтой	Хоёр хүчин зүйлийн нөлөөлөл тэнцүүхэн
2	Багахан эсвэл сул	
3	Дунд зэргийн ач холбогдолтой	Нэг нь нөгөөгөөсөө арай илүү нөлөөлөл үзүүлэх
4	Дундаас арай илүү	
5	Хүчтэй ач холбогдолтой	Нэг нь нөгөөгөөсөө илүү хүчтэй нөлөөлөл үзүүлэх
6	Илүү хүчтэй ач холбогдолтой	
7	Маш хүчтэй эсвэл маш чухал ач холбогдолтой	Нэг нь нөгөөгөөсөө маш хүчтэй нөлөөлөл үзүүлэн ноёрхох байдалтай
8	Маш их хүчтэй ач холбогдолтой	
9	Хамгийн дээд зэргийн ач холбогдолтой	Нэгнээсээ дээд зэргээр илүү нөлөөлөл үзүүлэх
1/k	1/2, ..., 1/9 урвуу хамаарал	C1 бол C3 аас илүү хүчтэй нөлөөлөлтэй бол 5 Харин C3-ийг C1 тэй харьцуулахад 1/5

J гээр хос хосоор нь харьцуулсан онооны матрицыг тэмдэглэе. J нь шалгуурын тоотой тэнцүү тооны мөр, мөн тийм тооны баганатай квадрат матриц байна. Өөрийг нь өөртэй нь харьцуулж байгаа тул гол диагональ дээр 1-тоо байрлана. Жишээлбэл C_1 ба C_3 шалгуурууд сонголтонд аль хир ач холбогдолтойг харьцуулах гэж байгаа гэж үзье. C_1 нь C_3 аас нилээд илүү чухал (дундаас арай илүү) гэж үзсэн. (Дараах зургаар илэрхийлж байна.)



$C_1 = 4C_3$ гэж математик илэрхийлэлээр бичиж бөгөөд J матрицын 1-р мөрний 3-р багананы утга нь 4 болно. Иймд $C_3 = \frac{1}{4}C_1$ болох учир 3-с р мөрний 1-р багананы утга нь $\frac{1}{4}$ болно. Гол диагналас дээр орших утгуудыг олсноор матрицын бусад утгыг олдоно. Дээр дурьдсанчлан энэхүү жинлэлтийг туршлагатай экспертүүд болон мэргэжлийн нийгэмлэг, холбоодтой хамтран хийхийг зорих хэрэгтэй. АШП техник болон программыг ашиглан уг J матрицын нийцэлийг тодорхойлох $C.R.$ (consistency ratio) гэсэн утгаар тодорхойдог ба өөрөөр хэлбэл нийцэл гэдэг нь уг харьцуулалт зөрчилгүй, тууштай байгаа зэргийг илэрхийлэх юм. Практикт $C.R. < 0.1$ байхыг хүлээн зөвшөөрөхүйц гэж үздэг. Хэрэв $C.R. \geq 0.1$ бол J матрицын утгууд нийцэлгүй байна гэж үзээд жинлэлтийг эргэж харах хэрэгтэй. Энэ тохиолдолд уг аргыг үргэжлүүлэх боломжгүй гэж үздэг. Өмнөх жишээний нийцлийг тодорхойлох утга $C.R. = 0.057$ тул ухаалаг нийцтэй жинлэлт хийсэн гэж үзээд анализыг цааш үргэлжлүүлэн бусад тооцооллыг хийж шалгуур бүрийн ач холбогдлын жин $W = (w_1, w_2, \dots, w_k)$ багананы утгыг гаргаж ирнэ. Жинлэлтийн J матрицыг зохиох нь хэрэглэгчид илүү төвөггүй байлгах үүднээс хялбар аргачлалыг Хавсралт хүснэгт 1-д хийсэн.

Дараах матриц нь J матрицын ард ач холбогдлын жинг буюу $W = (w_1, w_2, w_3, w_4)$ баганыг залгаж бичиж харуулсан байна.

	C_1	C_2	C_3	C_4	W
C_1	1	3	4	9	0.58
C_2	1/3	1	1/2	3	0.16
C_3	1/4	2	1	2	0.19
C_4	1/9	1/3	1/2	1	0.07

Энэ тохиолдолд C_1 шалгуур нь хамгийн их ач холбогдолтой гэж гарсан бөгөөд жин нь 0.58 байна.


5.2 PROMETHEE арга

Preference-Ranking Organisation METHod for Enrichment Evaluation (PROMETHEE) аргыг анх 1982 онд профессор Ж. П. Бранс (Univ. Brussel) дэвшүүлэн хөгжүүлсэн бөгөөд PROMETHEE I арга нь сонголтуудыг хагас эрэмбэлэх арга бол PROMETHEE II нь гүйцэд эрэмбэлэдэг арга юм (Brans et al. (1986)).

Бид энэ судалгаанд PROMETHEE II аргаар сонголтуудын эрэмбийг тогтоосон болно. Энэхүү эрэмбэлэх аргын математик томъёоллыг товч танилцуулбал:

$$\max\{C_1(a), C_2(a), \dots, C_k(a) \mid a \in A\}$$

энд $A = \{a_1, a_2, \dots, a_n\}$ бол сонголтуудын олонлог, C_i нь i -р шалгуур, $C_i(a)$ бол a сонголтын C_i шалгуураарх үнэлгээг тэмдэглэсэн.



Энэ бодлогын хувьд аль шалгуурыг хамгийн их байлгах, алийг нь бага байлгах бэ гэдэг зорилгыг шийдвэр гаргагчид (экспертүүд) тодорхойлох болно. Энэ нь бид өмнөх бүлэгт шалгуурын жинг тодорхойлох тухай дурьдсантай адилхан ойлголт юм. Дараах хүснэгтээр шалгууруудын хувьд сонголтуудын өгөгдлийг харууллаа.

a	$C_1(\cdot)$	$C_2(\cdot)$...	$C_j(\cdot)$...	$C_k(\cdot)$
a_1	$C_1(a_1)$	$C_2(a_1)$...	$C_j(a_1)$...	$C_k(a_1)$
a_2	$C_1(a_2)$	$C_2(a_2)$...	$C_j(a_2)$...	$C_k(a_2)$
...
a_i	$C_1(a_i)$	$C_2(a_i)$...	$C_j(a_i)$...	$C_k(a_i)$
...
a_n	$C_1(a_n)$	$C_2(a_n)$...	$C_j(a_n)$...	$C_k(a_n)$

Бид судалгаандаа ашигласан PROMETHEE II аргын тооцооллын алхамуудыг Doumpos & Zorounidis (2004); Najkovicz & Higgins (2008), судалгаанд авч үзсэнээр танилцуулбал:

Алхам 1. Дээрх хүснэгтийн утгуудыг матриц гэж үзвэл $x_{ij} = C_j(a_i)$ буюу j -р шалгуурын хувьд i -р сонголтын

өгөгдлийг тэмдэглэсэн. Шалгуурууд нь тоон утгаар илэрхийлэгдэх эсвэл тоон утгаар илэрхийлэгдэхгүй үгээр илэрхийлэгдэх түүнчлэн хэмжих нэгж нь өөр өөр байдаг тул тэдгээрийн x_{ij} утгуудыг нэг ижил масштаб руу шилжүүлэх нэгжээс чөлөөлөх шаардлагатай болдог. Энэ асуудлыг X матрицыг нормалчилсоноор шийддэг. Гэхдээ шалгуурыг нөлөөллөөр нь эерэг болон сөрөг гэсэн 2 бүлэгт хувааж тус бүрт өөр өөр томъёогоор нормалчилна. Өөрөөр хэлбэл эерэг шалгуурын утга их л байвал сайн харин сөрөг шалгуурын харгалзах утга бага бол сайн байна гэсэн үг юм.

Эерэг шалгуурын хувьд:

$$R_{ij} = \frac{x_{ij} - \min X_j}{\max X_j - \min X_j}$$

Сөрөг шалгуурын хувьд:

$$R_{ij} = \frac{\max X_j - x_{ij}}{\max X_j - \min X_j}$$

Энд: X_j гэдгээр j -р баганыг тэмдэглэсэн ба $\min X_j$ бол j -р баганын хамгийн бага утга нь бол $\max X_j$ нь хамгийн их утга юм. Энэ алхамд R нормчлогдсон матриц үүснэ.

Алхам 2. Шалгуур бүрийн хувьд сонголтуудыг хос хосоор нь авч давуу байдлыг тодорхойлох $P_j(\cdot, \cdot)$ функцын утгын тооцоолохдоо дараах томъёог хэрэглэдэг. Үүнд:

$$P_j(i, i') = \max\{0, R_{ij} - R_{i'j}\}$$

Энэ алхамын үр дүнг бидэнд $n(n-1) \times k$ хэмжээтэй матрицад хадгалан авна.

Алхам 3. Нийт шалгуурын хувьд сонголтуудын хослолын давуу байдлыг илэрхийлэх нэгдмэл $\pi(\cdot, \cdot)$ функцийг (aggregated preference function) утгыг тооцоолсон. Энд өмнөх бүлэгт танилцуулсан шалгууруудын ач холбогдлын жин $W = (w_1, w_2, \dots, w_k)$ утгуудыг ашиглана.

$$\pi(i, i') = \frac{\sum_{j=1}^k w_j P_j(i, i')}{\sum_{j=1}^k w_j}$$

Энэ функцийг $(n \times n)$ хэмжээтэй матрицад хадгалсан болно.


Алхам 4. Тухайн сонголт бүрээс бусад сонголттой харьцуулахад давамгай байдлын эерэг урсгалыг тодорхойлоход (positive outranking flow) функцийг

$$\varphi^+(i) = \frac{1}{n-1} \sum_{i'=1}^n \pi(i, i'),$$

гэж харин бусад сонголтууд тухайн сонголтаас давамгай байх сөрөг урсгалыг тодорхойлох (negative outranking flow) функцийг

$$\varphi^-(i) = \frac{1}{n-1} \sum_{i'=1}^n \pi(i', i)$$

гэж тус тус тодорхойлдог. Учир нь энэхүү аргын харьцуулалт нь чиглэлтэй ойлголт учир хоёр талын урсгалыг тооцоолдог юм (Санааг доорх диаграмаар харууллаа).



Давамгай байдлын эерэг урсгал Давамгай байдлын сөрөг урсгал

Алхам 5. Сонголт бүрийн хувьд нийт урсгалын функцийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

$$\varphi(i) = \varphi^+(i) - \varphi^-(i)$$

Алхам 6. Бүх сонголтуудын хувьд $\varphi(i)$ утгын эрэмбээр ранкийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл $\varphi(i)$ утга хамгийн их байвал i -р буюу a_i сонголт хамгийн өндөр ранктай болно.

5.3 Үйлдвэрийн салбар бүрийн шалгуур үзүүлэлтийн жинг тодорхойлох

Хөнгөн үйлдвэрлэлийн мэргэжлийн холбоодын нэгдсэн уулзалт, хэлэлцүүлгээр “Үйлдвэрлэлийн оновчтой байршлийн хүчин зүйлүүдийг тогтоох, тухайн хүчин зүйлийн ач холбогдлын жинг тодорхойлох” судалгааны ажлын тайланг энэ хэсэгт дурдав.

Хөнгөн үйлдвэрүүдийн мэргэжлийн холбоодын тэргүүн, үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн уулзалт, хэлэлцүүлгийг 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 11-13 цагийн хооронд зохион байгуулж уг уулзалтанд:

- Монголын Махны Холбоо (Ментор Б.Баярбаатар)
- Монголын Ноос Ноолуурын Холбоо (Ментор С.Батбилэг)
- Монголын Арьс Ширний Үйлдвэрлэлийн Холбоо (Ментор Д.Мөнхжаргал)
- Монголын Жимс Жимсгэнийн Үндэсний Холбоо (Ментор Ц.Сэлэнгэ)
- Монголын Сүүний Холбоо (Ментор Т.Делтуяа)
- Монголын Үр Тариа эрхлэгчдийн төлөөлөл (Ментор Ц.Сэлэнгэ)
- Хаягдал дахин боловсруулах салбарын төлөөлөл (Ментор Г.Баттөр)
- Ой, Модны Үйлдвэрлэл Эрхлэгчдийн Холбоо (Ментор Ж. Энхбаяр)
- Монголын Оёдлын Нэгдсэн Холбоо (2019.08.23 Төв аймагт Могол Ноосны Үйлдвэрт зохион байгуулсан, Ментор С.Батбилэг, Ц.Сэлэнгэ)

оролцож өөрсдийн саналаа солилцон холбогдох хүчин зүйлүүдийг гарган тэдгээрийн ач холбогдлын жинг тодорхойлоход өөр өөрсдийн саналыг өгсөн болно. Судалгааны баг өөрсдийн сонгосон аргачлалаар саналын хүснэгт боловсруулж түүнд менторуудын боловсруулалт хийж төлөөллүүд тус бүрийн болон салбарын нэгдсэн үнэлгээг тус тус гарган доор танилцуулж байна. Тодруулбал оролцогчдоос санал авахдаа хүчин зүйлсийг хос хосоор нь харьцуулах замаар 1, 3, 5, 7, 9 болон $1/3$, $1/5$, $1/7$, $1/9$ гэсэн оноонуудаар үнэлүүлсэн бөгөөд энэхүү үнэлгээнд суурилсан онооны матриц дээр математик боловсруулалт хийж хүчин зүйл тус бүрийн оролцооны жинг тодорхойлсон болно. Олон мэргэжилтнүүдийн үнэлгээнээс нэгдсэн жинг гаргахдаа геометр дунджаар тооцоолсон. Хүчин зүйлийн жингийн хамгийн их байгаа нь хамгийн их ач холбогдолтой нь болно.

Мах, махан бүтээгдэхүүний салбарын оролцогчид

Санал асуулгад мах, махан бүтээгдэхүүний салбарын төлөөлөл Б.Очирбат, Д.Оюунтуяа, Н. Жавхлан, И.Баттогтох, Амарсайхан болон, ментороор А.Баярбаатар нар оролцов.

Говийн дэд бүсийн 47 сумдын хувьд сүүний үйлдвэр барихад тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг хангах хамгийн их потенциалтай сонгох бодлогыг томъёолон эхлээд шалгуур үзүүлэлтүүдийг сонгон тэдгээрийн ач холбогдлын жинг АШП аргаар тодорхойлон нийцтэй эсэхийг шалгаж сонголтууд болох 47 сумыг сүүний үйлдвэр барихад тохиромжтой байдлаар нь эрэмбэлэн харуулсан. Тус салбарын оролцогчдод тухайн санал асуулгыг хэрхэн хийх, санал асуулгад өөрсдийн саналыг хэрхэн тусгах тухай танилцуулж ярьсны дараа тухайн салбарын мэргэжилтнүүд 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлдөв. Энэхүү зөвлөлдөөний үр дүнд дараах 15 хүчин зүйлс нь тухайн салбарын хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйлс гэдэг дээр санал нэгдэж, эдгээрийн хүчин зүйлүүдийн нөлөөллийн эрчмийг тодорхойлох санал асуулга хийв. Үүнд: Мах, махан бүтээгдэхүүний салбарын хөгжилд нөлөөлөх боломжтой хүчин зүйлсийн нөлөөллийн эрчим жинг тодорхойлох, хооронд нь харьцуулах зорилготой санал асуулга судалгаа болно. Махны үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
<i>C₁</i>	<i>Ус</i>	<i>0.16</i>
<i>C₂</i>	<i>Цахилгаан эрчим хүч</i>	<i>0.13</i>
<i>C₃</i>	<i>Бохирын системийн хүчин чадал</i>	<i>0.09</i>
<i>C₄</i>	<i>Дулаан</i>	<i>0.06</i>
<i>C₅</i>	<i>Газрын байршил</i>	<i>0.06</i>
<i>C₆</i>	<i>Дэд бүтэц</i>	<i>0.03</i>
<i>C₇</i>	<i>Малын нөөц, төрөл</i>	<i>0.08</i>
<i>C₈</i>	<i>Хүний нөөц</i>	<i>0.06</i>
<i>C₉</i>	<i>Хэрэглэгчийн тоо, хүрээлэл</i>	<i>0.05</i>
<i>C₁₀</i>	<i>Малын эрүүл мэнд</i>	<i>0.12</i>
<i>C₁₁</i>	<i>Түүхий эд боловруулах үйлдвэртэй ойр байх</i>	<i>0.04</i>
<i>C₁₂</i>	<i>Бусад ижил төрлий үйлдвэрээс алслагдсан байдал</i>	<i>0.02</i>
<i>C₁₃</i>	<i>Тээвэр ложистик</i>	<i>0.04</i>
<i>C₁₄</i>	<i>Бэлчээрийн нөөц</i>	<i>0.05</i>
<i>C₁₅</i>	<i>Малын тууврын зам</i>	<i>0.03</i>

Ноос, ноолуурын салбарын оролцогчид

Ноос ноолуурын салбарын Энхболд, Оюунгэрэл, Одгэрэл, Сайнбаяр, ментор нь С.Батбилэг Тус салбарын оролцогчдод санал асуулгын талаар зөвлөлгөө өгсний дараа мэргэжлийн хүмүүс нь зөвлөлдөөд дараах зүйлүүдэд санал нэгдэв. Ноос, ноолуурын салбарын үйлдвэрлэл нь 3 үе шаттай явагддаг. Үүнд:

1. Анхан шатны боловсруулалт /угаах, хялгас ялгах/. Эдгээр үйлдвэрийг орон нутагт сумуудад байгуулах боломжтой. /Жич: УБ хотоос эдгээр үйлдвэрүүдийг гаргах шийдвэр хэрэгжихгүй байгаа тул орон нутагт энэ төрлийн үйлдвэрийг байгуулахад саад болж байна. Энэ талаар төр засаг, мэргэжлийн холбооноос бодлого гаргасан боловч хэрэгжилт тун хангалтгүй/
2. Дунд шатны боловсруулалт/самнах, ээрэх, будах/. Энэ үйлдвэрүүдийг тэр бүр орон нутагт байгуулахад хүндрэлтэй. Химийн бодис хэрэглэдэг тул байгаль орчны талаасаа эрсдэлтэй тул хэсэг аймаг, бүсийн хэмжээнд сайтар тооцож байгуулбал болох талтай. Нөгөө талаас мөн мэргэжлийн ажиллах техник ажилтнууд хөдөө орон нутагт дутагдалтай.
3. Сүлжмэл эдлэл, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл. Энэ төрлийн үйлдвэрлэл нь технологи, өндөр мэргэжлийн ажилтан, ажилчдыг шаарддаг. Энэ төрлийн үйлдвэрүүд УБ хотод байхад хангалттай.

Оролцогчид эдгээр хүчин зүйлийг тооцоод анхан шатны боловсруулах үйлдвэрүүд дээр хүчин зүйлсийн нэрс, санал асуулгыг явуулахаар тогтлоо. Жич: Мэргэжлийн холбоон дээр энэ талаар гаргасан судалгаа, бодлогын баримт бичиг байдаг, мөн энэ өдөр мэргэжлийн холбооноос болон энэ төрлийн үйлдвэрлэл эрхлэгчдээс

төлөөлөл нь болж чадахуйц хангалттай тооны хүн ирээгүй тул дараа С.Батбилэгийг цаг өдөр товлож, мэргэжлийн холбоотой хамтран аль болох олон хүнээс дээрх санал асуулгыг авахыг санал болгосон болно. Ноос, ноолуурын үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
C_1	Түүхий эдийн нөөц	0.21
C_2	Цахилгаан эрчим хүч	0.11
C_3	Дэд бүтэц	0.06
C_4	Мэргэжилтэй боловсон хүчин	0.12
C_5	Ус, уур, бохир	0.1
C_6	Цэвэрлэх байгууламж	0.04
C_7	Борлуулалтын зах зээл	0.2
C_8	Техник тоног төхөөрөмж	0.16

Арьс Ширний Үйлдвэрлэгчдийн төлөөлөл

Арьс, ширний үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
<i>C₁</i>	<i>Ус</i>	<i>0.08</i>
<i>C₂</i>	<i>Цахилгаан эрчим хүч</i>	<i>0.05</i>
<i>C₃</i>	<i>Түүхий эдийн нөөц</i>	<i>0.07</i>
<i>C₄</i>	<i>Хүний нөөц</i>	<i>0.06</i>
<i>C₅</i>	<i>Технологи</i>	<i>0.08</i>
<i>C₆</i>	<i>Авто зам</i>	<i>0.03</i>
<i>C₇</i>	<i>Мал эмнэлэгийн үйлчилгээ</i>	<i>0.06</i>
<i>C₈</i>	<i>Зориулалтын агуулах</i>	<i>0.05</i>
<i>C₉</i>	<i>Мал нядлах цех</i>	<i>0.05</i>
<i>C₁₀</i>	<i>Түүхий эдийн тордолын цех</i>	<i>0.06</i>
<i>C₁₁</i>	<i>Цэвэрлэх байгууламж</i>	<i>0.11</i>
<i>C₁₂</i>	<i>Зах зээлтэй ойр байх</i>	<i>0.05</i>
<i>C₁₃</i>	<i>Төмөр зам</i>	<i>0.04</i>
<i>C₁₄</i>	<i>Уур, ус, дулаан</i>	<i>0.07</i>
<i>C₁₅</i>	<i>Хүнд үйлдвэртэй ойр байрлах</i>	<i>0.03</i>
<i>C₁₆</i>	<i>Хүн амын төвлөрөл</i>	<i>0.05</i>
<i>C₁₇</i>	<i>Лаборатори</i>	<i>0.06</i>

Жимс жимсгэний үйдвэрлэлийн оролцогчид

Санал асуулгад Монголын жимс жимсгэнийн үндэсний холбооны тэргүүн Д. Насанжаргал, менежер Мөнхцэцэг, ХАИСийн зөвлөх Б. Нинж, ХААБТ-ийн захирал Тамир нар оролцон өөрсдийн мэргэжлийн мэдлэг олон жилийн туршлага дээр үндэслэн зөвлөлдөж энэ салбарын үйлдвэрлэлд хамгийн чухал хүчин зүйлүүдийг тодорхойлсон. Энэхүү зөвлөлдөөний үр дүнд дараах 9 хүчин зүйлс нь тухайн салбарын хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйлс гэдэг дээр санал нэгдэж, эдгээрийн хүчин зүйлүүдийн ач холбогдлын жинг тодорхойлох санал асуулгад хамрагдсан. Санал асуулгыг боловсруулан үр дүнг дараах хүснэгтээр үзүүлээ. Ментор Ц. Сэлэнгэ. Жимс, жимсгэнийн үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
C_1	Түүхий эдийн нөөцтэй ойр байх	0.20
C_2	Дэд бүтэц	0.09
C_3	Борлуулалтын зах зээлтэй ойр байх	0.12
C_4	Цэвэр усын нөөц	0.15
C_5	Ажиллах хүчний нөөц	0.14
C_6	Цахилгаан эрчим хүч	0.15
C_7	Түүхий эдийн чанар агууламж	0.11
C_8	Байгаль, цаг уур, орчны нөлөөлөл	0.05

Эдгээр хүчин зүйлийн хамгийн их ач холбогдолтой нь түүхий эдийн нөөцтэй ойр байх бол байгаль цаг уур, орчны нөлөөлөл нь хамгийн бага ач холбогдолтой нь гэж дүгнэж байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийн оролцогчид

Тус салбарын үйлвэрлэгч Витафит милк ХХК-ны Ичинхорлоо, Сүү ХК-ны Амарбаясгалан, Баярцэцэг, Монголын ээдэмцэрийн холбооны захирал Чимэд-Очир, Гантөмөр, ШУТИС-ийн профессор Дамдинсүрэн, Сүүн сондор ХК-ны Болормаа, Монголын Сүүний Нэгдсэн Холбооны Амарцэнгөл, Ганхуяг нар оролцсон, ментор Т.Дөлтуяа. Тус салбарын оролцогчдод санал асуулгын талаар зөвлөлгөө өгсний дараа мэргэжлийн хүмүүс нь зөвлөлдөөд дараах зүйлүүдэд санал нэгдэв. Сүү, сүүн бүтээгдэхүүний салбарын үйлдвэрлэл нь 2 салбарт хуваагддаг. Үүнд:

1. Түүхий сүүний үйлдвэрлэл. Эдгээр үйлдвэрийг суурин хотжисон газар байгуулах нь илүү тохиромжтой
2. Сүүний эрчимжсэн аж ахуй. Энэ үйлдвэрүүдийг сум бүр дээр байгуулах нь тохиромжтой. Тиймээс түүхий сүүний үйлдвэрлэлд тохирох хүчин зүйлүүдийг жагсааж жинг тодорхойлсон болно.

Жич: Мэргэжлийн холбоон дээр энэ талаар гаргасан судалгаа, бодлогын баримт бичиг байдаг тухай яригдсан. Түүхий сүүний үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
<i>C₁</i>	<i>Сүүний нөөц</i>	<i>0.09</i>
<i>C₂</i>	<i>Авто зам</i>	<i>0.09</i>
<i>C₃</i>	<i>Цахилгаан эрчим хүч</i>	<i>0.09</i>
<i>C₄</i>	<i>Цэвэр ус</i>	<i>0.11</i>
<i>C₅</i>	<i>Дулаан</i>	<i>0.05</i>
<i>C₆</i>	<i>Ажиллах хүч</i>	<i>0.09</i>
<i>C₇</i>	<i>Бохирын систем</i>	<i>0.07</i>
<i>C₈</i>	<i>Цэвэрлэх байгууламж</i>	<i>0.07</i>
<i>C₉</i>	<i>Ложистик</i>	<i>0.13</i>
<i>C₈</i>	<i>Тогтвортой нийлүүлэлт</i>	<i>0.22</i>

Үр тариа эрхлэгчдийн төлөөлөл

Энэ хэлэлцүүлэгт Дэлгэрцээл ХХК-наас нягтлан бодогч Д. Нарангэрэл, Алаг-түрүү ХХК-ний захирал Г. Дамбийсүрэн, Шахайт Уул ХХК захирал Д. Батцэцэг нар оролцлоо. Оролцогчид зөвлөлдөн үйлдвэрлэлийн байршилд хамгийн чухал хүчин зүйлийг тодорхойлон тэдгээрийн жинг тооцоолох санал асуулгад хамрагдсан. Оролцогчид тийм ч хангалттай олон байгаагүй тул цаашид илүү олон хүмүүс хамруулах хэрэгтэй гэж үзсэн. Тус хүчин зүйлсийн боловсруулалтыг ментор Ц. Сэлэнгэ хийж доор танилцуулж байна. Үр тарианы боловсруулах үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
<i>C₁</i>	<i>Түүхий эдийн нөөцтэй ойр байх</i>	<i>0.12</i>
<i>C₂</i>	<i>Зам, харилцаа холбоо</i>	<i>0.09</i>
<i>C₃</i>	<i>Цахилгаан эрчим хүч</i>	<i>0.14</i>
<i>C₄</i>	<i>Ажиллах хүч</i>	<i>0.07</i>
<i>C₅</i>	<i>Усны нөөц</i>	<i>0.06</i>
<i>C₆</i>	<i>Хөрсний үржил шим</i>	<i>0.06</i>
<i>C₇</i>	<i>Мал аж ахуйтай ойр байх</i>	<i>0.08</i>
<i>C₈</i>	<i>Дотоодын зах зээлтэй ойр байх</i>	<i>0.17</i>
<i>C₉</i>	<i>Боомтой ойр байх</i>	<i>0.23</i>

Ой, Модны Үйлдвэрлэл Эрхлэгчдийн Холбоо

Ой, Модны боловсруулах үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
<i>C₁</i>	<i>Нийт ойн нөөц</i>	<i>0.14</i>
<i>C₂</i>	<i>Хүний нөөц</i>	<i>0.09</i>
<i>C₃</i>	<i>Эрчим хүчний хангамж</i>	<i>0.10</i>
<i>C₄</i>	<i>Зах зээлийн эрэлт</i>	<i>0.10</i>
<i>C₅</i>	<i>Техник технологи</i>	<i>0.09</i>
<i>C₆</i>	<i>Ойн зам</i>	<i>0.10</i>
<i>C₇</i>	<i>Авто зам</i>	<i>0.08</i>
<i>C₈</i>	<i>Усан хангамж</i>	<i>0.04</i>
<i>C₉</i>	<i>Судлагдсан байдал</i>	<i>0.10</i>
<i>C₁₀</i>	<i>Хилийн боомтын төвлөрсөн байдал</i>	<i>0.08</i>
<i>C₁₁</i>	<i>Нийгмийн байгууламжийн хөгжил</i>	<i>0.09</i>

Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбар

Хаягдал дахин боловсруулах салбарын төлөөлөл болж Батжаргал, Содбуян, Энхцэцэг, Эрдэнэсайхан, Рагчаасүрэн, Ганболд нарын хүмүүс оролцлоо. Ментор Г.Баттөр Тус салбарын оролцогчдод санал асуулгын талаар зөвлөгөө өгсний дараа мэргэжлийн хүмүүс нь зөвлөлдөөд дараах зүйлүүдэд санал нэгдэв.

1. Хог хаягдалтай харицах тал дээр иргэдийн экологийн боловсрол маш муу. Хогоо ангилан ялгаж хаях ямар ч ойлголт байхгүй
2. Төр засгийн зүгээс иргэдийн энэ талын боловсролд анхаарч байгаа зүйл байхгүй. Хог хаягдлыг дахин боловсруулах, хэмнэлт гаргах тал дээр хууль эрх зүйн зохицуулалт байхгүй
3. Энэ чиглэлээр хөрөнгө санхүү, бодлогын дэмжлэг маш сул гэлээ.

Оролцогчид дээрх асуудлуудыг дэвшүүлэн ярилцсаны эцэст хаягдал дахин боловсруулах үйлдвэр барьж байгуулахад шаардлагатай хүчин зүйлсийг тодорхойлж санал асуулгыг явуулахаар тогтлоо. Дараах хүчин зүйлсийн дарааллын дагуу АШП-ын аргыг хэрэглэв. Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
<i>C₁</i>	<i>Байршил</i>	<i>0.18</i>
<i>C₂</i>	<i>Дэд бүтэц</i>	<i>0.10</i>
<i>C₃</i>	<i>Түүхий эдийн нөөц</i>	<i>0.07</i>
<i>C₄</i>	<i>Хүн ам</i>	<i>0.08</i>
<i>C₅</i>	<i>Төрийн зохицуулалт</i>	<i>0.10</i>
<i>C₆</i>	<i>Экологийн боловсрол, бодлого</i>	<i>0.08</i>
<i>C₇</i>	<i>Мэдээлэл харилцаа</i>	<i>0.12</i>
<i>C₈</i>	<i>Хууль, эрх зүйн орчин</i>	<i>0.07</i>
<i>C₉</i>	<i>Эрчим хүч</i>	<i>0.08</i>
<i>C₁₀</i>	<i>Мэргэжлийн бүтэц</i>	<i>0.08</i>
<i>C₁₁</i>	<i>Тээвэр ложистик</i>	<i>0.05</i>

Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбоо

Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбооны хурал 2019-08-24 ны өдөр Төв аймагт Могол оёдлын үйлдвэрийн байранд боллоо. Хуралд холбооны тэргүүн Тунгалаг, удирдах зөвлөлийн гишүүд: Оюунчимэг, Энхцэцэг, Нэргүй,Тэмүүлэн, Баяржаргал, Чимэд-Очир, Батжаргал, Эрдэнэбат, Отгонболд, Жаргалсайхан, Палам, Жаргал нар оролцсон. Ажлын талаар С.Батбилэг, Ц.Сэлэнгэ нар танилцуулга хийж хүн бүрт зааварчилгаа өгч тус салбарын хүчин зүйлсийн жагсаалтыг санал нэгдсэн байдлаар гаргуулан, санал асуулгыг авлаа. Оёдлын салбар нь дараах онцлогуудтай байдаг. Үүнд:

1. Мэргэжлийн ажилтан хомс, ажиллах хүчнийг хүн ам олноор төвлөрсөн газраас олох боломжтой.
2. Түүхий эдийн хувьд нийлүүлэгч хэдэн үйлдвэрээс авдаг /дотоод болон гадаад/.

Иймд түүхий эд нийлүүлт дээр асуудал нэг их үүсээд байдаггүй. Энэ салбарын үйлдвэрүүдийг тэр бүр орон нутагт байгуулахад хүндрэлтэй. Өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмж, олон тооны ажиллах хүчин хэрэгтэй гэдгээс шалтгаалан хэсэг аймаг, бүсийн хэмжээнд сайтар тооцож байгуулбал болох талтай. Нөгөө талаас мөн мэргэжлийн ажиллах техник ажилтнууд хөдөө орон нутагт дутагдалтай. Иймээс энэ салбарын үйлдвэрлэл нь технологи, өндөр мэргэжлийн ажилтан, ажилчдыг шаарддаг тул хүн ам төвлөрсөн, мэргэжлийн боловсон хүчний нөөц сайтай, цахилгаан, уур, усны нөөцтэй, хаягдал, бохирын системийг шийдсэн байрлалд байгуулах боломжтой. Нөгөө талаар яг хэрэглэгчтэй ойр өөрийн дэлгүүрийг нээн ажиллуулах боломжтой. Ерөнхийдөө аймгийн төвүүдийг зохистой гэж харагдах байх гэж оролцогчид таамагласан. Оролцогчид эдгээр хүчин зүйлийг тооцоод байгуулах, байгуулсан ажиллаж буй үйлдвэрүүд дэээр хүчин зүйлсийн нэрс, санал асуулгыг явуулахаар тогтлоо. Санал асуулгын үр дүнг дараах хүснэгтэд нэгдгэн харууллаа. Оёдлын үйлдвэрлэлийн байршлын шалгуур үзүүлэлтийн нөлөөллийн дундаж жинг дараах хүснэгтээр харууллаа.

Индекс	Шалгуур үзүүлэлт	Дундаж жин
C_1	Дэд бүтэц	0.05
C_2	Цахилгаан эрчим хүч	0.16
C_3	Дулаан	0.09
C_4	Бохир	0.07
C_5	Мэргэжилтэй боловсон хүчин	0.18
C_6	Ажиллах хүч	0.17
C_7	Уур, ус	0.08
C_8	Түүхий эдтэй ойр байх	0.1
C_9	Зах зээлтэй ойр байх	0.1

5.4 Сүүний үйлдвэрийн оновчтой байршлыг тодорхойлох бодлого

1. Сүүний үйлдвэр барих тохиромжтой байрлалыг сонгоход нэн чухал гэж үзсэн 9 шалгууруудыг сонгож авсан. Үүнд

$C_1(\cdot)$	$C_2(\cdot)$	$C_3(\cdot)$	$C_4(\cdot)$	$C_5(\cdot)$
Сүүний нөөц	Хэрэглээ	Усны нөөц	Цахилгааны ачаалал	Ажиллах хүч
$C_6(\cdot)$	$C_7(\cdot)$	$C_8(\cdot)$	$C_9(\cdot)$	
Улаанбаатар хот хүртэлх зай	Боомт хүртэлх зай	Аймгийн төв хүртэлх зай	Төмөр зам хүртэлх зай	

2. Эдгээр шалгуурын ач холбогдлоор нь жинг АШП аргаар бодохдоо хос хосоор нь стандарт оноогоор жинлэх ажлыг мэргэжлийн холбооны экспертүүдээс саналыг авч үнэлгээний матрицыг ашигласан.

Түүнчлэн үнэлгээ нийцлийг шалгахад $C.R = 0.02$ буюу нийцтэй бөгөөд харгалзах жин

$$W = (0.2694, 0.2694, 0.0970, 0.1, 0.0297, 0.1, 0.0297, 0.0629, 0.0420)$$

байна. Өөрөөр хэлбэл C_1 буюу сүүний нөөцийн шалгуурын жин нь 0.27 буюу сүүний нөөцийг тохиромжтой байрлал тодорхойлоход 27 хувийн, C_9 төмөр зам хүртэлх зайг 4 хувийн ач холбогдолтойгоор тооцох болно.

3. PROMETHEE II аргаар говийн дэд бүсийн нийт 47 сумдын потенциалыг эрэмбэлэхэд дээрх 9-н шалгуурын харгалзах жин w_i -ийг ашиглан шалгуур бүрийн хувьд сумдын бодит өгөгдлүүдийг энэхүү төслийн бусад багуудын судалгаанаас авч анализ хийсэн.

Дээрх аргыг FLP бодлоготой хамт туршиж нийт 4 үр дүн гаргасан. Үүнд: Сүүн бүтээгдэхүүнийг Улаанбаатар, Аймгийн төв, Боомт, бусад гэсэн 4 газар нийлүүлнэ гэж үзсэн ба харгалзан нийлүүлэлтийн хэмжээ 10000, 20000, 15000 болон 20000тн. Туршилтын үр дүнг доорх хүснэгтээр үзүүлээ. Хүснэгтийн эхний багананд сумдын нэрсийг 2-р багананд зөвхөн Promethee аргаар олсон үр дүнг + тэмдэгээр харуулсан нь үйлдвэрийн боломжит байршлыг илэрхийлж байна. 3-р багананд FLP болон Promethee аргуудыг хослуулсан үр дүнг, 4-р багананд санамсаргүй үүсгэсэн цахилгаан эрчим хүчний датаг авч үзсэн FLP аргын бодолтын үр дүнг, 5-р

багананд 4-ын үр дүнг Promethee аргатай хослуулснаар хэрхэн өөрчлөгдөхийг харсан үр дүнгүүд тус тус орууллаа. Үүнээс бүх аргуудын үр дүнгээс давхардсанг харвал: Сүмбэр, Сайншанд, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ, Мандалговь, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрцогт, Дэрэн сумдууд байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Table 1: 111. Аргуудын харьцуулалт

Д/д	Сумдын нэрс	Promethee only	FLP with prom	FLP with electric data	FLP with electric and prom
0	Баянтал		+	+	+
1	Сүмбэр	+	+	+	+
2	Шивээговь				
3	Сайншанд	+	+	+	+
4	Хар-Айраг	+	+	+	+
5	Алтанширээ			+	+
6	Даланжаргалан	+	+		
7	Дэлгэрэх				+
8	Замын-Үүд	+	+		
9	Иххэт				+
10	Мандах			+	+
11	Өргөн	+	+		
12	Сайхандулаан	+	+		
13	Улаанбадрах			+	+
14	Хатанбулаг	+	+		
15	Хөвсгөл				
16	Эрдэнэ	+	+	+	+
17	Мандалговь	+	+	+	+
18	Адаацаг	+	+	+	+
19	Баянжаргалан			+	+
20	Говь-Угтаал			+	+
21	Гурвансайхан	+	+		
22	Дэлгэрхангай			+	+
23	Дэлгэрцогт	+	+		
24	Дэрэн	+	+	+	+
25	Луус				
26	Өлзийт	+	+		
27	Өндөршил				
28	Сайхан-Овоо				
29	Хулд	+	+		
30	Цагаан-Дэлгэр			+	+
31	Эрдэнэдалай	+	+		
32	Даланзадгад	+	+	+	+
33	Баяндалай				
34	Баян-Овоо				
35	Булган			+	
36	Гурвантэс				
37	Мандал-Овоо			+	
38	Манлай				
39	Ноён				
40	Номгон	+		+	+
41	Сэврэй				
42	Ханбогд			+	+
43	Ханхонгор				
44	Хүрмэн		29		
45	Цогт-Овоо				
46	Цогтцэций	+	+		

6 Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн ашгийг максимумчлах бодлого

Тоглоомын онол нь орчин үед улс төр, эдийн засаг, нийгэм, инженерчлэл, үйлдвэрлэл, үйлдлийн шинжлэл, цэрэг дайны салбар, мэдээлэл технологи, олон улсын худалдаа, гэрээ хэлцэл хийхэд өргөн ашиглагдахаас гадна хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлт зэргийг загварчлахад өргөнөөр ашиглагдаж байна. Тоглоомын онол нь дотроо матрицан тоглоом, биматрицан тоглоом, тэг нийлбэртэй тоглоом, тэг биш нийлбэртэй тоглоом, полиматрицан тоглоом, дифференциал тоглоом зэргээр ангилагдах ба тухайн ямар салбарт ашиглагдаж байгаагаасаа хамаараад өөр арга, онол, хэрэглээтэй байдаг. Тоглоомд оролцож байгаа оролцогчидын авч байгаа мэдээллээс хамаараад бүрэн ба бүрэн бус мэдээлэлтэй тоглоом гэж ангилагддаг. Бид энэхүү хэсэгт N – оролцогчтой тэг биш нийлбэртэй Курно-Нэшийн загварыг товч авч үзнэ. Энэ загвар нь олигополь зах зээлийн тэнцвэрийг судлахад өргөн ашиглагддаг. Сүүлийн үед энэхүү загварын өргөтгөлийг уул уурхай, гадаад худалдаа, объектын ашигтай байршил тогтоох зэрэг хэзээгээс олон салбаруудад ашиглаж байна. N – тоглогчтой Курно-Нэшийн классик загварыг дараах хэлбэртэй томъёолдог. Нэгэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг N – тооны үйлдвэрлэгч (тоглогчид) байг. Энэ зах зээлд оролцогчид тухайн бүтээгдэхүүнийг борлуулах үнийг дангаараа тогтоох боломжгүй гэж үзнэ. Ийм зах зээлийг олигополь зах зээлд хамааруулдаг. i – р тоглогч x_i хэмжээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба тухайн зах зээлд тогтож байгаа үнэ $P_i = P_i(Q) = a_i - b_i Q$, $Q = \sum_{i=1}^N x_i$ байг. Энд Q – нь бүх үйлдвэрлэгчидийн үйлдвэрлэх нийт бүтээгдэхүүн юм. Тэгвэл i – р тоглогчийн олох цэвэр ашгийг Курно-Нэшийн загвараар дараах хэлбэртэй олно.

$$(P_i) \quad \max_{x_i \in X_i} f(x_i, x_{-i}) = x_i P_i - C_i x_i, \quad i = 1, \dots, N$$

Энд C_i нь i – р тоглогчийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан нийт зардал, X_i тухайн тоглогчийн зааглалт (нөөц), $x_{-i} := (x_{i'})_{i'=1, i' \neq i} \in \mathbb{R}^{n-i}$ нь i – ээс бусад тоглогчидын үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээг тус тус илэрхийлж байгаа юм. Энэ төрлийн бодлого нь параллель, параметртэй програмчлалын бодлогод хамаарна. Одоо дээрх N – тооны параллель оптимизацийн бодлогын шийдийн тодорхойлолтыг өгье.

$$f_i(\bar{x}_i, \bar{x}_{-i}) \geq f_i(x_i, \bar{x}_{-i}), \quad \forall x_i \in X_i, \quad i = 1, \dots, N.$$

нөхцлийг хангах $\bar{x}_i \in X_i$ – цэгийг i – р тоглогчийн шийд гэх ба энэ бүх N – тооны уялдаатай цэгүүдийн векторыг Нэшийн тэнцвэрийн цэгүүд гэдэг. Тэгэхээр Курно-Нэшийн загварын гол зорилго бол тоглогч бүрийн ашгийг хамгийн их байлгах цэг Нэшийн тэнцвэрийн цэгийг олоход оршино. Ийм учраас дээрх бодлогыг хотгор програмчлалын бодлого хэлбэрээр загварчлах нь шийдийг олох боломжийг өгдөг. (P_i) – бодлогыг бодох хэд хэдэн төрлийн аргууд байдаг. Тухайлбал, үл хөдлөх цэгийн арга, Никайдо-Исодагийн функцийн арга, торгуулийн арга, вариацийн тэнцэтгэлбишийн арга гэх мэт. Одоо Курно-Нэшийн загварын практик хэрэглээг үйлдвэр барих шийдвэр гаргах дараах загварын тусламжтай тайлбарлана. Энэ бодлогыг говийн бүсийн 47 сумыг тус бүрд нь нэг тоглогч гэж үзээд хэрвээ сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр сум бүрт баригдсан гэж үзвэл тус бүрийн ашиг нь ямар байхыг сум бүрийн нөөц, зааглалт(сүүний нөөц, ажиллах хүч, эрчим хүч, тээврийн зардал гэх мэт) дээр тулгуурлан судлах зорилго тавья. Дараа нь дээрх тоглогчидоо ашгаар нь эрэмблэнэ. Ийм эрэмбэ тогтоосноор ашиг нь өндөр байгаа эхний k – тооны тоглогчидыг(сумд) шийдвэр гаргагчдын зүгээс анхаарах, хөрөнгө оруулалтыг зохистой оруулах, удирдах боломж үүснэ. $i = 1, \dots, N$ тоглогчдын бодлогыг дараах хэлбэртэй тавья.

$$(M_i) \quad \max_{(x_i, y_{ij})} f_i(x) = \omega_i s_i [x_i P_i(Q) - (c_{1i}^T + c_{1i}^P + c_{1i}^{var})x_i + \sum_{j=1}^{s_i} (\bar{P}_{ij} y_{ij} - (c_{2i}^T + c_{2i}^P + c_{2i}^{var})y_{ij})]$$

$$\begin{aligned}
X_k = \{ & (x_i, y_i) : P_i(Q) = (a_i - b_i Q), \bar{P}_{ij} = (\bar{a}_{ij} - \bar{b}_{ij} y_i) \\
& 0 \leq x_i \leq \text{cap}_i^{\text{milk}}, \\
& 0 \leq y_{ij} \leq \text{cap}_i^{\text{prod}}, \quad j = 1, \dots, s_i, \\
& Q = \sum_{i=1}^N x_i, \quad y_i = \sum_{j=1}^{s_i} y_{ij}, \\
& \alpha_1 x_1 + \alpha_2 x_2 + \dots + \alpha_N x_N \leq T, \\
& \beta_1 y_1 + \beta_2 y_2 + \dots + \beta_N y_N \leq M \}.
\end{aligned}$$

Энд

x_i нь i -р сумын үйлдвэрийн аргаар(ариутгаж савласан) бэлтгэсэн сүүний хэмжээ(литрээр),
 y_{ij} нь i -р сумын үйлдвэрлэж байгаа сүүн бүтээгдэхүүн(ааруул, өрөм, зөөхий, тараг, бяслаг гэх мэт)
 $\text{cap}_i^{\text{milk}}$ – нь i -р сумын бэлтгэж чадах сүүний дээд хүчин чадал(литрээр),
 $\text{cap}_i^{\text{prod}}$ – нь i -р сумын бэлтгэж чадах сүүн бүтээгдэхүүний дээд хүчин чадал(тонноор),
 $c_{1i}^T, c_{1i}^P, c_{1i}^{\text{var}}$ -нь харгалзан i -р сумын сүү тээвэрлэлт, үйлдвэрлэлийн болон хувьсах зардалууд,
 $c_{2i}^T, c_{2i}^P, c_{2i}^{\text{var}}$ -нь харгалзан i -р сумын сүүн бүтээгдэхүүний тээвэрлэлт, үйлдвэрлэлийн болон хувьсах зардалууд,
 $\alpha_1, \alpha_2, \dots, \alpha_N$ – сумдууд сүүний дотоодын хэрэгцээгээ хангаад улсад нийлүүлж болох илүүдэл хувиуд,
 T –улсаас энэ бүс нутагт бэлтгэхээр төлөвлөж байгаа төлөвлөгөөт сүүний хэмжээ,
 $\beta_1, \beta_2, \dots, \beta_N$ – сумдууд сүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээгээ хангаад улсад нийлүүлж болох илүүдэл хувиуд,
 M – төлөвлөгөөт сүүн бүтээгдэхүүний хэмжээ,

$$\omega_i = \begin{cases} 1, & \text{хэрэв } i\text{-р сум } 380\text{квт холбогдсон} \\ 0, & \text{үгүй бол} \end{cases}$$

$$s_i = \begin{cases} 1, & \text{хэрэв } i\text{-р сум төмөр зам болон засмал замтай} \\ 0.5, & \text{хэрэв } i\text{-р сум засмал замтай} \\ 0.2 & \text{хэрэв } i\text{-р сум шороон замтай} \end{cases}$$

Дээрх бодлого нь $N = 47$ тоглогчтой хамтын гүдгэр зааглалттай ерөнхийлсөн Нэшийн тэнцвэрийн бодлого юм. Тоглогч бүрийн зорилгын функц бусад тоглогчдын стратегиудаас хамаарсан, зааглалтын олонлог бэхлэгдсэн, битүү, гүдгэр олонлогууд байна. Мөн тоглогч бүрийн зорилгын функцүүд өөрийн стратегиудын хувьсагчуудаар хотгор учраас дээрх бодлого нь эквивалентаар тус бүрдээ гүдгэр програмчлалын параметрт бодлогууд юм. Хамтын гүдгэр зааглалттай ерөнхийлсөн Нэшийн тэнцвэрийн бодлогыг эквивалентаар дараах Вариацийн тэнцэтгэлбиш рүү шилжүүлж боддог.

$$F(x^*)^T(x - x^*) \geq 0, \quad \forall x \in X \subset R^n \quad (VIP)$$

Энд $F : R^n \rightarrow R^n$ өгөгдсөн вектор функц, $X \subset R^n$ өгөгдсөн битүү, гүдгэр олонлог.

$$X = X_1 \times X_2 \times X_3 \times \dots \times X_{47},$$

$$F(x) = (\nabla_{x_i} f_i(x))_{i=1}^{47}$$

F – буулгалт монотон үед (VIP) бодлого шийдтэй, хүчтэй монотон үед цор ганц шийдтэй байдаг.

6.1 Тоон туршилт

Одоо дээрх загвар дээрээ параметруудийг өгөх замаар тооцоолол хийж үзье. Сүүн бүтээгдэхүүний талаар дата өгөгдөл огт байхгүй учраас (M_i) – загвар дээр зөвхөн сүү үйлдвэрлэл гэсэн хэсгийг нь үлдээж тооцоо хийе. Өөрөөр хэлбэл y_{ii} хувьсагчаас хамаарсан хэсгийг тооцоонд оруулахгүй. $P_i(Q) = (a_i - b_i Q)$ томъёонд $a = 2000, b = -0.01$ гэж авъя. $c_{1i}^T = 200, c_{1i}^P = 300, c_{1i}^{var} = 100$ төг гэж тооцоонд оруулна. Сум тус бүрийн сүүний нөөцөөс хэрэгцээг нь хасаж нийт нөөцд нь харьцуулсан харьцаагаар сум бүрийн улсад төвлөрүүлэх боломжит хувь буюу α_i -нүүдийг тооцно. T – г шийдвэр гаргагчдын зүгээс тухайн бүс нутагт тавьж байгаа төлөвлөгөөт боловсруулсан сүүний хэмжээг авах ба энэ төлөвлөгөөт тоог өөрчлөх бүрт сум бүрийн ашиг харилцан адилгүй өөрчлөгдөж эрэмбэд өөрчлөлт орж байна. Сум бүрт үйлдвэр барьсан гэж үзэж байгаа тул сум бүрийг 380 квтд холбогдсон гэж үзнэ. Өөрөөр хэлбэл $\omega_i = 1, i = 1, \dots, 47$ гэж үзье. $T = 30000$ тн сүү үйлдвэрлэх төлөвлөгөөт норм өгвөл дараах байдлаар эрэмбэ үүсэв. Үйлдвэр баривал ашгаараа хамгийн эхэнд (Index=1) энэ хүснэгтийн эхний сум буюу Говьсүмбэрийн Сүмбэр сум, Хоёрдугаарт (Index=7) буюу Дорноговь-Даланжаргалан сум, гуравдугаарт (Index=5) Говьсүмбэр-Шивээговь сум тус тус ашигтай гарч байна. Усны нөөцийн талаар дата олдоогүй учраас энэ тооцоонд оруулсангүй. Мөн дээрх загварт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тодорхой хувийг хөрөнгө оруулалт байдлаар ашиглаж боломжийг тусгаж загварчлах боломжтой. Мах, Ноос, Ноолуурын үйлдвэрүүд дээр ийм эрэмбийг мөн гаргах боломжтой.

Аймаг	Сумдууд	Сүүний нөөц	Сүүний хэрэглээ	Ашгийн эрэмбэ	Замын нөхцөл
Дорноговь	Сайншанд сум	1623.374583	1090.629404	Index=35	1
Дорноговь	Айраг сум	1811.360379	169.7292874	Index=46	1
Дорноговь	Алтанширээ сум	1700.76054	58.46692106	Index=2	1
Дорноговь	Даланжаргалан сум	2161.316117	124.5419194	Index=33	1
Дорноговь	Дэлгэрэх сум	2790.816745	85.67156098	Index=3	0.2
Дорноговь	Замын-Үүд сум	481.3078062	784.415821	Index=18	1
Дорноговь	Иххэт сум	2347.23967	94.93958238	Index=9	0.2
Дорноговь	Мандах сум	1936.300215	72.16146014	Index=43	0.2
Дорноговь	Өргөн сум	1906.688549	87.33150511	Index=39	1
Дорноговь	Сайхандулаан сум	2278.782372	59.98853651	Index=34	0.2
Дорноговь	Улаанбадрах сум	2129.831118	66.85886083	Index=37	0.2
Дорноговь	Хатанбулаг сум	3417.327462	131.9655584	Index=47	0.2
Дорноговь	Хөвсгөл сум	1759.728307	72.34589837	Index=36	0.2
Дорноговь	Эрдэнэ сум	3219.631559	110.3862847	Index=42	1
Дорноговь	Дүн	29564.46542	3009.4326	Index=40	0
Дундговь	Сайнцагаан сум	4502.606833	685.6453124	Index=32	0.2
Дундговь	Адаацаг сум	3629.285026	133.4809012	Index=45	1
Дундговь	Баянжаргалан сум	1346.207464	56.52749908	Index=29	0.2
Дундговь	Говь-Угтаал сум	2134.216507	75.19582441	Index=12	0.2
Дундговь	Гурвансайхан сум	2668.331145	98.47185344	Index=44	0.2
Дундговь	Дэлгэрхангай сум	2225.077955	102.7945445	Index=41	0.2
Дундговь	Дэлгэрцогт сум	2234.271572	73.8657656	Index=26	1
Дундговь	Дэрэн сум	2968.692567	96.85678204	Index=19	0.2
Дундговь	Луус сум	2137.963165	85.36127382	Index=30	1
Дундговь	Өлзийт сум	3112.7471	110.6798932	Index=27	1
Дундговь	Өндөршил сум	2004.182713	67.3579779	Index=6	0.2
Дундговь	Сайхан-Овоо сум	2170.966383	102.1295151	Index=17	0.2
Дундговь	Хулд сум	3038.455966	109.3498344	Index=24	1
Дундговь	Цагаандэлгэр сум	1688.9873	46.50455597	Index=23	0.2
Дундговь	Эрдэнэдалай сум	7904.857859	266.2492709	Index=20	0.2
Дундговь	Дүн	43766.84955	2110.470804	Index=38	
Өмнөговь	Даланзадгад сум	956.1710169	1072.249037	Index=16	1
Өмнөговь	Баяндалай сум	1842.947149	95.17437744	Index=10	0.2
Өмнөговь	Баян-Овоо сум	1368.746749	77.87411694	Index=15	1
Өмнөговь	Булган сум	1664.178932	94.9908203	Index=11	0.2
Өмнөговь	Гурвантэс сум	1770.833304	214.1194046	Index=22	0.2
Өмнөговь	Мандал-Овоо сум	1803.12923	74.34064198	Index=21	0.2
Өмнөговь	Манлай сум	1848.993989	113.0253094	Index=28	0.2
Өмнөговь	Ноён сум	1159.664424	61.17041713	Index=25	0.2
Өмнөговь	Номгон сум	2620.075558	117.2012343	Index=14	1
Өмнөговь	Сэврэй сум	1572.091468	93.43058461	Index=8	0.2
Өмнөговь	Ханбогд сум	2174.449044	248.0315864	Index=31	0.2
Өмнөговь	Ханхонгор сум	2073.729502	93.84358817	Index=13	1
Өмнөговь	Хүрмэн сум	1532.618651	72.59684914		0.2
Өмнөговь	Цогт-Овоо сум	1187.921852	76.4515491		1
Өмнөговь	Цогтцэций сум	1757.11652	324.8043604		0.2
Өмнөговь	Дүн	25332.66739	2829.303877		

Аймаг	Сумдууд	Сүүний нөөц	Сүүний хэрэглээ	Ашгийн эрэмбэ	Замын нөхцөл
Говьсүмбэр	Сүмбэр сум	4798.130153	546.7586923	Index=1	1
Говьсүмбэр	Баянтал сум	1007.889276	53.22951362	Index=7	1
Говьсүмбэр	Шивээговь сум	944.0976177	149.1242507	Index=5	1
Говьсүмбэр	Дүн	6750.117046	749.1124566	Index=4	

7 Дүгнэлт

- Бид энэ судалгааны ажлаар аж үйлдвэрийн салбаруудыг тухайн бүс нутагт хэрхэн оновчтой байршуулах талаар математик судалгаа хийсэн. Үүний тулд тухайн сум орон нутгийн хувьд үйлдвэр барихад зайлшгүй шаардлагатай хүчин зүйлүүдийг эхлэн тодорхойлж Аналитик шаталсан процессын аргыг ашиглан эдгээр хүчин зүйлсийн нөлөөлөл буюу жингүүдийг тодорхойлсон.
- Үүний дараа эдгээр жингүүдийг ашиглан бусад нөөц, хязгаарлалтуудад тулгуурласан Facility Location бодлогыг дангаар нь болон АНР-аргатай хослуулан томъёолсон. Эдгээр бодлого нь холимог бүхэл тоон программчлалын бодлого учраас ерөнхий тохиолдолд NP-hard төрлийн бодлогод хамаардаг.
- Сум бүрийг нэг нэг тоглогч гэж үзэн, үйлдвэр барихад шаардлагатай хүчин зүйлсүүд харилцан адилгүй гэдгээс бид ерөнхийлсөн Нэшийн тэнцвэрийн загварыг томъёолж бүтээгдэхүүнийг борлуулахад олох цэвэр ашгаар нь эрэмбэ тогтоож болохыг үзүүлсэн.
- Дээрх загваруудаа Говийн бүсийн сүү, сүүн бүтээгдэхүүний салбар дээр туршиж үзсэн. Энэ салбарын хувьд бусад салбаруудаа бодвол дата өгөгдөл харьцангуй илүү олдож байсан.
- Эцэст нь дүгнэхэд бидний боловсруулсан загварууд бусад салбаруудад хэрэглэгдэх бүрэн боломжтой. Гагцхүү тухайн үйлдвэрийг барихад шаардлагатай нөөц, хязгаарлалтуудыг илэрхийлсэн бодит дата өгөгдлүүд олоход хүндрэлтэй байна.

References

- Alfonso-Lizarazo, E. H., Montoya-Torres, J. R., & Gutiérrez-Franco, E. (2013). Modeling reverse logistics process in the agro-industrial sector: The case of the palm oil supply chain. *Applied Mathematical Modelling*, 37(23), 9652–9664.
- Brans, J.-P., Vincke, P., & Mareschal, B. (1986). How to select and how to rank projects: The promethee method. *European journal of operational research*, 24(2), 228–238.
- Daskin, M. S. (2008). What you should know about location modeling. *Naval Research Logistics (NRL)*, 55(4), 283–294.
- Doumpos, M., & Zopounidis, C. (2004). A multicriteria classification approach based on pairwise comparisons. *European Journal of Operational Research*, 158(2), 378–389.
- Hajkowicz, S., & Higgins, A. (2008). A comparison of multiple criteria analysis techniques for water resource management. *European journal of operational research*, 184(1), 255–265.
- Herazo-Padilla, N., Montoya-Torres, J. R., Nieto Isaza, S., & Alvarado-Valencia, J. (2015). Simulation-optimization approach for the stochastic location-routing problem. *Journal of Simulation*, 9(4), 296–311.

- Holmberg, K., Rönnqvist, M., & Yuan, D. (1999). An exact algorithm for the capacitated facility location problems with single sourcing. *European Journal of Operational Research*, 113(3), 544–559.
- Klose, A., & Drexl, A. (2005). Facility location models for distribution system design. *European journal of operational research*, 162(1), 4–29.
- Lin, C.-T., Hung, K.-P., & Hu, S.-H. (2018). A decision-making model for evaluating and selecting suppliers for the sustainable operation and development of enterprises in the aerospace industry. *Sustainability*, 10(3), 735.
- Montoya-Torres, J. R., Franco, J. L., Isaza, S. N., Jiménez, H. F., & Herazo-Padilla, N. (2015). A literature review on the vehicle routing problem with multiple depots. *Computers & Industrial Engineering*, 79, 115–129.
- Muñoz-Villamizar, A., Montoya-Torres, J. R., & Faulin, J. (2017). Impact of the use of electric vehicles in collaborative urban transport networks: A case study. *Transportation Research Part D: Transport and Environment*, 50, 40–54.
- Saaty, T. L. (2007). The analytic hierarchy and analytic network measurement processes: applications to decisions under risk. *European journal of pure and applied mathematics*, 1(1), 122–196.
- Ueda, T., Tsutsumi, M., Muto, S., & Yamasaki, K. (2009). Computable urban economic models in japan. In *88th transportation research board annual meeting, washington dc*.
- Wang, Q., Batta, R., Bhadury, J., & Rump, C. M. (2003). Budget constrained location problem with opening and closing of facilities. *Computers & Operations Research*, 30(13), 2047–2069.

